



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
Хөдөлмөр,
нийгмийн хамгааллын яам



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
Хөгжлийн бэрхшээлтэй хүний
хөгжлийн ерөнхий газар



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ- 2021”

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ ПРАКТИКИЙН IX ХУРЛЫН ЭМХТГЭЛ



ЭРҮҮЛ МЭНД



БОЛОВСРОЛ



ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ



НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ



ДЭД БҮТЭЦ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ- 2021”

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ ПРАКТИКИЙН IX ХУРЛЫН ЭМХТГЭЛ



ЭРҮҮЛ МЭНД



БОЛОВСРОЛ



ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ



НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ



ДЭД БҮТЭЦ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ- 2021”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ ПРАКТИКИЙН IX ХУРЛЫН ЭМХТГЭЛ

Хэвлэлийн хуудас: 15 х.х.
Хэвлэлийн хэмжээ: В5

“Оргилпресс” ХХК-д хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛД <i>Зочин илтгэгч: М.Нарантуяа (PhD), дэд профессор</i>	8
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ ХАНДЛАГЫГ СУДЛАХ НЬ	16
<i>Г.Уянга¹</i>	
<i>¹ АЗДТГ-ын НБХ-ийн хүн амзүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫГ СУДАЛСАН НЬ	19
<i>Говь-Алтай аймгийн жишээн дээр!</i>	
<i>Д.Оюунчимэг¹, Э.Элбэрэлт¹, Г.Ганширмэн²</i>	
<i>¹Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг, ²АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар АУС</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨСӨӨЛӨЛ	22
<i>Д.Мөнх-Эрдэнэ¹</i>	
<i>¹Цагдаагийн ахлагч</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН	25
<i>Б.Дашдаваа¹</i>	
<i>¹Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨЖ БУЙ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	30
<i>Г.Жаргалмаа¹, Н.Болдмаа²</i>	
<i>¹Хараат Бус Судалгааны Хүрээлэн, ²Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль</i>	
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ШИЙДЭХ ГАРЦ	33
<i>Н.Мөнхбат¹</i>	
<i>¹Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН АМЬДРАЛЫН ЧАНАР	36
<i>Н.Золзаяа, Б.Батбаяр, Э.Болорцэцэг¹</i>	
<i>¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв</i>	
ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН НИЙГМИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС	38
<i>С.Дэлгэрмаа¹, З.Хишигсүрэн², Р.Оргилмаа¹, Л.Сундуй-Янжмаа¹, Н.Наранбаатар¹, Д.Мягмарцэрэн²</i>	
<i>¹АШУУИС, Сувिलाхуйн сургууль, ²АШУУИС, АУС</i>	
ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ	41
<i>Дуламсүрэн¹, Д.Юмжирмаа²</i>	
<i>¹Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолборын сэтгэл зүйч</i>	
<i>²ШУТИС, Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургуулийн сэтгэл судлалын багш</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН СЭТГЭЛЗҮЙН БАЙДЛЫГ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДЫН ЗҮГЭЭС СУДАЛСАН НЬ	44
<i>Ц.Тэргэл, Г.Номин¹</i>	
<i>Санхүү Эдийн Засгийн Их Сургууль¹</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	46
<i>М.Арцунзаяа, Б.Оюунтөгс-Эрдэнэ, А.Мянганбаяр¹</i>	
ГЭРТ ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	48
<i>Т.Эрдэнэчимэг, Г.Билгүн¹</i>	
<i>¹Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГЭРИЙН АСРАМЖ ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	52
<i>Ч.Дэлгэрмаа¹</i>	
<i>¹Хөгжлийн туслалцаа НҮТББ</i>	
БАЙНГЫН АСАРГААТАЙ АХМАД НАСТНЫ ТЭТГЭВЭР, ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛД	55
<i>Б.Энхтуяа¹</i>	
<i>¹БГД 22-р хорооны иргэн</i>	
ХҮНИЙ ХӨГЖИЛ БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	57
<i>Д.Батзаяа¹</i>	
<i>¹“Элгэсэг оршихуй” ТББ</i>	
ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТӨД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ	59
<i>У.Бадамсүрэн¹</i>	
<i>¹Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 233 дугаар дамжааны суралцагч</i>	
ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ	62
<i>Дэд.проф. Г.Батцэнгэл¹</i>	
<i>¹МУБИС, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛСАН НЬ	65
<i>О.Жаргалсайхан¹, Б.Ундрахболор, Б.Пүрэвбаатар, Н.Лүндаренчин²</i>	
<i>¹МУБИС доктор (Ph.D), ²МУБИС-БоСС НААЗТ-ийн 4-р курс</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ	67
<i>С.Цэрэндулам, М.Мичидмаа, Ц.Уянга¹</i>	
<i>¹Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт</i>	

СЭРГЭЭН ЗАСАЛТ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, УР ЧАДВАР ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	70
<i>Н.Ундрал¹</i>	
<i>¹Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГ ХАНДЛАГА (БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	73
<i>Б.Басбаяр¹</i>	
<i>¹БШУЯ, Боловсролын Зээлийн Сан</i>	
ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ, ХУГАЦААГ БИЕЙН ҮЙЛДЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДСААР ҮНЭЛСЭН ДҮН	76
<i>П.Мөнхтулга¹, Т.Лхагвадорж², Д.Тэмүүжин, Ц.Гансүх, Д.Анхбаяр, Б.Пүрэвсүрэн, Н.Нармандах³</i>	
<i>¹Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга,</i>	
<i>²Нарийн бичгийн дарга, ³Магадлах эмч нар</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ	79
<i>Ц.Батцэцэг¹</i>	
<i>¹Чингэлтэй дүүрэг 39 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч</i>	
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИЖ, ДҮҮРЭГ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ	81
<i>Б.Балжинням¹</i>	
<i>¹БНД НДХ-ийн Магадлагч эмч, Эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагч, Ерөнхий мэргэжлийн хүний их эмч</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	84
<i>Б.Баатарбүргэд¹</i>	
<i>¹Экологийн цагдаагийн албаны жижүүрийн цагдаа</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА САНХҮҮГИЙН БАТАЛГАА	87
<i>З.Бадамцэцэг¹</i>	
<i>¹Цагдаагийн ерөнхий газрын Авто бааз</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	90
<i>Б.Энхцэцэг¹</i>	
<i>¹Хөвд аймаг 6 дугаар сургуулийн бага ангийн багш</i>	
БНСУ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЧИГЛЭСЭН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СЭРГЭЭН ЗАСЛЫН ТАЛААРХ БАРИМТЛАХ БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ СУДАЛГАА	93
<i>Ц.Энхтүвшин¹</i>	
<i>¹Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Нийгмийн ажлын тэнхим</i>	
ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ НАСАНД ХҮРСЭН ХҮНД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН	96
<i>Б.Саранзаяа¹</i>	
<i>¹МУБИС-БоСС-Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	99
<i>Л.Номин¹</i>	
<i>¹Төв аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны гүйцэтгэх захирал</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨВШИНГ ТОГТООХ НЬ	102
<i>Г.Гал-Эрдэнэ, А. Анар¹</i>	
<i>¹Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн оюутнууд</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИРОМЖТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	104
<i>Б.Мянганбаяр, Г.Саранээрэл¹</i>	
<i>¹ДХИС, Эрх зүй нийгмийн ухааны сургууль, 221-р дамжаа</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ	106
<i>Д.Отгонбаяр¹</i>	
<i>¹Их Засаг Олон Улсын их сургуулийн IV курсын оюутан</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	109
<i>Б.Анужин, Ц.Анужин, Б.Анударь¹</i>	
<i>¹Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн 2-р дамжааны суралцагчид</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	112
<i>Ж.Ууганчимэг¹, Т.Мөнх-Өлзий, Д.Мичидмаа²</i>	
<i>¹Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, ахлах багш, ²ДХИС,ЭЗНУС-ийн 221-р дамжааны оюутнууд</i>	
ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖУУД	114
<i>Т.Хонгорзул¹</i>	
<i>¹Хөдөлмөр Нийгмийн Харилцааны Дээд Сургууль</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ	116
<i>Б.Оюунгэрэл, Г.Лхагважав, О.Халиунаа</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	119
<i>Э.Шинэлундаа¹</i>	
<i>¹СЭЗИС-н Санхүү Удирдлагын Тэнхимийн 3-р курсын оюутан</i>	
СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БҮТЭЭМЖ	122
<i>О.Золзаяа¹, М.Анужин²</i>	
<i>¹ШУТИС, ГХС-ийн ХХШС-ийн багш, ²ШУТИС, ГХС-ийн ТТО-англи хэлний оюутан</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	126
<i>Ж.Ариунболд Ph.D, Б.Басбаяр, Д.Энх-Амгалан Ph.D¹</i>	
<i>¹Боловсролын зээлийн сан, denkhamgalan0608@gmail.com</i>	

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ (СҮҮЛИЙН 6 ЖИЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	129
<i>С.Дэлгэрмаа¹</i>	
<i>¹БШУЯ, Боловсролын зээлийн сангийн Боловсролын хөгжлийн хэлтсийн дарга</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ДИЗАЙНЫ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА	132
<i>С.Өлзиймаа¹</i>	
<i>¹ШУТИС Үйлдвэрлэлийн технологийн сургууль</i>	
БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛЧДАД ХАНДАХ СУРАЛЦАГЧДЫН ХАНДЛАГА	135
<i>Б.Халиун, Э.Төгсжаргал¹</i>	
<i>¹Хялганат ерөнхий боловсролын сургууль</i>	
ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЖ БҮЙ ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА	137
<i>Г.Халиун¹</i>	
<i>¹Боловсролын Хүрээлэн</i>	
СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	140
<i>Б.Бямбацогт¹</i>	
<i>¹5 дугаар ангийн Хүний их эмч, дэслэгч</i>	
ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭЖ БҮЙ ЗАРИМ ОРНЫ САЙН ТУРШЛАГА (АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД, БНПУ)	143
<i>Э.Нарантуяа¹</i>	
<i>¹МУБИС магистрант</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	146
<i>А.Буянзаяа, П.Номуунзаяа, Т.Мөнхцэцэг</i>	
ИХ ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БҮЙ ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ОЮУТНУУДЫН “БИЕ БЯЛДАР”-ЫН ХИЧЭЭЛИЙГ САЙЖРУУЛАХ НЬ	149
<i>Э.Хичээнгүй, Н.Сарандэлээр, М.Должинмаа, Ч.Наранчимэг¹</i>	
<i>¹Санхүү эдийн засгийн их сургууль</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ	151
<i>Э.Болдмандах¹</i>	
<i>¹Шуурхай удирдлагын албаны мэдээлэл шуурхай удирдлагын төвийн шуурхай удирдлагын хэлтэс /102-ийн мэдээлэл хүлээн авагч цагдаагийн ахмад</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ТЭГШ ХАМРАН СУРГАХ НЬ	154
<i>Б.Болормаа¹</i>	
<i>¹Хөвд аймгийн Булган сумын 2-р дунд сургуулийн дизайн технологийн багш</i>	
“САЙН САНАА- САЙХАН СЭТГЭЛ” ОЮУТНЫ НЭГДЛИЙН ОРОЛЦООТОЙГООР ХЭРЭГЖҮҮЛСЭН “ХҮН БҮРД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН” ТӨСЛИЙН ҮР ДҮН	157
<i>П.Дуламжав, С.Цэвэрэгээн, Э.Ариунцэцэг, Д.Оюунсүрэн, Б.Мэндхүү¹</i>	
<i>¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн багш нар</i>	
ОЮУТНУУДЫН ОРОЛЦООТОЙГООР ХЭРЭГЖҮҮЛСЭН “10 ОЮУТАН & 10 ХБХ” ТӨСЛИЙН ҮР ДҮН	160
<i>н.Оюунчимэг, Э.Ариунцэцэг, Д.Оюунсүрэн, Б.Мэндхүү¹</i>	
<i>¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн багш нар</i>	
МӨЛХӨЖ БАЙВЧ, МӨРӨӨДЛӨӨР ЖИГҮҮРЛЭСЭН АЛТАН ХАРААЦАЙ	162
<i>У.Уранчимэг¹</i>	
<i>¹Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОЛОВСРОЛ	165
<i>Ц.Өлзийбат¹</i>	
<i>¹Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын Дадал сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЗУРАХ ҮЙЛИЙГ ДЭМЖИХ НЬ	168
<i>Д.Жавзансүрэн, Ч.Ням-Очир¹</i>	
<i>¹Увс аймаг, Улаангом сум, Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв</i>	
ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ МЭРГЭШСЭН БАГШ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХ, ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА	171
<i>Д.Алтансүх¹</i>	
<i>¹Нийслэлийн ерөнхий боловсролын 29 сургууль</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	174
<i>Г.Алтанцэцэг¹</i>	
<i>¹НХЖХОНАБХА-ны Захиргааны удирдлагын газрын бичээч, цагдаагийн дэд ахлагч</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ, ХӨГЖИХ ТЭГШ БОЛОМЖ	177
<i>Ч.Одонтуяа¹</i>	
<i>¹Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг</i>	
ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН БИЕЙН БҮРДЛИЙН СУДАЛГАА (ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)	180
<i>Ш.Энхбүрэн¹, Ц.Ариунбаяр, Х.Дүүрэнжаргал²</i>	
<i>¹МУБИС-Биеийн тамирын сургууль, ²ХУД 63-р тусгай сургууль</i>	
СЗСҮТ-ИЙН МБУЧОС-ИЙН ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН АСУУДАЛ БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ХАНДЛАГЫГ СУДАЛСАН НЬ	183
<i>Н.Уянга¹, Л.Ариунаа²</i>	
<i>¹СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн багш, ²МУБИС-ийн ТХБТ-ийн 4 дүгээр курсийн оюутан</i>	

ХӨДӨЛМӨРИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ	186
<i>Э.Нандин-Эрдэнэ¹</i>	
<i>¹Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургууль</i>	
МУБИС-Д СУРАЛЦАЖ БУЙ СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	189
<i>Ж.Хулан, Б.Мөнхзаяа¹</i>	
<i>¹МУБИС-ийн ТХБТ-ийн 4 дүгээр курсийн оюутан</i>	
RELATIONSHIP BETWEEN EARLY CHILDHOOD EDUCATION AND EQUITY	192
<i>Х.Сансармаа¹, С.Сэлэнгэ², Г.Болормаа³</i>	
<i>¹Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ²Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, ³Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын холбоо</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭ /ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ЖИШЭЭН ДЭЭР/	196
<i>Н.Түмэндэмбэрэл¹, Ч.Мандалсайхан, Ж.Жаргал, О.Мөнхөө, Б.Даваасүрэн²</i>	
<i>¹АШУУИС, ²Говь-Алтай Анагаах Ухааны сургууль</i>	
АТФ ЛЮМИНОЭФФЕКТИВ АППАРАТААР ЭМНЭЛГИЙН КЛИНИКИЙН БОЛОН АХУЙН ГАДАРГУУН ХАЛДВАРГҮЙЖҮҮТЭЙ, ЦЭВЭРЛЭГЭЭГ ШАЛГАСАН ДҮН	199
<i>Б.Өнөрбилэг, О.Гантулга-Д.Өлзийбүрэн Н.Урангоо А.Од¹</i>	
<i>¹Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэргээн Засалт, Сургалт, Үйлдвэрлэлийн Төвийн Сэргээн Засах Төв эмнэлэг</i>	
ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	202
<i>Э.Баасанхүү¹ Д.Батлхам² Б.Мөнх-Эрдэнэ² Д.Сарангэрэл³</i>	
<i>¹АШУУИС-ийн Төв эмнэлэг, ²АШУУИС Сувилахуйн сургууль, ³АШУУИС Био анагаахын сургууль</i>	
ТАРХИНЫ ХАРВАЛТЫН ДАРААХ ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ, ХӨДӨЛМӨР ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	205
<i>Д.Өлзийбүрэн, Д.Энхзаяа, Д.Сарантуяа¹</i>	
<i>¹Сэргээн засах төв эмнэлэг</i>	
БУРУУ СУУХ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДВАРЫГ БУУРУУЛЖ БУЙГ СУДЛАХ НЬ	207
<i>М.Эрдэнэтуяа¹</i>	
<i>¹ХБХСЭХТ-ийн Хөдөлгөөн засалч</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭ ХООРОНДЫН ЧАДВАР БУУРАЛТАД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС	209
<i>Б.Элбэгдорж, М.Ариунболд¹</i>	
<i>¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв</i>	
ГУАЙН АРЫН БҮЛЭГ БУЛЧИНГИЙН ЧАНГАРЛАЙ ХҮҮХДҮҮДЭД АШИГЛАХ СУНГАЛТЫН АВТОМАТ АППАРАТЫН ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭЖ ЭМЧИЛГЭЭНД АШИГЛАСАН ҮР ДҮН	212
<i>Н.Цэсэнжав, А.Нямсүрэн, Д.Батлхам¹</i>	
<i>¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв</i>	
КАМЕР АШИГЛАН МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛИЙГ ХӨРВҮҮЛЭХ НЬ	216
<i>Ч.Намуун-Эрдэнэ¹, Ч.Отгонхүү²</i>	
<i>¹МУИС, ²ХШУИС</i>	
ДОХИО ХЭЛНИЙ ЦАГААН ТОЛГОЙН ҮСЭГ ТАНИХ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЗАГВАР	219
<i>Б.Луубаатар, Г.Мөнхжаргал, Г.Мөнх-Эрдэнэ, А.Отгонбаяр, Д.Нандин-Эрдэнэ¹</i>	
<i>¹Монгол улс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль</i>	
МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ	222
<i>Г.Чулуун-Эрдэнэ, Д.Насанханд¹</i>	
<i>¹МУБИС, НХУС, АХТ</i>	
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ СТАНДАРТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ	225
<i>П.Чулуунчимэг¹</i>	
<i>¹МУИС-Хууль зүйн сургуулийн V курсын оюутан</i>	
МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	227
<i>Б.Шинэцэцэг, Т.Бямбацэрэн¹</i>	
<i>¹Хараат бус судалгааны хүрээлэнгийн судлаач нар</i>	
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМД ОРОЛЦОХ ОРОЛЦОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ	230
<i>Н.Алтжин, А.Гарамням, Э.Номуундарь, Э.Энэрэл¹</i>	
<i>¹Санхүү Эдийн Засгийн Их Сургууль</i>	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ НЬ АМЖИЛТАД ХҮРЭХЭД СААД БОЛОХ ЁСГҮЙ	233
<i>Б.Энхболд¹</i>	
<i>¹Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч</i>	
ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДЭХ АРГА ЗАМ	236
<i>Б.Хулан¹, Б.Отгонбат²</i>	
<i>¹Дотоод хэргийн их сургуулийн багш, цагдаагийн ахлах дэслэгч, ²Цагдаагийн ажил эрх зүй 2 жил 3222-р дамжааны сонсогч</i>	
УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЖ БУЙ ҮР ДҮН (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)	238
<i>Э.Мөнхжин, Г.Цовоодаваа¹</i>	
<i>¹ШУТИС</i>	

ӨМНӨХ ҮГ



ХНХЯ-аас авч хэрэгжүүлж буй “Халамжаас хөдөлмөрт” арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг эерэгжүүлэх, ээлтэй ажлын байр, орчин, дэд бүтэц бий болгох зорилгоор “Бэрх Биш Ээлтэй” аяныг өрнүүлж, хөгжлийн бэрхшээл судлал салбар дундын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээний хурлыг энэ удаад “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт-2021” сэдвийн дор 2013 оноос өнөөдрийг хүртэл 9 дэх удаагаа зохион байгуулж байна.

Хуралд Цагдаагийн ерөнхий газар, БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, Боловсролын зээлийн сан, Насан туршийн боловсролын үндэсний төв, ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, их дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагуудын хууль эрх зүй, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн чиглэлээрх нийт 88 илтгэл ирүүлснээс үзэхэд хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгаа, шинжилгээний ажил маань улам өргөжиж, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэхэд чухал байр суурь эзэлж байгааг илэрхийлэхэд таатай байна. Хөгжлийн бэрхшээлийн салбарт орж ирж буй судлаач бүхний оролцоог дэмжих, хичээл зүтгэлийг үнэлсэн учраас энэхүү эмхтгэлд шинжлэх ухаанч болон сонирхогчийн төвшинд харилцан адилгүй илтгэлүүдийн хураангуй орсон байгааг та бүхэн хүлээн авч хүндэтгэн үзээрэй.

Тус эрдэм шинжилгээний онол, практикийн хурлыг зохион байгуулахад дэмжиж ажилласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон салбарын хамт олон, хамтран ажиллаж үнэтэй санал зөвлөмж өгсөн шүүгчдийн бүрэлдэхүүн, илтгэл ирүүлсэн байгууллагуудын удирдлага, менежерүүд, ажилтан, эрдэмтэн багш, судлаач, оюутнууддаа талархал илэрхийлж, эрдэм судлалын ажилд нь амжилт хүсье.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э. ТАМИР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛД

Зочин илтгэгч: М.Нарантуяа (PhD), дэд профессор

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн аливаа бодлогын цоорхой нь шинжлэх ухааны холбогдох мэдлэг дутмаг байгаатай холбоотой ба тухалбайл, ямар бэрхшээлийг даван туулахад хамгийн үр ашигтай ямар стратеги, тактикууд хэрэглэгдэх нь тодорхойгүй асуудлууд байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь зөрчигдөж, гадуурхалд өргөн хүрээнд өртөж байгаа нь тодорхой боловч тэдний сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, “эмзэг” бүлгүүдэд тулгардаг нийгэм-сэтгэл зүйн, нийгэм-эдийн засгийн, нийгэм-улс төрийн тэгш бус байдлыг бууруулахад нэн чухал хэрэгсэл бол судалгаа гэдгийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага [2008], Дэлхийн банк [2011]–ны тайлангуудад тэмдэглэсэн байдаг. Энэхүү баримтын шинжилгээг манай боловсролын салбарт хийгдэж байгаа эрдэм шинжилгээ, судалгаанд хөгжлийн бэрхшээл судлал (БХС) нь ямар байр суурьтай байгааг зарим нэг тоо баримтад үндэслэн дүгнэх зорилготой. Судалгааны үр дүнгээс үзэхэд, манай орны хувьд ХБС нь хөгжлийнхөө эхэн үе шатанд байгаа ба гадаадын туршлагаас ихээхэн суралцах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Үүнтэй холбоотойгоор судалгааны байгууллагуудын чиг үүрэгт тусгах, энэ чиглэлээрх судалгаа-бизнесийн хамтарсан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, хөгжлийн бэрхшээл судалгаа хөгжлийн дагнасан сэтгүүлийг гаргаж, олон нийтийн мэдлэг, чадвар, хандлагад өөрчлөлт гаргахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл судлал, судалгаа, арга зүй, үр дүн, судалгааны байгууллага

Асуудлын тулгамдсан байдал, дэлхий нийтийн чиг хандлага

Хөгжлийн бэрхшээл судлал нь хөгжлийн бэрхшээлийн мөн чанар, хүний амьдрал, үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө, үр дагаврыг судалдаг шинжлэх ухааны салбар юм. Хөгжлийнхөө эхэнд “хэвийн бус хөгжил” ба “хөгжлийн бэрхшээл” гэсэн ойлголт, хандлагын ялгаатай байдлыг олон талаар судалж байсан бөгөөд “хэвийн бус хөгжил” нь хувь хүний оюун ухаан, бие махбод, эрхтэн тогтолцооны эмгэг өөрчлөлт, харин хөгжлийн бэрхшээл нь нийгмийн мөн чанартай болох дээр эрдэмтэд нэгдэж, судалгаа хөгжлийг чиглүүлж байна [*“Session Details: Avenues of Access: The State of Disability Studies”*. *Modern Language Association. Modern Language Association. Retrieved 3 March 2021*]. 1999 онд нийгмийн загварыг тэргүүлэх загвар гэж нийтээр хүлээн зөвшөөрсөн [*Bickenbach, Jerome E; Chatterji, Somnath; Badley, E.M.; Üstün, T.B. (1999). “Models of disablement, universalism and the international classification of impairments, disabilities and handicaps”. Social Science &*

Medicine. 48 (9): 1173–1187] ба хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын судалгаанд ихээхэн анхаарал хандуулж байна [**“*what is disability studies?*”**. **Society for Disability Studies. Archived from *the original* on 2 April 2015. Retrieved 26 March 2015**]. Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлийг нийгэм, соёл, эдийн засаг, материаллаг, түүхэн ба/эсвэл улс төрийн үзэгдэл талаас нь судалж, асуудлыг шийдвэрлэж байгаа хандлага, туршлага өргөжсөөр байна (**Ferguson, P. M., & Nusbaum, E. (2012). *Disability Studies: What Is It and What Difference Does It Make? Journal of Research & Practice with Persons with Severe Disabilities, 37, pp.70-80.***). Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг дарамталж, гадуурхаж буй багш нарыг илрүүлэх биш харин багш нарт өөрсдийн зан байдлаа, үйлдлээ өөрчлөх боломж олгоход судалгаа чухал үүрэгтэй (**Christine Ashby, *Disability Studies and Inclusive Teacher Preparation: A Socially Just Path for Teacher Education, journal of Research & Practice for Persons with Severe Disabilities, 2012, Vol. 37, No. 2, 89-99*** .

Судлаачдын үзэж байгаар хөгжлийн бэрхшээлийн судалгааг доорх чиглэлээр хийж олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлого, хөтөлбөрүүдийг мэдээлэх, нөөцийг үр ашигтай хуваарилахад зайлшгүй чухал юм. Үүнд:

- хөгжлийн бэрхшээлд хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн (бодлого, байшин барилга зэрэг материаллаг орчин, нийгмийн хандлага) үзүүлэх нөлөө, хэрэгжих механизмууд, түүнийг хэрхэн хэмжээжүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, сэтгэл зүйн сайн сайхан байдал;
- хүн амд чиглэсэн нийтлэг болон тусгай үйлчилгээг хүртэхэд учирч буй саад бэрхшээл, тэдгээрийг зохицуулах бусад арга замуудыг илрүүлэх;
- хүрээлэн буй орчны хүчин зүйлс, хөгжлийн бэрхшээл ба ядуурлын хоорондын харилцан үйлчлэл;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн хүртээмжтэй байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, судалгаа хөгжилд зарцуулсан хөрөнгө, төсвийн үр ашгийн судалгаа;

Олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээлэл цуглуулах соёл дундын, тодорхой соёлын хүчин зүйлээс ангид арга зүйг боловсруулж, туршин тууштай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүнтэй холбоотойгоор ДЭМБ-аас “хөгжлийн бэрхшээл судлалаар хийгдэж байгаа томоохон суурь судалгаанууд нь өндөр хөгжилтэй улс орнуудад, англиар ярьдаг улс орнуудад хийгдэж байгааг шүүмжилсэн” байдаг (**World Health Organization, 2008, World Health Organization, 2011, Marmot and on behalf of the Commission on Social Determinants of Health, 2007**). Үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээл судалгаа нь хөгжлийн бэрхшээлийн тархалтыг хүн ам зүйн үзүүлэлтээр нарийн, бүрэн гаргаад зогсохгүй, нөхөн сэргээх үйлчилгээ болон нийгмийн хүртээмжтэй, чанартай үйлчилгээний үр дүнгийн мониторингийн шалгуур үзүүлэлтүүд, нийгэм-эдийн засгийн

бодлогын хэрэгжилтийг харуулах бүх үзүүлэлтээр хийгдэж буй судалгаанд хамруулах нь чухал юм.

Шинжлэх ухааны байгууллагууд нь нийгмийн хөгжлийн аливаа судалгаа шинжилгээний үр шимийг хүртэгчдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргаа, оролцоо, чадавхи, сайн сайханд хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа тасралтгүй, чанартай, үр дүнтэй хийгдэж байгаад анхаарал хандуулж, судалгаа хөгжлийг дэмжих хэрэгтэй. Манай улсад хөгжлийн бэрхшээл судалгаа, эрдэм шинжилгээний ажлын нөхцөл байдал ямар байгааг үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлуудаар хэлэлцэж буй асуудалд хөгжлийн бэрхшээлийн асуудлууд ямар хэмжээнд хэлэлцэгдэж байгааг судалж үзэхэд дараах үр дүн гарч байна. Энэхүү өгөгдөл нь баримтын шинжилгээний аргаар гаргасан тоо ба тойм байдлаар дүгнэх зорилготой.

Баримтын шинжилгээний хүрээ, үр дүн

Судалгаа хөгжлийн гол үзүүлэлтүүдэд тухайн судалгааны чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байдал, мэргэжлийн тэнхимийн хүрээнд хамгаалсан бакалавр, магистрын ажлын тоо, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэгдсэн болон судалгааны институцүүдээс эрхлэн гаргадаг сэтгүүлд нийтлэгдсэн нийт илтгэлд эзлэх байр суурь зэргийг авч үздэг. Судалгааны хүрээнд 2002-2020 онуудад хөгжлийн бэрхшээлийн онол, арга зүйгээр бичигдэж, хамгаалагдсан 7н диссертац нь хөгжлийн бэрхшээлийгүүсгэж байгаа эмгэгийн нөхцөлдүүлж буй зан байдал, тэдгээрийн үнэлгээний аргачлал, эрт илрүүлэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа зэрэг асуудалд чиглэсэн байна. 2011-2020 онуудад үндэсний хэмжээнд цуврал \7-9 жил дараалан\ байдлаар зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний 3 хурлын хүрээнд хэлэлцэгдсэн нийт 800 орчим илтгэлийн 0.01% орчмыг эзэлж байна. Эдгээр илтгэлүүдийн 33% нь тэгш хамран сургах бодлогын хэрэгжилттэй холбоотой ба бусад нь тодорхой эмгэгтэй хүүхдийн хөгжлийн онцлогийг судалсан байна. Дээд боловсролын хүрээнд хэрэгжсэн төслийн зарим мэдээлэл нийтлэгдсэн байх боловч боловсролын чанар, хүртээмж, үр дүнгийн талаарх судалгаа ховор байна. Боловсролын хүрээлэнгээс эрхлэн жилд 8-10 дугаар гаргадаг сэтгүүлд ХБС-аар нийтлэгдсэн илтгэлд 0.01% орчим, МУИС-ийн Боловсрол сэтгэл судлалын тэнхимээс жилд 1 удаа эрхлэн гаргадаг Боловсрол судлал сэтгүүлийн 2011-2021 дугааруудад нийтлэгдсэн нийт өгүүллийн 0.014% нь хөгжлийн бэрхшээл судлалын асуудлыг хөндсөн байх юм. Монгол улсад тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн тэнхим МУБИС-ын Боловсрол судлалын сургуулийн дэргэд 2017 онд байгуулагдсан ба 2020 онд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж баталгаажуулсан байна. Дээрхээс үзэхэд, хөгжлийн бэрхшээл судлал нь манай оронд эхлэлийн төдий байна гэж дүгнэж болно.

Монгол улсад Хөгжлийн Бэрхшээл Судлалаар дагнасан эрдэм шинжилгээний хурлыг ХНХЯ-аас санаачилсан ба одоогоор нийт 270 илтгэл

хэлэлцүүлснээс 27.1% боловсрол, 23.7% эрүүл мэнд, 11.1% хөдөлмөр эрхлэлт, 12.2% хүний эрх, 8.1% хүртээмж, 17.8% нийгмийн халамжийн байдлын судалгаанууд хэлэлцэгдээд байна. Хэдийгээр хэлэлцүүлж байгаа судалгааны тоо жилээс жилд нэмэгдэж байгаа ч, боловсрол эрүүл мэндийн асуудлууд дийлэнхи талыг эзэлж, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний хүртээмж зэрэг тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг харуулах судалгаа хамгийн бага буюу тус тус 11.1% ба 8.1% байна.

Гадаадын сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийн тоог биш харин бодлогын нөлөөллийн судалгаануудыг “disability and social sustainability” гэсэн түлхүүр үгээр судалсан олон улсын судалгааг олж үзлээ. Үр дүнг сонирхож үзвэл,

Scopus, Web of Science, JSTOR зэрэг өндөр зэрэглэлийн шаардлагад нийцсэн судалгаанаас хийсэн хайлтын үр дүнг танилцуулсан байдлаас үзэхэд, хөгжлийн бэрхшээл судлалтай холбоотой төдийлөн олон байгаагүй ба Gregor Wolbring&heresa Rybchinski нар хөгжлийн бэрхшээл судлалын нийгмийн үр нөлөөний талаарх өгүүллийн хайлт хийсэн. Тэд “хөгжлийн тогтворжилт”, “хэрэгжилтийн тогтвортой механизмууд” зэрэг түлхүүр үг ашиглан хайж үзэхэд [Social Sustainability and Its Indicators through a Disability Studies and an Ability Studies Lens by Gregor Wolbring&heresa Rybchinski, Sustainability 2013, 5, 4889-4907] доорх үр дүн гарсан. Нийт хөгжлийн бэрхшээл судлалын нийгмийн үр нөлөөг судалсан судалгаа нь EBSCO –оос 8804 өгүүлэл болон 1920 хураангуй, SCOPUS-оос 748 өгүүлэл, 2307 абстракт, Web of Science –аас 424 өгүүлэл, JSTOR-оос 514 өгүүлэл нийтлэгдсэнийг тогтоожээ.

Table 1. Frequency analysis of four databases and various terms relating to “disability” combined with the term “social sustainability”.

Search Terms	EBSCO All all text/abstract	Scopus abstract/ all fields	Web of Science Whole topic	JSTOR full text
“Social sustainability”	8804/1920	748/2307	424	514
“Social sustainability” +disab* (full text search)	763/24	10/58	1	12
Disability and social sustainability	535/15	7/47	1	17
Disabled and social sustainability	324/11	4/21	0	19
Disabilities and social sustainability	534/15	7/47	1	12
“Social Sustainability” and “Social determinants of health”	11/0	3/12	0	0

Анхаарал татсан эх сурвалж бол 2015 оны ДЭМБ-аас гаргасан хөгжлийн бэрхшээл судлалын тайлан ба хөгжлийн бэрхшээл дотроос хамгийн анхаарал татаж байгаа нь оюуны бэрхшээлтэй, аутизмтай иргэдийн нийгэмшил, оролцоо гэжээ[**Setting global research priorities for developmental disabilities, including intellectual disabilities and autism by Mark Tomlinson, M. Taghi Yasamy, Eric Emerson, Alana Officer, Diane Richler, Shekhar Saxena. Journal of Intellect Disability, 2014 December ; 58(12): 1121–1130.** Юуны өмнө, оюуны бэрхшээлтэй болоод аутизмтай

иргэдийн нийгмийн дасан зохицоо, бие даан хөдөлмөр эрхлэх, амьдралаас сэтгэл ханамж авах асуудал хамгийн эрсдэлтэй байдалд байгааг дурдсан. Үүнд: (1) эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол дахь ялгаварлан гадуурхалт, (2) нэр төрд нь халдах, үл тоох, тохуурхах; (3) бие даасан байдлыг үгүйсгэх (жишээлбэл, албадан ариутгалд өртөх гэх мэт) зэргийн улмаас хууль эрх зүйн тэгш бус байдал үүссэн (**Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ба Дэлхийн банк, 2011**). Хоёрдугаарт, эдгээр хүмүүсийг албадан эмчилгээнд хамруулах, албадан үр хөндүүлэх зэргээр эрүүл мэндийн хандлагад суурилсан хандлагад нийгмийн оролцоо, хамтын ажиллагаанаас илүү анхаарлаа хандуулж байгаатай холбоотой (**Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2008, 2011**). Энэ хүрээнд өсөн нэмэгдэж буй олон тооны нотлох баримтууд нь “тэдний хожим насанд нь эрүүл мэндийн ноцтой хохирол, тэгш бус байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг ба эдгээр иргэдийг бага наснаас нь нийгэмшүүлэх, оролцоонд сургахын чухал болохыг онцолж байна (**Irwin et al., 2007, Shonkoff, 2010, Walker et al., 2011**). Эдгээр чиг хандлагыг нэгтгэн авч үзвэл, ID болон/эсвэл аутизмтай хүмүүсийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг ойлгож, шийдвэрлэхийн тулд нийгмийн эрүүл мэндийн өргөн хүрээтэй судалгааг хэрэгжүүлэхийн чухлыг онцолж байв; Сонирхолтой нь, эрүүл мэндийн тогтолцооны судалгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн судалгаанд тэргүүлэх ач холбогдол өгөх ба нийгмийн хөгжлийн, нийгмийн сайн сайханы хүчин зүйлийн асуудлаарх судалгаа хангалтгүй байсаар байна гэжээ (**Yasamy et al., 2011**).

Дүгнэлт

Баримтын шинжилгээнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн судалгаа хөгжлийн тэдний нийгмийн оролцоо, бие даах чадвар, ажил хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах шалгуур үзүүлэлттэй холбоотой ихэнх зорилтууд нь хойш тавигдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах талаас авч үзсэн ажлууд давамгайлж байгаагаас дүгнэж болохоор байна.

Манай орны хувьд хөгжлийн бэрхшээл судлалын эхлэл тавигдсан ба ХНХЯ-ны зүгээс энэ чиглэлээр тэргүүлж, санаачлагатай ажиллаж, судлаачдыг өргөн оролцуулах, тодорхой асуудлаар нийгмийн анхаарлыг хандуулж, мэргэжлийн судлаачдын хүрээнд өргөн хэлэлцүүлгүүдийг хийж байна. Шинжлэх ухаан, сургалтын байгууллагуудын хүрээнд нийгмийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суурь, мэргэжлийн боловсролын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой зорилго дэвшүүлж, үр дүнд хүрэх шаардлагатай байна. Үүнийг эрүүл, мэнд боловсролын салбарт зохион байгуулагдаж байгаа эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлж буй илтгэлүүдийн тоо (нийт хэлэлцэгдсэн илтгэлд эзлэх хувь $=0.001\%$), оролцооны хангалтгүй байдлаас дүгнэж болохоор байна.

Монгол улсад ХБС-аар дагнасан эрдэм шинжилгээний хурлыг ХНХЯ-аас санаачлан хэрэгжүүлж байгааг дурдах хэрэгтэй ба хэлэлцүүлж байгаа судалгааны тоо жилээс жилд нэмэгдэж байгаа, мөн чанарын үр дүнг

харуулахуйц үзүүлэлтүүд болох хөдөлмөр эрхлэлт, хүртээмжийн асуудлаар судалгаанууд хэлэлцэгдсэн байна.

Олонулсын судалгаанаас үзэхэд, хөгжлийн бэрхшээл судлал харьцангуй өндөр төвшинд хүрсэн нь тэдний тогтвортой амьжиргаа, хөгжлийн шалгуурт суурилсан судалгаа хөгжил эрчимтэй хийгдэж байгааг харж болно. Үүнийг, 2017 оны судалгаагаар тогтоогдсон доорх зарим үр дүн харуулж байна: нийт хөгжлийн бэрхшээл судлалын нийгмийн үр нөлөөг судалсан судалгаа нь EBSCO –оос 8804 өгүүлэл болон 1920 хураангуй, SCOPUS-оос 748 өгүүлэл, 2307 абстракт, Web of Science –аас 424 өгүүлэл, JSTOR-оос 514 өгүүлэл нийтлэгдсэнийг нь дурдаж болно. Олон улсын хэмжээнд хийгдэж байгаа Хөгжлийн бэрхшээл судалгааны тулгамдаж байгаа асуудалд оюуны бэрхшээлтэй болон аутизмтай иргэдийн ажил, амьдралын сайн сайхан ноцтой зөрчигдөж, ямар нэг ахиц өөрчлөлт муу байгааг дүгнэсэн нь анхаарал татаж байна.

Зөвлөмж

Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээл судлалын нийгмийн үр нөлөөг хэрхэн үнэлж, дүгнэх талаар доорх зөвлөмжийг өгч байна. Юуны өмнө 1. Одоо хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүд, судалганд шинжилгээ хийж дүгнэх, 2. Хөгжлийн бэрхшээл судлалын зөвлөлийн одоогийн стратеги, төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, дүгнэх шаардлагатай ба үүн дээр үндэслэн А. Зөвлөлийн хамтран ажиллаж байгаа нэгж, байгууллагуудтай зөвлөлдөх уулзалтуудыг төлөвлөх, Б. Одоогоор хэрэглэгдэж байгаа судалгааа хөгжлийн статистик өгөгдлүүдийг дахиж сайжруулах шаардлагатай юм. Дараагийн шатанд 1, Онлайн хэлэлцүүлгийг зохион байгуулах, Олон нийтийн \ хороо\ хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай ба 2, Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг тогтмолжуулах, Бичгээр санал, гомдол, зөвлөмж хүлээж авах хайрцаг ажиллуулна. Ахиц өөрчлөлтийг үнэлж дүгнэхдээ, 1, Судалгааны үр дүнг нэгтгэх тайлагнах, 2, Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэх. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, хорооны иргэдээс санал авах, сайжруулах, эцэслэх нь чухал юм.

Ашигласан материал:

Дотоодын судалгаанууд. Диссертацууд:

1. Д.Одгэрэл. Монгол дахь тусгай сургуулийн суралцагчдын оюуны хөгжлийн үнэлгээ, 2002;
2. Д.Баттуяа. Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийн судалгаа: 4-7 настай хүүхдийн жишээн дээр, 2003;
3. Г.Батцэнгэл. Тусгай сургуулийн бага ангийн сурагчдын авиа дуудлагын онцлог, 2006;
4. Б.Эрдэнэ-Очир. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын хэл ярианы хөгжлийн бэрхшээлийг засах боломжийг судалсан нь, 2006.
5. Б.Нарантуяа. Улаанбаатар хотын зургаа хүртэлх насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлсэн дүн, 2018;

Өгүүлүүд:

1. Ч.Жаргал, Ерөнхий Боловсролын Сургуулийн Хүртээмжтэй Орчны Өөрийн Үнэлгээнд Шинжилгээ Хийх нь. Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга ,УБ.,2021. х.213
2. Б.Золзаяа Тэгш Хамруулан Сургах Боловсролыг Хэрэгжүүлэх Явцад Багшид Тулгарч Буй Асуудлыг Судалсан нь.Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга ,УБ.,2021хх.195-202
3. Ч.Даариймаа, Н.Чулуунбанди. Хөгжлийн Бэрхшээлтэй Оюутнуудад Цахим Сургалтаар Дамжуулан Суралцах Боломжийг Нэмэгдүүлэх Асуудалд. Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга ,УБ.,2021. хх.98-105.
4. П.Алтанзул” Тэгш хамруулан сургах үзэл санааг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар хийсэн судалгаа, дэвшүүлж буй шийдэл, арга зам. Боловсрол судлал. БХ.,2021,№4, хх.49-56
5. Д.Энхтуяа, Т.Шинэцэцэг. Тусгай хэрэгцээт боловсролын багшид тулгамдаж буй зарим асуудал. Боловсрол судлал. БХ.,2021.№5, хх 3-10

Ашигласан гадаадын судалгааны жагсаалт:

1. Measuring, Demonstrating and Communicating Social Impact in the disability services market. National Disability Services, NSW, 19 August 2014
2. Monitoring and evaluation framework to track and assess the results of interventions aimed at changing attitudes and social norms towards children with disabilities in Europe and Central Asia. © United Nations Children’s Fund (UNICEF), 2019.
3. Social Sustainability and Its Indicators through a Disability Studies and an Ability Studies Lens. Gregor Wolbring 1,Theresa Rybchinski. Sustainability 2013, 5, 4889-4907;
4. Social Impact Assessment: Integrating social issues in development projects. Inter-American Development Bank- series on environmental and social risk and opportunity. Copyright © 2018
5. Disability Studies and Inclusive Teacher Preparation: A Socially Just Path for Teacher Education. Christine Ashby. “Research & Practice for Persons with Severe Disabilities” 2012, Vol. 37, No. 2, 89-99
6. Setting global research priorities for developmental disabilities, including intellectual disabilities and autism. Mark Tomlinson,M. Taghi Yasamy,Eric Emerson,Alana Officer,Diane Richler, Shekhar Saxena. J Intellect Disabil Res. 2014 December ; 58(12): 1121–1130.



I БҮЛЭГ
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ ХАНДЛАГЫГ СУДЛАХ НЬ

Г.Уянга¹

*¹ АЗДТГ-ын НБХ-ийн хүн амзүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр
эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн*

Үндэслэл

Дэлхийн 7 тэрбум хүний дотор төрөлхийн болон олдмол байдлаар бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой болсон бөгөөд энэ байдал нь орчны саадтай нийлснээр нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцож чадахгүй байгаа 1 тэрбум хүн амьдарч байна. Энэ нь дэлхийн нийт хүн амын 15 хувьтай тэнцэж байгаа бол манай улсын хувьд 2020 оны жилийн эцсийн байдлаар 108.399 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Энэ нь нийт хүн амын 3.2 хувийг эзэлж байгаа хэдий ч энэ тоо жил ирэх тусам байнгын өсөх хандлагатай байгаа билээ. Статистикийн тоо баримт бүхий мэдээлэл нь тухайн сегментийн хувьд ямар асуудал бэрхшээл байгааг олж харах анализ, дүгнэлт хийж асуудлыг шийдэхийн тулд гаргаж буй хууль тогтоомж, бодлого шийдвэрт хамгийн чухал ач холбогдол бүхий нөлөөлөгч хүчин зүйл юм. Тиймээс “Монгол улсад 108 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг юм байна” гээд хараад өнгөрөх биш, аливаа төрлийн осол гэмтлээс үүдэн “олдмол” байдлаар болон жирэмсэн эхийн амьдралын буруу зан үйл, удамшлын хүчин зүйлээс шалтгаалан “төрөлхийн” хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа эдгээр хүмүүсийн тоон мэдээллээс үндэслэн сэргийлж болох хүчин зүйлсийг тодруулан энэ байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь төрийн бодлого үйл ажиллагаа, иргэдийн хариуцлагатай байдалтай шууд холбоотой. Нөгөө талаас нэгэнт хөгжлийн бэрхшээлтэй төрсөн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн хувьд ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхалд өртөлгүйгээр бусадтай адил нийгмийн амьдралд оролцож бие даан амьдрахад нь шаардлагатай боломж нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хууль эрх зүй, дэд бүтэц, нийгмийн харилцаа хандлага гээд олон зүйлийг өөрчилж, шинэчлэх, засаж залруулах нь зүйтэй байна.

Зорилго

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал дэвшүүлэх

Материал ба арга зүй

Судалгааны объект – “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомж. Судалгааны арга арга зүйн хувьд баримт материал шинжлэн дүгнэх, харьцуулалтын арга зэргийг ашиглан дүн шинжилгээ хийнэ.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцын хувьд 2006 онд НҮБ-ийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенц”, 2011 онд “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан”, 2012 онд Ази номхон далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” Инчоны стратеги г.м. Харин Монгол улсын хувьд

- 2009 онд соёрхон баталсан НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” конвенц,
- 2016 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль зэрэг байна.

Түүнчлэн холбогдох бусад 100-аад хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зүйл заалтууд тусгайлан орсон байдаг. Мөн 2017 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” зэргийг батлан хэрэгжүүлж байна. 2006 оны хуульд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамж, хамгааллын асуудлыг голчлон тусгасан байсан бол 2016 оны хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох нийгмийн харилцаанд бусдын адил тэгш эрхтэй оролцох боломжийг хангах зохицуулалтыг тусгаж өгсөн. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн тэргүүн тулгамдаж байгаа нийтийн тээвэр, зам, орон сууц, тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зэрэг олон асуудлуудыг тусгасан.

Тус хууль хэрэгжиж эхэлснээс 4 жилийн дараа хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, талууд нэгдмэл ойлголтод хүрээгүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавх сул, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Түүнчлэн хуулийн зохицуулалтын давхардал 24.4 хувь, зөрчил 35.5 хувь, хийдэл 13.3 хувь байгаа тул хууль хоорондын нийцлийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа ажээ. Миний хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дараах хууль, эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгагдсан байдаг талаар голчлон судалж танилцлаа. Харин 2022 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх “Хөдөлмөрийн тухай” хуулийн 144.1-д “Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй”, 144.6-д “Ажил олгогч энэ хуулийн 144.1-д заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглоно” гэсэн 2 заалт тус тус оржээ. Дээрх 2 хуулийн аль алинд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын

байрны үндсэн шаардлагын талаар тодорхой дурдсан зүйл алга байна. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоог хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам:** Салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр орон нутагт гол үүрэг гүйцэтгэгч субъект болох "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоог хангах орон тооны бус зөвлөл"-ийн үйл ажиллагаа төдийлөн хангалттай хэрэгжихгүй байна. Ялангуяа зөвлөлийн бүрэлдэхүүний хариуцлага болон төсөв санхүүгийн асуудлаас шалтгаалан зөвлөлийн үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй байна.

Дүгнэлт

2016 онд батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрийг хангах чиглэлээр тулгамддаг олон асуудлуудыг шийдэж өгсөн хууль боловч зарим асуудлыг бусад холбогдох хуулиар зохицуулах байдлаар хуульчилсан байтал тухайн хуульд нь мөн л тодорхой бус байдлаар оруулж асуудлыг орхигдуулсан тохиолдол байна. Мөн миний хувьд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулийн заалтыг голчлон судалсан боловч хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай асуудлын урьдач нөхцөл болох сурч боловсрох эрхийн асуудлыг тусгайлан судлах шаардлагатайг олж харсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн талаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуульд тусгайлсан бүлэг заалт байгаа боловч практик дээр харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн бусадтай адил сурч боловсрох, мэргэжил эзэмших асуудал өнөөдрийг хүртэл бүрэн дүүрэн шийдэгдэж чадаагүй бөгөөд боловсролын үйлчилгээнд хамрагдалтын тоо ч хангалттай биш байна. Тухайлбал манай аймагт Хөгжлийн бэрхшээлтэй 253 хүүхэд байгаагаас 139 нь сургууль, цэцэрлэгт хамрагдаж байна гэсэн тоо байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт өндөр байгаа мэт харагдаж байгаа хэдий ч эндээс бас нэг асуудал урган гардаг. Юу гэвэл дээрх тоо бол зөвхөн боловсролын байгууллагаас гаргасан тоо бөгөөд энэхүү тоо нь бодитой бус байдаг тохиолдол олон байна. Учир нь сургууль, цэцэрлэгийн багш нь ямар хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцох нь харилцан адилгүй байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох болон бүртгэл мэдээлэлд оруулах асуудлыг илүү нарийн тогтоож нэг ойлголттой болох шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Сурч боловсрох эрх, Тохирох хэрэглэгдэхүүн, Бие даан амьдрах эрх*

Ашигласан материал:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хууль УБ., 2016
2. "Хөдөлмөрийн тухай" хууль УБ., 1999
3. "Хөдөлмөрийн тухай" хуулийн шинэчилсэн найруулга УБ., 2021
4. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль УБ., 2011
5. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоог хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам" УБ., 2016

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫГ СУДАЛСАН НЬ /Говь-Алтай аймгийн жишээн дээр/

Д.Оюунчимэг¹, Э.Элбэрэлт¹, Г.Ганширмэн²

¹ Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг

² АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар АУС
Dash_oyunchimeg@yahoo.com

Үндэслэл

Дэлхий дахинд нийт 1 тэрбум буюу дэлхийн хүн амын 15 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзлэж байна. Монгол улсад 12476 /эрэгтэй -7411, эмэгтэй-5065/ хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 7 мянга гаруй нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг боловч огт боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа 2900 хүүхдүүд байна. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн дэмжлэг боловсролын үйлчилгээ авах боломжийг судлах зорилгоор Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн диспансерийн бүртгэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн хэрэг, шийдвэрийн бүртгэл, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02-р сарын 23-ны өдрийн дугаар А/69/48 үнэлэх шалгуур үзүүлэлтийг ашиглан ретроспектив загвараар, дескрептив судалгааны аргаар судалгааг хийж явуулсан. Сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 29.6% нь гэртээ байдаг буюу суурь боловсролд хамрагдаагүй. Эм хэрэглэдэг хүүхдүүдийн 73.7% нь уналт таталтын эсрэг эм тогтмол хэрэглэдэг. Оношийн хувьд авч үзвэл мэдрэлийн эмгэг 31.3%, сэтгэцийн эмгэг 14,5 хувьтай байна. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийг хархад төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эзлэх хувь 54.4% байсан бөгөөд бид цаашид жирэмсний хугацаа, төрөлт, төрсний дараах үеийн хяналтыг сайжруулж эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгийг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад чанартай зөв хийх шаардлагатай байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн дэмжлэг боловсролын үйлчилгээ авах боломжийг судлах

Материал арга зүй

Бид судалгаагаа Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн нэг, хоёрдугаар хүүхдийн кабинетын диспансерийн бүртгэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн хэрэг, шийдвэрийн бүртгэл, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02-р сарын 23-ны өдрийн дугаар А/69/48 үнэлэх шалгуур үзүүлэлтийг ашиглан 2003-2020 оны 263 хүүхдийн мэдээллийг цуглуулан ретроспектив загвараар, дескрептив судалгааны аргаар судалгааг хийж явууллаа. Судалгааны мэдээ материалыг Exsell Microsoft-т түүвэрлэж, статистик боловсруулалтыг SPSS 21 программыг ашиглан гүйцэтгэв.

Үр дүн

Хүйсийн хувьд 62.6% эрэгтэй байна. Сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 29.6% нь гэртээ байдаг буюу суурь боловсролд хамрагдаагүй. Эм хэрэглэдэг хүүхдүүдийн 73.7% нь уналт таталтын эсрэг эм тогтмол хэрэглэж байна. Оношийн хувьд авч үзвэл мэдрэлийн эмгэг 31.3%, сэтгэцийн эмгэг 14,5 хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 54.4% төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

График 1.




График 2. Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны оноог харьцуулсан дүн

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийг хархад төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эзлэх хувь 54.4% байсан бөгөөд бид цаашид жирэмсний хугацаа, төрөлт, төрсний дараах үеийн хяналтыг сайжруулж эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгийг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад чанартай зөв хийх шаардлагатай байна. Цаашид уналтын эсрэг эмийн төвшинг лабораторийн орчинд цусанд тодорхойлох шаардлагатай байна. Мэдрэл, сэтгэцийн эмгэгийн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэжлийн эмч нарын тоо болон мэдрэлийн эмгэгээр төрөлжүүлэн мэргэжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээл, хүүхэд, уналт таталт***Ашигласан материал:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. 2016.
2. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1990.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн IV конгресс
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага. УБ. 2019. х. 47-602.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйлажиллагааны талаарх мэдээллийн лавлах “Цагаан ном”
6. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр. 2019.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨСӨӨЛӨЛ

Д.Мөнх-Эрдэнэ¹

¹ Цагдаагийн ахлагч

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хэрэгцээ, чадавхад үндэслэн тусгай ажлын байр бий болгон, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах асуудал нь Нэгдсэн үндэстний байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг нь бодит болгох Инчеоны стратеги 2013-2022 он Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого зэрэг урт болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж хэрэгжиж байдаг. Гэсэн хэдий ч ажил хөдөлмөр хийхийг хүсч байгаа боловч хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтын зөрүү, хандлагын саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байна. Харин хөдөлмөрийн насны 73285 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа нь өнөөгийн энэхүү зорилтод бүлгийн тулгамдсан асуудлын нэг болоод буй юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудалд төрийн бодлогын хэрэгжилтийг юуны өмнө хангах, тэднийг өөртөө итгэлтэй, нийгмийн идэвхитэй гишүүн болгож хөгжүүлэх бусдын адил амьдрах боломж нөхцөл, нийгэмд оролцох оролцоо, хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох.

Материал ба арга зүй

Баримт бичиг болон тоон мэдээлэлд анализ хийв.

Үр дүн

Үндэсний статистик хорооны 2020 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Ажил хөдөлмөрийн статусаар нь авч үзвэл 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг. 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан салбарт гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, харин албан бус салбарт ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал нь харьцангуй илүү байна.

1. Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, төсөөлөл

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу Үндэсний статистикийн хорооноос гаргадаг нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулан мэдээлдэг.

2. Хөгжлийн бэрхшээлийн тухай хоцрогдсон ойлголт

Ийм арга хандлага нь хүмүүсийн чадвар сонирхлыг нь үндэс болгох бус хөгжлийн бэрхшээлийг нь гол хүчин зүйл болгож сургалт ажлын байранд

хамруулдаг. Гэтэл сайн сургалтын төвүүд суралцагчийн чадвар сонирхлыг нь судлан тодорхойлж өөрсдөд нь мэргэжил сургалтын сонголт хийх боломж олгож байдаг. Ийм арга барилыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нэгэн адил хэрэгжүүлэх шаардлагатай. Хэвшмэл буруу сэтгэлгээ хандлагыг арилгаж өөрчлөх талаар ажиллах боломжуудыг нээлттэй болгох хэрэгтэй. Тусгаарлагдсан орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар анхаарал халамж тавьж ганцаарчилсан болон тусгай үйлчилгээ үзүүлэх илүү тохиромжтой гэж үздэг шийдвэр гаргагчид бий. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтыг тусгайлсан орчинд явуулах нь тэдгээрийн чадавхад илүү тохирно гэж үздэг бөгөөд тэдэнд илүү анхаарал тавих боломжтойгоос гадна энгийн иргэдийн сургалтын явц ахицыг сааруулахгүй байх онцлогтой гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар гаргасан зарим шийдвэрийг хөгжлийн бэрхшээлтэй тухайн хүн өөрөө бус өөр хэн нэгэн хүн тэдний өмнөөс гаргасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн хүсэл сонирхол, бодол мөрөөдөлд анхааралд хандуулах нь тохиолдлын шинжтэй байсан.

3. Хөгжлийн бэрхшээлийн талаарх орчин үеийн ойлголт, төсөөлөл

Хүний эрхийн төлөө хөдөлгөөнийг дагалдан хөгжлийн бэрхшээлийн нийгмийн төлөв загвар үүсэн бий болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эх орныхоо нийгэм эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцоход нийгэм өөрөө тодорхой саад бэрхшээлийг учруулж байдаг. Нийгэм өөрөө эдгээр саад бэрхшээлийг арилгах үүрэгтэй ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ саад бэрхшээлийг арилгах үйл явцад гол үүргийг гүйцэтгэх ёстой. Саад бэрхшээлийг арилгахдаа хүртээмжийг нэмэгдүүлэх мэдээллийг сайжруулах оролцоог нэмэгдүүлэх тухай хууль тогтоомж бодлого боловсруулах хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэн ажиллах хэрэгтэй. Мэргэжлийн сургалтын байгууллагад саад бэрхшээлийг арилгасан энгийн хоёр жишээг танилцуулъя.

Жишээ 1: Доржхөдөлгөөний бэрхшээлтэй ба компьютерын програмчлалд суралцах сонирхолтой гэтэл компьютерын лабораторид очиход олон шаттай байлаа. Энэ саадыг компьютерийн лабораторийг шилжүүлэн байршуулах эсвэл хэн нэгэн нь Доржид шатаар гарахад нь туслах сургалтын материалыг нь зөөж өгч болно. Хэрэв Дорж дугуйт тэргэнцрээр зорчдог бол шатнаас гадна эсвэл шатны оронд нэмэлт төхөөрөмж суурилуулах шаардлагатай.

Жишээ 2: Хараагүй хүнд зориулсан ярианы программ ашиглах эсвэл дүлий хүмүүст зориулж хэлмэрч хөлслөх нь харьцангуй өндөр өртөгтэй байдаг тул сургалтын байгууллага төсвөө эдгээрт зориулж зарцуулахыг хүсэхгүй байж болох ба энэ бэрхшээлийг даван туулах боломж бий. Төсөвт боловсролын тодорхой арга хэмжээг санхүүжүүлэх тусгай хөрөнгийг тусгайлан тусгаж болно. Энэ тохиолдолд багш зааварлагчийн сургалтын материалын зардлаас хөрөнгө гаргах шаардлагагүй болно. Түүнчлэн удирдлагын зүгээс орон нутгийн байгууллагуудтай сайн дурын үндсэн дээр эсвэл бага өртөг зардлаар хамтран ажиллах боломжтой юм. Саад бэрхшээлийг арилгах хамгийн сайн арга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцаж тэдний хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж болох тухай ярилцах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн өдөр тутмын амьдралд тулгарах саад бэрхшээлийг даван туулах арга хэдийнээ олсон байдаг.

4. Оролцоо-үйл ажиллагаанд хамтран оролцох нь:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн иргэдийн адил аливаа үйл

ажиллагаанд хамтран тэгш оролцож харилцахыг оролцоо гэнэ. Оролцоо гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн иргэдтэй нэг цаг хугацаанд нэг зүйлийг хийж туршлага солилцох тухай ойлголт юм. Өдөр тутмын амьдралдаа бид оролцооны жишээнүүдийг ажиглаж байдаг. Оролцоо нь хүний амьдралын зайлшгүй нэг хэсэг юм.

Үндэсний төвшинд хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хөтөлбөрийг сайжруулахын тулд хөдөлмөрийн харилцаанд орж буй бүхий л талуудад ээлтэй харилцан үрашигтай байхаар боловсруулж сайжруулах шаардлагатай байна. Үүнд: - Хөдөлмөрийн зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хөдөлмөрийн орчныг бүрдүүлж бүх талын оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд, торгуулийн тогтолцооноос урамшуулал дэмжлэгийн тогтолцоо руу шилжих хэрэгцээ байна. Үр дүнд нь урт хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд нэн шаардлагатай ажил эрхлэх сонирхолтой иргэдийг бүртгэх, ажлын байрны мэдээллээр хангах, сургах, тогтмол чадавхжуулах, ажил олгогчдод өөрсдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай дэд бүтцийг нь бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломж бүрдэх юм. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангууд, тэдгээрийн сан бүрдүүлэлт, төлөвлөлт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан бүрдүүлэх замаар онцлог хэрэгцээнд нь тулгуурласан бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөрийн чадвартай, тэднийг ажилд ажиллуулснаар нийгмийн хариуцлагаа биелүүлээд зогсохгүй ажил олгогчийн урамшуулал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, тогтвор суурьшилтай ажилчдаар хүний нөөцөө хангах гэх мэт олон боломж, давуу тал байдгийг сурталчилан таниулах, мэдээллийг хүртээмжтэй болгох хэрэгцээ их байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд ажил олгогчийн оролцоог бий болгох, урамшуулал, дэмжлэгийн арга хэмжээг боловсронгуй болгох нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр олноор бий болгосон, энэ талаар санаачлагатай ажиллаж байгаа ажил олгогчийг урамшуулж, тэднийг цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд тогтвортой байлгах, дэмжихэд нь ажил олгогчийг дэмжиж ажиллах шаардлагатай. Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай ойлголт, товч мэдээлэл, тэдний оролцоог хангах, мэргэжлийн сургалтыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтэд анхаарч, ялгаварлан гадуурхахгүй байх, тэднийг ажил орлоготой байлгах нь нэн тэргүүний зорилго юм.

Түлхүүр үг: *Хөдөлмөр эрхлэлт, дэд бүтэц, хүртээмж, ойлголт, хандлага*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөө үеийн байдал эмхтгэл, 2009 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Б.Дашдаваа¹

¹ Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах асуудлыг хөдөлмөр эрхлэлтийн байдалтай нягт холбон үзэх шаардлагатай. Учир нь өнөөдрийг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах төрийн бодлого нь халамжийн үйлчилгээнд суурилсан байдлаар хөгжиж ирсэн нь эргээд нийгмийн болоод эдийн засгийн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэх болсон.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг авч үзэх.

Материал ба арга зүй

Баримт бичгийн болон тоон мэдээлэлд анализ хийв.

Үр дүн

Одоогийн байдлаар нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт зэрэг 14 төрлийн багц үйлчилгээнд тулгуурласан тусламж үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжийн 70-аад төрлийн үйлчилгээ байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх дан ганц халамжийн тогтолцоогоор шийдвэрлэх боломжгүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд дараах хүчин зүйлүүдийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- Эрх зүйн зохицуулалт
- Хөдөлмөр эрхлэлтийн орчин
- Халамж үйлчилгээ.

Эрх зүйн зохицуулалт болон хөдөлмөр эрхлэлтийн орчин, халамж үйлчилгээний зохистой харилцаа бий болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах боломж нөхцөл бодитой бүрэлдэн тогтох юм.

Хэсэгчилсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан 8 аж ахуй нэгжийн 5 аж ахуй нэгж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах боломжгүй гэсэн тайлбарыг өгсөн.

График 1. Аж ахуй нэгжийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл Судалгаанаас аж ахуй нэгжийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл



хүндрэх, биеийн хүч ихээр шаардах тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэний хийж гүйцэтгэх ажлын байр багасаж байгааг харуулж байна.

ҮСХ-ны Бизнес регистрийн санд 2019 оны байдлаар 94.4 мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 67.3 хувь нь Улаанбаатар хотод, 32.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг ажиллагсдын тооны бүлгээр авч үзвэл 2019 оны байдлаар 81.2 мянга буюу 86.1 хувь нь 9 хүртэлх ажиллагчидтай, 6.3 мянга буюу 6.6 хувь нь 10-19 хүртэлх ажиллагчидтай байгаа бол 6.9 мянга буюу 7.3 хувь нь 20, түүнээс дээш ажиллагчидтай байна.

Хүснэгт 1. Одоогийн үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, ажиллагсдын тоо зэргийг харьцуулан үзвэл

25, түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж				Эрх зүйн зохицуулалт
	Нийт	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй	Хөдөлмөрийн тухай хууль 111.1. 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна.
1	7 766	3 423	4 343	111.2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө
Ажиллавал зохих хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо				
2	33018	19241	1377	

2019 оны байдлаар 25 ба түүнээс дээш ажилтантай нийт ААНБ-ууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулбал зохих нийт орон тооны 19 241 буюу 26.4 хувьд ажиллуулж байна. Байршлаар харвал орон нутагт нийт 10 210 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болох боломжтой ч 5 850 буюу 57.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод харьцангуй бага буюу 12.5 хувьтай байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны тайланд идэвхтэй үйл ажиллагаа эрхлэн, ажиллагчдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай 7 766 ААНБ байна. Эдгээр ААНБ-ын 3 423 нь буюу 44.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ААНБ-уудын 63.1 хувь нь орон нутагт, 36.9 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Дээрх тайлан, статистик мэдээ тусгагдсанаар хуулийн зүйл заалт хэрэгжихгүй байгаад олон талын асуудал байж болох боловч тус харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт нь өөрөө боловсронгуй байгаатай холбоотой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг

дэмжсэн эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоо хангалтгүй, хийдэл байгааг харуулж байна.

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байгаа аж ахуй нэгжид үзүүлэх татварын хөнгөлөлтийг тусгахдаа 22.5.2.нийт 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн ажиллагчдын гуравны хоёр ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох тухайн төрлийн албан татварыг 22.5.6.хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох албан татварыг..." гэж тусгасан байгаа хэт нийтлэг шинжтэй байна. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан аж ахуй нэгжийн үйл ажиллагааны онцлог, хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг, хүн амын төвлөрөл, газар зүйн байршил зэргийг харгалзан эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээг боловсруулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн төвшин нэмэгдэх нэг гол нөхцөл болно.

Дүгнэлт


Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг авч үзэхдээ аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, газар зүйн байршил, хөдөлмөр эрхлэлтийн орчин, халамж үйлчилгээ гэсэн цогц байдлаар авч үзэн зохицуулалт хийх нь халамжаас хөдөлмөр эрхлэлтрүү гэсэн зарчимд шилжих нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг бодитойгоор хангах нөхцөл бүрдэнэ. Судалгаанд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулснаар ямар хөнгөлөлт эдлэх тухай мэдээллийг аж ахуй нэгжид сурталчлах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохдоо газар зүйн байршил, хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг, аж ахуй нэгжийн үйл ажиллагааны онцлог зэргийг харгалзан үзэх
- Эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлт, нөхцөл боломж*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, 2016 он
2. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2005 он
3. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011 он
5. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он



II БҮЛЭГ
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨЖ БУЙ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Г.Жаргалмаа¹, Н.Болдмаа²

¹Хараат Бус Судалгааны Хүрээлэн, ²Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль
jargalmaa@irim.mn

Үндэслэл

Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийн хэргээр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хохирогчдын нэг хүрэхгүй хувийг (2017-2020 оны хооронд 36 хөгжлийн бэрхшээлтэй хохирогч бүртгэгдсэн [1]) хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ) эзэлж байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг хангалттай илрэхгүй байх, ХБХ гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн ч шаардлагатай хамгаалалт, дэмжлэг тусалцааг авч чадахгүй нөхцөлд байх өндөр магадлалтай байна. ГБХ-ийн нөхцөл байдал гаарч буй цар тахлын энэ цаг үед уг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамгийн өртөмтгий бүлгийн иргэдийн онцлог тусгай хэрэгцээг харгалзах, тусгахад шаардлагатай өнцгүүдийг тодруулах хэрэгцээ шаардлагын үүднээс тус судалгааг гүйцэтгэв.

Зорилго

ХБХ-ийн ГБХ-д өртөж буй байдал, үүнд хүчирхийллийн хэлбэр, төвшинг хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрээр тодорхойлох, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулснаар цаашид ГБХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөхөд анхаарах санал зөвлөмжүүдийг дэвшүүлэхийг зорьлоо.

Арга зүй

Судалгааг баримт бичгийн судалгаа болон кейс, хагас бүтэцлэгдсэн ярилцлага (ХБЯ)-ын аргуудыг ашиглан чанарын арга зүйгээр гүйцэтгэсэн. Кейс ярилцлагын аргаар 16-аас дээш насны 150 ХБХ-тэй ярилцлага хийсэн ба ХБХ-ий асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөллөөс ХБЯ-ын аргаар мэдээлэл цуглуулав. Хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг Эмзэг байдлыг тодорхойлох загвар (Determinants of Vulnerability Model)-ийн дагуу хувь хүн, гэр бүл, олон нийт, бүтцийн гэсэн дөрвөн түвшинд судаллаа [2].

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний ГБХ-д өртөж буй байдал: Судалгаанд хамрагдсан нийт ХБХ-ий 74 хувь (n=111) нь ГБХ-ийн аль нэг хэлбэрт өмнө нь өртсөн байсан. ҮСХ-оос 2017 онд гүйцэтгэсэн Жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний хэмжээний судалгааны дүнгээр Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн [3] гэсэн үр дүнтэй харьцуулбал ХБХ-ий ГБХ-д өртөх байдал ойролцоогоор хоёр дахин өндөр байна. Тэдний

дийлэнх нь (72.1%) эмэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж үзвэл, 31-ээс дээш насныхны өртсөн байдал бусад бүлгээс илүү өндөр байна.

Хүчирхийллийн хэлбэрээр нь ХБИ-ийн өртөж буй байдлыг авч үзэхэд тархалтын хувьд сэтгэл санаа, хянах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн байдал өндөр хэдий ч хүчирхийллийн хэлбэрүүдийн давхардсан байдал маш өндөр байв. Тодруулбал, нийт ГБХ-д өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүн тутмын нэг нь (46%) хүчирхийллийн таван хэлбэр (сэтгэл санаа, хянах, бие махбодын, бэлгийн, эдийн засгийн)-т бүгдэд нь өртсөн байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь ГБХ-д өртсөн байдлыг харьцуулж авч үзэхэд тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртөж буй байдал бусад ХБХ-ээс хамгийн өндөр байсан. Энэ нь нийтлэг тохиолдолд орон нутгийн дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжгүй байдлаас шалтгаалан тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс гэр бүлийн гишүүдээс хараат байдал нь өндөр байгаатай холбоотой байв.

Хүчирхийлэл хэр аюултай түвшинд үйлдэгдэж буйг тодруулахад [4] ГБХ-д өртсөн нийт ХБХ-ий 35 хувь нь маш аюултай буюу тухайн хүний амь насанд ч хүрч болох эрсдэлтэй нөхцөлд орж байжээ. Бэрхшээлийн төрлөөр нь үзвэл харааны бэрхшээлтэй хүмүүс бусад ХБХ-ээс илүү аюултай нөхцөлд хүчирхийлэлд өртсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлс: Судалгаанд хамрагдсан 150 ХБХ-ий амьдралын түүх, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тэдний мэдлэг, ойлголт, зан үйлд нь нийтлэг ажиглагдсан шинжүүд болон оролцогч талууд, асран хамгаалагч нартай хийсэн ярилцлагын мэдээлэлд үндэслэн ХБХ-ийг ГБХ-д өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг Эмзэг байдлыг тодорхойлох загварын дагуу 4 төвшинд судлахад:

Хүснэгт 1. ГБХ үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, төвшнөөр

Түвшин	ГБХ-д өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс
Хувь хүний төвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэй байх 2. Гэрлэсэн байх 3. Төрөлхийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдалт өндөр байх 4. Өмнө нь хүчирхийлэлд шууд болон дам байдлаар өртөж байсан байх 5. Боловсролын төвшин бага байх 6. Хөдөлмөр эрхэлдэггүй байх 7. Нийгмийн харилцаа холбоо бага байх
Гэр бүлийн төвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> 1. Өрхийн орлого бага, цөөн эх үүсвэрээс бүрддэг байх 2. Гэр бүлийн уур амьсгал таагүй, зөрчилтэй байх 3. Гэр бүлийн шийдвэр гаргалтад гэр бүлийн бусад гишүүдийн санал бодлыг харгалздаггүй байх

Олон нийтийн төвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээл болон бусад хүчин зүйлээс нь хамааруулан үе тэнгийнхэн, олон нийтийн дунд гадуурхалд өртдөг байх 2. Амьдарч буй орон нутагт нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сул, дэд бүтцийн хөгжил муу байх 3. Амьдарч буй орон нутагт нь олон нийтийн нэгдэл, нягтрал муу байх
Тогтолцооны төвшний хүчин зүйлс	<ol style="list-style-type: none"> 1. Хүчирхийллийг тэвчих, хүлцэх уламжлалт соёл, хэвшсэн ойлголт 2. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмж ХБХ-т хүрэхгүй байх 3. Ажилгүйдэл, ядуурал (үе дамжсан ядуурал төлөвших) 4. Тогтолцооны чадавх, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байх

Дүгнэлт

ХБХ ГБХ-ийн хохирогч болсон ч цагдаагийн байгууллагад мэдэгдэж, хамгаалалт, дэмжлэг тусалцаа авч чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна. ХБХ-ийг ГБХ-д өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг авч үзвэл дөрвөн төвшний хүчин зүйлүүд хоорондын харилцан хамаарал өндөр хэдий ч хувь хүн, гэр бүлийн төвшинд нөлөөлж буй асуудлууд нь олон нийт, бүтцийн төвшиндээ ижил дүгнэлтэд хөтөлж байсан нь тус төвшний хүчин зүйлүүд нь илүү суурь шалтгааны төвшинд нөлөөтэй болохыг харуулж байв. Иймд ХБХ-ийн ГБХ-д өртөх эмзэг байдлыг бууруулахын тулд олон нийт болон тогтолцооны төвшний асуудлуудыг шийдвэрлэх, ялангуяа эдгээр төвшинд иргэдийн тэсвэртэй байдлыг (resilience) нэмэгдүүлэх хамгаалагч хүчин зүйлүүдийг сайжруулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй байна.

Түлхүүр үг: *Хүчирхийллийн хэлбэр, аюулын түвшин, эрсдэлд хүчин зүйлс*

Ашигласан материал:

- [1]. ЦЕГ. (2020/08/19). “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас албан тоотоор ирүүлсэн мэдээлэл.”
- [2]. IOM. (2019). *Handbook on protection and assistance to migrants vulnerable to violence, exploitation and abuse.*
- [3]. ҮСХ. (2017). *Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа: Хүчирхийллийн нүцгэн үнэн.* Улаанбаатар.
- [4]. ХЗДХЯ. (2020). *Сайдын А/83 тушаалаар батлагдсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”.*
- [5]. VicHealth. (2015). *Current theories relating to resilience and young people: a literature review,* Victorian Health Promotion Foundation, Melbourne.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ШИЙДЭХ ГАРЦ

Н.Мөнхбат¹

¹ Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв
bataa0520@gmail.com

Үндэслэл

Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар 2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх чөлөөгөө эдлэх боломж нөхцөлийг төр хариуцна хэмээн заасан байдаг боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, орчны хүртээмжтэй байдал, нийгмийн хандлага зэрэг тэдэнд тулгарч буй саад бэрхшээлүүдийг арилгах, чанарыг сайжруулах зэрэг асуудлууд урган гарч ирж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих, оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, тэдний амьжиргааны түвшинг баталгаажуулах талаар хэрэгжсэн орон нутгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийв.

Материал ба арга зүй

Орон нутгийн төвшинд хэрэгжсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланд хийсэн шинжилгээ болон орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргагч, бодлогыг хэрэгжүүлэгч субъектууд, үр шимийг нь шууд хүртэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эцэг эхчүүд, харгалзан дэмжигчид, асран хамгаалагчид тухайн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, судлаачид, сонирхогчдоос авсан судалгааны үр дүнг ашиглах, дахин боловсруулалт хийн дүгнэлт гаргах зэргээр ашигласан болно.

Үр дүн

Сэлэнгэ аймагт 2020 оны жилийн эцсийн байдлаар 5169 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд үүнээс 2916 эрэгтэй, 2253 эмэгтэй байна. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг 3559, халамжийн сангаас тэтгэвэр авдаг 1589 иргэн байна. Тус судалгааны ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөтөлбөрүүдэд дэвшүүлэгдсэн ижил зорилтуудыг нэгтгэн багцалж хэрэгжилт, үр дүнд нь хяналт шинжилгээний аргуудыг ашиглан дүн шинжилгээ хийсэн болно.

Анкетын судалгаанд 155 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 42 халамжийн мэргэжилтэн болон төрийн албан хаагчаас авсан нийт 197 мэдээлэлд анхдагч ба хоёрдогч боловсруулалт хийсэн бөгөөд нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүл, ойр дотны хүмүүс, хоёрдугаарт, эдгээр иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчид гэж хоёр

ангилсан бөгөөд ийнхүү ангилж үр дүнг нь гаргаснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар хэрэгжиж буй төрийн бодлого, хөтөлбөрийн үр нөлөө, зорилтот бүлэгтээ хэр үр өгөөжтэй хүрсэн, ач холбогдолтой байсан эсэх, цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж ямар бодлого, хөтөлбөр төлөвлөж ажиллах шаардлагатай зэргийг судалсан ба фокус бүлгийн ярилцлагад оролцогчид болон экспертүүдийн үнэлгээнд тулгуурлан дээрх асуудлуудыг нарийвчлан тодруулсан болно.

Төрийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын баталгааг хангах үүднээс орон сууцны талбайн хөлс, түлээ нүүрсний тусламж, асаргааны тэтгэмж, халамжийн тэтгэвэр, нийтийн тээврээр үнэгүй зорчих, амралт сувиллын хөнгөлөлт зэрэг нийгмийн үйлчилгээнд хамруулдаг. Эдгээр үйлчилгээний талаар судалгаанд оролцогчдын сэтгэлж ханамж хир байгааг энэхүү графикаас харагдаж байна.




График 1. Төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд болон хувийн байгууллага нийтдээ 45 байгууллагад дэд бүтэц бий болсон эсэх, тэдгээрийн стандарт шаардлага, өнөөгийн байдлыг ажиглалтын хуудсаар бөглөн авсан бөгөөд судалгаанаас харахад ийм бүтэц бараг байхгүй бөгөөд байгаа цөөн хэд нь стандартын шаардлага нөхцлийг хангаж чадахгүй байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын өнөөгийн нөхцөл байдлыг судлахад хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харьцах талаар сургалтанд хамрагдаж, тусгай мэргэжил эзэмшин, тулгарч байгаа саад бэрхшээлийг даван туулах хэрэгцээ байгаа нь харагдсан.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын асуудлаар эрх зүйн орчин бүрдүүлэх тодорхой ажлууд хийгдэж, нийгэм иргэд олон нийтийн дунд эерэг өөрчлөлт, хандлага төлөвшиж эхэлсэн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө, мөн энэ чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагуудын оролцоо сайжирсан зэрэг нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч сайжруулж болохоор хэд

хэдэн зүйлс байна. Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан мэргэжилтнүүдийг аймаг, сум, хөдөлмөр халамжийн газар, нийгмийн даатгалын хэлтсүүдэд бий болгосон ч төрийн албан хаагчид мэргэшээгүй, тогтвор суурьшилгүй байгаа бөгөөд мөн тэднийг мэргэшүүлэх, ажлын байран дээр нь сургах,
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин үндсэн шаардлага” зэрэг стандартууд батлагдсан боловч орон нутагт баригдсан барилга байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, явган хүний замуудад эдгээр стандартыг мөрдөх,
- Бодлогын баримт бичиг боловсруулахдаа суурь түвшний шалгуур үзүүлэлтийн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийн, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлсон байх, хэрэгжүүлэх бүх шатанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өөрсдийг нь оролцуулах,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, илэрхийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төр болон төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах, тэдний оролцоог бүх төвшинд хангах,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгэм, хамт олны хандлагыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих, нийгмийн амьдралд бие даан оролцох дэд бүтцийг батлагдсан стандартын дагуу бий болгох, түүний хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хариуцлага тавих механизм тогтолцоог бүрдүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Төрийн үйлчилгээ, хүртээмжтэй орчин, нийгмийн хандлага*

Ашигласан материал:

1. Монгол улсын хууль (2016). “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай”. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2016-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан. (2020). Сэлэнгэ аймаг.
3. Сэлэнгэ аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн тайлан (2020). Сэлэнгэ аймаг.
4. Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн тайлан (2020). Сэлэнгэ аймаг.
5. www.1212.mn/ Статистикийн нэгдсэн мэдээллийн сайт (2020). Сэлэнгэ аймаг.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН АМЬДРАЛЫН ЧАНАР

Н.Золзаяа, Б.Батбаяр, Э.Болорцэцэг¹

¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
zoloo890108@gmail.com

Үндэслэл

Эцэг эхчүүд хүүхдийнхээ тусгай хэрэгцээг өөрсдийнхөөсөө дээгүүр тавьдаг учраас сэтгэлзүйн хувьд амьдралын чанар нь буурахаас гадна өөрсдийгөө буруутгах, гутрангүй үзэлтэй болох, түрэмгий ааш авиртай болох цаашлаад сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлдөг. Энэ нь эргээд хүүхдийн амьдралын чанар, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байна. Хүүхэд өсч томрох тусам олон нийтийн дунд хашгирах зэрэг тааварлаагүй зан авир гаргах тохиолдол байдаг учраас эвгүй байдалд орохгүйн тулд нийгмийн үйл ажиллагаанаас татгалздаг байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн амьдралын чанар болон хүүхдийн үйл ажиллагааны хараат бус байдлын хамаарлыг судлах.

Материал ба арга зүй

Аналитик судалгааны нэг агшингийн (cross-sectional) загвараар хийв. Судалгааг ХБХСЗХТ-өөр үйлчлүүлж буй 3-8 насны тархины саа, Аутизм, Дауны хам шинж, хөгжлийн хоцрогдол гэсэн онош бүхий 21 хүүхдийн эцэг эхээс (Б бүлэг), хяналтын бүлэгт эрүүл хүүхэдтэй 21 эцэг эхээс (А бүлэг) асуумж судалгаа авлаа. ДЭМБ-аас гаргасан амьдралын чанарыг үнэлэх WHOQOL-BREF асуумжийг ашигласан. Хүүхдийн үйл ажиллагааны чадварыг WeeFIM үнэлгээний аргаар үнэлэв.

Үр дүн

Бидний судалгаанд нийт 42 эцэг эх хамрагдсанаас дийлэнх нь нь эмэгтэй (71.4%) байлаа. Насны хувьд 14 нь 35-аас дээш настай (33.3%), 28 нь 35-аас доош насны (66.7%), боловсролын хувьд 34 нь дээд боловсролтой (81%), 6 нь бүрэн дунд боловсролтой (14.3%), 2 нь дунд боловсролтой (4.8%), гэрлэлтийн байдлын хувьд 37 нь гэрлэсэн (88.1%), 3 нь ганц бие (7.1%), 2 нь салсан (4.8%) байна. Дээрх хүн ам зүйн үзүүлэлтүүдийн хувьд 2 бүлгийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа байхгүй байна.

Хүснэгт 1. Эцэг эхийн амьдралын чанарын үзүүлэлт

	N	Дундаж	СХ	p*
Биемахбодийн эрүүл мэнд				
А бүлэг	21	69.1429	16.37158	.853
Б бүлэг	21	70.0952	16.60995	
Сэтгэцийн эрүүл мэнд				
А бүлэг	21	73.3810	16.51204	.886
Б бүлэг	21	72.7143	13.22552	
Нийгмийн харилцаа				
А бүлэг	21	77.4286	21.40928	.793
Б бүлэг	21	75.9048	15.49808	

Хүрээлэн буй орчин				
А бүлэг	21	63.2381	17.49544	.643
Б бүлэг	21	65.7143	16.88533	

* $p < 0.005$

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болон эрүүл хүүхэдтэй эцэг эхийн амьдралын чанарын үзүүлэлт бүлэг тус бүрт статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна ($p > 0.05$). Энэхүү судалгаа нь ковид-19 цар тахлын үеэр хийгдсэн тул хатуу хөл хорио нийт хүн амын амьдралын чанарт сөргөөр нөлөөлсөн байж болох талтай юм.

Хүснэгт 2. Эцэг эхийн амьдралын чанар хүүхдийн чадвар алдалтын харилцан хамаарал

Пирсоны корреляцийн коэффициент					
	Биемахбодийн эрүүл мэнд	Сэтгэцийн эрүүл мэнд	Нийгмийн харилцаа	Хүрээлэн буй орчин	Wee-FIM
Домэйн 1	1				
Домэйн 2	.504**	1			
Домэйн 3	.365*	.713**	1		
Домэйн 4	.596**	.655**	.654**	1	
Wee-FIM	.019	.062	.040	.004	1

** *Correlation is significant at the 0.01 level (2-tailed)*

* *Correlation is significant at the 0.05 level (2-tailed)*

Хүүхдийн үйл ажиллагааны хараат бус байдлыг WeeFIM үнэлгээний аргаар үнэлж, эцэг эхийн амьдралын чанартай харьцуулж үзэхэд сул хамааралтай ($p < 0.005$) байна.

Дүгнэлт

Хүүхдийн үйл ажиллагааны хараат бус байдал буюу хөдөлгөөний үйл ажиллагааны үзүүлэлт муу байх нь эцэг эхийн амьдралын чанарт нөлөөлж байна.

Түлхүүр үг: WHOQOL, WeeFIM, чадвар алдалт

Ашигласан материал:

- [1] Kazak, A.E. & Marvin, R. (1984). Differences, difficulties and adaptation: stress and social networks in families with a handicapped child. *Family Relations*, 33, 67–77
- [2] Ayrault, E.W. (2001). Beyond a Physical Disability. The Person Within – A Practical Guide. New York: The Continuum International Publishing Group.
- [3] Glasscock, R.F. (1997). The Experience of Being a Mother of a Child with Cerebral Palsy: a Phenomenological Study. Louisiana State University. Medical Ctr, 117
- [4] Schneider, J.W., Gurucharri, L.M., Gutierrez, A.L. & Gaebler-Spira, D.J. (2001). Health-related quality of life and functional outcome measures for children with cerebral palsy. *Developmental Medicine & Child Neurology*, 43, 601–608
- [5] Cecilia Yuen Shan Leung And Cecilia Wai Ping Li-Tsang. Quality of life of parents who have children with disabilities. *Hong Kong Journal of Occupational Therapy* 2003;13:19–2

ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН НИЙГМИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

С.Дэлгэрмаа¹, З.Хишигсүрэн², Р.Оргилмаа¹, Л.Сундуй-Янжмаа¹,
Н.Наранбаатар¹, Д.Мягмарцэрэн²

¹ АШУУИС, Сувилахуйн сургууль

² АШУУИС, АУС

delgermaa.s@mnum.edu.mn

Үндэслэл

ДЭМБ болон Дэлхийн банкны тооцоолсноор дэлхий дахинаа нэг тэрбум гаруй хүн хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь дэлхийн хүн амын 15%-ийг эзэлдэг бөгөөд^{1,2} үүнээс 450 сая хүн нь сэтгэцийн эмгэгтэй, сэтгэцийн эмгэгтэй нийт хүн амын 1-3% -ийг оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлдэг байна.³ Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй⁴ олон нийтийн байгууллагууд хангалтгүй тусламж үзүүлж байна гэж үзэж байна.

Зорилго

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамж тусламжийн хүчин зүйлсэд нөлөөлж буй тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Материал ба арга зүй

Уг судалгаанд Улаанбаатар хотын 8 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн, хяналтад байгаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй 642 үйлчлүүлэгч, тэдний асран хамгаалагчийг зорилтот түүврийн аргаар сонгон, асуумж судалгаа авсан. Асран хамгаалагчаас хүн амзүй, нийгэм, тусгайлсан асуумжийг тусгайлсан асуумжаар авч, судалгааны мэдээлэл статистик боловсруулалтын SPSS-21 программыг ашиглан үр дүнг тооцно

Үр дүн

Хүснэгт 1. Асруулагчийн хүн ам зүйн үзүүлэлт

	Үзүүлэлт	F71	F72	F73	P утга
Асруулагчийн насны байдал	<20	27 5.3%	9 8.2%	6 30.0%	0.007
	20-29	121 23.6%	25 25.5%	4 20.0%	
	30-39	140 27.3%	28 24.5%	5 25.0%	
	40-49	129 25.1%	27 11.8%	0 0.0%	
	50-59	72 14%	8 7.3%	0 0.0%	
	60- аас дээш	24 4.7%	8 7.3%	0 0.0%	
Асруулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	70%	52 10.1%	3 2.7%	2 10.0%	0.0001
	80%	79 15.4%	5 4.5%	1 5.0%	
	90%	331 64.5%	39 35.5%	7 35.0%	
	100%	51 9.9%	63 57.3%	10 50.0%	

Асруулагчийг гэрээр хэн голдуу асардаг	Аав, ээж	282	55.0%	66	60.0%	13	65.0%	0.01
	Ах, эгч, дүү	175	34.1%	32	29.1%	4	20.0%	
	Тусгай асрагчтай	20	3.9%	5	4.5%	0	0.0%	
	Хамаатан садан	7	1.4%	3	2.7%	3	15.0%	
	Хэн боломжтой нь	1	0.2%	0	0.0%	0	0.0%	
	Бусад	28	5.5%	4	3.6%	0	0.0%	

Хүснэгт 1-ээс харахад судалгаанд хамрагдсан нийт тохиолдлын (n=643) дундаж нас 40.8 ± 13.11 , насны бүлгээр харилцан ялгаатай байгаа нь статистик ач холбогдолтой ($p=0.007$) байсан ба хүйсний хувьд онцын ялгаа ажиглагдсангүй.

Судалгааны үр дүнгээс үзвэл оюуны хомстолтой үйлчлүүлэгчдийн оюуны маш хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний 85% нь, хүнд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 57.3%, оюуны хүндэвтэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 64.5% эзэлж байгаа нь үл хамааран хууль ёсны асран хамгаалагч нь хууль ёсны асран хамгаалагчдын хувьд 65%-ийг тэтгэвэрт гарсан эцэг, эх нь, 25% нь тухайн гэр бүлээс ажилгүй хэн нэг нь асардаг ба үйлчлүүлэгчдийн олонхид хөдөлмөрийн чадвар алдалт нь 90-100% -иар тогтоогдсон байгаа илүү их асаргаа сувилгаа шаардагдаж байна.

Оюуны хомстолтой хүмүүсийн 75.2% (n=484) нь гэрт, 21.3% (n=137) нь орон сууцанд, 3.4% (n=22) нь түрээсийн байранд амьдарч байгаа нөхцлийг орлоготой харьцуулан үзэхэд өрхийн амжиргаанд хүрэлцэхгүй байгаа ихэнх гэр бүл гэрт амьдарч байна. Судалгаанд хамрагдсан асран хамгаалагчдын ам бүлийн тоо 4-6 гишүүнтэй байсан бөгөөд өрхийн дундаж орлого нь 400.001–500.000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд оношийг орлоготой харьцуулахад хүнд, маш хүнд асруулагчдад зарцуулах эмийн, хэрэгцээний санхүү хүрэхгүй, улмаар өрхийн амжиргааны төвшин буурч, гэр бүлийн орлого хүрэлцэхгүй болох шалтгаан болж байна.

Асран хамгаалагч буй оюуны хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг бусад хүмүүс нь ад шоо үзэх, нэр хоч өгөх байдлаар ялгавартай харилцаж, алагчлах хандлагыг бий болгож байна. Асран хамгаалагч буй оюуны хомсдолтой үйлчлүүлэгчдэд нийгэм халамжийн тусламжийг халамжийн үйлчилгээ авахыг хүссэн 30.6% ($p=0.025$), гэр бүлийн аюулгүй байдал алдагдсан 19.7% ($p=0.039$), санхүүгийн тусламж авахыг хүссэн 46.4% ($p=0.05$), халамжийн ажилтны зөвлөгөө авах 53.8% ($p=0.031$) тусламж дэмжлэг илүү их хэрэгтэй байгаа нь гэр бүлдээ таатай орчныг бий болгох, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ амьдралын чанарт сайнаар нөлөөлнө гэж үздэг байна.

Дүгнэлт

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хүчин зүйлс нь асран хамгаалагчийн асаргаа, сувилгаанд нөлөөлж, улмаар өрхийн

амьжиргааны төвшинд нөлөөлөх хүчин зүйлс болж байгаа нь гэр бүлд нийгмийн халамжийн тусламж ихээхэн шаардлагатай байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Оюуны хөгжлийн бэрхшээл, асран хамгаалагч, нийгмийн халамж, тусламж дэмжлэг, өрхийн орлого

Ашигласан материал:

1. World Health Organization, The World Bank. Report on Disability. Malta 2011
2. [Azza Abdalla Ghoneim](#) December 2010. Health Promotion Toolkit: An Approach for Empowering Families Caring for Children with Developmental Disabilities in Tabuk [Open Access Maced J Med Sci](#). 2018 Aug 20; 6(8): 1503–1511.
3. Madden, R., Sykes, C., & Ustun, T. B. (2013). World Health Organization family of international classifications. Definition: Scope and purpose. 14, 2013
4. “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь (2010-2019) хөтөлбөр дэх “сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж”-д хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан

ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДҮҮДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

Дуламсүрэн¹

Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолборын сэтгэл зүйч

Dulamsurenbayrsaihan@gmail.com

Д.Юмжирмаа²

ШУТИС, Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургуулийн сэтгэл судлалын багш

yumjirmaa@must.edu.mn

Үндэслэл

Тархины саа (Cerebral palsy - CP) гэдэг үгийн утга нь хөдөлгөөн, биеийн байрлал, хөгжлийн эмгэг өөрчлөлтүүдийн хам шинж гэж тайлбарлагдана. Тархины саанаас шалтгаалсан хөдөлгөөний бэрхшээлд мэдрэхүйн эмгэг, танин мэдэхүй, харилцааны бэрхшээл, хүлээн зөвшөөрөх мөн үйл хөдлөлийн болон татвалзах саа зэрэг хам шинжүүдийг багтаадаг. Тархины саажилт нь сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямралд орох эрсдэлийг нэмэгдүүлдэг ба энэхүү түгшүүр, сэтгэлийн хямралийг эмчлэхгүй байх нь бие махбод цаашлаад эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг

Зорилго

Тархины саажилттай хүүхдүүдийн сэтгэл зүйн байдлыг судлахад чиглэнэ.

Материал ба арга зүй

Судалгаанд Люшерийн өнгөний тест хэрэглэв (Г. Сарантуяа, 2015). Уг тест нь түгшүүр, ядралт, идэвх, стресс, түүний шалтгаан зэргийг илрүүлдэг. Өөрт илүү таалагдаж байгаа дарааллаар өнгөнүүдээс сонголт хийн, үр дүнг компьютерын програмд боловсруулдаг. Энэхүү тестийг 1948 онд М.Люшер зохиосон. 1960-аад оны үеэс бие хүний сэтгэл зүйн байдлыг үнэлэх гол аргачлалын нэг болж өнөөг хүртэл хэрэглэгдэж байна. Уг тестийг сэтгэл зүйн оношилгоо хийх, зөвлөгөө өгөх, шүүхийн магадлан шинжилгээ, цэргийн, спортын болон сэтгэл зүйн бусад салбаруудад өргөн ашигладаг. Тестийн баталгаат чанар 0,81-с дээш гэж тогтоогдсон


Үр дүн

Судалгаанд хамрагдсан тархины саажилттай нийт хүүхдүүдийн 55%-д сэтгэл зүйн ачаалал ихэссэн шинж илэрсэн. Өөрөөр хэлбэл сэтгэл зүйн хувьд ядралт их, удаан хугацаанд эрч хүчтэй ажиллах чадвар хомс, түгшиж болгоомжилсон, өөрт итгэлгүй, биеэ барих чадвар султай. Тархины саажилттай хүүхдүүдийн 28,5 хувьд түгшүүр бага хэмжээнд, 32,2 хувьд дунд зэрэг, 39,3 хувьд өндөр байна. Хөгжлийн бэрхшээлтэйг тогтоолгосон насны байдлыг харуулбал хамгийн их хувьд болох 43% нь 3-6 насанд, 36% нь 1-2 настайд, 21% нь 0-6 настайдаа буюу нярай үед нь илрүүлсэн байна.

График 1. ХБ-г тогтоолгосон насны байдал



График 2. Тархины саажилттай хүүхдүүдийн дотоод зөрчилт асуудал



Тархины саажилттай хүүхдүүдийн 7% нь сэтгэл зүйн ачаалал маш бага, 10% нь бага, 28% дунд зэрэг, 55% нь сэтгэл зүйн ачаалал өндөр илэрч байна.

Сэтгэл зүйн ачаалал их байхад нас маш их хамааралтай байна. ($r = .096$)

Харин сэтгэл зүйн ачаалал их байх тусам идэвх буурах хандлагатай байна.

($r = -.070$)

Тархины саажилттай хүүхдүүдийн идэвхийн байдлыг үзвэл идэвх сул 68%, хэвийн идэвх 29%, хэт идэвхжсэн 2% байна.

Дүгнэлт

Судалгаандаа тархины саажилттай хүүхдүүдийн сэтгэл зүйн байдал хэвийн байдал алдагдсан гэсэн таамаглал судалгаагаар батлагдлаа. Судалгаанаас хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлээ тогтоолгосон насны үзүүлэлтээс харвал 43% буюу тал хувь нь 3-6 насандаа тогтоолгосон байна. Саажилт нэгэнт тархинд үүссэн бол бүрэн эмчлэгддэггүй ба тархины саажилтыг эрт үеийн илрүүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудал тулгамдаж буйг харуулж байна. Сэтгэл зүйн эдгээр байдлыг

тархины саажилттай хүүхэд тус бүрээр нарийвчлан судлан сэтгэл зүйн тусламж үйлчилгээг шинжлэх ухаан үндэслэлтэй шат дараалсан байдлаар хүргэх шаардлагатай байна. Одоо үзүүлж буй үйлчилгээ, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Олон улсад зүү эмчилгээ, усан, зан үйлийн, физик, хоол тэжээл, массаж, тоглоомын, амралт зугаалгын, амьсгалын, нийгмийн, хэл ярианы, хөгжмийн эмчилгээнүүдийг өргөн хэрэглэж байна. Мөн кондуктив боловсрол олгох бие хүний хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Ингэснээр амьдралын хэвийн дадалд суралцах, амьдрах ухааны чадвар, амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтой.

Түлхүүр үг: Люшерийн өнгөний тест, түгшүүр, сэтгэл зүйн ачаалал, идэвх, стресс

Ашигласан материал:

- [1] Г. Батцэнгэл. (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол*. УБ.
- [2] Г. Сарантуяа. (2015). *Сэтгэл судлалын шинэлэх ухаанч судалгааны аргууд*. УБ: Жиком Пресс.
- [3] Тимофеев, В.И., Филимоненко, Ю. И. (1995). *Цветовой тест Люшера*. Санкт-Петербург: Иматон.
- [4] Rebecca Yin Foo, Max Guppy, Leanne M Johnston. (2013). *Intelligence assessments for children with cerebral palsy: a systematic review*. *Developmental Medicine & Child Neurology*, 911-918.
- [5] World health organization. (2015). *World health statistics 2015 report*. WHO Library Cataloguing-in-Publication.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН СЭТГЭЛЗҮЙН БАЙДЛЫГ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДЫН ЗҮГЭЭС СУДАЛСАН НЬ

Ц.Тэргэл, Г.Номин¹
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль¹
gnominnn8084@gmail.com, tergeltседенбал@gmail.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хязгаарлалт, гэр бүл, нийгэм зэрэг орчны хүчин зүйл, хувь хүний зан чанар, өөрийгөө тодорхойлох чадвар зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийгөө үзэх үзэл, үнэлэмж, биеэ авч явах чадвар нь янз бүр байдгаас тэдний сэтгэлзүйн байдал ч мөн адил өөр өөр байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн багш, эцэг эх болон найз нөхөд нь тэдний сэтгэлзүйн байдлыг хэр сайн ойлгож, туслалцаа үзүүлдэг талаар судлан тусгай сэтгэл зүйчид болон бусад боловсон хүчин хэр их хэрэгцээтэй байгааг мөн тандаж бидний дэвшүүлсэн энэхүү тусгай сэтгэл зүйчдийг бэлтгэн гаргаж болно гэсэн санаа нь бодит байдал дээр үр дүнтэйгээр хэрэгжиж болох эсэх дээр үнэлэлт дүгнэлт хийсэн болно.

Зорилго

Тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сэтгэл зүйн байдлыг тэдний багш, асран хамгаалагчид хэр сайн ойлгож, дэмждэг талаар судлан үүн дээрээ үндэслэж тэдэнд тусгайлан бэлтгэгдсэн сэтгэл зүйчид хэр шаардлагатай байгаа талаар зорилгоо болгон судалж эхэлсэн билээ.

Материал ба арга зүй

Уг судалгааг Улаанбаатар хотын тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургууль дахь харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын нийт 51 эцэг/эх, асран хамгаалагчдыг дараах асуулгын судалгаанд хамруулан үр дүнг боловсруулав.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төрөл тус бүрээр нь ангилан авч үзэж тэдгээр хүүхдүүдийн асран хамгаалагчид сэтгэлзүйн байдлыг нь хэр сайн ойлгож чаддаг эсэх тал дээр нь судалгааны үр дүнгээ гаргасан. Дийлэнх буюу 43.1% болох 22 судалгаанд хамрагдагсад хүүхдийнхээ сэтгэлзүйн байдлыг сайн ойлгодог гэж үзсэн бол 41.2% болох 21 судалгаанд хамрагдагсад тухайн хүүхдийн сэтгэлзүйн байдлыг багш болон бусад мэргэжилтнүүд муу ойлгодог хэмээн хариулжээ. Мөн тусгайлан бэлтгэгдсэн сэтгэлзүйч мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна уу? гэсэн асуултад нийт судалгаанд оролцсон 51 асран хамгаалагчдын 84.3% буюу

43 нь тийм гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд эцэг эхчүүдийн зүгээс Монгол улсад тусгайлан бэлтгэгдсэн сэтгэлзүйч мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай гэж үздэг байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлзүйн байдлыг тэдний асран хамгаалагчдын зүгээс тандан судалснаар тухайн хүүхдүүдэд нэн түрүүнд тулгамдаж буй асуудлыг ойлгож мэдэхээс гадна тэрхүү асуудалд нь хэрхэн туслалцаа үзүүлж болох талаарх арга замыг олж мэдэн бодитоор хэрэгжүүлж болохуйц саналыг дэвшүүлэх талаар бидний хийсэн судалгаанаас харж болохоор байгаа билээ. Энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн 5-р асуултын хүрээнд эцэг эх, багш, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийнхээ сэтгэлзүйн эрүүл мэндэд хэр их санаа зовниж буйг харж болохоор байсан ба тэдний бичсэн санал хүсэлтийн дагуу өөрсдийн гаргасан саналтай уялдуулан өнөөдрийн хийсэн судалгааныхаа гаргалгааг олж мэдэж чадсан хэмээн дүгнэж байна. Тэдний түгээмэл гаргасан санал хүсэлт бол тусгай хэрэгцээт сургуулиуд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан боловсон хүчин болон ялангуяа сэтгэлзүйчдийг маш сайн бэлтгэж гаргах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэлзүй болон цаашлаад нийгэмд хандах хандлага, ертөнцийг үзэх үзэл, нийгэмд оруулах хувь нэмэр зэрэг маш олон талын сайн ач холбогдол гарч болохоос гадна нийгмийн аль ч давхаргын хүмүүст бид бүгд нэг дэлхийн хүн тиймээс адил тэгш эрхтэй гэсэн үзэл хандлагыг түгээн дэлгэрүүлэх боломжтой. Үүний үр дүнд дан ганц хөгжлийн бэрхшээлтэй иргэд бус бүхий л хүмүүст эерэг нөлөөлөл болж хүрч чадна гэж үзсэний үндсэн дээр энэхүү эрдэм шинжилгээний дүгнэлтээ өндөрлүүлж байна.

Түлхүүр үг: Сурагчид, мэдрэмж, мэргэжилтэн, ойлголт

Ашигласан хэвлэл:

- [1] Статистикийн мэдээллийн сан. (2020). Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, бүс, аймаг, нийслэлээр. Retrieved from https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2002_058V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=t1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table
- [2] Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. (2020). Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик 2020. Retrieved from <http://www.gadpwd.gov.mn/index.php/page/318>
- [3] Б. Туяа. (1998). Бие хүний сэтгэлзүй, бие заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

*М.Ариунзаяа
Б.Оюунтөгс-Эрдэнэ
А.Мянганбаяр
Ariuka2723@gmail.com*

Үндэслэл

Нийгмийн хамгааллын стратегид нийгмийн хамгаалал гэдэг нь үр өгөөжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмзэг аюултай байдал болон орлогогүй болохоос сэргийлэх, хөдөлмөр эрхлэх чадварыг бий болгох, түүнчлэн хөдөлмөр эрхлэх чадварыг бий болгосноор ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэгдсэн багц бодлого, хөтөлбөр юм. Нийгэмд хэчнээн их чадавх бий болж, боломж үүссэн ч үүнээс гадуур орхигддог хүмүүс байдаг. Үүнд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бусад бүлгийн хүмүүс хамаарна. Эдгээр хүмүүс нөхцөл байдлаасаа шалтгаалан бий болсон боломжууд, авах ёстой тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлтүүдийг бүрэн авч чаддаггүй.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ерөнхий ойлголт, тэтгэвэр, тэтгэмжийг хаанаас олгодог, тэтгэвэр тэтгэмжийн хэдэн төрөл байдаг, түүнийг ямар хүмүүст олгодог, ямар хуулиар зохицуулдаг, нийгмийн халамжаас ямар арга хэмжээг авдаг талаар болон бусад улс орон хөгжлийн бэрхшээлтэй хүндээ ямар арга хэмжээ авдаг зэргийг судлахад чиглэсэн.

Материал ба арга зүй

Монгол улсын нийгмийн хамгаалал, нийгмийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний авах тэтгэвэр тэтгэмжийн судалгаа, сайтууд (hudulmur.gov.mn, legalinfo.mn, mlsb.gov.mn) цахим орчин дэх мэдээллүүдэд дүгнэлт хийж боловсруулав.

Үр дүн

Нийгмийн хамгааллын бодлого болох хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох тэтгэвэр, тэтгэмж нь хүн бүрд адил тэнцүү олгогдохгүй байгаа ба эрх тэгш хүртээмжтэй байдал байхгүй байгаа юм.

Нийгмийн даатгалаас уг хүмүүст тусламж дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч зарим хүмүүсийн амьдралын төвшин хэт доогуур төвшинд байгаа тул олгох тэтгэвэр, тэтгэмжийн хөнгөлөлт, тусламж үйлчилгээг илүү нэмэгдүүлмээр байна.

Дүгнэлт

Олон жилийн өмнөөс саяхныг хүртэл хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол саяхнаас нийгмийн амьдралд оролцох талаас нь авч үздэг болоод байна. Нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэдэг болон бусад тодорхойлолтод ажил, хөдөлмөр эрхлэх чадваргүй байдлыг харуулах эдийн засгийн загвар, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт

үйлчилгээ, зэргийг үзүүлж байна. Харин олон улсын байгууллагууд хүний эрхийн талаас нь илүү авч үзэн тодорхойлдог. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн, адил тэгш эдлэх, хамгаалах, хөхүүлэн дэмжихийг зөвшөөрсөн байдаг.” Зөвшөөрсөн эрхүүд дотор нь нийгмийн хамгаалал багтаж байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний халамжийн тэтгэвэр багтдаг бол нийгмийн халамжийн тэтгэмжид нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж хамаардаг. Монгол улсын нийгмийн хамгаалалд зарцуулах зардал дээрх хөнгөлөлт, тусламж үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжид зарцуулах зардал жил бүр нэмэгдэж байгаа юм.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүн, Нийгмийн хамгаалал, Нийгмийн халамж, Тэтгэвэр, тэтгэмж*

Ашигласан материал:

1. legal.info
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн хамгаалал
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох нийгмийн хамгааллын журам
5. Нийгмийн даатгалын сан
6. www.1212.mn
7. advocate.mn

ГЭРТ ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Т. Эрдэнэчимэг¹

¹ Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
ta.erdenechimeg02@gmail.com

Г. Билгүн²

² Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Bilgun.mao@gmail.com

Үндэслэл

Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, түргэн шуурхай болгох, олон төрлийн бичиг баримт цуглуулах хүндрэлийг багасгах зорилтын хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээг e-halamj, эрүүл мэндийн үйлчилгээг e-health, иргэний бүртгэлийн баримт бичиг бүрдүүлэлтийг E-mongolia цахим сангаас авах зэргээр үйлчилгээний хэлбэр дөт болж байна. Гэвч ахмад настан, ХБИ-ийн мэдлэг, мэдээлэл дутмагаас эдгээр үйлчилгээг авахад ухаалаг утас, компьютер, цахим орчинд ажиллаж чадахгүй зэрэг бэрхшээлээс үүдэн төрийн байгууллагын олон төрлийн бичиг баримт бүрдүүлэх шаардлага, хуулийн хугацаа хүлээх, очер дараалалд удаан зогсох, ахмад настан, ХБИ заавал хэн нэгний туслалцаа авч өөрийн биеэр очих эсвэл үр хүүхэд, ах дүү, хамаатан садандаа итгэмжлэл олгох, зарим талаар итгэмжлэгчээр дамжуулсан төрийн үйлчилгээ, халамж, даатгалын тэтгэвэр, тэтгэмж эзэндээ хүрэхгүй байх, нийгмийн дэд бүтцийн хүртээмж зэрэг тулгамдсан асуудал байсаар байна. Дүүрэг 2020 оны хүн амын тоогоор 38650 хүнтэй түүнээс 1560 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 42.3 хувь нь эмэгтэйчүүд, 57.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 11.6 хувийг 0-14 насны хүүхдүүд эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3%-иар их байна. Мөн олдмол хөгжлийн бэрхшээлтэй 1024 хүний 538 хүн (52.5%) нь ердийн өвчнөөр, 421 хүн (41.1%) нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 32 хүн (3.1%) нь зам тээврийн ослоор, 18 хүн (1.8%) нь үйлдвэрийн ослоор, 15 хүн (1.5%) нь ахуйн ослоос шалтгаалсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийт 199 байна. Үүнээс: ЕБС-д 114, Албан бус-Насан туршийн боловсролын төвд 40, СӨБ-д 10 хүүхэд суралцаж, бусад нь эцэг эх, асран хамгаалагчийн гар дээр байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн амьдралд оролцох байдал нэмэгдсэн байна. Дээрх тоон мэдээллээс харахад 421 хүн буюу 41.1% нь мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэх тодорхойлолтод орох болжээ. Шалтгаан нь уурхайн хүнд хортой хөдөлмөрийн нөхцөл байдалтай салшгүй холбоотой юм. Налайхын нүүрсний их уурхай 1990 онд хаагдсанаас хойш иргэд хууль бус олборлолт хийж хувийн уурхайнууд ажиллаж эхэлсэн. ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах ангийн 2000-2017 оны статистик судалгаанаас харахад 214 хүн уурхайн ослоор алтан амиа алдсан байдаг бол, 512 хүнийг ослын голомтоос аварч гаргажээ. Уурхайн ослоос аврагдсан хүмүүсийн 80-90 хувь нь ямар нэг байдлаар гэмтэл, бэртэл авсан байдгийг эрүүл мэндийн

байгууллагаас тогтоосон байдаг. Энэхүү хэрэгцээг ажил хэрэг болгох үүднээс дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, дүүргийн Засаг даргын Тамгын газар төрийн байгууллагаас Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Албан бус насан туршийн боловсролын төв, хувийн хэвшлээс арилжааны банкнуудтай гэрээ хэлцэл хийж, төрийн үйлчилгээг гэрт нь хүргэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн “ГЭРТ ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ” нь эхэлсэн даруйдаа хэвтрийн болон байнгын асаргаатай, өндөр настан иргэдийн талархлыг хүлээн, амжилттай үргэлжлэн хэрэгжиж байгаа нь цаашдаа төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, бодит, хүртээмжтэй хүргэсэн олон эерэг үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна.

Зорилго

Дүүргийн хэвтрийн болон байнгын асаргаа, дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, төр захиргааны болон үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг сайжруулах, иргэдэд ээлтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилдэг тогтолцоог бий болгоход оршино.

Материал ба арга зүй


Хэвтрийн болон байнгын асаргаа дэмжлэг шаардлагатай 236 иргэдээс түүврийн судалгаанд 100 иргэнийг хамруулан асуумж авч, хэрэгцээг тодорхойлсон.

Үр дүн

Налайх дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, халамж, банк болон боловсролын үйлчилгээг гэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлдэг тогтолцоог бий болгоно” гэсэн зорилт дэвшүүлсэн нь “Гэрт хүрч үйлчлэх үйлчилгээ”-гээр бодитой хэрэгжсэн. “Гэрт хүрч үйлчлэх үйлчилгээ”-г дүүргийнхээ нийгмийн салбарын хамгийн том заалт болгон ажил хэрэг болгоход багагүй саад бэрхшээл тулгарсан. Учир нь энэхүү цогц үйлчилгээг улсын хэмжээнд өмнө нь хэрэгжүүлсэн туршлага байгаагүй. Хамгийн бэрхшээлтэй нь Банкны салбарыг татан оролцуулах байсан. Энэхүү үйлчилгээ үр дүнтэй зохион байгуулахад эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам, гэрээ байгуулан, Хаан банк, Төрийн банкны хяналтын хэлтэс, албанд хянагдсаны үндсэн дээр хамтарсан гурван талт гэрээг байгуулж, гэрээр үйлчилгээ үзүүлэх теллер, хамгаалагчийн орон тоог батлуулж чадсан явдал юм. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, банктай байгуулсан гурвалсан гэрээний хүрээнд хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэнд, боловсрол, халамж, банкны үйлчилгээг гэрээр хүрч үйлчлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болсон. Дүүргийн ЭМТ болон өрхийн ЭМТ-ийн нарийн мэргэжлийн “ГЭРТ ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ” үйлчилгээний хүрээнд үзүүлэх эмнэлгийн тусламжийн жагсаалттай болсон. 2018, 2019, 2020, 2021 онуудад “Гэрт хүрч үйлчлэх” үйлчилгээний хүрээнд

хэвтрийн болон байнгын асаргаатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 600 иргэнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоо, ЭХО, зүрхний цахилгаан бичлэг, бариа засал зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ, 19 хүүхдэд 470 цагийн боловсролын үйлчилгээ, 100 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 122 иргэнд 10,000,000 гаруй сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг гэрээр хүргэж, нийт 841 иргэнд гэрээр хүрч үйлчилсэн байна.

Зураг 1. Эрүүл мэндийн үйлчилгээ болон тэтгэвэр, тэтгэмжийг гэрээр олгож байгаа байдлууд.



Дүгнэлт

Хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэнд, халамж, банк болон боловсролын үйлчилгээг гэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлдэг загварыг туршлаа. Үүнийг цаашид дэлгэрүүлэх нь зүйтэй байна. Хэвтрийн болон байнгын асаргаа дэмжлэг шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн



хувьд хамгийн чухал үйлчилгээ болох эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгмийн даатгал, боловсрол, банкны үйлчилгээг гэрээг хүргэсэн Налайх дүүргийн энэхүү зорилт, үйлчилгээ нь улсын хэмжээнд анхдагч үйлчилгээ болон маш амжилттай хэрэгжиж байна. Хэвтрийн болон байнгын асаргаанд байгаа иргэн гэрээр банкны үйлчилгээ авснаар тэтгэмжийн мөнгөө өөртөө зарцуулдаг болсон. Мөн гэр бүлийн аль нэгэн гишүүн ажлаа зохицуулах шаардлага багассан нь тухайн гэр бүлд санхүүгийн эерэг өгөөжийг бий болгосон байна. Төрийн үйлчилгээний хүртээмжийн талаарх иргэдийн ойлголт, хандлага эерэг болсон байна. Цаашдаа “Гэрт хүрч үйлчлэх үйлчилгээ”-г улсын хэмжээний 103,630 /эх сурвалж: <http://www.1212.mn/> хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс хэвтрийн болон байнгын асаргаа дэмжлэг шаардлагатай иргэдэд хүргэх нь нэн чухал бөгөөд ач холбогдолтой гэдгийг энэхүү судалгаа болон зорилт, амжилттай хэрэгжиж байгаа туршлага, үр дүн харуулж байна.

Түлхүүр үг: ХБИ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ХБХ – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ЭМТ – Эрүүл мэндийн төв, ЕБС-Ерөнхий боловсролын сургууль, СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол

Ашигласан материал:

1. Р.Буяндэлгэр, Налайх дүүргийн түүхэн тэмдэглэл, 2002, хуудас 12
2. Налайх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 он, хуудас 22
3. Налайх дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал, 2018 он, хуудас 10, 11
4. ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах ангийн 2017 оны тайлан

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГЭРИЙН АСРАМЖ ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

(Home care services for people with disabilities)

Ч.Дэлгэрмаа¹

¹ Хөгжлийн туслалцаа НҮТББ

Үндэслэл

Монгол улсын Халамжийн тухай хуулийн 18.1.6-д заасан Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний тухай хууль нь өнгөц харахад Төр, иргэний байгууллага, Иргэний гурвалсан оролцоог хангасан мэт боловч төр давамгайлах шинжтэйгээр боловсруулсан нь хуулийг хэрэгжүүлэх явцад бодит үр дүн муутай байгаа нь харагддаг. Дээрх үйлчилгээ нь хугацааны хувьд богино байгаа нь үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагадаа хүний нөөцөө тогтоон барих, чадавхжуулах боломж олгохгүй, үйлчилгээ авагч хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэнд, эдийн засгийн хувьд дорвитой тус нэмэр болохгүй өнгөрч байна. Манай Хөгжлийн туслалцаа НҮТББайгууллага 2020 оноос эхлэн 2 дахь жилдээ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн асрамж халамжийн үйлчилгээ хийх тендерт шалгаран ажиллаж байна. Үйлчилгээ үзүүлэх явцад энэ үйлчилгээ нь түр зуур оромдоод өнгөрөөх ажил төдий биш, мэргэжлийн байгууллага, мэргэжлийн боловсон хүчний байнгын асаргааг хийж хэрэгжүүлэх нь олон талын ач холбогдолтойг олж мэдэн энэхүү ажилд иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, төр засгийн оролцоо ч нэн чухал юм гэдгийг ойлгосон юм. Иймд байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн асрамж халамжийн үйлчилгээг нэвтрүүлэх цаг болсон гэж үзэн энэхүү сэдвийг хөндлөө.

Зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагчийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, асран халамжлах үйлчилгээг мэргэжлийн байгууллагад даатгах боломж нөхцөлийг судлах юм. Өндөр хөгжилтэй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн асрамж халамжийн үйлчилгээний өнөөгийн байдал, зохион байгуулалтын арга туршлагыг судлан дүгнэж, санал зөвлөмжүүдийг боловсруулахыг зорилго болгов.

Материал ба арга зүй

Энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн асаргааны талаарх баримт бичиг мэдээллийг цуглуулж, асаргаа үйлчилгээний талаарх ойлголт, тодорхойлолт, арга зүйтэй холбоотой мэдээлэл багтсан болно.

Үр дүн

Эмчилгээний үйлчилгээнд өвчнийг эрт илрүүлэх, дэмжих, эм боолт, хэл яриа хөдөлмөрийн эмчилгээ, хөдөлгөөний засал, сэтгэл зүйн эмчилгээ, өөртөө туслах боломжуудыг идэвхжүүлэх, практик амьдралд сургах, өвчний эмчилгээ гэх мэт эмчилгээнүүд багтдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

сургалт, гэрийн асрамж үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ зэргийг үзүүлдэг мэргэжлийн байгууллага буюу бүлгүүд ажилладаг. Асрагчийг л гэхэд 3 жилийн хугацаанд мэргэжлийн түвшинд бэлтгэдэг бөгөөд асрагч нарын сарын цалин 1300-1600 евро байдаг. Асаргааны ажилтан нь тухайн өвчтөнд насан туршид үйлчилгээ үзүүлдгээрээ манай орноос онцлог юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэрийн асаргаа, хэсэгчлэн хэвтэн эмчлүүлэх үеийн асаргаа, хэвтэн эмчлүүлэгчдийн асаргаа гэсэн төрлүүдэд ангилж, гэрийн асаргаанд сард 1 өвчтөнд 384-1432 еврогийн тэтгэмжийг зарцуулахаар Нийгмийн хуульдаа тусгаж өгсөн байна. Уг хуулинд гэрийн асаргааны төрөл, хугацаа, үнэ тариф зэргийг нарийвчлан тусгасан ба өвчтөнд шаардлагатай тоног төхөөрөмжийг амжиргааны түвшнээс нь хамаарч үнэ төлбөргүй хэрэглүүлэх, түрээслэх, худалдах зэрэг зохицуулалтыг хийдэг. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гэрээлэн гүйцэтгүүлэх гэж заасны дагуу манай байгууллага нь 2020 оноос Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарч ажиллаж эхэлсэн. Ажиллах явцад гэр бүл асран хамгаалагчдын зүгээс ажлын бус оройн цагаар, амралтын өдрүүдэд үйлчилгээ авах, эмнэлэгт сахиулах, амралтад цуг явуулах, өдөрт зөвхөн 2 цагаар биш ажлын 8 цагаар хамтад нь байлгаж ном уншуулах, хамт гадуур явуулах, сэтгэл санааг нь сонгож үргэлж хамтдаа байлгахыг хүсч байсан. Хэвтрийн дэглэмтэй удсан болон өндөр настай хүмүүс бариа заслыг урт хугацаатай хийлгэх хүсэлттэй бөгөөд бие нь их чилээрхдэг, даралт өндөртэй, хавантай гэх мэт зовиуртай байсан хүмүүс бариа хийлгэсэн эхний өдрөөсөө тааламжтай байгаагаар илэрхийлсэн. Мөн үйлчилгээ үзүүлж байх явцад ахмад настан болон байнгын асаргаатай хүмүүст байдаг нийтлэг хэрэгцээ нь хүнтэй ярих хэрэгцээ байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй гэрийн асрамж үйлчилгээг 10 хоногийн хугацаанд үзүүлж байгаа нь гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдад нь ажил эрхлэх боломж бүрдэхгүй, тухайн үйлчилгээ авч байгаа хүнд бодит үр дүн өгч чадахгүй байна. Халамжийн байгууллагуудын үйл ажиллагаа бүрэн цахимжаагүй учир үйлчилгээ авч буй иргэнээс маш их цаасан баримт бичиг шаарддаг. Энэ нь тухайн иргэнд дарамт болдгоос гадна үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд бодит үйлчилгээнээс илүү бичиг баримт цуглуулахад ач холбогдол өгч байгаа нь ажиглагддаг. Мөн энэ үйлчилгээг жилд нэг удаа богино хугацаагаар явуулж байгаагаас шалтгаалан гэрээ байгуулсан байгууллагын хүний нөөцийн хувьд энэ чиглэлээр Өтогтвортой ажиллаж, мэргэжил мэдлэгтэй ахиц гаргаж, туршлага хуримтлуулах нөхцөл боломж бүрдэхгүй байгаа нь ажиглагдсан. Бид үйлчилгээг урт хугацаанд, цогцоор нь хэрэгжүүлбэл дараах үр дүнд хүрэх боломжтой юм. Үүнд:

- Иргэд хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хүртэнэ
- Ядуурал буурна
- Гэр бүлийн хүчирхийлэл багасна
- Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний стандарт боловсронгуй

болно

- Мэргэжлийн байгууллагууд мэргэжлийн хүний нөөц бүрдүүлнэ
- Мэргэжлийн байгууллагуудад ажиллах хүний нөөц нь байнгын ажлын байртай, тогтмол орлоготой болно
- Байнгын асаргаа шаардлагатай иргэдэд нийгмийн харилцаанд оролцох боломж бүрдэнэ

Мэргэжлийн асаргаа үйлчилгээ хийх мэргэжилтэн бэлтгэгдэн гарч үйлчилгээ үзүүлж эхлэхэд асруулагчийн ар гэрийнхэн хөдөлмөр эрхэлж орлоготой болсноор өрхийн амжиргаа дээшилж, гэр бүлийн таатай уур амьсгал бүрдэнэ гэж үзэж байна.

Дүгнэлт

Мэргэжлийн байгууллагууд шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчин, ном сурах бичиг, гарын авлагатай болсноор гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг тогтвортой, чанартай явуулах, иргэдийн амжиргаанаас шалтгаалан тоног төхөөрөмжийн түрээс, эмнэлгийн асрамж зэрэг төлбөртэй үйлчилгээг нэвтрүүлэх боломж бий болно. Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн ур чадвар, онцлогийг судлан тэдэнд тохирсон ажлын байрны жагсаалт гарган, цахимаар болон гэрээр нь хөдөлмөр эрхлэх боломжийг нээж өгөх нь чухал байна. Иймд асаргааны хуулийг санаачлан боловсруулж, хувь хүний онцлог руу чиглэсэн, судалгаанд суурилсан, системтэй, урт хугацааны цогц үйлчилгээ явуулах шаардлагатай байна. Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний үнийг нэг өвчтөнд нэг удаа үйлчилгээ үзүүлэх төлбөр нь 28.000₮ /Хүснэгт 1/ гэж тогтоосон байдаг. Үүнийг нэмэгдүүлж, үйлчилгээг төрөлжүүлсэн мэргэжлийн түвшинд хүргэх шаардлагатай байна. Энэхүү зардлыг гадны орны туршлага дээр үндэслэн эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалын байгууллагууд, Нийгмийн халамжийн төв, иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаас хуваарилах зарчмаар төсөв бүрдүүлэн ажиллавал бүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гэрийн асрамж үйлчилгээ*

Ашигласан материал:

1. Organization, W. H. (2010). *Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан*. USA.
2. *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагаа*. (2020). Улаанбаатар.
3. Хөдөлмөр, х. ү. (2018). *Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, журмын эмхэтгэл*. УБ.
4. Ч.Дэлгэрмаа. (2021). *Хөгжлийн туслалцаа НҮТББ-ын 2020, 2021 оны ажлын гүйцэтгэлийн тайлан*. УБ.
5. ХНХЯ (2017). *Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ*. УБ.

БАЙНГЫН АСАРГААТАЙ АХМАД НАСТНЫ ТЭТГЭВЭР, ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛД

Б. Энхтуяа¹

¹БГД 22-р хорооны иргэн

bayandorj@gmail.com

Үндэслэл

Би энэхүү илтгэлээрээ бусдын асаргаанд байж суралцсан, бас тийм байдлаар хөдөлмөрлөсөн ахмад настанд олгож буй тэтгэвэртэй холбоотой асуудлыг хөндөж, түүнийг шийдэхэд ямар боломжит гарц байгааг хайж олохыг оролдлоо. Миний бодлоор бол бодит амьдралд суурилсан бодлогыг үндэслэж одоогийн мөрдөж байгаагаас арай илүү боловсронгуй аргачлалыг хэрэглэх замаар сайжруулах боломжтой гэж үзэж байна.

Зорилго

Манай улсад болж бүтэж байгаа зүйл багагүй байгаа. Бас болж бүтэхгүй зүйл ч их. Үүний ихэнх шалтгаан нь орчны хүртээмжээс хамааралтай. Үүнийг хуульчилсан байдаг ч түүнд заагдсан стандарт, ёс зүйн хэм хэмжээг бүрэн дүүрэн хэрэгжүүлдэггүй. Үүнд хяналт тавьж, “Хүний эрх”-ийг нийтлэг хүрээнд дээдэлдэг болох хүртэлх шилжилтийн үед “Цөөнх”-өө золиослохгүй байх “Ээлтэй” бодлого хэрэгтэй тул энэ судалгааг хийв.

Материал ба арга зүй

Би гэхэд л амьдралынхаа бүх хугацааг саа өвчтэйгээр өнгөрүүлж байна. Ер нь хүмүүс янз бүрийн шалтгаанаар эмгэг согогтой болдог. Гэвч бидний хүчин чадлаас давсан асуудал алхам тутамд байнга тулгардаг. Энэ бүхнийг дүгнэж үзээд үр дүнг боловсруулав.

Үр дүн

Би сургуульд явахдаа дулааны улиралд үүрүүлдэг, бусад үед чарганд суугаад чирүүлдэг хүүхэд байсан. Цастай хүйтэнд бүсэлхийнээс доошх бие минь битонтой ус шиг хүйтэн болчихдог. Мөн сургуулийн хашааны буланд байх банзан жорлонд орж чадахгүйгээс ууж идэхээ зохицуулж өглөө уусан аяга цай, зүсэм талхаар бүтэн өдрийг өнгөрүүлж явсаар өлмөн зэлмүүнд дассан. МУИС-д сурахаар хотод ирэхэд орон нутагт байсан шигээ чаргаар явах боломжгүй учир 2 таяган дээр бүх биеэ ачааллаж явахад суга байнга шархалж шархнаасаа байсхийгээд л халуурдаг байсан. Автобусны өндөр гишгүүр өөд гарч чадалгүй чирэгдэж амь насаа гээх шахсан. Хоёр гарны тамир цуцаад тэргэнцэрт суух болсон. Сургуулиа төгсөөд ажил эрхэлсэн ч шүд зуун тэсвэрлэх зүйлс тулгарсаар байсан. Тэргэнцэртэй хүнд зориулсан зам байхгүй учир машинтай зэрэгцэн явахад шатахууны үнэрт дотор эвгүйрч толгой өвддөг, бас айдастай. Эрдэмтэдийн судалснаар нам дор төвшинд хорт бодис, утааны нягтаршил их учир бага насны хүүхдийг тэвэрч явахыг зөвлөдөг юм билээ. Гэх мэтээр хүн бүрийн эмгэг согоогоос хамаарч тулгарах асуудал олон дэс болно. **Энэ бүхнийг би хүнд, хортой, эрсдэлтэй өөрөөр хэлбэл хэвийн бус нөхцөл гэж үзэж буй юм.** Монгол улсын хэмжээнд

мөрдөгдөж буй тэтгэврийн хуулинд 20 жил ажилласан эрэгтэй 60 насандаа, эмэгтэй 55 насандаа бүрэн тэтгэвэр тогтоолгох эрхтэйг, 20-н жилийнхээ насандаа хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгохоор мөрдөж байгаа. Байнгын асаргаатай биднийг энэ нөхцөлд хамруулвал эрх тэгш байдал нь хангагдана гэж бодож байна. Бидний ихэнх нь богино насалдаг. Энхэл донхол зам, эрсдэлтэй шат довжоо, эд эсдээ шаардагдах хэмжээний хоол хүнс хэрэглэх боломжгүй зэрэг эрүүл аюулгүй амьдрах эрх зөрчигдсөнөөс бөөр өвдөх, холголт цооролт үүсэх гэх мэтээр хүндрэл тулгардаг. Саад бүхнийг давж гараад тэтгэвэр тогтоолгохоор хөдөлмөрийн чадвар алдсан жил тутамд 1%-иар нэмэгдэл тооцож олгодог заалтанд хамрагдаж гэвч түүнийг хүртэх нас нь гүйцэх үү. Энгийн хүнээс хэд дахин илүү хүчин чармайлт гаргачхаад эцэст нь үр шимийг үзэх боломж бүрдэхгүй байгаа нь асуудал юм.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн нөхцөл ажилласан жилээр

д/д	Хөдөлмөрийн нөхцөл	Хүйс	Нас	Ажилласан байх хугацаа
1	Хортой	Эр	50	10
		Эм	45	10
2	Хүнд	Эр	55	12,6
		Эм	50	10

Дүгнэлт

Угтаа "Хөгжлийн бэрхшээл"-тэй хүн гэж байдаггүй. Бидний амьдарч буй нийгэм хөгжлийн бэрхшээл гэдгийг үүсгэж байна. Иймээс насан туршийн эмгэг согогтой иргэн хэвийн бус нөхцөлд боловсрол мэргэжил эзэмших, хөдөлмөр эрхлэх, түүний насжилт, ахмад настны тэтгэвэр гээд хоорондоо харилцан хамааралтай энэ цогц асуудлыг бодит амьдралд суурилсан бодлогоор зохицуулах, тухайлбал:

1. Байнгын асаргаатай хүний мэргэжил эзэмшихээр суралцсан хугацааг ажилласан жилд оруулж тооцох.
2. Байнгын асаргаатай үедээ биеэр ажилласан хугацааг хэвийн бус нөхцөлөөр тооцон 1,5 коэффициентээр зохицуулан өсгөх.
3. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан

Хүснэгт 2.

д/д	Эрэгтэй	Эмэгтэй
нас	50	45

Насанд нь тэтгэвэрт гаргахыг Монгол улсын засгийн газраас авч хэрэгжүүлбэл энэ нь "Хүн" бүрд ижил боломж олгох, амьдралын чанарт өөрчлөлт оруулах, үнэ цэнэтэй нэгэн байхад нь нэлээн хувь нэмэр болох чухал шийдвэр болох юм.

Түлхүүр үг: Хэвийн бус нөхцөл, ажилласан жил, боловсронгуй аргачлал, зохицуулах коэффициент

Ашигласан материал.:

1. Монгол улсын хөдөлмөрийн хууль
2. Монгол улсын нийгмийн даатгал хууль
3. Монгол улсын тэтгэврийн хууль

ХҮНИЙ ХӨГЖИЛ БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

Д.Батзаяа¹

¹“Элэгсэг оршихуй” ТББ

zaya87654@gmail.com

Үндэслэл

Хүн ямар нэгэн согог эсвэл өвчтөн болсноор эдгэрэх найдвараа алдаж, ичиж зовон нуугдмал, ганцаардалд орж нийгмээс хөндийрч байдаг. Тэд ажил орлогогүй, хүний асрамжид тэжээн тэтгүүлж байгаа гэж өөрийгөө буруутган сэтгэлийн тэнхээгүй, гутранги үзэлд автдаг. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүл, хамт олонд түшиглэн хүмүүсийн нэгэн адил хүн ёсоор сурч, хөдөлмөрлөж амьдрах нөхцөл боломжийг түгээн нийгэмшүүлэх шаардлага нэн тулгамдсан асуудал болоод байна.

Зорилго

Хүмүүс эхлээд тодорхой чадавхтай, нийгэмшсэн байх шаардлагатай. Тухайн хүн нь хөгжлийн бэрхшээлтэй ч мэдлэгтэй, ур чадвартай, амьжиргааны боловсон түвшинд амьдарч байна гэдэг бол хүний чадавхтай байна гэсэн үг. Хүний чадавхыг сайжруулахын тулд хоол хүнс, эрүүл мэндийг хангах эм, тоног төхөөрөмж, боловсрол зэрэг зүйлсийг хүртээмжтэй болгон сайжруулах хэрэгтэй.

Материал ба арга зүй

Статистик судалгаануудын тайлан, сайтууд (www.legalinfo.mn, www.legaldata.mn, www.google.mn, Хүний эрхийн үндэсний комисс), илтгэлүүд, нийгмийн социал медиа орчны мэдээллүүдэд шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн

Бусад хүмүүстэй зэрэгцэн ажиллах чадавхтай хүн хүртэл бий нь тодорхой. Манай дэлхийд ойролцоогоор 1,2 тэрбум орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг. Энэ нь нийт хүн амын 15 хувийг эзлэж байгаа нь бага тоо биш.

Хүснэгт 1. МУ-ын ХБИ-ийн тоо

Төрөл \ Он		2017	2018	2019	2020
Харааны	Бүгд	11,071	11,534	11,690	11,871
Сэтгэцийн	Бүгд	19,733	20,364	20,728	20,742
Хэл ярианы	Бүгд	4,228	4,299	4,137	4,060
Сонсголын	Бүгд	8,554	8,445	8,585	8,708
Хөдөлгөөний	Бүгд	20,688	21,614	21,545	21,810
Хавсарсан	Бүгд	7,842	7,288	7,334	7,678
Бусад	Бүгд	31,514	32,064	33,107	33,530
Бүгд		103,630	105,565	107,075	108,399

Бид амжилтад хүрэхийн тулд хүний хөгжлөө хоёр талтай авч үзэх хэрэгтэй байна. Үүнд нэгдүгээрт эрүүл мэнд, мэдлэг боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, хоёрдугаарт олж авсан чадвараа хүн өөрөө хэр ашиглаж байна вэ гэдгээ хянах хэрэгтэй. Өрсөлдөх, манлайлах чадвартай, нийгмийн идэвхтэй, шийдвэр гаргах төвшинд хүрч байж амжилтад бусдыгаа хөтлөх, хоорондоо харилцан мэдээлэл солилцох чадвартай болгоно. Хамтын ажиллагаагаар хөдөлбөл нийлж суугаад хоёр, гурван сэдэв судлах биш бүгдээрээ бие биендээ сурсан мэдсэнээ хуваалцах мөн улс, олон нийтийн байгууллагууд болон салбар бүрийн төрийн бус байгууллага хамтран хэрэгжүүлэх ажлуудын өргөн хэмжээний хэрэгцээ, шаардлага байна. Энэхүү үйлдлийг цахимаар нээлттэй хийснээр сүүлийн үеийн бүгд оролцож чадах бусад иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тодорхой ойлголтыг бий болгож тэдэнд хандах хандлага яваандаа сайжрах болно. 21-р зуун бол техник технологи, мэдлэг мэдээллийн эрин үе билээ. Бидний эргэн тойронд өдөр бүр хүмүүсийн ажил амьдралыг илүү сонирхолтой, бүтээмж өндөртэй болгох, сайжруулах, алдаа эндэгдлийг арилгаж, аюул ослыг бууруулах техник технологийн шинэ нээлтүүд, шилдэг санаанууд хурдтай төрөн гарч бидний амьдралд бүтээгдэхүүн болон нийлүүлэгдсээр байна.

Дүгнэлт

Хамгийн гол зүйл болох тэгш эрхтэй, хүртээмжтэй орчинд сурч, ажиллаж, амьдрах боломж хомсдолтой байсаар... 1990 онд, 2000 онд, 2010 онд, 2020 онд гээд бодит зүйлсээс жишээ авахад хүний хэрэглээ, хэрэгцээ өссөөр байгаа хэдий ч орчин нөхцөл хэвэндээ оршин буй нь эмгэнэлтэй. Бэрхшээлээ даван туулах сэтгэл зүйн мэдлэг мэдээллийг түгээх, мэргэжлийн зөвлөгөө, тусламж үзүүлэх, сурч боловсрох ээлтэй, таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн компьютер, гар утас, интернетээр хангах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хүсэл, сонирхол хэрэгцээнд тулгуурлан ажил, хөдөлмөр эрхлэх сургалтад хамруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүн бүрд хэрэгцээтэй орчинг шинээр бий болгох, Орон нутгийн бэрхшээлтэй хүмүүст зайны сургалтын хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх, эцэг эхэд бэрхшээлтэй хүүхэдтэйгээ харилцах зөвлөмж, зөвлөгөөг өргөнөөр нэвтрүүлэх шаардлагатай байна. Хамгийн гол нь салбар дундын болох ХНХЯ, ЭМЯ, ГХЯ, БХЯ-ны дэмжлэг, тусалцааг шаардсан асуудал юм.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээл- Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан байдал*

Ашигласан материал:

1. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 469, А/269 дүгээр хамтарсан тушаалын хавсралт. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. "Нээлттэй нийгэм форум"-ын уулзалт, хэлэлцүүлэг, 2021
3. Asian and Oceanian congress of neurology. September 1-6, 1991, Tokyo.Japan.
4. Richard Appleton, Gus Baker, David Chadwick, David Smith. Epilepsy, 1992

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТӨД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

У. Бадамсүрэн¹

*¹Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
233 дугаар дамжааны суралцагч
urnasanbadamsuren@gmail.com*

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох явцдаа хөдөлмөр эрхлэх, бусдаар хүлээн зөвшөөрүүлэх байдал, гэр бүлийн харилцаанд оролцох, гэр бүл зохиох, бие дааж амьдрах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, аюулгүй орчинд амьдрах гэх мэт асар олон тооны хүндрэл бэрхшээлтэй цаг үргэлж нүүр тулдаг. Эдгээр олон асуудлуудаас илтгэгч миний бие хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлт, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтөд тулгамдаж буй зарим асуудлын талаар авч үзсэн. 20-с дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 32,8% нь огт гэрлээгүй, 14,9% нь салсан буюу бэлэвсэн амьдралтай байна. Тэдэнд гэр бүл төлөвлөлт нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг дутмаг байгаагаас гадна олон нийт, эмч мэргэжилтнүүд тэдний хүүхэд төрүүлэх, хүнтэй гэрлэх эрхтэй мэдрэмжтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй хандлагатай холбоотой. Энэхүү илтгэлээрээ харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтийн талаар судалгаа хийж дүгнэлт санал дэвшүүлсэн болно.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлт, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтөд тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Материал ба арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа Мэдээллийн лавлах, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос гаргасан тоон мэдээлэл, Хас банк иргэд олон нийттэй харилцах мэдээллийн сан, Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллүүдэд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн

Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд харааны бэрхшээлтэй иргэдэд гэр бүл төлөвлөхөд хангалттай хэмжээний мэдээлэл дутмаг, төлөвлөлгүй гэр бүл болдог байна. Гэр бүлээ төлөвлөхөд гадны болон, хэн нэгний албадлагын аргаар гэр бүл болдоггүй ба өөрсдийн дотны танилаар дамжуулан дотносож болон өөрийн амьдарч буй хүрээллээсээ гэр бүл болдог. Дуу хоолойны өнгөөр харилцан бие биедээ татагддаг. Харааны бэрхшээл гэдэг бусад хөгжлийн бэрхшээлээс хамгийн хүнд бэрхшээл. Хүн насан туршдаа нийгмийн нэгэн хэсэг байж нийгэмшсээр байдаг. Хараагүй иргэдийн хувьд нийгмийн олон төрлийн харилцаанд орох боломж бага

үүгээрээ ч жирийн иргэд шиг нийгэмшиж хангалттай чадахгүй. Нийгмийн харилцаанд орохын хэрээр хүн бусадтай харилцаа холбоо үүсгэн хүрээлэл тэлсээр байдаг боловч судалгаанд оролцогчдын 72.4 % нь нийгэмдээ бага буюу огт оролцдоггүй байна. Харааны бэрхшээлтэй иргэд гэр бүлийн хүнээ сонгохдоо өөрийн сонсох мэдрэмж дээрээ тулгуурлан эсвэл танилын тусламжтайгаар гэр бүлээ сонгож байна.

Дүгнэлт

2016 оны 02-р сарын 5-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийг арван хоёр бүлэг дөчин таван зүйлтэйгээр баталсан. Энэхүү хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэмд оролцох бүхий л эрх, ашиг сонирхлыг хуульчилсан. Гэвч бидний судалгааны сэдэв нь хуульд тусгагдаагүй байдаг. Яагаад гэвэл гэрлэлт гэдэг нь гэрлэгчдийн сайн дурын болон тэгш эрхийн үндсэн дээр тулгуурладаг тул хүн хэн нэгэнтэй гэрлэх, хамт амьдран суух зэрэг нь амин хувийн харилцаа тул гэр бүл төлөвлөлтийн тухай хуульчилсан заалт байхгүй. Иймд харааны бэрхшээлтэй иргэдийн гэр бүл төлөвлөлтийн талаар гэр бүл болох, амьдрал зохиох гэж буй харааны бэрхшээлтэй залууст гэр бүл болсны дараах үүсэх харилцааг (орон байр авах, сургалтад хамрагдах, хүүхэд төрүүлэх, нийгмийн даатгал төлөх зэрэг) бүгдийг багтаасан хараагүй иргэдийн уншиж чадах (брайл үсгээр) зөвлөмж гарган, нийгэмдээ оролцох идэвхийг нь нэмэх видео, дууг сонсох ажиллагааг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо хийж өгвөл тэд мэдээлэлтэй болж чадна. Харааны бэрхшээлтэй иргэд хүртэхүй болон сонсох мэдрэмж дээрээ тулгуурлан гэр бүлийн амьдралаа сонгодог тул хэрхэн бусдыг таньж мэдэж сурах тал дээр мэдээ мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулан харааны бэрхшээлтэй иргэдийг хамруулбал үр дүнтэй байж чадна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээл, харааны бэрхшээл, гэр бүл төлөвлөлт*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа Мэдээллийн лавлах УБ хот 2017 он.
2. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос гаргасан тоон мэдээлэл УБ хот 2020он
3. Хас банк иргэд олон нийттэй харилцах мэдээллийн сан 2018 он.
4. Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_3300_014V1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=0&Sex_select_all=0&SexSingleSelect=1&YearY_select_all=0&YearYSingleSelect=2018&viewtype=table



III БҮЛЭГ ХӨДӨЛМӨР

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

Дэд.проф. Г.Батцэнгэл¹

¹ МУБИС, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим
tsengee_518@yahoo.com

Үндэслэл

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсрол эзэмших эрх хангах, боловсролын чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд тусгай хэрэгцээт боловсролын багшийг системтэй бэлтгэх, тэдний хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны эрэлт хэрэгцээг судалж хөтөлбөрийг сайжруулах замаар боловсролын үйлчилгээний хэлбэрийг хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулах нь чухал асуудлын нэг болж байна.

Зорилго

МУБИС-ийн “Багш, тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөр”-ийн хэрэгжилт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны эрэлт хэрэгцээ, цаашдын чиг хандлагын байдалд дүн шинжилгээ хийх.

Материал ба арга зүй

МУБИС-ийн “ Багш, тусгай хэрэгцээт боловсрол”- ын хөтөлбөрийн БМИУЗ-д нэгтгэсэн тайлан (2020), 2021 оны 6 сард бакалаврын хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийсэн SWOT шинжилгээ, ТХББ мэргэжлээр 25 төгсөгчдөөс (2019, 2020, 2021 он), УБ хотын 6 тусгай сургууль, цэцэрлэг, ХБХСЗТ, СЗСҮТ-ийн ажил олгогч нараас асуулга, ярилцлагаар авсан мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж, үр дүнг боловсруулав.

Үр дүн

2013 онд “Багш боловсролын шинэчлэл” - ийн хүрээнд БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр тусгай хэрэгцээт боловсролын багш (цаашид ТХББ) бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж улмаар 2013 оны 10 - р сараас ТХББ - ийн (D140300) кодтой 1 жилийн хөрвөх сургалтын үйл ажиллагааг эхлүүлж, 4 удаа нийт 113 багш, 2015 - 2016 оны хичээлийн жилээс ТХББ- ийн 3,5 жилийн бакалаврын (D011406) кодтой сургалтын хөтөлбөрөөр 44 оюутан төгссөн. ИАББ мэргэжлээр нийт 16 сонсголын бэрхшээлтэй оюутан төгсч 62,5 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна. 2021- 2022 оны хичээлийн жилийн байдлаар 1-4 - р ангид нийт 59 оюутан суралцаж байна. Багш, тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөр нь 2020 оны 6-р сард Хөтөлбөрийн Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн хурлаар 2025 он хүртэл 5 жилийн хугацаатай амжилттай магадлан итгэмжлэгдсэн. Бид, төгсөгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тусгай боловсролын чиглэлээр гүнзгийрүүлэн мэргэшүүлэх зорилгоор “Хэл заслын үндэс” 3 кр нэмэлт сургалтын хөтөлбөр шинээр боловсруулан сертификатын, БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр “Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалтыг ОХУ-ын Эрхүүгийн ИС-ийн хэл засалч профессор багштай хамтран зохион байгуулж багш, төгсөгчдөө хөгжүүлсэн. Хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлийг хөгжүүлэх үүднээс 2019-2020 оны хичээлийн жилээс “Тусгай хэрэгцээт боловсрол” - ын магистрын сургалт эхлүүлснээр төгсөгчид

суралцаж байна. Тэнхимийн багш нар 2015-2016 оны хичээлийн жилээс “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс “ 2 кр сонгон судлах хичээлийг багш мэргэжлийн суурийн ангид зааж байна. Төгсөгчид, багш, оюутнуудыг судалгаа шинжилгээний ажилд сургах зорилгоор багш, судлаачдын (2 удаа) болон оюутны (3 удаа) ЭШХ-ыг зохион байгуулж эмхтгэл гаргадаг уламжлалтай болсон. 2021 оны 4-р сард ТХББ, мэргэжилтэй 24 төгсөгчдөөс хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийн ажлын байранд тавигдаж буй шаардлагыг хангаж буй байдал, хөтөлбөр хэрэгжилт, түүнийг сайжруулах талаарх санал хүсэлтийг тодруулах зорилгоор асуулга, ярилцлагын аргаар судалгааг “КОВИД-19” цар тахлын улмаас хөл хорио тогтоосон нөхцөлд цахимаар авч дүн шинжилгээ хийсэн. БМИУЗ-ийн тайлан болон судалгааны зарим үр дүнгээс авч үзвэл:


ТХББ мэргэжлээр УБ хотын тусгай цэцэрлэг, сургуульд ажиллаж буй төгсөгчид

№	Тусгай сургуулиуд	1 жилийн хөрвөх	3,5 жилийн бакалавр	Нийт
1.	25 - р тусгай сургууль	18	-	18
2.	29 - р тусгай сургууль	9	-	9
3.	55 - р тусгай сургууль	13	6	19
4.	63- р тусгай сургууль	17	4	21
5.	70- р тусгай сургууль	7	6	13
6.	116- р тусгай сургууль	4	-	4
7.	186-р тусгай цэцэрлэг	3	-	3
	Бүгд	71	16	87

Хүснэгт 1. Хамгийн олон буюу 71 төгсөгчид (ТХББ- ийн 1 жилийн хөрвөх) УБ хотын хараа, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд дохионы хэл, туслах, үндсэн багшаар ажиллаж байна.

1. ТХББ мэргэжлээр суралцах хугацаанд олж авсан мэдлэг, чадвар, хандлага Таны ажлын байран дээр

хэр зэрэг хэрэг болж байна вэ?
 Зураг 1- ээс харахад судалгаанд оролцсон төгсөгчдийн хамгийн их буюу нийтдээ 87 хувь нь маш ихээс, их хэрэг болж байна, хамгийн бага 4 хувь нь зарим талаар хэрэг болж байна гэж үзсэн байна.



Та, төгссөн мэргэжилдээ хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?

Зураг 2-оос харахад төгсөгчдийн хамгийн их буюу 96 хувь нь мэргэжилдээ маш их, их сэтгэл ханамжтай, 4 хувь дунд зэргийн сэтгэл ханамжтай байна.

Кейс 1: Нийслэлийн 63- р тусгай сургуулийн сургалтын менежер О. Мөнхцэцэг: МУБИС-ийн ТХББ мэргэжлээр төгсөөд тус сургуульд ажиллаж буй багш нарын байдалд “хангалттай” үнэлгээг өгч байгаа. Тусгай хэрэгцээт сурагчидтай ажиллахад тэдний хөгжлийн онцлогийг шинжлэх ухааны үндэстэй судалж, таньж мэдсэн байгаа нь хичээл зааж буй арга барил, нэгж ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж буй чадвар, арга зүй, хөтөлбөрийн тохиргоо хийж чадаж байгаагаас харагддаг. Оюутнууд заавал тусгай сургууль цэцэрлэг дээр урт хугацааны дадлагыг чанартай хийснээр цаашид төгсөөд шууд тэгш хамрагдаж буй сурагчидтай ЕБС дээр ажиллахад бэрхшээл бага тулгарна гэсэн саналтай байна. 2 дугаар курсээс нь хэл засал, хараа, сонсгол, оюун ухаан гэх мэтээр сонгож мэргэшүүлэх боломж байдаг бол илүү оновчтой санагдаж байна...

2022 оны 1 сард 25 оюутан төгсөхтэй холбогдуулан ажил олгогчдоос ажлын байрны эрэлт хэрэгцээний судалгаа авахад боловсролын 5 байгууллагаас нийт 15 туслах болон үндсэн багш захиалсан нь төгсөгчдийн 60 хувь хөдөлмөр эрхлэх боломжтой нь харагдаж байна. БСШУЯ - ын сайдын 2019 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” А/292 тоот тушаал гарсантай холбоотойгоор сүүлийн 2 жилд ЕБС-д суралцах боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн тоо нэмэгдэх болсон, тэдэнтэй ажиллахад тулгамдсан асуудал нэлээдгүй гарч байгаа, ТХББ – ийн эрэлт хэрэгцээ үүссэн талаар сургуулийн удирдлага, сэтгэл зүйч, багш нарын зүгээс ярьж байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай боловсролын мэргэжлийн багш хомстсон нөхцөлд үндэсний мэргэжилтэн багш нарын дэмжлэгтэйгээр өөрийн оронд ТХББ - ийн 1 жилийн хөрвөх, 3,5 жилийн бакалаврын сургалтаар нийт 157 багшийг бэлтгэсэн нь тусгай боловсролын салбарт гарсан ахиц дэвшлийн нэг болсон. ТХББ мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өндөр 86,2 хувьтай, төгсөгчдийн 96 хувь нь маш ихээс, их, мэргэжлийн сэтгэл ханамжтай, ажлын байрны эрэлт хэрэгцээ их байгаа, ЕБС-д ТХББ ажиллах шинэ эрэлт хэрэгцээ үүсч байгаа, цаашид ч нэмэгдэх хандлагатай талаар ажил олгогч сургуулийн захирал, сэтгэл зүйч, эцэг эх, багш нартай хийсэн ярилцлага, мэдүүлэг, санал хүсэлтээс харагдаж байна. Багш, тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөрөөр оюутанд олгож буй мэдлэг, чадвар, хандлага нь төгсөгчдийн ажлын байранд, хамгийн их буюу 74-87 хувь маш ихээс, ерөнхийдөө нийцсэн, хамгийн бага буюу 4-9 хувь нь зарим талаар нийцэхгүй байна гэсэн хариулт өгч байгаа нь хөтөлбөр зорилго, зорилтоо хангаж байна, цаашид нийцэхгүй байгаа зарим асуудлыг тодруулж, тэгш хамруулах боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр олон талт дэмжин туслах үйлчилгээ үзүүлэх хөрвөх чадвартай багш мэргэжилтэн бэлтгэх чиглэлд анхаарч хөтөлбөрийн сайжруулалтыг үе шаттай хийх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Түлхүүр үг: *Ерөнхий боловсролын тусгай сургууль, цэцэрлэг, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, ажлын байр, мэргэжлийн сэтгэл ханамж.*

Ашигласан материал:

1. Батцэнгэл.Г, Байгалмаа Ч, (2018) “Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэж буй байдал”, ТХБ багш, онол практикийн асуудлууд ЭШХ - ын эмхтгэл, Улаанбаатар
2. Батцэнгэл.Г, Золзаяа.Б, (2021) “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс сонгон судлах хичээлийн явц, үр дүн”, Тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын онол ба практик үйл ажиллагаа” ЭШХ - ын эмхтгэл, Улаанбаатар
3. “Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хөтөлбөр” өөрийн үнэлгээний тайлан УБ, (2021) Улаанбаатар

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛСАН НЬ

О.Жаргалсайхан¹, Б. Ундрахболор, Б. Пүрэвбаатар, Н. Лүндааренчин²
¹МУБИС. доктор (Ph.D), ²МУБИС-БоСС НААЗТ-ийн 4-р курс
uundrah247@gmail.com

Үндэслэл

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, үр дүн, бүтээмжид ажлын сэтгэл ханамж чухал нөлөөтэй. Иймд тэдний ажиллаж буй орчин нөхцөл, ажил үүрэг, цалин урамшуулал, ажил амралтын цаг, ажлын байрны хангамж, удирдлага, хамт олны харилцаа хандлага зэрэгт хэр сэтгэл ханамжтай байгааг судлан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ажил олгогчдод тулгарч буй асуудал бэрхшээл, шийдэл, гарцуудыг шинжлэн тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсч байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын сэтгэл ханамж түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж илрүүлэх.

Материал ба арга зүй

Судалгаанд Улаанбаатар хотод ажиллаж, амьдардаг 30 ХБИ-ийг хамрагдсан. ХБИ-ийн ажлын сэтгэл ханамжийн судалгааны мэдээллийг 8 дэд бүлэг, нийт 27 өгөгдөл бүхий асуулгаар цуглуулж, IBM SPSS 25 програм дээр нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн. Мөн ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, ажлын байрны сэтгэл ханамж, цаашдын хэрэгцээг тодорхойлох зорилгоор 10 ажил олгогчтой ганцаарчилсан ярилцлага хийж, үр дүнг боловсруулсан.

Үр дүн

Ажлын сэтгэл ханамж

1- сэтгэл ханамж маш муу. 2-сэтгэл ханамж муу. 3-сэтгэл ханамж дунд. 4-сэтгэл ханамжтай. 5- сэтгэл ханамж өндөр

	Дэд шалгуур	Дундаж	SD
1	Ажлын ачаалал, ажилдаа хандах хандлага	3.80	1.31
2	Карьер хөгжил	3.07	1.38
3	Ажлын орчин нөхцөл	3.29	1.30
4	Удирдлагын арга барил	3.78	1.52
5	Хамт олны уур амьсгал	3.44	1.10
6	Хөдөлмөрийн хөлс, цалин	2.87	1.17
7	Байгууллагдаа хандах хандлага	3.30	1.39
8	Шагнал, урамшуулах	3.04	1.35
АЖЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ		3.32	1.21

Судалгааны асуулгыг сэтгэл ханамжийг тодорхойлох 8 бүлэгт хувааж 1-5 оноогоор үнэлүүлсэн. Судалгаанаас үзэхэд ажлын ачаалал, ажилдаа хандах хандлага болон удирдлагын арга барилд сэтгэл ханамж хамгийн өндөр оноотой гарсан бол хөдөлмөрийн хөлс, цалин болон шагнал, урамшуулалд сэтгэл ханамж доогуур гарсан байна. Үүнээс үзвэл хөдөлмөр эрхэлж буй ХБИ-д ажлын орчин нөхцөл гэхээсээ илүүтэй ажлын цалин хөлс, шагнал урамшуулал, карьераа хөгжүүлэх боломжид сэтгэл ханамж доогуур байгаа бөгөөд нийлбэр оноо 3.32 буюу сэтгэл ханамж дундуур гарсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын сэтгэл ханамжийг хүйс, боловсролын төвшин, ажилласан жил зэргээр харьцуулахад бүлгүүдийн хооронд ялгаатай үр дүн ажиглагдаж байна.

Дүгнэлт

Хөдөлмөр эрхэлдэг ХБ-тэй иргэд ихэвчлэн дээд боловсролтой иргэд байгаа бөгөөд боловсролын төвшин дээшлэх тусам ажлын сэтгэл ханамж нэмэгдэх хандлагатай байна. Мөн хүйс болон ажилласан жилээс хамаарч тэдний ажлын сэтгэл ханамж ялгаатай байгаа нь анхаарал татаж байна.

ХБИ хөдөлмөр эрхлэхэд ажлын орчин нөхцөл, дэд бүтэц, хамт ажиллагсдын харилцаа хандлага, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны олдоц хүрэлцээ, эрүүл мэнд зэрэг олон асуудал нөлөөлж байна. Иймд наад зах нь ХБ-тэй хүний талаар иргэд олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа хандлагыг нь өөрчлөх зэрэгт анхаарал хандуулахаас эхлээд хэрэгцээ шаардлага их байна.

ААН байгууллагуудын хувьд ХБИ-ийг ажилд авахад төдийлөн асуудал бэрхшээл гардаггүй ч гагцхүү тэдэнд зориулсан ажлын байрны тусгай тохируулга хийхэд хүндрэлтэй байна. Үүнд, ААН байгууллагатай хамтран ХБИ-ний онцлогт тохирсон ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах тал дээр төрийн дэмжлэг оролцоо чухал. Түүнчлэн, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, тухайлбал, ААНБ, ажил олгогчдыг дэмжсэн татварын орчин, урамшууллын бодлогыг боловсронгуй болгох зэрэг тодорхой ажлуудыг төрөөс хийж хэрэгжүүлэх шаардлагатай.

Түлхүүр үг: Сэтгэл ханамж, хөгжлийн бэрхшээл, хүртээмжтэй байдал, ажил хөдөлмөр

Ашигласан материал:

1. О.Мягмар (2016). *Хүний хөгжлийн лекцүүд*. Улаанбаатар хот.
2. УИХ (1999). *Хөдөлмөрийн тухай хууль*. УИХ.
3. УИХ (2011). *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль*. Төрийн ордон.
4. УИХ (2016). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*. Төрийн ордон.
5. ХНХЯ (2021). *Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2021 i-р улирал*. Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

С.Цэрэндулам, М.Мичидмаа, Ц.Уянга¹

*¹Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
santserendulam@gmail.com*

Үндэслэл

Судалгааны ажлаар 2019 оны Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн сангаас Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дугаар заалтыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тоон мэдээнд шинжилгээ хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах өнөөгийн боломж, бололцоог тооцоолсон явдал юм. НДЕГ-ын мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2018 онд 7.2 мянга, 2019 онд 7.7 мянга байна. 2019 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж байгууллагын 3.4 мянга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байна.

Зорилго

Судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой захиргааны тоо мэдээнд дүн шинжилгээ хийхэд оршино.

Материал ба арга зүй

Судалгааны ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг холбогдох байгууллагуудаас цуглуулж нэгтгэсэн. Холбогдох тоон мэдээлэл дээр үндэслэн харьцуулалтын аргыг ашиглан мэдээллийг шинжилж дүгнэлт хийсэн.

Үр дүн


НДЕГ-ын мэдээгээр 2019 оны байдлаар 25 ба түүнээс дээш ажиллагчидтай нийт 7 766 ААНБ байгаагаас 3 423 нь буюу 44.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ААНБ-уудын 63.1 хувь нь орон нутагт, 36.9 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын 62.1 хувь нь төрийн, 31.2 хувь нь хувийн, 6.7 хувь нь орон нутгийн өмчит ААНБ байна. Нийт нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 3 423 ААНБ-д 3 805 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа бөгөөд хуулийн дагуу ажилбал зохих ХБИ-ийн орон тоо нь 18 551 мянга байна. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд энгийн ажил, мэргэжил болон мэргэжилтэн, менежерээр ажиллах нь хамгийн түгээмэл байгаа бол техникч, үйлдвэрлэл, барилга, машин механизмтай холбоотой ажил мэргэжил эрхлэх нь бага хувьтай байна.

График 1. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай нийт ААНБ-ын өмчийн хэлбэр, байршлаар




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

График 2. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилтц, салбараар, 2019 он



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

График 3. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилт, аймгаар, 2019 он



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж буй ААНБ, 2019 онд нийт 7 766 ААНБ-д 8 697 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. 25 - түүнээс дээш ажиллагчидтай 3 423 ААНБ-д 3 805 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байна. 25-аас дээш ажилтантай нийт ААНБ-ын нийт ажилтны тоо 481.0 мянга, Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын дагуу ажиллах боломжтой ХБИ-ийн орон тоо 18 551, хөгжлийн бэрхшээлтэй ажиллаагүй орон тоо 14 746 байна. Хуулинд заасан ажил олголтын квотыг харвал биелэлтийн хувь өндөр салбар нь ус хангамж 94.7%, боловсрол 87.3%, эрүүл мэнд 54.3% байсан. Нөгөө талаар ус хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ийн тоо боловсрол болон эрүүл мэндийн салбартай харьцуулахад маш цөөхөн байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн биелэлтийн хувь бага салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 24.9%, барилга 28.0%, уул уурхай 29.0%-ийн дараалалтай байсан. ХБИ-ийг ажиллуулж буй хуулийн этгээдийн тоо нь боловсролын салбарт ойролцоогоор 1000 ААНБ болох хамгийн их, төрийн байгууллага 400, эрүүл мэнд болон үйлдвэрлэлийн салбарт 200 орчим ААНБ, бөөний болон жижиглэнгийн салбарт 200 хүрэхгүй ААНБ-ууд байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөдөлмөр эрхлэлт, хуулийн хэрэгжилт*

Ашигласан материал:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2012 оны 01 19). Нийгмийн халамжийн тухай хууль. Монгол улс.
2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn
3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын захиргааны тоон мэдээ

СЭРГЭЭН ЗАСАЛТ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, УР ЧАДВАР ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

¹Н.Ундрал

*¹Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв
undralnyamsuren@gmail.com*

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй гэж тусгасан байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх ашиг, ажлын байртай болох боломж хомс хэвээр байна.

Зорилго

Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт болон ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг тодорхойлох хэрэгцээтэй байгаа учраас энэ судалгааг хийж гүйцэтгэлээ.

Материал ба арга зүй

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа урьдчилан бэлдсэн асуулгын хуудас,

Судалгааны арга

Өмнө хийгдсэн судалгаа болон дүн шинжилгээний аргаар хийсэн.

Үр дүн

Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг тодорхойлох

Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 61,7% нь мэргэжилдээ дуртай сонирхолтой гэж хариулсан бол 23,6 % нь эцэг эх, гэр бүл, найз нөхөд нь санал болгосноор мэргэжлээ сонгосон бол үлдсэн 14,7% нь бэрхшээлээс шалтгаалан мэргэжлээ сонгож суралцаж төгссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэргэжилээ сонгохдоо мэргэжлийн эрэлт болон тэтгэлэг, санхүүгийн хөшүүрэг, хүртээмжийн асуудлыг харгалзан үзэж суралцах хандлагатай буюу 7,4 %-ийг эзэлж байна. Судалгаанд оролцогч төгсөгчдийн дийлэнх нь мэргэжил эзэмшихээс гадна, нийгэмших, олон нийтийн харилцаанд оролцох сонирхолтой байдаг байна.

Хүснэгт 1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь

№	Мэргэжлийн чиглэл	Хичээлийн жил			
		2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020
1 жилийн сургалт					
1	Тогооч	66%	72%	66%	16%
2	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	81%	63%	71%	25%
3	Модон эдлэлийн мужаан	75%	55%	33%	66%
4	Бэлэг дурсгалын зүйл урлаач		80%	0%	12%
5	Гар утас, телефон аппаратын засварчин		57%	33%	33%
2,5 жилийн сургалт					
6	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	66%		60%	
7	Хэвлэлийн график дизайнч	81%		69%	81%
8	Вэб техникч	50%	Элсэлт аваагүй		
	Гутал засварчин	100%	Элсэлт аваагүй		
Захиалгат сургалт					
9	Киттельчин	Элсэлт аваагүй		100%	
10	Сүлжмэлийн үйлдвэрлэлийн технологийн ажилтан	Элсэлт аваагүй			100%
Нийт хөдөлмөр эрхлэлтийн хувь		72%	65%	56%	45%

Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн сүүлийн 4 жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн авч үзвэл 2016-2017 онд нийт ажил хөдөлмөр эрхэлж буй төгсөгч 72 хувьтай байсан бол 2017-2018 онд 65 хувьтай болж буурсан байна. 2018-2019 онд нийт хөдөлмөр эрхлэлт 56 хувьтай байсан бол 2019-2020 онд 45 хувь болон буурсан байна. Шалтгаанаар нь авч үзвэл бусад төрлийн шалтгаанаар ажил хайхгүй байгаа төгсөгчид 40 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин өвчтэй болон жирэмсэн, хүүхдээ харж байгаа одоогоор ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй иргэд 14 хувийг эзэлж байна. Мөн барилга байгууламжийн болон ажлын орчин, хөдөлмөрийн нөхцөлийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй төгсөгчид 20 хувийг эзэлж байна. Судалгаанд нийт 20 ажил олгогч хамрагдсан бөгөөд түүний 60 хувь нь байгууллагын хүртээмжийн асуудалтай бол 40 орчим хувь нь ажлын бүтээмж муу гэж тодорхойлжээ. Мөн судалгаагаар 30 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн сэтгэл санааны хувьд тогтворгүй, бусад ажиллагч нартай нийцтэй биш гэсэн хариулт өгсөн бол 50 орчим хувь нь илүү цагаар ажиллуулахад хүндрэлтэй байдаг гэсэн байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс илүү татвар, торгуулийн арга хэмжээг сонгодог байна.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 39 хувь нь одоогоор ямар нэг ажил хөдөлмөр эрхлээгүй бөгөөд 11 хувь нь хувиараа бизнес эрхэлж байна. Мөн 7 хувь нь төвшин ахиулахаар тухайн сургуульдаа суралцаж байгаа бол 5 хувь нь суралцаж төгссөн мэргэжлээрээ мэргэжил дээшлүүлж байна. Судалгаанд хамрагдсан ажил хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 34 хувь нь хувийн байгууллагад хөдөлмөр эрхэлж байна. Ажил эрхэлж буй хүмүүсийн хувьд ихэвчлэн туслах ажилтан, цагийн ажилтан, бэлтгэгч зэрэг албан тушаалууд дээр ажиллаж байна.

Ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг авч үзвэл бусад төрлийн шалтгаанаар ажил хайхгүй байгаа төгсөгчид 40 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин өвчтэй болон жирэмсэн хүүхдээ харж байгаа одоогоор ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй 14 хувийг эзэлж байна. Мөн барилга байгууламжийн болон ажлын орчин, хөдөлмөрийн нөхцөлийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй төгсөгчид 20 хувийг эзэлж байна. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүй, ажиллах орчны дутагдал байсаар байгаа бөгөөд бусадтай ижил төрлийн үйлчилгээ авах, хөдөлмөр эрхлэхэд саад тотгор үзүүлсээр байгааг энэхүү судалгаа харуулж байна.

Төгсөгчдийн ажил хайхгүй байгаа шалтгаан олон төрөл байгаа бөгөөд бусад төрлийн шалтгаанаар ажил хайхгүй байгаа төгсөгчид 40 хувь, хүртээмжийн асуудлаас болоод ажил эрхэлж чадахгүй байгаа төгсөгчид 20 орчим хувийг эзэлж байна. Иймд тус сургууль нь төгсөгчдийг бойжуулах, ажлын байран дээр гаргахад төвийн харъя Инкубатор төв байх нь зайлшгүй шаардлагатай байна. Солонгос улсын Дэжоны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжил олгодог тус төвтэй ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь сургуулийнхаа дэргэд Инкубатор төвийг бий болгон ажилласнаар хүнд хэлбэрийн оюуны бэрхшээлтэй иргэдийг үйлдвэрлэлийн орчинд ажиллуулах боломжтой болсон сайн жишээ байна.

Түлхүүр үг: *Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль, хөгжлийн бэрхшээлтэй иргэн*

Ашигласан материал:

1. mlsp.gov.mn Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
2. [Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийн тухай конвенц / НҮБ/
4. Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн Статистик мэдээ
5. Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн төгсөгчдийн Мөшгөх судалгаа

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГ ХАНДЛАГА (БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

Б.Басбаяр¹

¹БШУЯ, Боловсролын Зээлийн Сан
basbayar@elf.gov.mn

Үндэслэл

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн мэдээлснээр 1 тэрбум хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол дэлхийн хамгийн том цөөнх бөгөөд дэлхийн хүн амын 15 орчим хувийг эзэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь чанартай боловсролыг тэгш хүртэхээс эхлээд нийгмийн халамжид бүрэн хамрагдах зайлшгүй шаардлагатай. Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг үзэл санаа өргөжин тэлж, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцох, ажил эрхэлж энгийн хүмүүстэй эрх тэгш ажиллаж, амьдрахад тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгаар хөгжиж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь жирийн иргэдтэй адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, ажил хөдөлмөр эрхэлж, ижил хөлс авах зэрэг үзэл санаанд үндэслэн хөгжиж байна.

Зорилго

Энэхүү судалгаа нь БШУЯ-ны дэргэдэх Боловсролын зээлийн сангийн хэрэгжүүлдэг өөрөө хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийг олгох журмын дагуу хэчнээн тооны өөрөө хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, ямар мэргэжлээр дээд боловсрол эзэмшин, хөдөлмөрийн зах зээлд ямар мэргэжлийн чиглэлээр ажил эрхэлж байгааг тодорхойлох нь оюутанд олгож байгаа буцалтгүй тусламжийн нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа үр ашгаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарт хэр нөлөөлж байгааг харуулах юм.

Материал ба арга зүй

Судалгааг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт Levine, L. (2000, August) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон дээд боловсрол: Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд- ажиллах хүчний бэлтгэл НҮБ-ын хурлын тайлан, Хөгжлийн бэрхшээл ба ажил эрхлэлтэд тулгарч буй бэрхшээл сэдэвт судалгааны ажил зэрэгт баримт бичгийн судалгаа хийж, БЗС-ийн зээлд хамрагдаж төгссөн хөгжлийн бэрхшээлтэй төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаар цуглуулсан мэдээлэлд тоон судалгааны аргаар SPSS програм ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Үр дүн

Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төвшинг харьцуулсан судалгаагаар нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүн амтай (64%) харьцуулахад 30(%) нь ажил эрхэлж байгаа тоон мэдээлэл байна. (<https://www.1212.mn/tables.aspx?>).

Статистик мэдээллийн хувьд дээд боловсрол олгож байгаа их , дээд сургуулиудад БЗС-ийн буцалтгүй тусламжаар суралцаж төгссөн 2014-2018 оны 2,131 төгсөгчдийг хамруулсан судалгаа юм. БЗС-аас өөрийн сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үзүүлэх буцалтгүй тусламжийн хэмжээ, ХБ-тэй оюутны тоо харилцан адилгүй байв. Судалгаанд хамрагдсан оюутан нь бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт суралцаж төгссөн хөгжлийн бэрхшээлтэй төгсөгчид бөгөөд буцалтгүй тусламжид хамрагдан төгссөн .

2016-2021 оны хичээлийн жилүүдэд төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд буцалтгүй тусламжаар суралцаж 2020, 2021 онд төгсөөд хөдөлмөр эрхэлж буй 116 төгсөгч байна. 2020, 2021 онд төгсөөд төрийн өмчийн байгууллагад хөдөлмөр эрхэлж буй өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэдийн 55 хувь эрүүл мэнд, 20 хувь нь боловсрол, 5 хувь нь банк, 20 хувь нь бусад салбарт тус тус ажиллаж байна. (Зураг 1)




График 1. Хөдөлмөр эрхлэлт (чиглэлээр)

Хүснэгт 1-д БЗС-ийн буцалтгүй тусламжид хамрагдсан өөрөө хөгжлийн бэрхшээлтэй дээд боловсролын байгууллагад суралцаж төгсөгчдийн ажил эрхэлж байгаа хувь, төгссөн мэргэжлийн чиглэл, ажил эрхлэлтийн талаар мэдээллийг харуулав. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хамгийн их ажил эрхэлж байгаа салбарууд нь Эрүүл мэнд (29%), Бусад (27%), Боловсрол (18%), Бизнес (9%) байв.

Дүгнэлт

Дэлхий нийтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт, боловсрол эзэмших үйл явцыг дэмжихэд чиглэсэн олон төрлийн санаачилга, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал сайжирч байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажилгүйдэл эрс өндөр хэвээр байж, дээд боловсрол эзэмшээгүй иргэдийн урт хугацааны ажлын байр, орлогын боломж улам бүр муудаж байна. Тэгэхээр дээд боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын эдийн засгийн хэтийн төлөв, бие даах хүсэл эрмэлзлийн түлхүүр болж байгаа нь тодорхой харагдаж байна. Менежмент, боловсрол,

бизнес, эрүүл мэндийн салбарын карьерууд нь бие бялдрын ур чадвар, тэсвэр хатуужил бага шаарддаг учраас хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь энэ төрлийн мэргэжил сонгон суралцаж төгсдөг юм байна. Ажил эрхлэлтийн хувь өндөр байгаа салбарууд нь эдгээр салбарууд байгаагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дээд боловсрол эзэмших, мэргэжил эзэмших, мэргэжлээрээ ажиллахыг илүү их дэмжих хэрэгтэй нь харагдаж байна.

Түлхүүр үг: *Ажил эрхлэлт, салбар, боловсрол, хөгжлийн бэрхшээл*

Ашигласан материал:

1. Gerber, P. J. (n.d.). Gerber, P. J. (1997). Life after school: Challenges in the workplace. In P. Learning disabilities and employment . Austin, TX: Pro-Ed.
2. <https://www.1212.mn/tables.aspx?> (n.d.).
3. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_3300_014V1. (n.d.).oecd.org. (n.d.). <https://www.oecd.org/education/education-at-a-glance/>.
4. ЗГ-ын тогтоол, 2. д. (2016). Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.МУИХурлын тогтоол, 1. д. (2016).
5. Хөдөлмөр эрхлэлт(2012). АНУ, Хөгжлийн бэрхшээлтэй болон нөхөн сэргээх судалгааны үндэсний хүрээлэн .

ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ, ХУГАЦААГ БИЕИЙН ҮЙЛДЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДСААР ҮНЭЛСЭН ДҮН

*П.Мөнхтулга¹, Т.Лхагвадорж², Д.Тэмүүжин, Ц.Гансүх, Д.Анхбаяр, Б.Пүрэвсүрэн,
Н.Нармандах³*

*¹Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах
төв комиссын дарга, ²Нарийн бичгийн дарга, ³Магадлах эмч нар*

Үндэслэл

БҮҮАОУА дээр тулгуурласан хөдөлмөрийн чадвар алдалтын үнэлгээ нь иргэний талаар их хэмжээний мэдээлэл цуглуулах бөгөөд тухайн мэдээлэлд үндэслэсэн оновчтой зөв бодлого боловсруулах, иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тухайн хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тодорхойлохоос гадна, өдөр тутмын хэрэгцээг давхар тодорхойлж, түүнд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай, оновчтой болгох боломжтой байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүд, эмнэлэг хөдөлмөр магадлалын тогтолцоо нь БҮҮАОУА-аар хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход бэлэн бус, тохиромжгүй гэж үзэж байна.

Зорилго

БҮҮАОУА-ын товч үнэлгээний хуудас (checklist) ашиглан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг үнэлэн үр дүнг тооцох, үнэлгээний үр дүнд тулгуурлан БҮҮАОУА-ыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэхэд гарч болох хүндрэл, одоогийн эмнэлэг хөдөлмөрийн магадлалын тогтолцооны давуу тал, сул тал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Материал ба арга зүй

Судалгаанд хамруулах иргэнийг 2020 оны 06 дугаар сарын 12-ноос 07 дугаар сарын 9-ны хооронд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцож буй 1.4.1 заалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдээс авсан болно. Судалгааны үнэлгээний хуудсыг олон улсын судалгааны "ICF research branch" байгууллагаас эрхлэн гаргасан тархины цус харвалтын /Stroke brief core set/ үндсэн бүрдлийг орчуулан бэлдсэн. Үнэлгээний хуудас нь Хүн амзүйн мэдээлэл, Биеийн үйл ажиллагааны өөрчлөлт, Биеийн бүтцийн, Үйл хөдлөл ба оролцооны хязгаарлагдмал байдал, Хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн гэсэн 5 хэсэг, 19 шалгуур үзүүлэлттэй.

Үр дүн

Биеийн үйл ажиллагааны өөрчлөлт

Ухамсарт байдал, орчны харьцаа, хэл яриа, сэтгэцийн үйл ажиллагаанд өөрчлөлтгүй болон хөнгөн зэргийн өөрчлөлттэй, 30-с доош хувь дунд болон

хүнд зэргийн өөрчлөлт илэрсэн байна. Харин анхаарал хандуулах чадвар, ой санамжийн үйл ажиллагаанд өөрчлөлтгүй байх тохиолдол харьцангуй бага байна.

Булчин ясны болон хөдөлгөөн хамааралт үйл ажиллагаанд өөрчлөлтгүй, хөнгөн зэргийн өөрчлөлт илрэх тохиолдол харьцангуй бага, хүнд зэргийн өөрчлөлт илрэх тохиолдол их байна. Тархины бүтцийн өөрчлөлтийг үнэлэхэд хөнгөн ба дунд зэргийн өөрчлөлт иргэдийн 48.7 хувьд илэрч байна. Биеийн дээд /гар, сарвуу/ болон доод /хөл/ хэсгийн бүтцийн өөрчлөлтийг үнэлэхэд өөрчлөлтгүй байх тохиолдол бага, хөнгөн болон дунд зэргийн өөрчлөлтөд орох тохиолдол өндөр байна.

Өөрчлөлт үүссэн байрлалаар авч үзвэл биеийн дээд болон доод хэсгийн аль нэгт өөрчлөлт давамгайлж илрээгүй ойролцоо байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд хэл яриагаар ярилцах болон ярих чадвар хөнгөн зэргийн, алхах чадварын дунд зэргийн өөрчлөлт түлхүү илэрч байв. Судалгаанд хамрагдсан иргэдийн биеэ угаах, бие засах, хувцаслах, идэх чадварын үнэлгээнд өөрчлөлтгүй болон хөнгөн зэргийн өөрчлөлт давамгайлж байв.

Халамж ба харилцааг үнэлсэн үнэлгээнээс үзэхэд судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ, бодлого зохицуулалтын хэрэгжилт, гэр бүлийнх нь зүгээс үзүүлэх дэмжлэг, тусламж, эрүүл мэндийн мэргэжилтний эмчилгээ, тусламж сайн байна.

Хэлцэмж

Монгол улсад эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтний үзлэг, шинжилгээ дүгнэлт нь хувь, хүнийг хөдөлмөрийн чадвар алдалттай эсэхийг шийдвэрлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна.

БҮҮАОУА-ыг хэрэгжүүлж, нэвтрүүлснээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдээс гадна үйл ажиллагааны чадвар, хүрээлэн буй орчны нөлөөллийг давхар үнэлснээр хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдэд учирч буй хүндрэл, амьдралын хэрэгцээний талаар илүү өргөн хүрээтэй оновчтой мэдээллийг цуглуулан авах боломжтой байна.

Цаашид уг мэдээлэлд тулгуурлан гаргасан хөдөлмөрийн чадвар алдалтын талаар шийдвэр гаргах эрх бүхий тушаалтны бодлого, шийдвэр, эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, эмчилгээ, хяналт нь түргэн шуурхай, чанартай, үр дүнтэй байх болно гэж үзэж байна.

Хэдий БҮҮАОУА нь олон давуу талтай боловч хэрэгжүүлэхэд тулгарч болох хэд хэдэн хүндрэл байна. Үүнд:

БҮҮАОУА-аар нэг хүнийг үнэлэх хугацаа их байна. Уг судалгаанд ашигласан үнэлгээний хуудас нь Brief буюу түргэвчилсэн хувилбар боловч нэг хүнийг үнэлэх хугацаа 15-20 минут байна. БҮҮАОУА-ын comprehensive ICF-CY хувилбараар мэргэшсэн мэргэжилтэн нэг хүнийг үнэлэх хугацаа

дунджаар 3 цаг байна. Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг БҮҮАОУА ашиглан тогтоох, мэргэшсэн мэргэжилтэн дутмаг байна. Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдийн дунд БҮҮАОУА-ын талаарх мэдлэг бага байна. БҮҮАОУА-ыг орчуулсан албан ёсны орчуулга байхгүй байна. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс эсвэл эрүүл мэндийн байгууллагын аль нь БҮҮАОУА-аар үнэлгээ хийх нь тодорхойгүй байна. Учир нь нэг иргэнийг 2 удаа урт удаан хугацаагаар үнэлэх нь тухайн иргэнд хүндрэлтэй. БҮҮАОУА-ын зарим нэг кодын шалгуур үзүүлэлт дээр тодорхой хэм хэмжээ тогтоож өгөх нь зүйтэй. Жишээ нь алхах үйл ажиллагааг үнэлэхэд хэр хол, хэдий хугацаанд алхах зэрэг нь тодорхой биш байгаа учир үнэлж буй хүний үзэмжээр шийдэгдэх тохиолдол байж болох юм. Одоогийн байдлаар Монгол улсад БҮҮАОУА-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ямар нэг төлөвлөгөө алга байна.

Дүгнэлт

БҮҮАОУА дээр тулгуурласан хөдөлмөрийн чадвар алдалтын үнэлгээ нь тухайн хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тодорхойлохоос гадна, өдөр тутмын хэрэгцээг давхар тодорхойлж, түүнд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай, оновчтой болгох боломжтой байна.

Мөн БҮҮАОУА-ын үнэлгээ нь тухайн иргэний талаар их хэмжээний мэдээлэл цуглуулах бөгөөд тухайн мэдээлэлд үндэслэсэн оновчтой зөв бодлого боловсруулах, иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бий болгож байна. Жишээ нь: Хэрэв хүрээлэн буй орчны үнэлгээг зөв хийсэн тохиолдолд тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид бодит үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой болно.

БҮҮАОУА-ын хувьд их хэмжээний мэдээлэл цуглуулах боломжийг бий болгож байгаа ч уг мэдээллийн үнэн зөв байдал зарим талаараа эргэлзээтэй байж болох юм.

Судалгаанаас үзэхэд эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүд, эмнэлэг хөдөлмөр магадлалын тогтолцоо нь БҮҮАОУА-аар хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход бэлэн бус, тохиромжгүй гэж үзэж байна.

Түлхүүр үг: *Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, үнэлгээ*

Ашигласан материал:

1. "https://www.lcf-research-branch.org/."
2. Sanches-Ferreira et al., "Conditions for Implementing the ICF-CY in Education: The Experience in Portugal."
3. "ЭХК Болон ЭХМК-ын гишүүдийн ICF-ийн талаарх мэдлэгийн төвшинг тодорхойлох судалгаа" ЭХМТК 2020 Он.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ

Ц.Батцэцэг¹

*¹Чингэлтэй дүүрэг 39 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
btseweenjaw@gmail.com*

Үндэслэл

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт тогтвортой бус байгаа нь тэдний хөдөлмөрлөх эрхийг хангах гол үндэс болсон тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бага байгаатай холбоотой гэж үзэж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ААН, албан байгууллагууд 25 хүн тутамд нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах үүрэгтэй хэдий ч түүнийг биелүүлэхгүй байгаа нь нь тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байрыг бэлтгэж чадахгүй байна.

Зорилго

Урт хугацааны туршид халамж хүртэгч хэмээн тодорхойлогдож ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өнөө үед ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалгүйгээр, тэгш боломжийн үндсэн дээр хөдөлмөрлөх эрхээ шаардах эрх агуулагч гэж олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай конвенцын 27 дугаар зүйлд Ажил хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүртээлтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхлэх боломж бүрдэх болно

Шинэлэг байдал, ач холбогдол

Өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлсэн гэгдэмжлэг авахаас гадна байгууллага хамт олны харилцаа, соёл өөрөө мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрлөхөд дэмжлэг болж чадна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад л гэхэд Боловсролын тухай хуулинд заасан бусад ажилтан гэх статусын хүрээнд боловсролын үйлчилгээ үзүүлэхэд туслах үүрэг бүхий нягтлан бодогч, нярав, цагаан хэрэглэл угаагч, тогооч зэрэг аж ахуйн ажилтнаас гадна НҮБ-с зөвлөсний дагуу хөгжлийн бэрхшээлтэй багшийг ажлын байраар хангах тухай асуудлыг ч мөн орхигдуулж болохгүй санагдана.

Материал ба арга зүй

Эрх зүйн баримт бичигт анализ хийж тайлбарлан, хувилбар санал болгох дизайнаар энэ судалгааг гүйцэтгэсэн болно. Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоон дахь үйлчилгээ, байгууламж, бүтэц зохион байгуулалтыг ерөнхий хүрэлцээтэй байдлын үүднээс авч үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн чадамжаа хамгийн дээд хэмжээнд хүргэх нөхцлийг хангаж чадахуйц таатай орчин, нөхцөл бүрдсэн газар байхаар шийдэгдсэн байх ёстой. Гэтэл

ажил олгогч, байгууллага хамт олны бодлого, соёл болон хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөггүй, үйлчилгээнээс зөвхөн бага насны хүүхэд үр ашиг хүртэнэ гэж бодон өөрсдийн нөөцөө анзаарахгүй байна. Жишээлбэл хамт олны эерэг дулаан, чин сэтгэлийн харилцаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэтгэлийн дэмжлэг болж чаддаг. Мөн заах арга зүйн чадвар сайн багш болон бусад ажилтаны хувьд аливаа мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хялбар аргаар ойлгуулах туршлагатай болсон байдаг нь мөн л ажлын байран дахь тохируулгын нэг хэлбэр. Цагийн хуваарь уян хатан байх, цахим орчинд ажиллах зэрэг хэлбэрээр хөдөлмөрийн харилцааг цар тахлын үед өөрчилсөн туршлага нь мөн л тохируулгат орчинд хамаарна. Мөн сэтгэл зүйч, холбогдох эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээний мэргэжилтэнтэй байх, тэтгэлэг, санхүүгийн эх үүсвэр хүртээмжтэй байх зэрэг ч үүнд хамаатай. Хэрэв энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлж чадвал төсвийн захирагч-цэцэрлэгийн эрхлэгч Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байрыг төлөвлөх, төсөвлөх, худалдан авах ажиллагаа бодитой хэрэгжинэ. Үүнд мөн УИХ-н 2017 оны 46-р тогтоол “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ын 2т заасан “улсын төсвийн зарлагын ангилалд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих зардлын ангиллыг шинээр нэмж тусгах” Сангийн яамнаас эхлэн өөрчлөлт хийх шаардлага үүсэж байна.

Дүгнэлт

Хүн бүхэн ялгаатай бөгөөд ялгаатай байдлын нэг хэлбэр нь хөгжлийн бэрхшээл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг зөвхөн хувь хүний эрүүл мэндийн байдал, согогтой нь холбон үздэг байсан сөрөг хандлага ХБХЭК батлагдан гарснаар өөрчлөгдөж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил эрхтэй гэж үзэх болсон. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын ажил ажил хөдөлмөрлөх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг ханган хэрэгжүүлэхэд дэмжлэг буюу тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байраар хангах явдал чухал. Олон улсын болон монгол улсын хөдөлмөрийн эрх зүйд хүний эрхийн байр сууринаас хандан зохицуулалт хийсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байраар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хангахад ажил олгогч болон хамт олны уламжлалт сөрөг хандлага өөрөө саад тотгорыг үүсгэж байна.

Ашигласан материал

1. Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн тухай НҮБ-ын Конвенц
2. Монгол улсын хууль Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн тухай
3. Монгол улсын хууль Хөдөлмөрийн тухай
4. УИХ-н 2017 оны 46-р тогтоол “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

БАГАНУУР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИЖ, ДҮҮРЭГ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Балжинням¹

¹БНД НДХ-ийн Магадлагч эмч, Эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагч, Ерөнхий мэргэжлийн хүний их эмч,

Үндэслэл

Монгол Улсад 2010 онд нийт 82,631 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байсан бөгөөд энэ нь нийт хүн амын 2,97 хувийг эзэлж байсан бол 2019 онд 10 жилийн хугацаанд 28737 хүнээр нэмэгдэж 111386 хөгжлийн бэрхшээлтэй иргэн/ХБИ/ нь нийт хүн амын 3,6%-ийг эзэлж байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80 хувь нь хөдөлмөрийн насны хүн байгаа бөгөөд тэднийг ажлын байртай болгож, эрхийг баталгаажуулах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого хөтөлбөрөө илүү боловсронгуй болгон хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Хөдөлмөрийн чадвар алдсан /ХЧА/ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжвэл дүүрэг орон нутгийн хөгжилд түлхэц болно гэж үзэж байна. ХЧА-г нөхөн сэргээж, ХЧА иргэний амьдралын идэвх нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн орлогыг тогтворжуулах шинэлэг талтай болно.

Зорилго

Хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдал, дүүргийн хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлт, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлснээр дүүрэг, орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөхийг судлахад оршино. Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дэлхийн болон Монгол улс, дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтыг судлах;
2. Дүүргийн хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлах;
3. Хөдөлмөрийн чадвар алдалт /ХЧА/ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн бэрхшээлийн шалтгааныг судлах;
4. ХБИ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлснээр дүүрэг, орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ

Материал ба арга зүй

- Хөдөлмөрийн чадвар алдалт болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд холбоотой эрх зүйн баримт бичиг, судалгаа шинжилгээг судалж, дүгнэлт хийхдээ *онолын судалгааны арга*;
- ХЧА-н статистик мэдээлэл, тус дүүргийн ЭХМК-н health committee програм *математик боловсруулалтын арга*;
- ХЧА иргэдтэй хийх ярилцлагын сонголтыг *түүврийн арга*;
- Дүгнэлт болон саналыг *SWOT анализын аргаар* хийж гүйцэтгэсэн

Үр дүн

НДЕГ-ын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс/ЭХМТК/-ын тайлангаас харахад улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2018 онд 111464 байсан бол 2019 онд 111386 болж -0,07 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч цаашид энэ тоог үр дүнтэйгээр бууруулж, ХЧА-ыг нөхөн сэргээх болон ХЧА иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд анхаарал хандуулах нь ач холбогдолтой юм. Ажил хөдөлмөр эрхлэх боловсон хүчин нэмэгдэх нь нийгэмд бүтээлч олонх бий болж дүүрэг орон нутгийн хөгжилд эерэгээр нөлөөлнө.

Багануур дүүрэгт 2019 онд 82 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг тогтоолгож 1002 иргэн нийгмийн даатгалын сангаас 635 нь, нийгмийн халамжийн сангаас 367 иргэн тэтгэвэр, тэтгэмж авч байна. Дээрх 1002 иргэнээс хөдөлмөрийн насны эрэгтэй 507, эмэгтэй 428 иргэн байгаагаас хөдөлмөрийн чадварыг 70%-с дээш буюу бүрэн алдсан 37, хагас буюу хэсэгчлэн алдсан 68, нийт 105 /10,4%/ иргэн хөдөлмөр эрхэлж байна. Үүнд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй-16, ахуйн болон үйлдвэрлэлийн осол-25 иргэн байна. Хөдөлмөр эрхлэлт боловсрол, эрүүл мэндийн салбарт дийлэнх иргэн ажиллаж байна. 16-34 насны 34 иргэн, 35-61 насны 71 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байна. ХЧА/ХБИ-ний ажил хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчний үнэлэмж Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт 65%.

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөрийн албанд ажиллах хүсэлт өгсөн ХБИ иргэн 4 байгаа нь 1 эмэгтэй, 25-34 настай 1, 35-44 насны 3 иргэн байна. Тус албанд 2019 онд 2 ХБИргэнг түр ажлын байранд зуучилж ажиллуулсан байна.

Хүснэгт 1. Зарим дүүргийн ХЧА-ын ажил хөдөлмөр эрхлэлттэй харьцуулбал 2019 он:

Дүүрэг	Нийт ХЧА	Ажил хөдөлмөр эрхэлдэг	Хувь
Багануур	1002	105	10,9%
Хан-Уул	4422	790	17,8%
Налайх	1315	496	37,7%
Сонгинохайрхан	8193	3583	43,7%

Дүгнэлт

ХБИ-д яагаад ажиллах хүсэл, сонирхол бага байна вэ?

Бидний харж байгаагаар хөгжлийн бэрхшээл нь янз бүрийн хэлбэрээр ирдэг бөгөөд зарим нь түр зуурын шинжтэй байдаг ч зарим хүмүүс хөгжлийн олон бэрхшээлтэй байдаг. Бие эрхтний бэрхшээлтэй иргэдийг нийтэд нь хамруулаад хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж тодорхойлох нь тохиромжгүй бөгөөд тэдгээр иргэдийг нийгмийн оролцоог хангахад нь сөргөөр хүлээж авахад хүргэж байна. Энэ нь эргээд тэдгээр иргэдийн өөртөө итгэх итгэл болон амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгаа учраас нийгмийн хандлагыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ байгаа юм. Судалгаанд нийт бие эрхтний бэрхшээлтэй 80 иргэнийг түүвэрлэн

асуумж авахад 65% нь ажил хийж чадахгүй гэж боддог ба хүсэлгүй иргэд байсан. Дундаж наслалт дунджаар 70-аас дээш жил байдаг орнуудад хувь хүн дунджаар 8 жил буюу амьдралынхаа 11.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна. Дунджаар боловсрол багатай хүмүүсийн 19 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байдаг бол боловсрол сайтай хүмүүсийн дунд 11 хувь байна. ХБХ-ийн 80 орчим хувь нь хөдөлмөрийн насны хүмүүс байдаг. ХЧА иргэний хөдөлмөр эрхлэлт нь орлого олохоос гадна нийгмийн оролцоог хангах боломжийг олгодог. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст онцгой ач холбогдолтой юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулснаар хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдээ илүү сайн ойлгож, үйлчилж чаддаг болохыг олон улс орон олж тогтоосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин нь бүх нийтэд ээлтэй орчин байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон талт хэрэгцээг хангах, үйлчилгээнд зохицуулалт хийх нь бизнесийн уян хатан байдлыг бий болгож, хөгжлийг нэмэгдүүлэх, томоохон зах зээлд гарах боломжийг олгоно. Дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: ХЧА иргэн талаас:

- ХЧА иргэн идэвхтэй хяналтад байх
- эмчийн зөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, диспансерийн үзлэг, хяналтад бүрэн хамрагдах, ХЧА-аа нөхөн сэргээх

ЭМБайгууллага:

- Өрхийн болон төрөлжсөн эмчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацаа тогтоолгосон иргэний нарийн мэргэжлийн эмчийн идэвхтэй хяналт, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний дагуу үр дүнг тооцох, ХЧА-г нөхөн сэргээх ажлыг тусгах

ЭХМТК:

- ХЧА тогтоолтыг ICD - Олон улсын өвчний ангиллаас гадна ICF буюу олон улсын үйл ажиллагааны ангилалтай хослуулан тогтоодог болох

Дүүрэг орон нутгийн удирдлага:

- Нэгдсэн арга зүй, удирдлагаар хангаж, үр дүнг тооцох нэгж байгуулах. Уг нэгжийг байгуулснаар ХБИ-нийг мэргэжил боловсролын төвшинг цахимаар болон танхимаар нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулснаар тэдний амьдралын идэвхтэй дээшлэх, илүү орлого олох, хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээж, эрүүлжих сэтгэхүй нэмэгдэнэ. Ингэснээр иргэний амьдралын төвшин нэмэгдэж, орон нутгийн хөгжил дээшилнэ.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөдөлмөрийн чадвар алдалт, хөдөлмөр эрхлэлт, дүүрэг орон нутгийн хөгжил

Ашигласан материал:

1. НДЕГ-ын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс/ ЭХМТК/-ын тайлан, 2019 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Б.Баатарбүргэд¹

¹Экологийн цагдаагийн албаны жижүүрийн цагдаа

Үндэслэл

Ажил, хөдөлмөр хийхийг хүсэлтэй байгаа боловч олон саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон бий. Өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээ, чадавхад үндэслэн тусгай ажлын байр бий болгох, тэдний боловсролын төвшин мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядууралд өртөхөөс хамгаалах зайлшгүй шаардлага тулгараад байгаа билээ. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудалд төрийн бодлогын хэрэгжилтийг юуны өмнө хангах, тэднийг өөртөө итгэлтэй, нийгмийн идэвхтэй гишүүн болгож хөгжүүлэх, бусдын адил амьдрах боломж нөхцөл, нийгэмд оролцох оролцоо, хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох үүднээс энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.12, 111.23 дах хэсэг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, тушаал, журмын хэрэгжилтийг үнэлэх, биелэлтийг сайжруулах арга замыг тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Материал ба арга зүй

Судалгааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2 дах заалтыг хэрэгжүүлж буй ААНБ-уудын захиргааны тоон мэдээнд шинжилгээ хийж, мөн уг заалтуудыг хэрэгжүүлж байгаа болон хуулийг үл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл болсон 117 ААНБ, хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хайж буй 142 ХБИ-ээс судалгааны мэдээлэл цуглуулж, үр дүнг Байгууллагын болон Хувь хүний гэсэн үндсэн 2 төрлийн асуулгаар цуглуулсан. Байгууллагын асуулга болон хувь хүний асуулгын аргыг ашигласан. Судалгааны мэдээллийг сонгогдсон ААНБ болон өрх бүрээр зочилж ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан. Судлаачийн аюулгүй байдлыг хангах үүднээс Улаанбаатар хотод хорооны хэсгийн ахлагч, аймагт багийн засаг дарга нарыг хөтчөөр ажиллуулсан. Судалгааны мэдээллийг оруулах, шалгах, засварлахдаа тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSpPro багц программ, мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцох ажлыг STATA программыг тус тус ашиглан гүйцэтгэлээ.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан ААНБ-уудыг өмчийн хэлбэрээр авч үзвэл 50.4 хувь нь хувийн, 39.3 хувь нь төрийн, 10.3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагууд байлаа. Эдгээр байгууллагуудын 46.3 хувь нь ХБИ-ийг ажиллуулдаг, 29.9 хувь нь ажиллуулбал зохих орон тоонд төлбөр

төлдөг, 23.9 хувь нь хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй байгууллагууд байв. Судалгаанд хамрагдсан гурван ААНБ тутмын хоёр (59.0 хувь) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж, гарахад зориулсан налуу замтай байсан боловч тэдгээрийн ихэнх нь стандартын бус, огцом замтай байлаа. Харин хараагүй хүнд зориулсан хөтөч зам (8.5 хувь) болон өрөөний дугаарын брайл тэмдэглэгээ (7.7 хувь)-тэй байгууллага цөөн байна.

Судалгаагаар ХБИ-ийг ажиллуулдаг ААНБ-ын 28.6 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 71.1 дэх заалтын дагуу тухайн ХБИ-ийг богиносгосон цагаар ажиллуулдаг, 37.1 хувь нь ажилдаа ирэх, буцах унааны дэмжлэг үзүүлдэг байна. Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-аас 29.9 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-т заасны дагуу буюу хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлж байна. Эдгээр ААНБ-аас хамгийн их нь 12 тооны ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлдөг бөгөөд дунджаар нэг ААНБ гурван ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлж байна.

Мөн тэдгээр байгууллагуудын 82.9 хувь нь сар бүр төлбөр төлөх нь хүндрэлтэй байдаг тул цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бол 17.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахгүй, цаашид хуулиа хэрэгжүүлэн сар бүр төлбөрөө төлнө хэмээн хариулжээ.

Судалгаанд хамрагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй ААНБ-уудын хувьд ажилчдын тооноос хамаараад хамгийн их нь 25, бага нь 1 орон тоонд, нийт 120 орон тоонд ХБИ ажиллах үүрэгтэй хэдий ч ХБИ ажиллуулаагүй, ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлөөгүй байна. Тэдгээр байгууллагуудын гуравны хоёр нь энэхүү заалтын талаарх мэддэг хэдий ч хэрэгжүүлдэггүй байна.

Уг хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй ААНБ-уудыг шалтгаанаар авч үзвэл дөрөвний гуравт (74.1 хувь) ХБИ ажилд орохоор хандаж байгаагүй бөгөөд 55.6 хувьд нь ХБИ-ийн ур чадвар шаардлагад нь нийцдэггүй, 40.7 хувь нь ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй, 22.2 хувь нь ХБИ ажиллуулах сонирхолгүй байдаг гэжээ. ХБИ ажиллуулснаар төрөөс авах дэмжлэгийн талаарх мэдлэг хуулийг үл хэрэгжүүлэгч байгууллагуудын хувьд нэлээд тааруу байна. Энэ нь мөн тус хуулийг хэрэгжүүлэхэд хойрго хандах нэг үндэс юм.

Судалгаанд хамрагдсан иргэдийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл 39.4 хувь нь хөдөлгөөний, 21.1 хувь нь бусад, 10.6 хувь нь харааны бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 73.9 хувь нь олдмол, үлдсэн 26.1 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхэлж буй ХБИ-ийн хувьд 94.3 хувь нь цалин хөлстэй ажиллагч байна. Хөдөлмөр эрхэлж буй ХБИ-ийн 91.7 хувь нь ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 93.1 хувь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллаж буй иргэдийн хувьд ажил олгогчтой аман байдлаар гэрээ хийсэн, түр ажилтан гэх шалтгаанаар гэрээ байгуулаагүй байна.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан иргэд хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол дүүрэн байдаг хэдий ч нийгмийн болон бусдын хандлага сөрөг байдаг нь тэдний урам зоригийг мохоодог нь ажиглагдсан. Нийгэм, эдийн засгийн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг. Энэхүү судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт талаас нь цогцоор авч үзсэнээр нэлээд онцлог болно. Хуулийн хэрэгжилтийг төлбөрийн хүрээгээр хязгаарлаж байгаа нь аж ахуйн нэгж, байгууллагуудад хүлээлгэх хариуцлага байхгүй, хуулийн хэрэгжилтийг хангах түлхэц болж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр олноор бий болгосон, энэ талаар илүү санаачилгатай ажиллаж байгаа ажил олгогчийг урамшуулах систем байхгүй байгаа нь тэдний цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд тогтвортой байлгах, дэмжих, ажлын байр нэмж бий болгох урамгүй болгож байгааг ажил олгогчид илэрхийлж байгаа нь хуулийн хэрэгжилтэд зохих хэмжээгээр нөлөөлдгийг харуулж байна. Төсөвт байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн улмаас төлөх төлбөрийг төсөвтөө тусгагдаагүй гэх шалтгаанаар төлдөггүй нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тусгай дансны бүрдүүлэлтэд ихээхэн сөрөг нөлөөтэй байна. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй байгууллагаас, мөн тухайн байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс судалгаа авсан бөгөөд судалгааны туршид анзаарагдсан нэг зүйл нь дотор эрхтнээр, даралт ихсэх өвчнөөр, сахарын өвчнөөр групп тогтоолгосон иргэд олон байлаа. Дотор эрхтний өвчнөөр групп тогтоолгосон иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн ойлголтоос ангид үзэх, ойлголт, тодорхойлолтыг дахин шинэчлэх нь зүйтэй хэмээн хөгжлийн бэрхшээлтэй олон иргэн саналаа илэрхийлж байсан. Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд: - Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, урамшууллын системийг боловсронгуй болгох, - Хуулийн хэрэгжилтийн хяналтыг эрчимжүүлэх, - Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг нарийн ангилах, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн ур чадвар олгох арга хэмжээг сайжруулах, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг дэмжих.

Түлхүүр үг: *Налуу зам, хөдөлмөрийн гэрээ, брайл тэмдэглэгээ, хараагүй хүн*

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль.,УБ. 1992 он
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
4. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс "Монгол улс дах хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл" сэтгүүл, 2007 он
5. Хөдөлмөрийн Яам, Хөдөлмөрийн Судалгааны Институт, "Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа" 2013 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА САНХҮҮГИЙН БАТАЛГАА

З.Бадамцэцэг¹

¹*Цагдаагийн ерөнхий газрын Авто бааз*

Үндэслэл

Дэлхий нийтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг дээдлэх, нийгмийн халамжийг тасралтгүй хүртээмжтэй олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар өдөр бүр шинэ, шинэлэг санааг дэвшүүлэн тэднийг нийгэмтэй хөл нийлүүлэн алхах боломжоор хангахыг зорин үйл ажиллагаа явуулж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 25.1.3-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулна” гэж заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Нийгмийн халамжийн тэтгэвэр/ цаашид “тэтгэвэр” гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сар бүр төрөөс мөнгөн тэтгэмж олгож байгаа хэдий ч тэр нь гэр бүлээ тэжээх, өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, амар тайван амьдрахад хүрэлцээтэй эсэх нь тодорхойгүй байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өрхийн орлогыг судлан тогтоож, амьжиргааны зардалд хүрэлцэж буй эсэхийг тогтооход оршино.

Материал ба арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, асуулгын аргаар, харилцан ярилцах байдлаар судалгааг авсан.

Үр дүн

Харааны, сонсголын, сэтгэцийн, хэл ярианы, хөдөлгөөний тус бүр 10 нийт 60 хөгжлийн бэрхшээлтэй иргэн санамсаргүй түүврийн аргаар сонгосноос 11 буюу 18.3 хувь нь төрөлхийн, 49 буюу 81.7 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй. 36 буюу 60 хувь нь эрэгтэй, 24 буюу 40 хувь нь эмэгтэй хүн байв.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	Судалгаанд хамрагдсан иргэний тоо	Түүнээс идэвхтэй хөдөлмөр эрхэлдэг ХБИ-ий тоо	Түүнээс идэвхтэй хөдөлмөр эрхэлдэг ХБИ-ий хувь
Харааны	10	2	20
Сонсголын	10	8	80
Сэтгэцийн	10	3	30
Хэл ярианы	10	4	40
Хөдөлгөөний	10	5	50
Хавсарсан	10	3	30

Ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл: Харааны бэрхшээлтэй 10 иргэний 2 нь буюу 20 хувь нь, сонсголын бэрхшээлтэй 10 иргэний 8 нь буюу 80 хувь нь, сэтгэцийн бэрхшээлтэй 10 хүний 3 нь буюу 30 хувь нь, хэл ярианы бэрхшээлтэй 10 хүний 4 буюу 40 хувь нь, хөдөлгөөний бэрхшээлтэй 10 хүний 5 буюу 50 хувь нь, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 10 хүний 30 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Хүснэгт 2. Гэр бүлийн байдлаар нь авч үзвэл:

Нийт судалгаанд оролцогсдын 30 буюу 5 хувь нь 3-аас 4 тооны ам бүлтэй байна.

Ам бүлийн тоо	Судалгаанд оролцогсдын тоо	Хувь
Ам бүлийн тоо 1-2	13	21.6
Ам бүлийн тоо 3-4	30	50
Ам бүлийн тоо 5-6	10	16.6
Ам бүл 6-аас дээш	7	11.6

Хүснэгт 3. Өрхийн орлогын байдлаар нь авч үзвэл:

Өрхийн орлого 1 сард	Судалгаанд оролцогсдын тоо	Хувь
500 мянган төгрөгөөс доош	10	16.6
500-700 мянган төгрөгийн хооронд	38	63.3
700 мянган төгрөгөөс дээш	12	20

Хүснэгт 4. Өрхийн зарлагын байдлаар нь авч үзвэл:

	Судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо	Хувь
500 мянган төгрөгөөс доош	8	13.3
500-700 мянган төгрөг	27	45
700 мянган төгрөгөөс дээш	25	42

Дүгнэлт

2021 оны 2 дугаар сарын байдлаар Үндэсний Статистикийн хорооны тоон мэдээлэлд нэг өрхийн сарын дундаж зарлага нийслэл хотод хүнсний зүйлийн зарлага 429.216, хүнсний бус бараа үйлчилгээний зарлага 978.241 гэсэн судалгаа гарсан байна.

Судалгаанд оролцогсдын 50 хувь нь ам бүл 3-4, 63.3 хувь нь өрхийн сарын орлого нийт 500-700 мянган төгрөг бол 45 хувь нь сарын нийт зарлага 500-700 мянган төгрөг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны хомс байдал, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй өрхийн орлого нь зарлагаасаа бага байгаагаас харахад дан ганц нийгмийн халамжийн тэтгэмжээр нийгэмтэй, хөл нийлүүлэн алхах, өрхийн хэрэглээний зардлаа бүрэн хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Нийгмийн халамжаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэмжид хяналт тавих, яг шаардлагатай хүндээ очиж байгаа эсэхэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг онцлогт тохирсон ажлын байрыг нэмэгдүүлэх, сошиал орчин, бусад цахим эх үүсвэрүүдийг ашиглан, нийгэмд үүссэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ойлгох, дэмжих сурталчилгааны ажлыг эрчимтэй

зохион байгуулж, ялгаварлан гадуурхалтыг бууруулах төлөвлөгөөт ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Нийгмийн халамж, санхүүгийн байдал, өрхийн орлого ба зардал, ажил эрхлэлт*

Ашигласан материал:

1. http://hudulmur-halamj.gov.mn/uploads/pdf/sudalгаа_pdf/buleg5.pdf- Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа 2013 он
2. <https://www.1212.mn/> -Үндэсний статистикийн хороо
3. <https://mlsp.gov.mn/> -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал
4. <https://legalinfo.mn/mn/detail/11711> -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Б.Энхцэцэг¹

¹Ховд аймаг 6 дугаар сургуулийн бага ангийн багш

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хэрэгцээ, чадавхад үндэслэн тусгай ажлын байр бий болгох, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах асуудал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодит болгох” Инчеоны стратеги 2013-2022 он, “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” зэрэг урт болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж, хэрэгжиж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийн бэрхшээл адилгүй. Тэдний бэрхшээл бие бялдрын, мэдрэхүйн эрхтний, оюуны болон сэтгэцийн шинжтэй байж болдог. Түүнчлэн энэхүү бэрхшээл нь төрөлхийн болон амьдралын аль нэг үед ахуйн болон үйлдвэрийн ослоос шалтгаалан үүссэн байж болдог. Хөгжлийн бэрхшээл нь тухайн хүнийг хөдөлмөрлөх, нийгэмшихэд нөлөөлдөг бөгөөд зарим тохиолдолд дэмжлэг, туслалцаа шаардах нь ч бий. Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил, хөдөлмөрийн бүхий л төвшинд ажиллаж хувь нэмрээ оруулж байна. Гэсэн хэдий ч ажил, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй байгаа боловч олон саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон бий.

Зорилго

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.12 , 111.23 дах хэсэг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, тушаал, журмын хэрэгжилтийг үнэлэх, биелэлтийг сайжруулах арга замыг тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Материал ба арга зүй

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль нь бүх нийтэд ижил үйлчилдэг учир судалгаанд газар зүйн 4 бүсийг хамруулахаар төлөвлөж, хот, хөдөөгийн ялгааг тодруулж, Хөдөлмөр эрхэлж буй болон ажилгүй байгаа хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар харьцуулан хийв.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал:


Албан ёсны статистикийн мэдээлэл буюу ҮСХ-оос гаргадаг Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулан, мэдээлдэг. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар

алдалтын хувь хэмжээ, шалтгаан, хугацааг тогтоодог. “Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 1.5-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг:

- 50-69 хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа хагас алдсанд
- 70 ба түүнээс дээш хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсанд тус тус тооцдог.


Монгол Улсад 2020 оны байдлаар 108,399 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд нийт хүн амын 3.1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн иргэдийн 43 хувь нь төрөлхийн, 57 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл хөдөлмөрийн насны нийт ХБИ-ийн 15 хувь нь (13634 иргэн) хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чухал асуудал нь хүртээмжтэй дэд бүтэц, ажил олгогчдын эерэг хандлага, ХБИ-дэд ээлтэй ажлын байрны орчин, ХБИ-д ажиллах боломжтой ажлын байрны мэдээллийн хүртээмжтэй байдал зэргээс шууд хамааралтай байдаг.

График 1.



хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр

График 2. Ажилгүйдлийн түвшин (хувиар), хүйс, насны бүлэг,



Энэ судалгаанаас хархад 15-24 насны хүмүүс хамгийн их ажилгүйдлийн төвшинд байгаа бөгөөд хамгийн бага үзүүлэлт нь хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүйдэл бага байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнг шүүн хэлэлцэхүй:

Өнөөгийн байдлаар, Монгол улсын нийт барилгын 17.5 хувь нь ХБИ-дэд зориулсан орц, гарцтай, нийт тээврийн хэрэгслийн 2.6 хувь нь тэргэнцэртэй иргэдэд ээлтэй, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс 1.6 хувь нь дохионы хэлээр мэдээлэл хүргэдэг гэх мэт нөхцөл байдал байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байрны тухай мэдээлэл авах, гэр-ажил хооронд бие даан зорчих, ажлын байранд ээлтэй орчинд ажиллах боломж маш дутмаг байгааг харуулж байгаа юм. Эдгээрээс гадна, ерөнхийдөө

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд боловсролын төвшин харьцангуй бага, бүрэн дунд болон дээд боловсролд хамрагдалт бага байдаг. ХБИ-н суурь боловсролыг дээшлүүлэх, тэднийг ажлын байранд бэлтгэх, сургах, чадавхжуулах ажил дутмаг байгаа нь ажлын байранд үр дүнтэй, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг нь хязгаарлаж байгаа сул тал бий.

Дүгнэлт

Үндэсний төвшинд хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг сайжруулахын тулд хөдөлмөрийн харилцаанд орж буй бүхий л талуудад ээлтэй, харилцан үр ашигтай байхаар боловсруулж, сайжруулах шаардлагатай байна. Нэгдүгээрт, Хөдөлмөрийн зах зээлд ХБИ-д ээлтэй, хөдөлмөрийн орчныг бүрдүүлж, бүх талын оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Хоёрдугаарт, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд торгуулийн тогтолцооноос урамшуулал, дэмжлэгийн тогтолцооруу шилжих хэрэгцээ байна. Гуравдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангууд, тэдгээрийн сан бүрдүүлэлт, төлөвлөлт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Дөрөвдүгээрт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан бүрдүүлэх замаар онцлог хэрэгцээнд нь тулгуурласан бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Хөдөлмөр эрхлэлт, бодлого, хөдөлмөрийн орчин

Ашигласан материал:

- Үндэсний статистикийн хороо
- Гюоглэ вэб сайт <https://www.google.com/>
- Gogo.mn

БНСУ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЧИГЛЭСЭН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СЭРГЭЭН ЗАСЛЫН ТАЛААРХ БАРИМТЛАХ БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ СУДАЛГАА

Ц.Энхтүвшин¹

*¹Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Нийгмийн ажлын тэнхим
enkhtuvshin.ts@ulaanbaatar.edu.mn*

Үндэслэл

Олон улсад ажил, мэргэжлийн сэргээн заслын ойлголт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлдэг утгаар анхаарал татдаг томоохон сэдвийн нэг болжээ. Хөгжингүй орнуудын ХБИ-нд үзүүлж буй ажил мэргэжлийн сэргээн заслын талаарх авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны онцлог, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, гарч буй үр дүн, туршлагыг судалж үүнийг өөрийн орны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалтай уялдуулж бодлого, хууль эрхзүйн, хөтөлбөрийн шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага үүссээр байна.

Зорилго

БНСУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн ажил мэргэжлийн сэргээн заслын талаарх баримталж буй бодлого, хууль эрхзүйн өөрчлөлт, тавьж буй зорилго, дамжуулагч тогтолцоо буюу хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг судлах

Материал ба арга зүй

Судалгааны арга зүйн хүрээнд дараах баримт бичиг, судалгааны материалуудад задлан шинжлэл хийж судалсан.

- Ажил мэргэжлийн сэргээн заслын талаар баримталж буй бодлого, хууль эрхзүйн баримт бичгүүд, судалгаа шинжилгээний материалууд
- БНСУ-ын ажил мэргэжлийн сэргээн заслын бодлогыг хэрэгжүүлж үйлчилгээ үзүүлдэг тогтолцоо, байгууллагуудын үйл ажиллагааны онцлог, бүтэц чиг үүргүүд

Үр дүн

- БНСУ-ын ажил мэргэжлийн сэргээн заслын талаарх баримтлах бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, хууль эрхзүйн шинэчлэлийг таван жилээр төлөвлөж энэ хугацаандаа бодлого, хууль эрхзүйн орчны өөрчлөлт хийх, холбогдох бие даасан хуулиудыг батлан гаргадаг.

Хүснэгт 1. Хууль эрхзүй, хөтөлбөрийн өөрчлөлтүүд

Хууль эрх зүйн орчин, хөтөлбөр	Он
<ul style="list-style-type: none"> - “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх халамжийн хууль” - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх тухай хууль” 	1980-1990 онуудад
<ul style="list-style-type: none"> - 1,2,3,4-р таван жилийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогын нэгдсэн төлөвлөгөө” - “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогын нэгдсэн төлөвлөгөө” “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх халамжийн хууль” - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх болон ажил мэргэжлийн сэргээн заслын тухай хууль” - “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаварлан гадуурхлыг хориглох, болон эрхийг хамгаалах хууль” - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний аж ахуйн үйл ажиллагааг нэмэгдүүлэх тухай хууль” - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүтээгдэхүүн худалдан авалтын тухайн хууль” 	1998-2017 онуудад
<ul style="list-style-type: none"> - Эрүүл Мэнд Халамжийн Яам. 5-р таван жилийн төлөвлөгөөнд байгууллагууд албан журмаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулах бодлого, - ХБИ тохирсон ажил мэргэжлийн чиг баримжааг нэмэгдүүлэх, ХБИ-д ажил мэргэжлийн сэргээн заслыг олгодог байгууллага, төвийн үйл ажиллагааг системчлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлж чанаржуулахад анхаарч байна. 	2018-2022 оны 5-р таван жилийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогын нэгдсэн төлөвлөгөө”

- Хүнд хэлбэрийн ХБХ-ий ажил хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг сайжруулж хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэхэд онцгой анхаарч сэргээн заслын төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн нь нийт ХБИ-ны хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.
- Бодлогын дамжуулах тогтолцоо буюу хэрэгжүүлэгч яамдууд, холбогдох байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгосноор байгууллагуудын уялдаа холбоо олон талт оролцоог хангах боломжийг нэмэгдүүлсэн.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс өөрийн орны ажил мэргэжлийн сэргээн заслын талаарх бодлого, эрхзүйн орчин, тогтолцоог сайжруулахад чиглэсэн дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

- ХБХ-ний хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн сэргээн заслын

үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхдээ хууль эрхзүйн орчныг сайжруулж ажил мэргэжлийн сэргээн засалд чиглэсэн бие даасан хуулийн төслийг боловсруулах.

- Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлог, чадамж зэргийг харгалзан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөнгөн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон хөтөлбөр, зорилтуудыг дэвшүүлж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Хот, дүүрэг, аймаг орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, үзүүлэх үйлчилгээний төрлүүдийн нэмэгдүүлж чадавхжуулан хүний нөөцийг сургаж мэргэшүүлэх.

Түлхүүр үг: Ажил мэргэжлийн сэргээн засал, бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа,

Ашигласан материал:

1. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын судалгааны институт (2018). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт судалгааны тайлан
2. 임종호, 이명미, 이은미 공저, 장애인복지론, 학지사. 2015
3.
 - 성과분석 및 발전방안 연구. 2019
 - 박사학위논문. 최 웅 선. 중증장애인 직업재활지원사업 수행기관의 효율성에 관한 연구. 2018 A Study on the Efficiency on Vocational Rehabilitation Institution for Persons with Severe Disabilities
 - 보건복지부. 우석대학교 산학협력단. 중증장애인 직업재활시설 운영 개선에 관한 연구. 2016 A study on Improvement of Vocational Rehabilitation Services and Centers for People with Disabilities
 - 한국직업재활학회. Journal of Vocational Rehabilitation. Vol.23, No (2013) pp5-25, 이미정. 일본의 중증장애인 직업재활 정책에 관한 일 고찰. 2013
4. <http://www.gadpwd.gov.mn/>
<https://search.daum.net/>
<http://www.riss.kr/>
<https://www.dbpia.co.kr/>

ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ НАСАНД ХҮРСЭН ХҮНД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Саранзаяа¹

*¹ МУБИС-БоСС-Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим
Saranzaya1116@gmail.com*

Үндэслэл

Хөдөлмөрийн үйл ажиллагаа нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, дутагдлыг даван туулах хамгийн чухал хэрэгсэл гэж үздэг. Оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмшүүлэх байдал нь тэдний ажил мэргэжил болон хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн зөвлөгөө өгөх боломжуудаас ихээхэн хамаардаг. Тусгайн онол нь мэргэжлийн болон хөдөлмөрийн чадварыг бий болгох, оюун ухааны бэрхшээлтэй хүмүүст тэдгээрийг хадгалах, цаашид хөгжүүлэхэд шаардагдах сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх нөхцөлийн агуулга зэргийг хангалттай тусгадаггүй. Оюуны бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн онцлог нь бие даан амьдрахад хүндрэл учруулж, цаашлаад ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс оюуны бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг аль болох эрт шийдэх ёстой бөгөөд энэ нь цогц бөгөөд тууштай ажил байх ёстой.

Зорилго

Оюун ухааны бэрхшээлтэй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох талаар онолын хувьд судлах, хөгжүүлэх. Оюун ухааны хүндэвтэр, хүнд бэрхшээлтэй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлд тэднийг нийгэмд илүү идэвхтэй оролцуулах зорилгоор ОХУ-ын туршлагыг судлав.

Материал ба арга зүй

Судалгаанд нийт оюун ухааны бэрхшээлтэй 17-30 насны 11 хүн мөн мэргэжлийн чиг баримжаа олгогч 4 багш нийт 15 хүн судалгаанд хамрагдсан. Москва хотод хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мэргэшүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 2 байгууллагыг сонгон судалсан. Энэ судалгаа нь 2 жилийн хугацаанд явагдсан. Судалгаа Москва хотод үйл ажиллагаа явуулдаг 5 байгууллага дээр ажиглалт дадлагыг 2 жилийн хугацаанд тууштай хийн 2 байгууллага 11 оюуны бэрхшээлтэй хүмүүс, 4 мэргэжлийн чиг баримжаа олгох багш нараас ерөнхий зохион байгуулалт үйл ажиллагаа, мэргэшүүлэх сургалтын талаар асуулга, ажиглалт, ярилцлагын аргаар судалсан. Судалгааг "spss" программ дээр эх бэлтгэлийг хийсэн.

Үр дүн

Монголын хувьд одоогоор судлагдаагүй бөгөөд гадны эх сурвалжаас тухайн сэдвээр судлагдсан байдлыг ажиглахад Н.Н. Захаров, О.М. Горева, Е.Н. Андреева, О.И. Акимова судлаачдын үзэж байгаагаар мэргэжлийн чиг баримжаа өгөх сургалтыг 8 аас дээших ангид олгож эхлэх нь чухал. Тиймийн тулд мэргэжлийн чиг баримжаа олгох "Зөвлөгч" ажиллах ба тэр зөвлөгч нь

эцэг эх, сурагч, ангийн багштай хамтран тухайн хүүхдийн авьяас чадварыг нээн мэргэжлийг тодорхойлж өгөх ба энэ нь цаашид суралцагчийг бүрэн дунд боловсрол эзэмшсэний дараа мэргэжлийн мэргэшүүлэх ажилд сургахад ихээхэн дэмжлэг болох бөгөөд мэргэжил сонголтод бас асар их нөлөөлдөг. Миний судалгааны хувьд насанд хүрсэн оюун ухааны бэрхшээлтэй хүнд хэрхэн ажил мэргэжил олгох талаар судлахад эдгээр хүмүүсийн хувьд эхлээд бэрхшээлийн төвшинг тогтоон дараа нь мэргэшүүлэх төвд явуулах эсвэл мэргэжлийн чиг баримжааг олгох гэсэн 2 хэсэгт хуваан авч үзэх нь зүйтэй. Бэрхшээлийн зэрэг хөнгөн тохиолдолд энгийн мэргэшүүлэх төвд хамруулан мэргэжил эзэмшүүлж ажиллах бүрэн боломжтой. Харин хүндэвтэр, хүнд бэрхшээлтэй хүний хувьд мэргэжлийн чиг баримжаа олгох нэршлээр насан туршид нийгмийн үйл ажиллагааг тасалдуулалгүй хамруулах нь чухал байна. Ингэж чадваас Монгол улсын хувьд сүүлийн 30 жил яригдсан оюуны бэрхшээлтэй хүнд мэргэжил олгох дэлхийн үйл ажиллагаанаас хоцролгүй хөл нийлүүлэн явах үндэс бүрдэнэ.

График 1. Ямар нийгмийн үйл ажиллагаанд хамрагдаж байна вэ?





График 2. Хичнээн жил ажиллаж байна вэ?



Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээл дундаа оюун ухааны бэрхшээл хамгийн эмзэг бүлэг тэдэнд ажил эрхлэх боломж хязгаарлагдмал байдаг үүнийг шийдэх тэднийг амьдралын идэвхтэй байлгах ганц гарц бол мэргэшүүлэх төв. Насанд хүрсэн иргэдийг тухайн төвд нийгэмшлийн болон ажилд мэргэшүүлэх үйлчилгээг мэргэшигч, мэргэжлийн багш байгууллага гэсэн 3-н үндсэн хэсгээс судалгаа авахад. Мэргэшигч нь мэргэжлийн чиг баримжаагаа өөрөө болон асран хамгаалагчийн тусламжтай тодорхойлсон байх, тууштай, хичээл зүтгэлтэй байх шаардлагатай. Мэргэшигчийн өөрийн болон гэр бүлийн хүслийн дагуу мэргэшүүлэх төвд хамруулж маш нарийн ажлын төлөвлөгөө гарган мэргэжлийн багш, асран хамгаалагчтай нягт уялдаа холбоотой ажиллаж мэргэшигчийг нийгмийн орчинд дасгах бусадтай хамтран ажиллахад чиглүүлэн ажиллах шаардлагатай. Байгууллагын зүгээс мэргэшигчийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх нийгмийн бусад бүлгүүдтэй холбон ажиллахад голчлон ажиллах нь зүйтэй гэдгийг дээрх судалгаанаас олж харлаа. Тэд нийгэмшиж энгийн хүн шиг амьдрахын төлөө маш их хичээж байна. Харин нийгмийн зүгээс өгөх хамгийн том дэмжлэг бол тэднийг хүлээн зөвшөөрч ойлгох явдал юм.

Түлхүүр үг: *Нийгэмшүүлэх, өөрийгөө тодорхойлох, мэргэшүүлэх анги*

Ашигласан материал:

[1]. Саранзаяа,Б., (2021) “Особенности профориентации лиц с умственной отсталостью” Москва.,

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Л.Номин¹

¹Төв аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны гүйцэтгэх захирал

Үндэслэл

Бидэнд насан туршдаа олон тооны саад бэрхшээлтэй учирдаг тул бага наснаас нь эхлэн тусламж үзүүлж, боловсрол эзэмших, мэргэжлээрээ ажиллах амьдралын туршид нь дэмжлэгээр ханган, нийгэм дэх амжилттай оролцоог баталгаажуулах зайлшгүй шаардлага байна. Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын хууль эрх зүй, хөгжлийн зорилтуудыг биелүүлэх амлалт өгч, ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Энэ нь Засгийн газрын зүгээс ХБИБ-тай идэвхтэй хамтран ажиллаж, 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлуулснаар нотлогдоно. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлийг анагаах ухааны өнцгөөс хардаг, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал дээр суурилсан загвараас биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (*ICF ангилал*)-д түшиглэсэн, хөгжлийн бэрхшээлийг био-сэтгэц-нийгмийн өнцгөөс тодорхойлдог хүний эрх-төвтэй загвар руу салбарыг бүхэлд нь шилжүүлсэн. Шинэ хууль батлагдсанаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний хөгжлийн үзүүлэлт сул байдгийг шийдвэрлэх боломж нээгдэж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийх нөхцөл бүрдээгүйн улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлох.

Материал ба арга зүй

Баримт бичгийн болон тоон мэдээлэлд анализ хийв.

Үр дүн

Бусад төрлийн бэрхшээл, орчны саад гэж юуг хэлдэг вэ?

Нийгмийн хандлага, хүрээлэн буй орчны саадыг хэлээд байгаа юм.

Тухайлбал:

1. Хууль тогтоогчид, шийдвэр гаргагчид, хамт олон, ажил олгогч, үйлчилгээний ажилчид, гэр бүлийн гишүүд зэрэг нийгмийн бусад гишүүдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандаж байгаа сөрөг хандлага үүсдэг.
2. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ажлын байр, кино театр, музей, дэлгүүр, зам, талбай зэрэг олон нийтийн барилга байгууламжууд, нийтийн тээвэр, мэдээлэл харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохиромжгүй, хүртээмжгүй байх нь тухайн газруудаар үйлчлүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд саад учруулдаг.

Иймд: Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийх нөхцөл бүрдээгүйн

улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсны дараа ажлын байрандаа дасан зохицох боломжийг олгох нь чухал. Хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг хүчин зүйл нь тухайн хүнд үүссэн согогоос гадна нийгмийн хандлага, орчны хязгаарлалт гэж бодож байна. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй ажилтандаа зориулан дараах өөрчлөлтийг хийвэл хэрэгтэй байна. Үүнд:

1. Ажлын байр болон ажлын байрны гадаад, дотоод орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, тохиромжтой болгох
2. Ажилчдынхаа хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд хандах хандлагыг өөрчлөх
3. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд сургалт зохион байгуулах

Тухайлбал, ХБИ-тэй өрхийн 42 хувь ядуу бол ХБИ-гүй өрхүүдэд энэ үзүүлэлт 18 хувь байдаг, 15-59 насны ХБИ-дийн 28 хувь хөдөлмөр эрхэлдэг бол хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлт 69 хувь байдаг, 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (ХБХ)-ийн 43 хувь нь бичиг үсэг тайлагдаагүй байдаг бол бусад хүүхдийн хувьд энэ үзүүлэлт 4 хувь байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлүүд эрүүл мэндийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс илүү өндөр зардал гаргадаг нь эм тариа, эмчилгээний ажилбар, аймгийн эрүүл мэндийн төвүүдэд байдаггүй шинжилгээ хийлгэхээр нийслэл рүү явах замын зардал зэргээс бүрддэг. Ийнхүү өндөр зардал гаргадгаас улбаалж хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхүүд ядууралд илүү өртөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгож буй боловсролын чанарыг эцэх эхчүүд муу хэмээн үнэлдэг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх байгууллагуудын мэдээлж байгаагаар тухайн дээд боловсрол эзэмших боломж хомс байдаг. Ингэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ядуурлын төвшин илүү өндөр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлсөн байгууллага, засгийн газар, салбарын мэргэжилтнүүдийн тодорхойлсноор дараах чиглэлүүдэд тэргүүн ээлжид сайжруулах арга хэмжээ шаардлагатай. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлийг эрт оношлох, үүнд хүүхдийн хөгжил, сурах чадварт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг эртнээс авах;
2. Нийгмийн үйлчилгээ, эмчилгээ, нөхөн сэргээх дэмжлэгээр хангах замаар биеийн үйлдэл, эдийн засгийн оролцоог хамгийн дээд төвшинд байлгах;
3. Оролцоог хангасан боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээгээр хангах;
4. Барилга байгууламж, нийтийн тээврийн орц гарцыг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулахын тулд дүрэм журмын нийцлийг сайжруулах, дэмжих хэрэгсэл, технологийн олдоц, хангамжийг нэмэгдүүлэх;
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн үзэл

бодол, хандлагыг өөрчлөх, нийгмийн халамжийн тогтолцоог илүү зорилтот, шударга болгох, хөгжлийн бэрхшээлийн дэмжлэг, төлөвлөлтийн үйлчилгээг ICF ангиллаар үнэлэх, мониторинг ба өгөгдлийн менежментийн тогтолцоон дахь хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтыг нарийвчлах зэрэг стратегийн үйл ажиллагаанууд шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг нь хязгаарлагдмал байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлсөн байгууллага нь “хамгаалагдсан орчны” болон хувиараа хөдөлмөр эрхлэлт зэрэг тусгаарлагдмал хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр голлон ажиллаж байгаа нь дараах шалтгаантай байна.

Дүгнэлт

Стратегийн уялдаа стратегийн дунд хугацааны үнэлгээгээр нийгмийн хамгааллыг онцгойлон тодорхойлсны дагуу нийгмийн хамгийн эмзэг гишүүдийг хамгаалах зорилгыг тэргүүнд тавьсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгаалал, нийгмийн тусламж үйлчилгээгээр хангах замаар зохистой амьжиргааг нь баталгаажуулах үйл ажиллагаа хэрэгжүүлснээр, 2017-2021 онуудад АХБ-наас Монгол Улсад хэрэгжүүлэх Улс орны түншлэлийн стратегитай нийцнэ. Хөгжлийн бэрхшээл эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусдаг бөгөөд нас болон ядуурлын улмаас жендэрийн тэгш бус байдал улам даамжирдаг. Эмэгтэйчүүдийн ядуурлын төвшин эрэгтэйчүүдийнхээс илүү гүнзгий байдаг ба хөгжлийн бэрхшээл, ядуурлын хооронд шууд хамааралтай юм. Аль ч насны бүлэгт, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ялангуяа хүнд төвшний хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс өндөр байдаг. Гэтэл дүн шинжилгээнээс харахад, охид эмэгтэйчүүдийн хөгжлийн бэрхшээлийг дутуу мэдээлдэг ба эрэгтэйчүүдийг хөгжлийн бэрхшээлтэйгээр бүртгэх магадлал 28 хувь илүү байна. Мөн түүнчлэн, 15-59 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 30 хувь ажил эрхэлдэг бол эмэгтэйчүүдийн үзүүлэлт ердөө 25 хувь байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран сувилагчдын 80 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд тэд нийгмийн хамгаалал, дэмжих үйлчилгээнд хангалттай төвшинд хамрагдаж чаддаггүй. Нийгмийн хамгаалал, нийгмийн тусламж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэгт бүгдэд нь хамааралтай байна.

Түлхүүр үг: *Хамгаалагдсан орчин, боловсрол, хөдөлмөр эрхлэлт,*

Ашигласан материал:

1. Монгол Улсын статистикийн эмхтгэл, ҮсХ, 2019 он
2. Монгол Улсын статистикийн эмхтгэл, ҮсХ, 2020 он
3. Нийслэлийн статистикийн эмхтгэл, ҮсХ, 2020 он
4. Хүн ам, нийгмийн халамжийн үзүүлэлтүүд, ХХҮЕГ, 2020 он
5. Нийгмийн даатгалын ерөнхий газар, 2020 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨВШИНГ ТОГТООХ НЬ

Г. Гал-Эрдэнэ, А. Анар¹

¹Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн оюутнууд

B18FA1031@ufe.edu.mn

B18FA1038@ufe.edu.mn

Үндэслэл

Энэхүү судалгаагаар 2021 оны байдлаар Улаанбаатар хотод оршин сууж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын төвшин, хөдөлмөр эрхлэлтийн төвшин болон хөдөлмөр эрхлэхтэй холбоотой тулгамдаж буй бэрхшээлийг судлан, шийдвэрлэж болох шийдэл, санал зөвлөмжийг хүргэнэ.

Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан судалгаагаар 2020 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 108,399 байсан ба хөдөлмөр эрхлэлтийн төвшин 7%-тай буюу 7,588 хүн хөдөлмөр эрхэлж байна гэсэн статистик үзүүлэлттэй байна. Харин бидний судалгаагаар судалгаанд оролцогчдын цөөнх нь тодорхой нэг байдлаар ажил эрхэлдэг ба тэдний дийлэнх хувиараа хөдөлмөр эрхлэн, нийтийн тээврээр зорчин ажлын байрандаа очдог байна.

Зорилго




Энэхүү судалгааны зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) боловсролын төвшин, хөдөлмөр эрхлэлтийн хувь, хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудыг судалгаа хийн олж илрүүлэх юм.

Материал ба арга зүй

Улаанбаатар хотод бүртгэлтэй нийт хөгжлийн бэрхшээлтэй 200-300 хүнээс санамсаргүй түүврийн байдлаар анкетын /асуулгын/ болон ярилцлагын аргаар судалгааг хийв.

Үр дүн

Энэхүү судалгаанд нийт 264 хүн хамрагдсаны дийлэнх 80 хүн буюу 30,3% нь 40-өөс дээш насны иргэд, хүйсийн харьцаа 150 эмэгтэй, 114 нь эрэгтэй байсан. Хөгжлийн бэрхшээлийн байдлаар нь ангилбал 163 хүн олдмол, 101 хүн төрөлхийн гэж хариулсан байсан. Судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 49.6% (131) хүн хөдөлгөөний бэрхшээлтэй байсан. Судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн төвшин 33%-тай байсан ба ажил эрхлэгчдийн дийлэнх буюу 39 нь сувилагч, тогооч, засварчин гэх мэргэжилтэй байсан. Мөн хөдөлмөр эрхлэгчдийн 40% нь 400,000-700,000₮-ний цалинтай байсан ба ажлын сэтгэл ханамжийн байдалд 63% нь хангалуун, 21% нь маш хангалуун, 16% нь хангалуун бус гэж хариулсан. Хөдөлмөр эрхлэгч иргэдийн ажлын байранд асуудал тулгардаг уу гэсэн асуулгад 47% нь тийм гэж хариулсан ба түгээмэл тулгамддаг асуудал нь ажлын ачаалал их, ажлын цаг их, дотоод орчин муу, зориулалтын шат байдаггүй, цахилгаан шатны хэрэгцээ зэргийг дурдсан байсан.



Дүгнэлт

Судалгаанд оролцогч ХБИ-ийн дийлэнх хувийг нь олдмол хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд эзэлж буйгаас аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл олон нийтэд сайтар түгээх, боловсруулах хэрэгтэйг харуулж байна. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн төвшин 33% байгаа нь нийт ХБИ-ийн үр дүнг илтгэхгүй ч тус үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн төвшин бага байгааг илтгэж байна. Тийм учир ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд анхаарал хандуулах нь зайлшгүй асуудал болж буйг дээрх үр дүн нь илтгэнэ. Мөн хөдөлмөр эрхлэгч иргэдийн ажлын байранд тулгамддаг асуудлуудыг шийдэх хэрэгтэйг харуулж байна. Судалгаанд оролцогчдоос авсан асуулгад ажлын орон тоог нэмэх, багасгасан цагаар ажиллах, налуу зам, зориулалтын цахилгаан шат, ажлын байрны агааржуулалт сайжруулах, бусад иргэдэд ХБИ-ийн талаарх мэдээллийг сурталчлах гэх мэт асуудлуудыг дэвшүүлсэн байна. Дээрх асуудлууд нь хамгийн их тулгамддаг асуудлууд ба эдгээрээс гадна олон асуудал тулгамдсаар байна. ХБИ-ийн ажлын байранд тулгамддаг асуудлуудыг буруулснаар ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх алхам болно хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын төвшин, хөдөлмөр эрхлэлт, орчин нөхцөл, тулгамдсан асуудал

Ашигласан материал:

1. Статистик мэдээллийн нэгдсэн сан (2021). Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, 1212.mn
2. ХХЕГ (2019). Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь - 2019. Монгол Улс, Улаанбаатар хот,
3. ХХЕГ (2020). Хөгжлийн бэрхшээл судлал ба инноваци - 2020. Монгол Улс, Улаанбаатар хот,

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИРОМЖТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Б.Мянганбаяр, Г.Сарангэрэл¹

*¹ДХИС, Эрх зүй нийгмийн ухааны сургууль, 221-р дамжаа
sarangerel.g202012v@gmail.com
batsvhmynganbayr@gmail.com*

Үндэслэл

Олон арван жилийн туршид хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол одоо нийгмийн амьдралд оролцох талаас нь авч үздэг болсон. Тэд хөдөлмөрийн харилцаанд өргөн оролцдог бөгөөд тэдгээрт тохирсон ажил хөдөлмөр, хөдөлмөр нийгэм хамгааллын асуудал хөндөгддөг байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон байнгын ажлын байрыг нэмэгдүүлэн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэх ба энэхүү байдал хэрхэн хангагдаж буйг хүргэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийсэн болно.

Материал ба арга зүй

НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай, хөдөлмөр эрхлэлтийн, эрэлттэй ба тохиромжтой ажил мэргэжлийн тухай илтгэлүүд, нийгмийн сүлжэээ буюу интернэт орчны мэдээллүүдэд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүх тогтолцоо болон үйлчилгээг хүртээмжтэй болгох шаардлагатай бөгөөд тэдэнд зориулсан тусгай хөтөлбөр, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүсийг хамруулах, тохирох санхүүжилтийг олгож, боломжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийн талаар судалгааны ажил хийхийг дэмжих, манай Монгол улсад дээрх 7 ажлын байрыг /нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, зөвлөх, эмнэлгийн удирдлагын туслах, дуудлагын төв, хуулийн туслах, эмийн сангийн техникч, гэрийн ажил/ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжоор хангах шаардлагатай.

Дүгнэлт

Орчин үед нийгэм хөгжихийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн байдлаас нь болж гэртээ байнга сууна гэсэн ойлголт байхаа больсон билээ. Өөрсдийн боломж бололцоондоо тохируулан хөдөлмөрийн зах

зээлд оролцдог болсон. Хөдөлмөрийн тухай хуулинд ч аж ахуй нэгжүүдэд тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулах тухай зааж өгсөн байдаг. Мөн олон төрлийн гэрээ, конвенцууд хэрэгжиж байдаг. Тэд өөрсдийн нийгэмд гарч ажиллах боломж бололцоогоо мэдэхгүйгээс ажил хөдөлмөр эрхэлдэггүй тохиолдол цөөнгүй байдаг. Тэдэнд мэдээлэл олгохын тулд олон төрлийн хөтөлбөрүүд зохион байгуулж идэвхтэй явуулж байсаар байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хийхэд тохиромжтой ажил мэргэжлүүд цөөнгүй бий. Мэргэжил сургалтын төвүүд ч цөөнгүй байдаг бөгөөд олон чадварлаг мэргэжилтнүүд төрөн гарч байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бэрхшээлтэй гэдгээсээ болж нийгэмд оролцохгүй байхаас илүү нийгмийн нэг хэсэг гэдгээрээ ажил хөдөлмөр эрхлэн нийгэмдээ хөрөнгө оруулалт хийн амьдрах нь зүйтэй юм. Дэлхийн ихэнх улс орнуудын уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг үзэл санаа өргөжин тэлж, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгаар хөгжиж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдтэй адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, тэдгээртэй ажил хөдөлмөр эрхэлж, ижил хөлс авах зэрэг үзэл санаанд үндэслэн хөгжиж байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил хөдөлмөр, нийгэм хамгаалал, ажлын байр, таатай нөхцөл*

Ашигласан материал:

1. НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц 2006 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэлхийн тайлан 2011 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа УБ. 2020 он
4. Ажил хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны зуучлал 2003 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Отгонбаяр¹

¹Их Засаг Олон Улсын их сургуулийн IV курсын оюутан

Үндэслэл

Хүн бүр яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, язгуур угсаа, бусад ялгааг эс харгалзан хүний эрх, эрх чөлөөг алагчлалгүйгээр эдлэх нь хүний эрхийн үндсэн зарчим юм. Энэхүү эрх, эрх чөлөө нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактууд болон НҮБ-ын хүний эрхийн талаарх бусад гэрээ, конвенцоор баталгаажсан. ХЭТТ-ын 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт "хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг тохиолдолд төрөөс эд мөнгөний тусламж авах эрхтэй" хэмээн заажээ. Дээрх суурь харилцаануудаас үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн баталгааг дээшлүүлэх ажлууд хийгдэж байгаа хэдий ч нийгэмд одоог хүртэл тулгамдсан асуудлууд байсаар байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгарч буй олон асуудлууд байгаа ч энэхүү илтгэлээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, сурч боловсрох эрхийн талаар авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгч, саналаа дэвшүүлэхийг зорилоо.

Материал ба арга зүй

Баримт бичгийн болон тоон мэдээлэлд анализ хийв.

Үр дүн

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн болон санхүүгийн бус урамшуулал олгохоор, түүнчлэн хуульд заасан хувь хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллаагүй бол сар бүр төлбөр төлөх үүрэг хүлээлгэсэн хэдий ч Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилт хангалтгүй байна. Ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулахаас илүүтэй ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөр төлөх байдал давамгайлж байна. Гэвч сар бүр төлбөр төлөх нь мөн хүндрэлтэй байгаа учир цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах сонирхол өндөр байгааг судалгаагаар тогтоожээ. 2018 оны байдлаар 25-аас дээш даатгуулагчтай ААНБ-ын тоо 5230 байгаа бөгөөд үүнээс 39.4 хувь буюу 2061 ААНБ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Үүнээс 41.9 хувь буюу 863 ААНБ нь квотын дагуу зохих тоогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулжээ. Харин үлдсэн ААНБ-ын дөнгөж 5.2 хувь буюу 273 нь Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих санд төлбөр төлжээ. Үүнээс хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, хууль зөрчсөн ААНБ-д тогтоосон хэмжээгээр төлбөр гаргуулах ажиллагаа хангалтгүй байгаа нь харагдаж байна. Ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулахаас зайлсхийж байгаа үндсэн шалтгаан нь ажилд орохоор хандаж байгаагүй (42.9%), боломжтой ажлын байр байхгүй (25.5%), ажиллуулах сонирхол байхгүй (8.6%), Ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй (5.7%), Хөгжлийн бэрхшээлтэй хүний ур чадвар нь шаардлагад нийцээгүй (20%) гэжээ. Харин зарим судалгаагаар хөдөлмөр эрхлэхэд тулгардаг бэрхшээлийг тодруулахад 21.4 хувь нь ажлын туршлагагүй, 22.9 хувь нь гадаад төрх, бие бялдрын хөгжил, 17.1 хувь нь дэд бүтцийн хүртээмж, 15.7 хувь нь ялгаварлан гадуурхалт, сөрөг хандлага, 12.9 хувь нь ар гэрийн асуудал, 11.4 хувь нь боловсролын төвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй хэмээн үзжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх эрх зүйн орчин сайтар бүрдсэн хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн төвшин хангалтгүй байна. Зарим судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэхэд тулгардаг бэрхшээлийг тодруулахад 21.4 хувь нь Ажлын туршлагагүй, 22.9 хувь нь гадаад төрх, бие бялдрын хөгжил, 17.1 хувь нь дэд бүтцийн хүртээмж, 15.7 хувь нь ялгаварлан гадуурхалт, сөрөг хандлага, 12.9 хувь нь ар гэрийн асуудал, 11.4 хувь нь боловсролын төвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй хэмээн үзжээ.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн асуудал

Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бүрэн, үнэн зөв мэдээллийн тогтолцоо бүрдээгүй нь системийн алдаанд нөлөөлж байна. 2019 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 3.3 хувь буюу 107,075 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа ерөнхий статистик тоо мэдээ байгаа хэдий ч үндэсний хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн нийгэмшихүй-сэтгэл хөдлөлийн хөгжлийн талаарх нас, хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй, мөн бага, дунд, ахлах анги суралцагч болон их, дээд сургуулийн оюутны нэгдсэн бүртгэл, тоо мэдээлэл байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэр дундаа сурч боловсрох эрхийг чиглэлээр олон тооны судалгааны тайлан байгаа хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр өгөөжийн талаар цогц дүн шинжилгээ судалгааны явцад олдсонгүй. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар зэрэгт дүн шинжилгээ хийх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй болон онцлог хэрэгцээтэй хүүхдийн боловсролын санхүүжилтийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд бусад улс орны загвар, аргачлал, тэргүүн туршлагыг судлах замаар одоогийн санхүүжилтийн тогтолцоог шинэтгэх шаардлагатай. Жишээ нь: АНУ-ын муж бүр хөгжлийн бэрхшээлтэй болон онцлог хэрэгцээтэй хүүхдийн боловсролын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхдээ харилцан адилгүй долоон өөр төрлийн аргыг өөрийн онцлогт тохируулан хэрэглэдэг. Эдгээрт, (i) Multiple student weight, (ii) Single student weight, (iii) Census-based system,

(iv) Resourceallocation model, (v) Reimbursement System, (vi) Block Grant, (vii) High-cost student system

Дүгнэлт

Ажлын туршлагагүй, эсхүл боловсрол мэдлэг нь хөдөлмөр эрхлэхэд шаардлага хангахгүй байгаа асуудлыг сургалтын бодлогоор шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмж, түүний чанарыг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангах асуудалд онцгойлон анхаарч, холбогдох дэд бүтцийн стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхах хандлагыг эцэс болгох, тэдний хөдөлмөр эрхлэх идэвх, санаачилгыг өдөөх зохион байгуулалтын ажлыг олон арга, төрлөөр зохион байгуулах. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа ААНБ-д үзүүлэх урамшууллын талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг таниулан сурталчлах ажлын хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийг хангуулах

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой ажлын байраар хангасан ААНБ-д татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг таниулан сурталчлах ажлыг эрчимжүүлэх;
- ✓ ААНБ-ын үүргийн хэрэгжилтийг хангуулах шалгалтыг ажлыг эрчимжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллаагүй ААНБ-ын төлөх төлбөрийг зайлшгүй авч хэвших;
- ✓ Ажлын байрны тохируулга хийсэн ААНБ-ыг татварын бодлогоор дэмжих;

Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалал хүртэх, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлж, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд тогтмол дүн шинжилгээ хийхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх өргөн хүрээний бодит, үнэн зөв мэдээллийг бий болгож, салбар хоорондын уялдаа холбоог бий болгох шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх чиглэлээр батлан гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, төслүүдийн бодит хэрэгжилтэд иж бүрэн, дүн шинжилгээ, судалгаа хийх онцгой шаардлагатай байна.

Түлхүүр үг: Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, дэд бүтэц, хүртээмж, бодлого

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль.,УБ. 1992 он
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
4. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс “Монгол улс дах хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл” сэтгүүл, 2007 он
5. Хөдөлмөрийн Яам, Хөдөлмөрийн Судалгааны Институт, “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа” 2013 он
6. Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан 2019 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Б.Анужин, Ц.Анужин, Б.Анударь¹

¹Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
2-р дамжааны суралцагчид
anujinanu137@gmail.com

Үндэслэл

Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах тал дээр төрөөс зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч хангалттай хэмжээнд хүрч хэрэгжихгүй байгаа билээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээ, чадавхад үндэслэсэн тусгай ажлын байр дутмаг байгаа нь тэдний ихэнх нь хувиараа бизнес эрхлэх, төрийн бус байгууллагад ажиллахад хүргэж байгаа. Үүгээр зогсохгүй огт хөдөлмөр эрхлэхгүй байх асуудалд хүргэж байгаа юм. Нийгмийн хандлага нь тэднийг бусдаас өөр гэж хүлээж авдаг нь тэднийг хөдөлмөр эрхлэхэд хамгийн том асуудал болдог ба хөдөлмөр эрхлэх байгууллагад тэдний ажиллах орчин бүрдээгүй байдаг нь дараагийн хүчин зүйл болдог.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрөөс тогтоосон бодлогын хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэх орчин нөхцөлийг сайжруулах арга замыг олох зорилгоор энэхүү судалгааг хийв.


Материал ба арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, орчин нөхцөл, Хөдөлмөрийн тухай хуулийг харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг боловсролын төвшнөөр харахад суурь боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй залуучууд хамгийн өндөр буюу 42.3 хувийг, дараа нь бүрэн дунд боловсролтой залуучууд 31.2 хувийг эзэлж байна. Харин 7.5 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, 0.1 хувь магистр залуучууд байна.

График 1. ХБИ-ийн боловсролын төвшин



“Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажил эрхлэлтийн статусаар нь харахад 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, харин албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй өндөр байна. Үүнээс үзвэл “Хөдөлмөрийн тухай хууль” болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль” нь хангалттай хэрэгжиж үйлчлэхгүй байгаа ба ямарваа нэгэн байгууллагад ажиллахад тэдэнд зориулсан ажиллах нөхцөл байдал хангагдаагүй байдаг нь асуудалтай юм. Хэрэв хууль болон конвенц нь бүрэн утгаараа хэрэгжиж байсан бол байгууллага бүр зохион байгуулалтандаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан орчин, нөхцөлийг бүрдүүлэх боломжтой байсан ба одоо ч хэрэгжүүлэх боломжтой юм.

График 2. ХБИ-ийн ажил эрхлэлтийн статус



Дүгнэлт

Нийгэм, эдийн засгийн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал байдгаас ядууралд өртөх магадлал өндөр байдаг учир мэргэжлийн чиг баримжаа олгох, тэдний онцлогт тохирсон ажлын байр бий болгох талаар анхаарах хэрэгтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрөөс дэмжих бодлогын хувьд хангалттай төвшинд байдаг хэдий ч хэрэгжилт нь төдий чинээ хангагдаж чаддаггүй байна. Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, урамшууллын системийг боловсронгуй болгох, Хуулийн хэрэгжилтийн хяналтыг эрчимжүүлэх, Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг нарийн ангилах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн ур

чадвар олгох арга хэмжээг сайжруулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх, мэргэшүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хууль эрх зүйн хэрэгжилт, хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны хомсдол.*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2018
2. Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
4. Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик 2020

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ж.Ууганчимэг¹, Т.Мөнх-Өлзий, Д.Мичидмаа²

¹Хувийн эрх зүйн тэнхмийн дэд профессор, ахлах багш

²ДХИС, ЭЗНУС-ийн 221-р дамжааны оюутнууд

Үндэслэл

Эрх тэгш хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн хавтгайрал, ялгаварлан гадуурхлыг багасгана. Энэхүү зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуульд тусгайлан зааж өгсөн байдаг бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэгдсэн найруулгад илүү нарийвчлан зааж өгсөн байна. Хөгжлийн бэрхшээл нь хөдөлмөрлөх эрхээ хязгаарлуулах шалтгаан болох ёсгүй гэдгийг энэхүү илтгэлийн агуулга болгон хөндсөн ба нийгмийн хариуцлагатай аж ахуй нэгж, байгууллага бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах онцгой нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай юм. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ажиллах ажил мэргэжлийн хувьд онцлогтой бөгөөд ажиллах нөхцөлийг бий болгох нь нэн тэргүүний ажил мөн. Хөдөлмөрийн харилцаанд хүн бүр тэгш эрхтэйгээр оролцох эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жирийн иргэдтэй харьцуулбал сурч боловсрох, ялангуяа мэргэжил эзэмших сургалтад хамрагдахад илүү хүндрэлтэй тулгардаг бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй олон иргэдийн цаашдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр хайж олоход нь томоохон саад болдог. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд авч ажиллуулах сонирхол ажил олгогчдод төдийлөн байдаггүй.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйл болох боловсролын асуудлыг тодорхойлох.

Материал ба арга зүй/ Судалгааны арга зүй

Баримт бичиг дээр дүн шинжилгээ хийв.

Үр дүн

Хөдөлмөрийн харилцаанд оролцох хамгийн гол шалтгаан бол материаллаг хэрэгцээг хангаж анхдагч хэрэгцээгээ бүрдүүлэх юм. Энэ шаардлага нь хүн бүрд тулгардаг боловч бүгд хөдөлмөрийн харилцаанд эрх тэгш байдлаар одоогоор оролцох бололцоогүй байна.

Монгол орны хувьд 2020 оны байдлаар 107075 хүн хөгжлийн бэрхшээлтэй буюу нийт хүн амын 3.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

График 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт:/15 ба түүнээс дээш нас/



Тэдгээр хүмүүсийн хувьд хөдөлмөр эрхлэхэд дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:Гадаад төрх, бие бялдрын хөгжил-22.9%,Ажлын туршлагагүй-21.4%,Дэд бүтцийн хүртээлгүй байдал-17.1%,Ялгаварлан гадуурхал, сөрөг хандлагууд-15.7%

Ар гэрийн асуудал-12.9%, Боловсролын төвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй-11.4%. Эдгээр асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй нэн тэргүүний асуудал боловч засаж залруулах боломж тэдгээр хүмүүст байдаггүй гадаад хүчин зүйлсийн нөлөөтэй байгааг энэхүү судалгаа харуулж байна.

Дүгнэлт

Хөдөлмөрийн нээлттэй зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэнд тулгарч буй бэрхшээл нь тэдгээр иргэдийн “Хөгжлийн бэрхшээл”-ээс шалтгаалах бус харин хөндлөнгийн буюу нийгмийн хандлагаас шалтгаалж байдаг. Нийгмийн хандлагыг өөрчилснөөр дээр дурдсан дэвшилттэй талууд бий болохын зэрэгцээ хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд зуучлах, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг илүү бүрдүүлэх боломжтой учраас тусгай хэрэгцээтэй хүмүүсийн амьдралын баталгаа болсон хөдөлмөрийн үр шимийг эдлүүлэх боломжтой болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэхэд нэн тэргүүнд дараах асуудлуудыг шийдэх хэрэгтэй байна:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох нөхцөл, боломжийг дээшлүүлэх, хүртээмжтэй болгох хэрэгтэй. Ингэснээр нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, сурч боловсрох, цаашлаад нийгэмд эзлэх байр суурьтай бие хүн болж төлөвшихийн эхлэл болох юм. Мөн ажил олгогчдийн чиг хандлагыг сайжруулж, хариуцлага, хууль эрх зүйн орчинг сайжруулах.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, Хөдөлмөрлөх нөхцөл, ажил, асуудал

Ашигласан материал:

1. https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf,
2. <https://zety.com/blog/jobs-for-people-with-disabilities>,
3. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_537355.pdf

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖУУД

Т. Хонгорзул¹

¹Хөдөлмөр Нийгмийн Харилцааны Дээд Сургууль

Khongorzul.tumursukh0525@gmail.com

Үндэслэл

Монгол улсын хэмжээнд 11 мянга орчим харааны бэрхшээлтэй хүн байгаагаас 4,6% нь хөдөлмөр эрхэлдэг байна. Үүнээс харахад “Хараагүй иргэдийн хөдөлмөр сургалтын төв”-д 320 хүн хамарснаас 70 орчим хувь нь массажистаар ажилладаг. Хараагүй иргэдийн дийлэнх хувь нь массажист болон хараагүйчүүдийн үйлдвэрт ажилладаг. Харин бусад орны хараагүй иргэд компьютер, интернетийн мэдлэг эзэмшин хүмүүст мэдээлэл өгөх зэрэг ажил хийдэг тиймээс хөдөлмөр эрхлэлтийн ажлын байрыг нэмэх шаардлага харагдаж байна.

Зорилго

Уг судалгааны зорилго нь харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх боломж нөхцөлийг гаргаж ирэх.

Материал ба арга зүй

Энэхүү судалгааг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооноос 2021 оны 11-р сарын 03-наас 11-р сарын 10-ны хооронд санамсаргүй түүврийн аргаар 12 хүнээс ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргаар авсан.

Үр дүн

График 1.

Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт




График 2.

Харааны бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал




График 3. БНХАУ-ын Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төрөл



Дүгнэлт

Судалгааны дүгнэлтээс харахад харааны бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэхэд хамгийн хүндрэлтэй зүйлсийг хэлэхдээ ажлын байрны олдоц хомс, хөтөч үйлчилгээ мөн хөтөч нохойн үйлчилгээ, дэд бүтэц, олон нийтийн хандлага, мэргэжлийн суурь олгох сургалт зэрэг асуудлуудыг тодорхойлсон нь эдгээр үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Бусад орны туршлагаас харахад манай урд хөрш болох БНХАУ гэхэд харааны бэрхшээлтэй 17.31 сая иргэн байдгаас 5 сая буюу 29.4% харааны бэрхшээлтэй иргэдээ нь харилцаа үйлчилгээ үйлчилгээний салбарын сэтгэл зүйн зөвлөх, радио нэвтрүүлгийн хөтлөгч, лавлах утасны оператор, утсаар зөвлөгөө өгөх ажилтан, харилцааны ажилтан, гадаад хэлний орчуулагч, мөн гадаад хэлний орчуулга, анагаах ухааны массаж зэрэг салбар бүрт олон төрлийн хөдөлмөр эрхэлдэг байна. Монгол улсын хувьд харааны бэрхшээлтэй ажил эрхэлж байгаа 5.4% иргэдээс нэг хүрэхгүй хувь нь массажны газарт ажиллаж байна. Тиймээс бариа газруудыг нэмэгдүүлж хувь хүнд чиглэсэн сургалтуудыг явуулж ажлын байруудыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөдөлмөр эрхлэлт, Хөтөч нохой

Ашигласан материал:

- [1]. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. (2021). Монгол улс дахь харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [2]. Сэтгэц эрүүл мэндийн үндэсний төв, (2017) Сэтгэцийн эрүүл мэндийн статистикийн үзүүлэлт. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [3]. Батцэнгэл Г, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэл зүйн асуудлууд”, УБ хот 2014
- [4]. www.News.cctv.com

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ 2021” (ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ)

Б.Оюунгэрэл, Г.Лхагважав, О.Халиунаа
gegeenee.ob@gmail.com

Үндэслэл

Японы ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршлагыг ХБИ-нд Мэргэжлийн чиг баримжаа олгодог сургалтын байгууллагууд хэрэгжүүлэн, “Ажлын байранд дадлагажуулагч”-ийг ажиллуулж, тухайн ХБИ-нд тохирсон ажилд зуучлан, ажлын байранд нь дасан зохицож дадлагажих хүртэл нь “Ажлын байранд дадлагажуулагч” нь зөвлөн туслах, чиглүүлэх, дэмжих үйлчилгээг үзүүлдэг болсноор Монгол Улсын ХБИ-н хөдөлмөр эрхлэлтийн төвшин нэмэгдэнэ гэж үзэж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэний дараа ирээдүйд хийх ажил мэргэжлийн талаарх төсөөллийг судлах, ХБИ-д тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжийг судлах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ.

Материал ба арга зүй

- 55 дугаар сургуулийн 9-р ангийн болон мэргэжлийн ангийн сурагчдын эцэг эхчүүдээс
- Мэргэжлийн ангид суралцдаг ахлан ангийн сурагчдаас
- Мэргэжлийн ангийг төгсөөд ажил эрхэлж байгаа төгсөгчдөөс
- Хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа ХБИ-с тус тус санал асуулгын аргаар судалгаа авч, үр дүнг боловсруулав.

Үр дүн

Суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөх гэж буй сурагчдын эцэг эхчүүд ихэнх хувь нь хүүхдүүдээ бэрхшээлд нь тохирсон хөдөлмөр эрхлүүлэх хүсэлтэй байгаа нь судалгаагаар харагдаж байна. Нийслэлийн ерөнхий боловсролын 55 дугаар сургуулийн мэргэжлийн ангид суралцаж байгаа сурагчдын ирээдүйд ямар ажил хийх хүсэлтэйг тандахад Багш, Тамирчин, Жолооч, Хамгаалагч, Барилгын дарга, Ахлах тогооч, Зураач, Бичиг хэргийн ажилтан, Гал командлагч, Дизайнер зэрэг хүсэл мөрөөдлөө хуваалцаж байсан ч сургуулиа төгсөөд ямар ажил хийхээр төлөвлөсөн талаарх судалгаанд мэргэжлийн дагуу ажиллана гэж 47% нь хариулжээ.

Ерөнхий Боловсролын 55 дугаар сургуулийн мэргэжлийн ангид суралцаж төгссөн 5 төгсөгчийн 3 нь “Тогооч”, 1 нь “Зочид буудлын өрөө үйлчлэгч”, 1 нь “Компьютер” мэргэжлийн ангийг төгссөн. Төгсөгчид ААНБ-д, Төрийн байгууллагад үйлчилгээний ажил, туслах тогооч, бэлтгэгч, бичиг хэргийн туслах ажил гэх мэт мэргэжлийн дагуу ажил эрхэлж байгаа ба хамт

олон нь хэт их анхаарал тавьдаг байна. Ажил эрхлэхэд цагийн ачаалал хэт их, тухайн байгууллагын тусгай хэрэгслийн хүртээмж муу байдаг ба ажлын байран дээр тулгамдаж байгаа асуудлаа шийдвэрлэхдээ ихэнхдээ бусдаас тусламж авдаг байна. (график1)



Хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа Сэтгэцийн ХБИ-с авсан судалгаанд Үсчин, Цэцэрлэгийн багш, Мужаан, Засал чимэглэл, Тогооч, Гануурчин зэрэг мэргэжилтэй ХБИ хамрагдсан ба ихэнх нь ААНБ болон Төрийн байгууллагад ажиллах хүсэлтэй байгаа боловч ажилд зуучлах газар мэддэггүй, мэргэжлийн ур чадвар дутмаг байдаг нь томоохон асуудал болоод байгаа юм. (график2)

Нийслэлийн Ерөнхий боловсролын 55 дугаар сургуулиас “Тогооч” мэргэжлийн багш О.Буд хамрагдан Япон улсын ХБИ-дэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн юм. Хөдөлмөр эрхлэлтийн сэргээн засалтын (хөдөлмөр эрхлэлтийн үнэлгээ, дадлага сургуулилт, ажлын байранд дадлагажуулагч гэх мэт) үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн болон орон нутгийн байгууллагууд халамжийн бодлоготой нягт уялдаатайгаар ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн бие даасан байдлыг дэмжиж ажилладаг. Ажлын байранд дадлагажуулагчийн үүрэг:

- Дэмжлэгт хамрагдаж буй ХБИ тухайн ажлыг гүйцэтгэх, ажлын байрандаа дасан зохицоход шаардлагатай бодит зорилтуудыг тодорхойлж, дэмжлэгийн төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлнэ.
- Тухайн ХБИ төдийгүй, байгууллага болон ХБИ-ийн гэр бүлийнхэнд ч дэмжлэг үзүүлнэ.
- Ажлын байранд дадлагажуулагчийн зүгээс ХБИ-д үзүүлж буй дэмжлэгийг байгууллагын удирдлага болон хамт олны дэмжлэг рүү саадгүй шилжүүлэх үйл явцыг зорилт болгоно.

график 1.

график 2.



Дүгнэлт

Бэрхшээл бүрийн цаана боломж байдаг. Судалгааны ажлаа хийж гүйцэтгээд дараах дүгнэлтийг хийж байна.

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлууд:

Улсаас ХБИ-д чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээ явагддаг боловч хүртээмж, үр дүн муутай байна. ХБИ-тэй иргэдийн бэрхшээлийн онцлогт тохирсон уян хатан цагийн зохицуулалт байдаггүй. ХБИ-ийн ажиллах ур чадварт тохирсон ажлын төрөл маш ховор, өөрт тохирсон ажлыг хэрхэн хайж олохыг мэдэхгүй, мэргэжил олгох сургалтын байгууллага цөөн

байдаг, ажлын байран дахь тусгай хэрэгслийн хүртээмж муу байдаг.

Хөдөлмөрийн насны ХБИ болон хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй иргэдэд:

ХБИ-д Мэргэжлийн сургалт явуулдаг улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд ХБИ-дэд мэргэжлийн чиг баримжаа олгосоноор, өөрт тохирсон ажил хөдөлмөр эрхлэх боломж нээгдэж байна. Зарим ААНБ хуульд заасан квотыг биелүүлэн ХБИ-ийг тохирох ажилд авч ажиллуулж байна. Япон болон малайзын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог судалж сайн туршлагыг Монголдоо хэрэгжүүлэхээр Улсын хэмжээний төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Дэвшүүлэх санал:

1. Япон улсын ХБИ-ийн нөхцөл байдалд нийцсэн ажилд зуучлах үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, ажлын байрны мэдээлэл цуглуулах, танилцуулах “Ажлын байранд дадлагажуулагч” гэх мэт сайн туршлагыг Монголын ХБИ-д Мэргэжлийн боловсрол олгодог сурргалтын байгууллагууд хэрэгжүүлж, байгууллага болгон “Ажлын байранд дадлагажуулагч”-ийн шинэ орон тоог бий болгох.

2. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хууль “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулахаар тус тус тусгасан байдаг. Эдгээр хуулийн дагуу ажил олгогчийг дэмжих урамшууллыг сайжруулах.

Түлхүүр үг: Зөвлөгч, чиглүүлэгч, дэмжигч

Ашигласан материал:

- [1] Барбара Мюррей, Роберт Херон “Ажил хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны зуучлал – Үйлчирлгээний үр дүнг сайжруулах арга замууд” 2003 он
- [2] ХНХЯ болон ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас явуулсан “Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн “Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн загварт суурилсан ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо ба үр дүн” сургалт
- [3] Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт” судалгааны тайлан 2018 он
- ХНХЯ, ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа- Мэдээллийн лавлах” 2017 он
- [4] Монгол Улс 1998.02.03-нд соёрхон баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенц”
- [5] www.legalinfo.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Э.Шинэлүндаа¹

¹СЭЗИС-н Санхүү Удирдлагын Тэнхимийн 3-р курсын оюутан
B19FT1041@ufe.edu.mn

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хангах, бүрэн боломжийг нь дэлгэрүүлэн, тэгш боломж олгох нь бидэнд болон дэлхий нийтэд тулгарч буй асуудал юм. Дийлэнх ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг энгийн иргэдээс ажлын чадвар дутмаг бус байсан ч илүүд үзэж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ямар ихээр зөрчигдөж байгааг илтгэнэ.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих арга зүйг хайхад оршино.

Материал ба арга зүй

Баримт бичгийн болон тоон мэдээлэлд анализ хийв.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь жирийн бидний л ижил хэрэгцээ шаардлагаар ажил хайж байдаг. Тэд орлоготой байж, бусдаас хараат бусаар амьдарч, нийгмийн харилцаанд оролцохыг хүсдэг. Ажил хайж буй бусад хүмүүсийн нэгэн адилаар хүссэн, сонирхсон ажлаа хайж олох, ажиллах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөртөө итгэх итгэл хамгийн чухал ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жирийн иргэдтэй харьцуулбал, сурч боловсрох, мэргэжил эзэмших сургалтад хамрагдахад илүү хүндрэлтэй тулгардаг бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй олон иргэдийн цаашдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр хайж олоход нь томоохон саад болж тэдний өөртөө итгэх итгэлийг үгүй хийдэг. Мэдээж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд авч ажиллуулах сонирхол ажил олгогчид төдийлөн байдаггүй, эдгээр иргэдийн ажлын бүтээмж, байгууллагын үйл ажиллагаанд оруулах хувь нэмэрт эргэлздэг зэрэг сөрөг хандлага нь маш том бэрхшээл болдог. Үүнд төрийн оролцоо томоохон хувь эзлэх болно. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь хэд, хэдэн хэлбэртэй байх бөгөөд үүнд ажил олгогчдыг урамшуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, тэдэнд хөдөлмөр эрхлэх нөөц боломж, чадамжаа батлах боломж олгох хэрэгтэй. Энэхүү аргаар ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажиллах боломж олгосноор тухайн албан газар төр засгаас үзүүлэх ямар нэгэн урамшуулал, хөнгөлөлтөд оролцох боломжийг олгоно. Өөр нэгэн арга бол квотын зохицуулалт буюу нийт ажиллагсдын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлсэн байх зохицуулалт ба энэ нь ерөнхийдөө албан журмын зохицуулалт юм.

Эдгээр арга замын үр дүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь тухайн

аж ахуйн нэгж байгууллага төдийгүй улс орны эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах боломж олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажиллах боломж олгосноор улс, орны ажилгүйдлийн төвшин буурч улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр эзлэх болно. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн болгоныг хүссэн ажилд нь хуваарилбал тухайн аж ахуй нэгж байгууллагын хөдөлмөрийн төвшинг унагаах аюултай ба тухайн ажлын байранд тавигдах ур чадварыг бүрэн эзэмшсэн, зөв ажлын байрандаа тавигдсан эсэх болон шаардлагатай туслалцаа дэмжлэг авсан эсэх нь чухал болно.

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгч иргэдийн тоо өссөн, нөгөөтээгүүр тэдгээрийн олонход нь тусгай үйлчилгээ, дэмжлэг шаардлагагүй байсан зэргээс шалтгаалан олон улс орнууд тэдгээрийн иргэдийг ажил хайгч бусад жирийн иргэдийн нэгэн адилаар ажлын байранд зуучлах болсон. Үүний тод жишээ нь Монголд орж ирж буй үндэстэн дамнасан компаниуд болох CU, Circle K, KFC гэх мэт газрууд олон улсын ажлын байрны дүрмийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах нь заагдсан байдаг учир хүснэгт1.-ийн дагуу монгол улс дахь ажилгүйдлийн төвшин буурсан байдал нь харагдана.

Хүснэгт1. Ажилгүйдлийн төвшин, хувиар

2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
11.6	9.9	7.7	8.2	7.9	7.9	7.5	10	8.8	7.8

Уг хүснэгтээс ажиглахад 2013-14 онд KFC гэх мэт олон улсын ажлын байрны стандарттай газрууд нээгдсэн нь ажилгүйдлийг бууруулах нэг шалтгаан болж өгсөн нь харагдах ба 2017 оноос Монголд CU, Circle K гэх мэт газрууд маш олноор гарч ирсэн нь 10% хүртэл өсөөд байсан ажилгүйдлийн төвшинг бууруулж чадсан.

Уламжлал ёсоор бол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хариуцах хариуцлага нь халамжийн үйлчилгээний яам, эсвэл эрүүл мэндийн яамны хариуцах асуудал байсаар ирсэн ба одоо ч зарим улс орнуудад байсаар байна. “Хөгжлийн бэрхшээл”-ийн талаарх ойлголтод гарч буй өөрчлөлтийн улмаас хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон бодлого, үйлчилгээ нь аажмаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн яаманд шилжиж байна. Энэхүү хандлагатай зэрэгцэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бий болгож буй улс орнууд эхнээс нь хөдөлмөр эсвэл хүний нөөцийн асуудал эрхэлсэн яаманд хариуцуулах ёстой гэж үзэж байна.

Олон улс оронд төрийн бус байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй, ажил хайгч иргэдийг дэмжих асуудалд чухал оролцоотой явж ирсэн бөгөөд төрийн үйлчилгээг сайжруулан шинэчлэх хэлбэрээр оролцож ирсэн. Төрийн бус байгууллагууд ажлын байрны зуучлалын үйлчилгээ үзүүлсээр байгаа бөгөөд төрийн үйлчилгээний ажлыг хөнгөвчлөх нэгэн чухал үүсвэр болж байна. Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээнд төрийн бус байгууллагуудын ажлын байрны зуучлалын үйлчилгээ болон хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны сүлжээг ашиглах боломжтой.

Миний санал болгож байгаа зүйл бол төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд зуучлах газрыг санхүүжүүлж гаргаж өгөх хэрэгтэй ба эдгээр газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь тухайн ажлын байранд тавигдах үр чадварыг эзэмшсэн эсэх болон зөв ажлын байранд тавигдсан эсэхийг зөв тогтоож өгөх үүрэгтэй ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш эрхийг олгох болно.

Хөгжиж буй олон улс орон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны зуучлалын үйлчилгээг саяхнаас нэвтрүүлж эхэлсэн бөгөөд ажил хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо харьцангуй олон, тэдэнд чиглэсэн тусгай үйлчилгээ нь нийтэд чиглэсэн нийтлэг үйлчилгээтэй нягт холбоотой байдаг. Ойрын ирээдүйд ажилгүйдэл тодорхой хэмжээгээр буурах хандлагатай бол энэхүү холбоо маш чухал юм . Зарим улс оронд хөгжлийн бэрхшээлтэй , ажил хайгч иргэд нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд анхлан ханддаг ба хэрвээ тэдний эрэлтийг тухайн үйлчилгээ хангахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгай шаардлага бүхий иргэдэд зориулагдсан мэргэжлийн тусгай үйлчилгээнд зуучлуулдаг.

Дүгнэлт

Энэхүү судалгааны үр дүнд төр засаг болон аж ахуй нэгжүүд хичээн ажиллахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал арилах мэт байгаа боловч нийгмийн хариуцлагаа ухамсарладаггүй байгууллагууд болон төр засгийн муу үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урам зоригийг мохоож байна.

Түлхүүр үг: *Ажил эрхлэлт, дэмжих арга зүй, хөдөлмөр эрхлэлт*

Ашигласан материал:

1. Монгол Улсын статистикийн эмхтгэл, ҮсХ, 2019 он
2. Монгол Улсын статистикийн эмхтгэл, ҮсХ, 2020 он
3. Нийслэлийн статистикийн эмхтгэл, ҮсХ, 2020 он
4. Хүн ам, нийгмийн халамжийн үзүүлэлтүүд, ХХҮЕГ, 2020 он
5. Нийгмийн даатгалын ерөнхий газар, 2020 он

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БҮТЭЭМЖ

О.Золзаяа¹

¹ ШУТИС, ГХС-ийн ХХШС-ийн багш
zolzayaz@must.edu.mn

М.Анужин²

²ШУТИС, ГХС-ийн ТТО-англи хэлний оюутан
munkhbayaranujin11@gmail.com

Үндэслэл

Энэхүү судалгаа нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх байдал, бүтээмжийг судлан дүн шинжилгээ хийснээр тэдний ажлын байран дахь сэтгэл ханамжийг тодорхойлох зорилготой. Судалгаанаас дүгнэн үзэхэд юун түрүүнд эдгээр иргэдийг ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах хэрэгтэйг харуулж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд нь сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй ажилгүй иргэнийг бүртгэх ажлыг идэвхжүүлэх, тэдний чадвар чадамжийг нарийн тодорхойлон түүнд тулгуурлан ажлын байранд зуучлах хэрэгцээ өндөр байна. Эдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн олдмол байр сууриа тодорхойлоход анзаарагдахгүйгээр далд хэлбэрээр хамгийн чухал нөлөөлж буй зүйл нь өөртөө итгэх итгэл, давуу талаа тодорхойлох байна. Тэдэнд нийгмийн халамж, олон төрлийн сургалт олгох бус өөртөө итгэх итгэл гэдэг зүйлийг бий болгох хэрэгтэй. Өөрийн давуу талыг тодорхойлох асуултыг бөглөж чадалгүй орхигдуулсан нь өөртөө итгэх итгэл бага байгаа нь анзаарагдаж байна. Өөртөө итгэх итгэлгүйгээр тэдний хөдөлмөрлөх үйл явцад болон нийгмийн олдмол статус буюу байр сууриа олж авахад хүндрэл үүснэ хэмээн дүгнэж байна.

Зорилго

Сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судалж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний үе шат, хэрэгжүүлэх арга зам, онцлогийг харуулахад оршино. Судалгаанд дараах асуудлыг онцолж харсан.

Материал ба арга зүй

Сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, түүнд тулгарч буй бэрхшээлүүдийг судлах зорилготой. Энэхүү судалгааг 31-40 насны 10 иргэн буюу “Interwood” модны үйлдвэрийн 6 ажилтан, Сайншандад хөдөлмөр эрхэлдэг 4 иргэдээс нийт 20 асуулттай санал асуулга авсан. Судалгааг 2021 оны 11 сард хийж гүйцэтгэн, цуглуулсан мэдээллээ шалган засварлаж үр дүнг гаргаж дүн шинжилгээ хийлээ.

Үр дүн

Судалгаанд оролцсон 10 иргэний 2 нь эмэгтэй, 8 нь эрэгтэй байсан.

Судалгааг анкетын аргаар явуулсан. Судалгаанд нас, хүйс, одоо эрхэлж буй ажилдаа хэр сэтгэл хангалуун байгаа эсэх, өөрийн сонирхсон ажлаа хийж чадаж байгаа эсэх, ажлын байрны олдоц сайн байдаг эсэх гэх мэт асуултууд багтсан. Судалгаа нийт 20 асуулттай байсан. Үүнээс 11 асуултыг сонгон үр дүнг тайлагнав.

График 1. Судалгаанд оролцсон иргэд өөрт оногдсон эрхээ хэрхэн эдэлдэг тухай

Энэхүү асуултад хариулсан байдлыг харахад судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 78% нь хөдөлмөрийн тухай хуулинд тусгасанчлан өөрт олгогдсон эрхээ бүрэн дүүрэн эдэлж чаддаггүй, 22% нь чаддаг гэж хариулсан байна.




График 2. Судалгаанд оролцогчдын цалин хангамж тэдний сэтгэлд хэр нийцдэг талаар

Хариултын үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан иргэдийн цалин хөлсний хэмжээ өөр ч 100% сэтгэл хангалуун байж чадаж байгаа нь тэднийг нийгмээс халамж хүртээд суух биш хөдөлмөр эрхлэх хүсэлтэй байгааг харуулж байна.




График 3. Судалгаанд оролцогчид эрхэлж буй ажилдаа хэр сэтгэл хангалуун байдаг талаар

Судалгаанд оролцогчдын 67% нь одоогийн эрхэлж буй ажилдаа тийм ч сэтгэл хангалуун бус, 22% нь сэтгэл дундуур, 11% нь огт сэтгэл ханамжгүй байна.




График 4. Судалгаанд оролцож буй хүмүүст ажлын байрны олдоц хэр байдаг талаар

89% нь ажлын байрны олдоц муу, 11% нь ажлын байрны олдоц сайн гэж тодорхойлсон нь өнөөдөр Монгол улсад сонсгол болон хэл ярианы чадамжгүй иргэд хөдөлмөр эрхлэх боломж маш тааруу байгааг харуулж байна.





График 5. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй асуудлуудын тухай

Судалгаанд оролцсон иргэдийн 67%-д нь хөдөлмөрлөх явцад тулгарч буй бэрхшээл нь ХБИ-д зориулсан хүртээмж, 22% нь ажил олгогчдын хандлага, 11% нь ажил олгох нөхцөл гэж хариулсан байгаа нь өнөөдөр манай улсад энэхүү хүртээмж дутуу дулимаг байгааг харуулж байна.



Дүгнэлт

Хөл хорионд байгаа хүүхдүүдэд ганцаардлаа даван туулах сэтгэл зүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх, мэргэжлийн зөвлөгөө, тусламж үзүүлэх, сурч боловсрох ээлтэй, таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн компьютер, гар утас, интернетээр хангах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сурагчдын хүсэл, сонирхол хэрэгцээнд тулгуурлан нэмэлт дугуйлан секцэд хамруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сургуулиудаар нь дамжуулан хүүхэд бүрд хэрэгцээтэй цар тахлаас урьдчилан сэргийлэх багцыг улсаас хангах, хүүхэд, залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх дасгал хөдөлгөөн хийх ногоон байгууламжийг шинээр бий болгох, малчдын хүүхдийн зайны сургалтын хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх, эцэг эхэд хичээл заах арга барил, хүүхэдтэйгээ харилцах зөвлөгөө, контентуудыг өргөнөөр нэвтрүүлэх шаардлагатай байна. Хамгийн гол нь энэ цар тахлын үед боловсролын эрх тэгш байдлыг хангах нь зөвхөн боловсролын салбарын асуудал биш салбар дундын, тэр дундаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэмжлэг, тусалцааг шаардсан асуудал юм гэдгийг ойлгох хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Ажлын бүтээмж, хөгжлийн бэрхшээл

Ашигласан материал:

- [1] Батцэцэг, Д., (2016)Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээний онцлог. *Магистрын ажил*, 2016, ШУТИС, УБ.
- [2] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, 2006, УБ, Хөх судар принтинг
- [3] Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, 4 дүгээр зүйл, 4.1.1 [ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)
- [4] Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш боломжийг эрх зүйн хүрээнд дэмжих нь, 2007, УБ,
- [5] Сэргээн засалтын багц гарын авлага ДЭМБ, Женев 1989
- [6] 1212 статистикийн мэдээллийн сан



IV БҮЛЭГ
БОЛОВСРОЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ж.Ариунболд Ph.D, Б.Басбаяр, Д.Энх-Амгалан Ph.D¹

¹ Боловсролын зээлийн сан
denkhamgalan0608@gmail.com

Үндэслэл

Монгол улсад төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцаж буй оюутны буцалтгүй тусламжийг Боловсрол, Шинжлэх ухааны яамны Боловсролын зээлийн сангаар дамжуулан олгодог, сунгадаг. Боловсролын зээлийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үзүүлдэг санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж, тэтгэлгийг олгох, сунгахдаа Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол, 2011 оны 102 дугаар тогтоолыг баримтлан ажиллаж байна.

Зорилго

Төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцах хугацаандаа “хөгжлийн бэрхшээлтэй оюутан” гэдгээ нотлон буцалтгүй тусламжаар суралцан 2020, 2021 онд төгссөн оюутны хөдөлмөр эрхлэлт, суралцсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх, ажиллаж буй байгууллагын өмчийн хэв шинжээр тус тус судлахыг зорилго.


Материал ба арга зүй

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй оюутан (өөрөө, эцэг эх)-ны мэдээллийн өгөгдөл дээр SPSS програм ашиглан статистик боловсруулалт хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн


2020, 2021 онд төгсөөд хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй 841 иргэдийн 14 хувь нь 2016-2021 оны хичээлийн жилүүдэд Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцсан байна.

График 1.



■ Буцалтгүй тусламжаар
■ Бусад эх үүсвэрээр

График 2.



■ Хөгжлийн бэрхшээлтэй /өөрөө/
■ Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх

2016-2021 оны хичээлийн жилүүдэд төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд буцалтгүй тусламжаар суралцаж 2020, 2021 онд төгсөөд

хөдөлмөр эрхэлж буй 116 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 54 хувь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. 2016-2021 оны хичээлийн жилүүдэд төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд буцалтгүй тусламжаар суралцаж 2020, 2021 онд төгсөөд хөдөлмөр эрхэлж буй өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 63 иргэдийн 32 хувь нь төрийн өмчийн байгууллагад ажиллаж байна.

2020, 2021 онд төгсөөд төрийн өмчийн байгууллагад хөдөлмөр эрхэлж буй өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэдийн 55 хувь эрүүл мэнд, 20 хувь нь боловсрол, 5 хувь нь банк, 20 хувь нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

График 3.





График 4.



2016-2021 оны хичээлийн жилд Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар суралцаж 2020, 2021 онд төгссөн төрийн ба төрийн өмчийн бус байгууллагад хөдөлмөр эрхэлж буй өөрөө хөгжлийн бэрхшээлтэй 63 иргэдээс багшаар төгссөн оюутны 44 хувь нь, анагаахаар төгссөн оюутны 65 хувь нь тус тус мэргэжлээрээ ажиллаж байна.

Дүгнэлт

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцаад төгссөн өөрөө хөгжлийн бэрхшээлтэй оюутан хөдөлмөр эрхэлж байна. Төрийн бус өмчийн байгууллага өөрөө хөгжлийн бэрхшээлтэй оюутны хөдөлмөр эрхлэлтийг илүү дэмжин ажиллаж байна. Төрийн өмчийн байгууллагаас эрүүл мэндийн салбар өөрөө хөгжлийн бэрхшээлтэй оюутны хөдөлмөр эрхлэлтийг илүү дэмжиж ажиллаж байна. Анагаахын чиглэлээр их, дээд сургууль төгссөн өөрөө хөгжлийн бэрхшээлтэй оюутны 65 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.

Түлхүүр үг: Буцалтгүй тусламж

Ашигласан материал:

1. Gerber, P. J. (n.d.). Gerber, P. J. (1997). Life after school: Challenges in the workplace. In P. Learning disabilities and employment . Austin, TX: Pro-Ed.
2. OECD (n.d.). <https://www.oecd.org/education/education-at-a-glance/>.
3. ЗГ-ын тогтоол, 2. д. (2016). Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.
4. МУИХурлын тогтоол, 1. д. (2016).
5. АНУ, Хөгжлийн бэрхшээлтэй болон нөхөн сэргээх судалгааны үндэсний хүрээлэн (2012). Хөдөлмөр эрхлэлт. Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ (СҮҮЛИЙН 6 ЖИЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

С.Дэлгэрмаа¹

¹БШУЯ, Боловсролын зээлийн сангийн Боловсролын хөгжлийн хэлтсийн дарга
delgermaa@elf.gov.mn

Үндэслэл

Боловсролын зээлийн сан нь Монгол улсын Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.6 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн 15.6 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 4.1.2, 4.1.3 дахь заалтын дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын өдрийн ангид суралцах эрхтэй болсон өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэний бакалавр, магистр, докторын зэрэг эзэмших зардал, эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч мөн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан өрхийн гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг буцалтгүй тусламж, тэтгэлэг хэлбэрээр олгох төрийн үйлчилгээ үзүүлдэг юм.

Зорилго

Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 4.1.2, 4.1.3 заалтаар дээд боловсролын байгууллагад суралцаж буй суралцагчдын тоо, сургалтын төлбөрийн санхүүжилт, нас, хүйс, болон улсын хэмжээний нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоотой харьцуулах, тэдний сурах эрхээр хангагдаж байгаа эсэх зэргийг тоон үзүүлэлтээр харьцуулж харуулах.

Материал ба арга зүй

2014-2020 оны боловсролын зээлийн сангийн тайлан, судалгаа, Үндэсний статистикийн хорооны тоо мэдээ, судалгаа, БШУЯ-ны статистик мэдээ, судалгаа, тоо мэдээг үндэслэсэн ба SPSS програм ашиглан дүн шинжилгээ хийсэн болно.

Үр дүн

График 1. ЗГ-ын 71 дүгээр тогтоолын 3 ангиллаар суралцагчдын тоо



График 2. ЗГ-ын 71 дүгээр тогтоолын 3 ангиллаар суралцагчдын тоо, санхүүжилт




График 3. ЗГ-ын 71-р тогтоолын дагуу БЗС-ийн буцалтгүй тусламж тэтгэлгийн өөрөө хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо санхүүжилт он тус бүрээр




График 4. ЗГ-ын 71 дүгээр тогтоолын 3 ангиллаар суралцагчдын тоог өөрөө хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эзлэх хувь (он бүрээр)





График 5. ЗГ-ын 71 дүгээр тогтоолын 3 ангиллаар суралцагчдын тоог эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эзлэх хувь (он бүрээр)



Дүгнэлт

Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 4.1.2, 4.1.3 дахь заалтын дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын өдрийн ангид суралцах эрхтэй болсон өөрөө хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бакалавр, магистр, докторын зэрэг эзэмших зардал, мөн хөдөлмөрийн

чадвараа бүрэн алдсан өрхийн гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг буцалтгүй тусламж, тэтгэлэг хэлбэрээр сүүлийн 6 жилд давхардсан тоогоор **34314** суралцагчид **48.8** тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн санхүүжилт Боловсролын зээлийн сангаас олгосон байна.

Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт **112663** хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс Боловсролын зээлийн сангаар **4634** буюу 4% нь сургалтын төлбөрийн санхүүжилт авч байна.

***Түлхүүр үг:** Дээд боловсрол, буцалтгүй тусламж, тогтоол, тэтгэлэг*

Ашигласан материал:

- <https://www.1212.mn/> - Үндэсний статистикийн газар
- <http://202.5.205.51:8181/home> - БЗС-н буцалтгүй тусламж тэтгэлэгийн программ
- <https://www.meds.gov.mn/statistics> - БШУЯамны статистик мэдээлэл
- Боловсролын хөгжлийн хэлтсийн 2014-2020 оны тайлангууд
- Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тайлан

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ДИЗАЙНЫ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

С.Өлзиймаа¹

¹ШУТИС Үйлдвэрлэлийн технологийн сургууль

Үндэслэл

Дэлхийд боловсрол мэдлэг дээр суурилсан эдийн засаг хүч түрэн орж ирж, бүх улс орон энэ үйл явцад иргэдээ тэгш хамруулан суралцуулахыг зорьж байна. Энэ хэрэгцээ шаардлагатай хөл нийлүүлэхийн тулд Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилгоо 2030 онд боловсролын байгууллага... хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс,...хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах [1] гэж тусгасан. Манай ихэнх их, дээд сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан сургалтын тусгай хөтөлбөр хангалтгүй байдгаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 18-34 насны залуучуудын дөнгөж 10 хүрэх хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна [2]. Статистикийн тоон үзүүлэлтээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо цаашид улам өсөх хандлагатай байна. Энэ тоо өсөх тусам бид хөгжлийн бэрхшээлтэй иргэнээ боловсруулах, чадваржуулах, нийгэмд идэвхтэй оролцоотой болгох асуудлыг анхааран ажиллах хэрэгцээ, шаардлага мөн цаашдаа манай оронд ажиллах хүний нөөцийн хомстолд үүсэх эрсдэлийг ч урьдчилан харах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийн онцгой хэрэгцээнд тулгуурлан суралцах болон ажиллах боломжтой нэг чиглэл бол дизайны салбар юм. Энэ арга замыг тодорхойлсноор тэдэнд суралцах тэгш боломж олгож, ирээдүйд хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй олон залуусыг ажлын байраар хангаж тэднийг нийгмийн үнэт зүйлийг туурвигч болгох боломжтой юм. Иймээс бид ШУТИС-ҮТСургуульд дизайны мэргэжлээр суралцаж буй тусгай хэрэгцээт суралцагчдын өнөөгийн байдлыг судлан дүгнэх, хэрхэн хүртээмжтэй суралцах нөхцөлийг тодорхойлоход судалгаагаа чиглүүллээ.

Зорилго

Энэхүү судалгаагаар олон нийтийн дунд суралцах боломжоор хязгаарлагдмал суралцагчдад ялангуяа бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил боловсрол олгодог их дээд сургуульд хэрхэн суралцах боломж олгох, үүнд ямар боломж бололцоо байна гэдгийг эрэлхийлэхийг зорьсон.

Материал ба арга зүй

Судалгааны ажлын хүрээнд Шинжлэх Ухаан Технологийн Сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудтай ярилцлага хийн, асуулгын аргыг ашиглан үр дүнг гаргасан.

Үр дүн

АНУ-ын Портланд хотын Institute for Human Centered Design (Хүн Төвтэй Дизайны Хүрээлэнгийн) "Хүмүүст Тохирсон Дэлхийг бүтээх нь:

Хөгжлийн бэрхшээлтэй дизайнерууд” нийтлэлд дурдсанаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дизайнераар баг бүрэлдэхүүнд орж ажилласнаар дизайн өөрөө сайжирдаг” [3]. Хөгжлийн бэрхшээлтэй дизайнерууд нь хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд тохирсон загварыг хөгжүүлэн загварчлахын хажуугаар тэдний бодол санаа, төлөвшил, асуудлыг шийдвэрлэх чадвар, бусдыг ойлгох, гоо зүйн ухамсар, нийгмийн шударга ёсыг дээшлүүлэхэд шийдэл хайж байдгийг тогтоожээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дизайны чиглэлээр ажиллахад шаардагддаг чухал ур чадварууд бол бодит орчинд дасан зохицох, мэдээлэл, технологи ашиглах, судалгаа хийх болон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүтээлч хандлагыг хөгжүүлэх юм. Үүнээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн доорх дизайны чиглэлээр их дээд сургуульд суралцах боломжтой. Интерьер дизайн, Хувцасны дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Компьютер график, График дизайн, Хот төлөвлөлт, Ландшафтын архитектур. Эдгээр мэргэжлүүдээс ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль нь График дизайн, Хувцас дизайн, Компьютер график дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Интерьер дизайн гэсэн 5 мэргэжлээр сургалт олгож байна. Энэ нь бидэнд давуу талууд байгааг илтгэнэ. ШУТИС-д 2018-2019 оны хичээлийн жилд нийт 94 хөгжлийн бэрхшээлтэй оюутан үүнээс ҮТСургуульд 12 оюутан суралцсан байна. Суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо нийт их дээд сургуульд суралцах боломжтой 18-34 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад маш бага тоог харуулж байна. Үүнээс дизайны чиглэлээр сургалт явуулдаг ҮТСургуульд суралцаж буй оюутны хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл:

Хүснэгт 1: Үйлдвэрлэлийн технологийн сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутны тоо (давхардсан тоогоор)

	Сонсголын бэрхшээл	Харааны бэрхшээл	Тулгуур эрхтэн	Хэл, ярианы бэрхшээл	Оюун санааны	Бусад, хавсарсан
2019 онд	6	1	1	2	1	1
2020 онд	2	0	0	2	0	2

Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Дизайны салбарт 2019 оны хичээлийн жилд 4 оюутан, 2020 оны 3 хөгжлийн бэрхшээлтэй оюутан элсэн суралцаж байна. Эдгээр оюутнуудаас харааны бэрхшээлтэй 1, сонсголын бэрхшээлтэй 5, бусад хавсарсан бэрхшээлтэй 2 суралцагч суралцаж байна. Үүнээс харахад ШУТИС-ҮТС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байна. Дизайны салбарт сурч буй хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд график дизайны хөтөлбөр болон интерьер дизайны хөтөлбөрөөр суралцаж байна. Суралцахад тохиолддог хүндрэлийн талаар эдгээр оюутнуудтай ярилцахад. Сонсголын бэрхшээлтэй оюутнуудад хичээл болон бусад мэдээллийг дохионы хэлээр давхар хүргэдэггүйгээс хичээлийн хоцрогдол байнга үүсдэг, мэргэжлийн үг хэллэгийг ойлгож хүлээн авахад хүнд. Харааны бэрхшээлтэй оюутнуудад мэргэжлийн ном, сурах бичгийг брайль үсгээр хэвлээгүйн улмаас нэмэлт мэдээлэл, судалгаа хийх боломжгүй, сургалтын орчинд зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй. Бусад бэрхшээлтэй оюутнуудад

байнгын эрүүл мэндийн хамааралтай байдаг тул хичээлдээ байнга танхимаар оролцох боломжгүйн улмаас хичээлээсээ хоцордог. Мөн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй оюутны мэдээлэл бага хүрдэг учраас тухайн хичээлийн багшдаа өөрийнхөө тухай илэрхийлэх нь хүндрэлтэй. Дээрх хүндрэлүүд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад өдөр бүр тохиолдож байна гэдэг боловсрол тэгш бус, хүртээмжгүй байгааг илтгэж байна.

Дүгнэлт

Өнөөгийн нөхцөл байдал, судалгааны үр дүнгээс харахад их дээд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо харьцангуй бага байна. Энэ тоог ихэсгэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нарт зориулсан сургалтын орчинг бий болгох дээр ажиллах шаардлагатай. Хэрэгжилтийг хангахын тулд тухай чиглэлийн сургуулиуд нөөц боломжоо судлах, орчин үеийн сургалтын давуу талуудыг ашиглахын зэрэгцээ төр, засгийн дэмжлэгийг авч тусгайлан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, орчин нөхцөлөө сайжруулахад нэн даруй анхаарах шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч цаашид мэргэжлээрээ ажиллах мөн түүнчлэн дизайны мэргэжлийн хамгийн гол давуу тал нь тухайн хүн өөрөө ажлын байраа буй болгох боломжийн хувьд өндөр юм. Хөгжлийн бэрхшээлтэй дизайнер нийгмээ тохижуулах нь тэдэнд тулгардаг олон асуудлыг дээрээс биш яг хажуугаас, дотроос нь оновчтой шийдэх боломжийг олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоог нэмэхийн тулд ЭЕШ оролцох боломжоор хангах, сургалтын орчин буй болгох, мэргэжлийн хичээлд тулгуурласан дохионы хэлний багш бэлтгэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Тусгай хэрэгцээт суралцагч, бүтээлч үйлдвэрлэл, дизайн, дизайнер*

Ашигласан материал:

- [1] Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт *“зорилт 4 хүртээмжтэй, тэгш, чанартай боловсрол олгох” 4.5, 4а*
- [2] Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (2020), *“Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”, Нэгдсэн дүн*. Улаанбаатар
- [3] АНУ-ын Портланд хотын Institute for Human Centered Design <https://www.humancenterreddesign.org/>
- [4] Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал (2020): *Бодлого, үйл ажиллагаа*, Улаанбаатар
- [5] ХНХЯ, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгуулга (2019), *“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа-2019”*, Улаанбаатар,

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛЧДАД ХАНДАХ СУРАЛЦАГЧДЫН ХАНДЛАГА

Б. Халиун, Э. Төгсжаргал¹

¹Хялганат ерөнхий боловсролын сургууль
hlnkhaliun@yahoo.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил эрхлэхэд бусад хүмүүсийн хандлага хэрхэн нөлөөлдөг тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаарх судалгаа ил болоогүйгээс гадна боловсролын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй ажилчдад хандах суралцагч хүүхдүүдийн хандлагыг судалсан судалгаа хомс байна. Боловсролын байгууллага дах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд тэдгээр хүмүүст хандах хандлагыг судлах нь чухал юм.

Зорилго

Боловсролын байгууллага дах хөгжлийн бэрхшээлтэй ажилчдад хандах суралцагчдын хандлагыг судлах зорилгоор энэхүү судалгааг хийв.

Материал ба арга зүй

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг асуулгын аргаар цуглуулж үр дүнг боловсруулав.

Үр дүн

Судалгаанд Хялганат, Баян нуур, Баян Агт, Сайхан, Эрдмийн өргөө, Хутга Өндөр сургуулийн 11-18 насны 200 оролцогчид оролцсон. Суралцагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар ерөнхий мэдээлэлтэй гэсэн үр дүн гарсан ба Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чамд хэрхэн санагддаг вэ гэсэн асуултанд суралцагчдын 45,5% нь хүлээн зөвшөөрдөг бидэнтэй адил энгийн л хүмүүс гэж үзсэн. Сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг талаар мэдээлэлгүй ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч хөдөлмөрлөх эрхтэй, сургуулийн орчинд ажиллах нь зөв гэж үзэж хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэн танай сургуульд ажиллавал чамд ямар санагдах вэ хэмээх асуултанд дийлэнх хувь нь буюу 47,5% маш сайхан би туслахад хэзээд бэлэн гэсэн бол 22% нь ямар ч биш, 20% нь ажиллаж болох ч надад хамаагүй, 8% нь сургууль дээрээ ажиллуулахыг хүсэхгүй байна хэмээн хариулжээ.

График 1. Тийм бол танай сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг нь чамд ямар санагддаг вэ? 200 responses



График 2. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэд танай сургуульд ажиллавал чамд ямар санагдах вэ? 200 responses



Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс ерөнхий боловсролын сургуулийн орчинд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэддэггүй боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн зөвшөөрч, хүндэлж дээдэлдэг боловч хэрхэн харилцахаа мэддэггүй. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил хөдөлмөр эрхлэх нь зүй ёсны хэрэг хэмээн үзэж сургуулийн орчинд ажил эрхэлж буй хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдэд тусалж дэмжин ажиллахад хэзээд бэлэн байгаа нь энэхүү судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эдгээр үр дүнгээс үзвэл боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх нь зөв ба энэхүү судалгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ буй нь харагдаж байна

Түлхүүр үг: Ерөнхий боловсролын сургууль, ажил эрхлэлт

Ашигласан материал:

1. Баярмаа, Б., Сарантуяа, Ж., Батдэлгэр, Н. (2015). Монгол ажиллагчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагын харьцуулсан судалгаа. Монгол Хүн Амын Сэтгүүл, 424, 25–39. <http://dep.num.edu.mn/econ/wp-content/uploads/2020/03/25-3.pdf>
2. Cairns, B., & McClatchey, K. (2013, September). Comparing children's attitudes towards disability. Research Gate. Retrieved November 12, 2021, from https://www.researchgate.net/publication/263110659_Comparing_children's_attitudes_towards_disability

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЖ БУЙ ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА

Г.Халиун¹

¹ Боловсролын Хүрээлэн

khaliun@mier.mn

Үндэслэл

1990-ээд оноос хойш дэлхийн боловсролын чиг хандлагад тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг тусгай сургуульд тусгаарлан сургаж байснаас ердийн сургуульд сургах хандлага ажиглагдаж эхэлсэн. Тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхэд ерөнхий боловсролын сургуулийн багш нарын оролцоо, мэдлэг чадвар чухал үүрэгтэй ба багш нар суралцагчдын, олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих, шаардлагатай ур чадвараар хангагдсан байх шаардлагатай болж байна. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн орны багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөртэй харьцуулж судлан үзэх хэрэгцээ байна.

Зорилго

Олон улсад хэрэгжүүлдэг тэгш хамран сургах багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн сайн туршлагыг судлах

Материал ба арга зүй

Ази, Европын улсуудаас тэгш хамран сургах боловсролын үзэл санааг амжилттай хэрэгжүүлж буй 6 улсын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт баримт бичгийн шинжилгээний арга ашиглаж боловсруулалт хийлээ.

Үр дүн

Тэгш хамран сургах болон тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэжилдээшлүүлэх сургалтыг зохион байгуулах тогтолцоо болон сургалтын хөтөлбөр, агуулга нь улс бүрд харилцан адилгүй байна. Зүүн Өмнөд Азийн орнуудаас Вьетнам улсын багшийн мэргэжил дээшлүүлэх тал дээр авч хэрэгжүүлж буй сайн туршлага нь нийт багш нарыг сургалтад хамруулах бус “key teachers”-г хөгжүүлжээ. Энэ нь тэгш хамран сургах боловсрол эзэмших сонирхол, хандлага, мэргэжлийн нэр хүнд, сурган хүмүүжүүлэх ур чадварын үндсэн дээр сонгогдсон сургуулийн захирал, дүүрэг мужийн боловсролын ажилтан байдаг. Тэгш хамран сургах боловсролын үндсэн хүний нөөц гэж үзэн эдгээр багш нарыг мэдлэг чадварыг хөгжүүлэх сургалтад тогтмол хамруулдаг. Сургалтад хамрагдсаны дараа сургуулиудад хуваарилагдан, ээлжлэн ажиллаж, бусад багш нартаа дэмжлэг үзүүлэх нэмэлт үүргээр ажилладаг.

Оросын Холбооны улс, Тайвань, Хонконг улсууд нь нийт багш нараа тэгш хамран сургах боловсролын тусгай агуулгаар мэргэжил дээшлүүлж байна. Оросын холбооны улсын боловсролын стандартын шаардлагын дагуу багш нарыг тусгайлсан арга зүй тэр дундаа анатоми, физиологи, сэтгэл зүй, согог судлал, нийгмийн ажлын дадлыг эзэмшсэн байхыг

шаарддаг байна. Тайваньд 2007 оноос ерөнхий боловсролын сургуулийн багш нар тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдтэй ажиллахаас өмнө тэгш хамран сургах боловсролын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байхыг хуулиар шаардаж эхэлжээ. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор “Тусгай боловсролын Кредит” хөтөлбөрийг (30-аас доошгүй кредит) эхлүүлсэн. Тухайн орон нутгийн засаг захиргаанаас уг хөтөлбөрт тусгай боловсролын багш (дор хаяж 18 цаг), ердийн сургуулийн багш (3-аас доошгүй) цагийг жил бүр судлах хэрэгтэй гэсэн шаардлага тавьдаг байна. Тусгай хэрэгцээт болон тэгш хамран сургах боловсролын сургалтын чанар, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад үзүүлж буй дэмжлэгийг шинжээчид, эрдэмтэн судлаачид, эцэг эхийн бүлгүүд болон засгийн газраас бүрдсэн баг үнэлдэг. Сайн үр дүнтэй сургуулийг нэмэлт санхүүжилтээр дэмжиж, туршлага солилцох ажлыг өрнүүлдэг. Хонгконгийн Боловсролын Их Сургууль нь Хонгконг дахь тусгай болон тэгш хамран сургах боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх цор ганц байгууллага бөгөөд засгийн газраас тогтоосон VAT гэж нэрлэгдэх “Үндсэн сургалт (30 цаг)”, “Гүнзгийрүүлсэн сургалт (102 цаг)”, Сэдэвчилсэн сургалт (120 цаг) –уудыг зохион байгуулдаг. 2018 онд тэгш хамран сургах боловсролын 30 цагийн үндсэн сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн багш нарын тоо нийт багшийн ажиллах хүчний дөнгөж 36%-ийг эзэлж байгаа нь хангалтгүй гэж үзэн сургуулийн удирдлагуудаас багш ажилчдаа ажлын байрандаа хөгжиж, мэргэжил дээшлүүлэх сургалтад заавал хамрагдахыг санал болгодог байна. Хонгконгийн засгийн газраас 2018-2019 оны хичээлийн жилд улсын нийт ерөнхий боловсролын сургуулиудад тусгай боловсролын хэрэгцээний зохицуулагч (Special Educational Needs Coordinator - “SENCO”) гэсэн шинэ орон тоо бий болгож, тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдад дэмжлэг үзүүлж ажиллах, арга зүйн сургалт, семинарыг зохион байгуулах, тусгайлсан үүрэг хариуцлага хүлээлгэж эхэлжээ.

Япон улсын хувьд тэгш хамруулах боловсролын сургалтыг багш нар сайн дурын үндсэн дээр сонгож суралцах боломжтой байдаг ба сургалтын хөтөлбөр болон агуулга нь мужаасаа хамаарч өөр өөр байдаг.

Польш улсын тусгай хэрэгцээт боловсролын багшийг чадавхжуулах, сургалтыг цаашид тусгай хэрэгцээт боловсролын багш, мэргэжилтэн болох багш нар заавал сонгон суралцдаг бол бусад багш нар сайн дурын үндсэн дээр сонгон суралцах боломжтой байдаг. Мэргэжил дээшлүүлэх сургал нь танхимын болон цахим, дадлага хосолсон хэлбэрээр 3 семестр ордог.

Дүгнэлт

- Хөгжиж буй орнуудад тэгш хамран сургах боловсролын талаарх багш нарыг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт нь олон улсын байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг нийтлэг жишиг байгаа бол тэгш хамран сургах боловсрол хөгжсөн орнуудад тогтсон сургалтын хөтөлбөр болон агуулгатай байна.
- Сургалтын хөтөлбөрийн бүтцийн хувьд сургалтын зорилго, зорилт, сургалтын агуулга, арга зүй, сургагч багш ба оролцогчид, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын үнэлгээ гэсэн хэсгүүдийг багтаасан байна.
- Сургалтын агуулгын хувьд тэгш хамран сургах боловсролын үндсэн

ойлголт, хууль, эрх зүйн орчин, сурган хүмүүжүүлэх онолын үндэс, сургалтын арга хэрэглэгдэхүүн бусад туслах технологи, үнэлгээний арга, сургууль болон эцэг эх олон нийтийн хамтын ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл санааг ойлгох дэмжлэг үзүүлэх арга, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах талаарх агуулгууд давхцжээ. Агуулгыг тодорхойлохдоо оролцогч талуудын эрэлт хэрэгцээг хангахыг чухалчилдаг байна.

- Улс орон бүр өөрийн онцлогт тохирсон багш нарын тэгш хамран сургах боловсролын мэдлэг ойлголт, чадварыг дээшлүүлэх аргуудыг хэрэглэж байна. Улс дотроо сайн туршлагаа хуваалцдаг, түгээн дэлгэрүүлдэг нийтлэг тал ажиглагдлаа.

Санал зөвлөмж

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад багш нарыг чадавхжуулах онол, арга зүйн сургалтыг зохион байгуулж буй мэргэжлийн байгууллагын сургалтын хөтөлбөрийг нээлттэй болгох, сургалтад боловсролын бүх мэргэжилтэн, багш нарыг заавал хамруулах
- Тэгш хамран сургах боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн бүтэц болон агуулгыг олон улсын жишигт нийцүүлж, өөрийн улсын онцлогийг тусган, сургалтын эцэст эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг нарийн тодорхойлж өгөх
- Тэгш хамран сургах боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургагч багш нарын мэдээлэл тодорхой байх, мэргэшсэн, сургалтын арга зүйн ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх

Түлхүүр үг: *Тэгш хамран сургах боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт*

Ашигласан материал:

1. Leung Chi-kit. (2019). *Teacher training on special educational needs in selected places*. <https://www.legco.gov.hk/research-publications/english/1819in22-teacher-training-on-special-educational-needs-in-selected-places-20190918-e.pdf>
2. Kubacka., D'Addio. (2020). Targeting Teacher Education and Professional Development for Inclusion. CICE Hiroshima University, *Journal of International Cooperation in Education*, Vol.2-2/23-2.
3. Dinh Thi Nguyet., Le Thu Ha (2010). Preparing Teachers for Inclusive education by CRS Vietnam.
4. The education university of Hong Kong. (2020) Training programme for special educational needs program handbook 2020-2021.
5. Хүүхдийг ивээх сан, МУБИС. (2017). Багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тэгш хамруулан сургах асуудлыг тусгасан байдлын үнэлгээ. *Зөвлөх ажлын дүгнэлт*

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Б.Бямбацогт¹

¹5 дугаар ангийн Хүний их эмч, дэслэгч

Үндэслэл

Сонсголын бэрхшээлтэй хүний сонсож чадахгүй байгаа нь бэрхшээл биш харин нийгэмд бусдын адил сурч боловсроход саад болж буй орчин нөхцөл, нийгмийн хандлага нь бэрхшээл болж байдаг. Бүхий л улс орон нийгмийн зорилтод бүлэгт анхаарлаа хандуулж тэднийг бусдын адил амьдарч, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөр эрхлэх бүхий л нөхцөл боломжийг сайжруулахад онцгой анхаарч байна. Гэтэл өнөөдөр Монгол улсад хөгжлийн бэрхшээлийн талаарх ард иргэдийн ойлголт, хандлага нь хуучирсан, тэднийг өрөвдсөн, тавиланд нь халагласан хэвээр байна. Хөгжлийн бэрхшээл дундаас сонсголын бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хөгжлийн бодлогыг илүү нарийн мэдрэмжтэй авч үзэх шаардлагатай. Тэд бэрхшээлийнхээ онцлогоос шалтгаалж өнөөдрийн бодит нийгмээс хэдэн жилийн хойно явдаг гэх ч үг бий. Ялангуяа эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн бэрхшээлийн салбарт улс төрийн хөдөлгөөн биш, мэргэшсэн чадвартай боловсон хүчин удирдаж энэ улсын хөгжлийн хамгийн том үзүүлэлт болох ард иргэдийнхээ амьдралын чанарт анхаарах ёстой юм. Улаанбаатар хотын 6-н дүүрэгт бүртгэлтэй СБИ нийт 2284 байна. Дүүргүүдэд бүртгэлтэй СБИ –ийн дунджаар 55% нь одоогийн байдлаар ажил эрхлээгүй байна. Иймээс Монгол улсын бүх сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, иргэдийг цаашид нийгмийн ямарч бэрхшээлгүйгээр сурч, боловсорч, хөгжиж, бусдын адил хөдөлмөр эрхлэх боломжид нийгэмд дуу хоолойгоо хүргэхээр энэхүү сэдвийг сонгосон юм.

Зорилго

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, чадамжийн мэдээлэлд тулгуурлан сонсголын бэрхшээлтэй залуус бусдын адил тэгш эрхтэйгээр сурч, хөгжих боломж байгааг харуулах, тэдний дуу хоолой болоход оршино.

Материал ба арга зүй

Энэхүү судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашиглаж цуглуулсан. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага болон Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв (МСҮТ)-ийн удирдлагуудаас гүнзгийрүүлсэн ярилцлагын аргаар, сонсголын бэрхшээлтэй иргэдээс хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Мөн баримт бичгийн судалгааны аргыг ашиглан холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Хагас бүтэцлэгдсэн ярилцлагад нийт 100 сонсголын

бэрхшээлтэй иргэд болон сонсголын бэрхшээлтэй болон бэрхшээлгүй иргэдийн ажиллуулж буй 60 ажил олгогч компаниудаас энэхүү ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Ярилцлага тус бүр ойролцоогоор 20-40 минут үргэлжилсэн. Ярилцлагын мэдээллийг СИМТ-ийн судалгааны баг дохионы хэл ашиглан цуглуулсан. Гүнзгийрүүлсэн ярилцлагад энэхүү ярилцлагын аргаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн нийт 39 байгууллагын удирдлагуудаас мэдээлэл Ярилцлага тус бүр ойролцоогоор 20-40 минут үргэлжилсэн. Эдгээр ярилцлагыг IRIM судалгааны хүрээлэнгийн судалгааны баг гүйцэтгэсэн.

Үр дүн

Монгол улсад 2020 оны байдлаар 108,399 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнээс 12,768 нь СБИ байна. Улаанбаатар хотын 6-н дүүрэгт бүртгэлтэй СБИ нийт 2284 байна. Дүүргүүдэд бүртгэлтэй СБИ –ийн дунджаар 55% нь одоогийн байдлаар ажил эрхлээгүй байна. Мөн ажил эрхэлж байгаа иргэд нийт бүртгэлтэй иргэдийн 20 орчим хувийг эзэлж байгааг харж болохоор байна. Мөн бүртгэлтэй тэтгэврийн насны СБИ –ийн 28% нь тэтгэвэр авдаг гэж бүртгэгдсэн байгаа бөгөөд үлдсэн 72% нь үгүй буюу тодорхойгүй байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 35% нь бүрэн дунд боловсролтой, 25 хувь нь дээд боловсролтой иргэд хамгийн өндөр хувьтай байна. Боловсролгүй иргэд хамгийн бага буюу 1%-тай байна. Нийт бүрэн дунд боловсролтой иргэдийн 59% нь, дээд боловсролтой иргэдийн 61% нь эмэгтэй байна. Боловсролын төвшин ажил эрхлэлттэй хэрхэн холбогдож байгаа талаар харьцуулан харахад бүрэн дунд боловсролтой иргэдийн 34% нь дээд боловсролтой иргэдийн 61% ажил эрхэлж байна. Нийт судалгаанд хамрагдсан СБИ –ийн 41% хувийг эзэлж байгаа иргэдийн өрхийн орлого нь 250,000-500,000 төгрөг, хамгийн бага буюу 2% -ийг эзэлж байгаа иргэдийн өрхийн орлого 1000,001-1250000 төгрөгийн хооронд байна. Харин судалгаанд хамрагдсан иргэдээс өөрийн орлогыг асуухад дийлэнх буюу 58% нь 250,000 төгрөг хүртэлх орлоготой байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс хөдөлмөрийн чадвар алдалтын талаар тодруулахад хөдөлмөрийн чадвар 70% -ийн алдалттай гэж хамгийн өндөр буюу 83% нь хариулсан байна. Дээрх зураглалаас харахад хамгийн өндөр орлоготой буюу 750,001-1000,000 төгрөг хүртэлх орлоготой иргэд дээд болон бүрэн дунд боловсролтой байна. Харин боловсролгүй иргэд хамгийн бага орлоготой байгааг мөн дээрх графикаас харж болж байна. Ажил эрхлэхэд хамгийн гол тулгамддаг бэрхшээлээр харилцааны асуудал гэж судалгаанд оролцогчид нэрлэж байсан ба дохионы хэл мэддэг хэлмэрч байхгүй тохиолдолд бүхий л төрлийн бэрхшээл тулгардаг болохыг онцолж байсан.

Дараагаар нь өөрсдийнх нь мэдлэг чадвар дутмаг байдаг нь нэг талаас бэрхшээл учруулдаг гэсэн хариултуудыг түгээмэл өгч байсан. Ажил олгогч байгууллагуудын удирдлагаас СБИ-г ажлын байранд авч ажиллуулахад ямар нэгэн бэрхшээл тулгардаг эсэхийг тодруулахад, харилцааны бэрхшээл тулгардаг гэсэн хариулт 50 орчим хувь нь өгсөн бол ямар нэгэн бэрхшээл

тулгардаггүй гэсэн хариултыг 40 орчим хувь нь өгсөн байна. Ажилтай иргэдийн 64.5 хувь нь ажлаасаа гадуур өөрийгөө хөгжүүлэх хүсэлтэй байна гэж хариулсан байна. Сургалтад хамрагдахыг хүсч буй иргэдийн олонхи нь хүний хөгжлийн сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдахыг хүссэн байна. Судалгаанд оролцсон ажилгүй сонсголын бэрхшээлтэй иргэдийн 41.0 хувь нь сургуульд суралцах хүсэлтэй, 59.0 хувь нь сургуульд суралцах сонирхолгүй байна гэж хариулсан байна. Сургуульд суралцахыг хүссэн ажилгүй иргэдийн олонх нь мэргэжил дээшлүүлэх сургуульд суралцахыг хүссэн байна. Ажилгүй сонсголтгүй иргэдийн 63,9 хувь нь сургалтад суухыг хүсч байгаа бол 36.1 хувь нь сургалтад суухыг хүсээгүй байна. Сургалтанд суухыг хүссэн иргэдийн мэргэжил олгох, бизнес, оёдол, тогооч, гадаад хэл, барилга, мужаан сийлбэр гэх мэт чиглэлээр сургалтад суухыг хүссэн байна. Дээрх судалгааны үр дүнгээс харахад, ажилтай ажилгүйгээс үл хамааран, сонсголын бэрхшээлтэй иргэдийн олонх нь сургууль, сургалтад хамрагдах хүсэлтэй, ялангуяа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах ихээхэн сонирхолтой байдаг нь харагдаж байна.

Дүгнэлт

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дэмжиж буй хууль эрх зүйн орчин, бодлого хөтөлбөрүүд, Монгол улсын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсролтой холбоотой тодорхой хууль тогтоомж болон хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Судалгаанаас үзэхэд СБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин бага байгаа нь СБИ-ийн боловсролд нь эхэлж анхаарах ёстойн тод жишээ харагдаж байна. Нийгмээс СБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээнд түлхүү анхаардаг ч сонсголын бэрхшээлтэй залуучуудын асуудал орхигдож байгаа нь ажиглагддаг. Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд их сургуульд ороход нээлттэй боловч үе тэнгийн залуучуудтай хөл зэрэгцэн алхах боломж нь туйлын муу байдаг. Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үл хамааран онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын орчин, мэргэшсэн боловсон хүчин, мэргэжлийн дохионы хэлний орчуулагчийг бэлтгэсэн "Төв"-үүд их дээд сургуулиудыг түшиглэн байгуулагдаж, сонсголын бэрхшээлтэй оюутан залуусын хичээл сургалт шууд орчуулгатай явагдсанаар СБ оюутан залуучуудын мэдлэг боловсрол, ур чадвар сайжирснаар цаашид Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт өсч, Монгол улсын хөгжлийг тодорхойлох хүний хөгжлийн индекс өснө гэж үзэж байна.

Түлхүүр үг: Сонсголын бэрхшээлтэй иргэн, сурч боловсрох, хууль тогтоомж

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
2. Үндэсний статистикийн хороо, 2020 мэдээллийн сан.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭЖ БУЙ ЗАРИМ ОРНЫ САЙН ТУРШЛАГА (Австрали, Шинэ Зеланд, БНПУ)

Э.Нарантуяа¹

¹МУБИС магистрант

naraaa1227@gmail.com

Үндэслэл

Тусгай хэрэгцээт боловсролын багш нь зөвхөн сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын онол, арга зүйн мэдлэгээс гадна тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн талаар анагаах ухаан, хөгжлийн бэрхшээл судлалын онол арга зүйн мэдлэгтэй байна. Түүнчлэн бэрхшээлтэй үүхдэд ямар тусгай хэрэгцээ шаардлагатай болох, хэрхэн дэмжих тухай онолын болон практик үйл ажиллагаанд сайн хэрэгжүүлж чаддаг мэргэшсэн байх, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжийг эрэлхийлдэг байх шаардлагатай юм. Иймд тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэн сургаж буй олон улсын чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон арга замыг хэрэгжүүлэх шаардлага гарч ирж байгаа юм.

Зорилго

Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэж буй байдлыг судалж багш бэлтгэх агуулгад тусгах санааг илрүүлэх

Материал ба арга зүй

Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэж буй улс орны өнөөгийн байдлыг шинжихэд чиглэсэн тул “тайлбар” судалгааны төрөлд хамаарна. Хэрхэн өрнөж буй үзэгдэлийг тодорхойлсны дараа “яагаад” тийм байгааг тайлбарлан хариулт өгнө. Энэхүү өгүүллээр зарим орны тусгай хэрэгцээт боловсролын багшийг бэлтгэж буй хэв шинж, онцлогийн талаар авч үзэхийг зорив.

Үр дүн

Австрали улс нь тусгай боловсролын багш болохын тулд тусгай боловсролын чиглэлээр мэргэшсэн боловсролын бакалаврын зэрэгтэй байх, стандартын дагуу сайн дурын болон багшлахуйн дадлага хийсэн байх шаардлагатай[3]. Их сургууль бүр тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөртэй байх ба суралцахуйн бэрхшээл, сонсголын бэрхшээл, харааны бэрхшээл болон хавсарсан бэрхшээл зэрэг заавал судлах курсыг сургалтын хөтөлбөртөө багтаасан байна. Өөр мэргэжлийн багш нар энэ чиглэлээр мэргэшихийн тулд тусгай боловсролын чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшлийг олж авч болно.

Дэлхийн 2-р дайны үед Польш улс дахь тусгай сургууль болон сэтгэцийн эмнэлгүүдийг хааж, тусгай боловсролыг хөгжүүлэхтэй холбоотой шинжлэх ухааны бүх ажлыг зогссон ч сурган хүмүүжүүлэгчид хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүст зориулсан арга хэмжээгээ нууцаар үргэлжлүүлсээр ирсэн. Яг энэ үед тусгай боловсролын сурган хүмүүжүүлэгч нь хувь хүний ёс зүйтэй байх гэсэн үзэл санааг дэвшүүлсэн. Энэ нь орчин үеийн хэллэгээр буюу зөөлөн ур чадвартай байх нь чухал юм. [7] Өдгөө тусгай хэрэгцээт боловсролын багш болоход магистр, доктор, дипломын дараах сургалт болон мэргэжил дээшлүүлэх зэрэг сургалтаар дамжуулан тусгай боловсролын мэргэжилтэн, тусгай хэрэгцээт боловсролын багшийг бэлтгэж байна. Сургалт нь 5 жил (10 семестр) үргэлжинэ. Бүтэн цагаар (өдрийн) болон хагас цаг (эчнээ) хэлбэрээр явагддаг. Магистрын зэрэгтэй болсноор сургалт төгсдөг.

Сургалтын явцад ёс зүйн хичээлээр дамжуулан оюутнуудаас хувь хүний төлөвшилтийн олон төрлийн тест авж, дадлага ажлаар дамжуулан нөхөн сэргээх төв, асрамжийн газар, дэмжлэгийн төвүүдээр 50-75 цагийн сайн дурын асрах, хүмүүжүүлэх дадлага ажил гүйцэтгүүлэн хариуцсан мэргэжилтнээс тодорхойлолт авч шалгадаг. Энэхүү процесс нь тусгай боловсролын багшийн хувийн сэтгэл зүйг давхар бэлдэж буйн нэгээхэн илрэл юм.

Дүгнэлт

Тэгш хамран сургах боловсролыг бодитой болгох нэг хүчин зүйл нь тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх үйл явц юм. Багш нарыг шинэлэг арга зүйгээр дэмжих, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжийг эрэлхийлдэг байх, хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэх, сургалтын болон нийгмийн орчинд тэдний тэгш оролцоог хангадаг байх, бүх хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, ёс зүйтэй сургалтын орчинд сургах боломжийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлээр сурч байгаа оюутны хичээл сургалтын үеэр сайн дурын асрах, хүмүүжүүлэх, дадлага ажил гүйцэтгүүлж байгаа нь сэтгэл зүй, хандлага, зөөлөн ур чадварыг түлхүү төлөвшүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үр дүнтэйгээр багшлах нь хүрээлэн буй орчиндоо амар хялбар дасан зохицох, өөрт байгаа дээд боломжоор хөгжиж, бие даан амьдрах чадварыг эзэмшихэд нь тусалж чадна. Энэ нь хүүхдүүдийн амьдралыг арай хялбар, үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа хөгжих боломжийг бий болгоно гэсэн үг юм. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэл соёлыг хүндэтгэж, таньж мэдэх, ойлгох, хүүхдийн хөгжлийн болон сурах хэрэгцээг судалж мэдэх, уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, идэвхтэй сургалтын арга зүйд суралцах, сургалтын техник хэрэгслийг ашиглах, сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой бэлтгэхэд багшийн зөөлөн ур чадвартай байх нь чухал гэж үзэж байна.

Түрхүүр үг: *Тусгай хэрэгцээт боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, багш*

Ашигласан материал:

- [1] БСШУЯ, Б.Гэрэлтуяа: Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг мэргэшүүлэх шаардлагатай. 2020.10.09. Retrieved from <https://www.meds.gov.mn/post/64631>
- [2] Education Act of South Australia, part VI Section 74-81
- [3] AUSTRALIAN EDUCATION ACT 2013 - SECT 21 Financial assistance for schools. *www.austlii.edu.au*. Archived from the original on 31 January 2017. Retrieved 19 January 2017
- [4] Retention of students in senior secondary schools. Ministry of Education. Archived from the original on 28 March 2016. Retrieved 19 January 2018.
- [5] Policy guidelines on inclusion in education. Unesco 2009.
- [6] Za: Dykcik W. Pedagogika specjalna. Poznań 2001, s. 24.
- [7] Sękowska Z. Pedagogika specjalna. Warszawa 1985, s. 173.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

А.Буянзаяа, П.Номуунзаяа, Т.Мөнхцэцэг¹

¹ B20FA1506@ufe.edu.mn B20FA1532@ufe.edu.mn B20FA1531@ufe.edu.mn

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд тэгш оролцох болон тэгш боловсрол эзэмшүүлэх эрх нь манай улсын хувьд хангалтгүй байгаа гэсэн дүгнэлтэд хүрсэн. Нийгэмд цааш цаашдаа эрх тэгш эрхээ эдлэхийн тусгай хэрэгцээт хүүхдүүдийг бага наснаас оношийг нь тогтоох мөн тэдгээр хүмүүст хөгжихөд шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүн нь хангалттай байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Мөн түүнчлэн олонхын адил боловсрол эзэмшсэн иргэд нийгэмд гараад ажлын байр нээлттэй байдаг эсэх, тэдний хичээл зүтгэл, хөдөлмөрийг хангалттай үнэлдэг эсэх дээр судалгаа хийх үндэслэлтэй.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон тэдгээрийн боловсролын хүртээмж нь бусад иргэдтэй ижил байх шаардлагатай буюу нийгэмд ямар нэгэн гадуурхал болон тэгш бус байдлын зөрүү байх ёсгүй. Иймд бид тусгай хэрэгцээт иргэдийн боловсрол, түүний хүртээмжтэй стандартчилагдсан байдал болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, түүнд тулгарч буй асуудал зэргийг судлахаар зорьсон болно.

Материал ба арга зүй

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн 10-р цэцэрлэгийн 50 эцэг эхчүүдээс асуулгын аргаар, Өвөрхангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ярилцлагын аргаар судалгаагаа авч дүн шинжилгээ хийн боловсруулсан.

Үр дүн

Судалгаа 1: Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн боловсрол эзэмшиж байгаа байдал нь ердийн хүүхдүүдтэй адил хэмжээний боловсрол эзэмших ёстой байдаг. Тус цэцэрлэгийн хувьд тухайн хүүхдүүдийн боловсрол эзэмших, хөгжих нөхцөл байдал нь тус хүүхдүүдийн шаардлагад нийцэх эсэх асуулга дээр эцэг эхчүүдийн 48% нь хангалттай, сайн гэж хариулсан ба 22% нь шаардлага нийцдэггүй хэмээн хариулсан байна. Тус цэцэрлэгийн тоглоом шаардлагад нийцэхгүй хэмээн хариулсан хүүхдүүдийн онош нь хүнд хэлбэрийн саажилттай, доод мөч чангаралттай гэсэн хариултауд өгсөн байна.

Хүснэгт 1. Цэцэрлэгийн үйл ажиллганаад сэтгэл хангалуун байдаг эсэх

	Абсолют тоо	Эзлэх хувь
Тийм	41	82%
Үгүй	9	18%
Нийт	50	100%

Хүснэгт 2. Хүүхдийн нийгэмд өөрийгөө илэрхийлэх байдал

Оноо	Абсолют тоо	Эзлэх хувь
1	9	18%
2	8	16%
3	18	36%
4	7	14%
5	8	16%
Нийт	50	100%

Судалгаа 2: Өвөрхангай аймагт хийсэн судалгаанаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд дээд боловсрол эзэмшсэн хүмүүс дийлэнх хувийг эзэлж байгаа боловч энэ тоо ажил эрхлэлтэд буурь байна. Энэ нь нийгэм эдгээр хүмүүсийг энгийн бусадтай адил сурч, хөдөлмөрлөж, хөгжих боломжтойг нь ойлголгүй санаагүй магадгүй санаатай байдлаар ялгаварласнаас үүдэн нөөц бололцоогоо бүрэн гаргаж ажиллаж чадахгүй байгааг илтгэж байна.

График 1.




График 2.



Дүгнэлт

Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт 108399-н хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба тэдний хөдөлмөр эрхлэлт, боловсролын чанар, стандарт, тэгш байдлыг дүгнэхийг зорьсон бөгөөд тэдгээрийн төлөөлөл болгон Өвөрхангай аймгийн 18-34 насны хөгжлийн бэрхшээлтэй залуус болон тусгай боловсролын 10-р цэцэрлэгээс судалгаа авсан юм. Үүний үр дүнд тус боловсролын байгууллагаас үйлчилгээ авч буй тусгай хэрэгцээт хүүхдүүд болон тэдгээрийн эцэг эх нар тус боловсролын байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдаг хэдий ч 1. Тус боловсролын байгууллага бүрэн хүчин чадлаараа үйл ажиллагаагаа явуулахгүй 2. Тус боловсролын байгууллага нь хотын нэг л цэгт үйл ажиллагаа явуулж байгаа нь хүрэлцээтэй бус хэмээн үзэж байна. Мөн тухайн хүүхдүүдтэй ажиллах багш, асрагч нар нь мэргэшсэн байдал болон цаашдын хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлээр нь ангилж нэг ангид хамруулах нь тус

хүүхдүүдэд тохирох хичээлийн хэрэгсэл, тоглоом болон сурган хүмүүжүүлэх арга барил нь илүү тохиромжтой байна гэж үзсэн болно. Иймд нийгэмд энэ талын мэдлэгийг түгээж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусадтай адил сурч хөгжих боломжтойг нь түгээн эерэгээр хүлээн авах тал дээр анхааран ажиллах шаардлагатай юм.

Түлхүүр үг: *Мэргэшсэн байдал, стандарт, бодлого, хэрэгжилт, боловсрол*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
2. Үндэсний статистикийн хороо, дата мэдээлэл, 2020 он

ИХ ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БУЙ ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ОЮУТНУУДЫН “БИЕ БЯЛДАР”-ЫН ХИЧЭЭЛИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

*Э.Хичээнгүй¹ Н.Сарандэлгэр² М.Должинмаа³ Ч.Наранчимэг⁴
^{1,2,3,4}Санхүү эдийн засгийн их сургууль
B20FC1320@ufe.edu.mn*

Үндэслэл

Тусгай хэрэгцээт оюутнуудад зориулсан бие бялдын хичээлийн хөтөлбөр байдаг эсэхийг их дээд сургуулиудын хүрээнд судалсан боловч нийтээр дагаж мөрддөг, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр байдаггүй, хэд хэдэн их сургууль эмчилгээний биеийн тамирын хичээл ордогч агуулгын хувьд хангалттай төвшинд хэрэгжиж чаддаггүй байна. Мөн тусгай хэрэгцээт оюутнуудын хэрэгцээ, хүсэл сонирхол руу чиглэсэн бие бялдын хичээлийн хөтөлбөрийг дан ганц биеийн тамирын багш хэрэгжүүлэх нь учир дутагдалтай гэж үзсэн тул тэдгээр оюутны сэтгэл зүй, биеийн ерөнхий байдал, цаашлаад үүссэн асуудал хүндрэлийг шийдэх олон талын цогц үйлчилгээ үзүүлэх “Тусгай мэргэжлийн баг”-ийг сургууль бүрт ажиллуулах зайлшгүй шаардлагатай байна.

Зорилго

Их, дээд сургуулиудад суралцаж буй тусгай хэрэгцээт оюутнуудын дасгал хөдөлгөөний хэрэгцээг тодорхойлох, дасгал хөдөлгөөн хийхэд саад болж буй хүчин зүйлсийг илрүүлж засаж сайжруулах. Үүний тулд “Тусгай мэргэжлийн баг”-ийг их, дээд сургууль бүрд бүрдүүлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Материал ба арга зүй

Их дээд сургуулиудад суралцаж буй тусгай хэрэгцээт оюутнуудаас түүвэр бүрдүүлж, ярилцлагын болон асуулга судалгааны аргаар өгөгдөл цуглуулсан ба уг сэдвийн хүрээнд судлагдсан байдлын судалгаанд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн таамаглалаа дэвшүүлж, дэвшүүлсэн таамаглалаа судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэж, бусад эх сурвалжийн мэдээллүүд дээр үндэслэн батлав.

Үр дүн

Эмч болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд нь тусгай хэрэгцээт хүмүүсийг дасгал хөдөлгөөн хийхэд нь өндөр нөлөө үзүүлдэг ба судалгаанаас үзэхэд тусгай хэрэгцээт хүмүүсийн 82 хувь нь эмчийн зөвлөж, санал болгосон дасгал хөдөлгөөнийг хийх хандлагатай байдаг байна. Онол, стандартыг практик дээрх хичээлийн цаг, агуулгатай уялдуулан мөн судалгаанд хамрагдсан тусгай хэрэгцээт оюутнуудын хүсэл, сонирхол хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдэл хайх явцад одоогийн хэрэгжиж байгаа биеийн тамирын хичээлийн хөтөлбөр нь тэдгээр оюутнуудын хөдөлгөөний хэрэгцээ, эрх тэгш суралцахад хангалттай биш байгаа учир зайлшгүй шинэчлэх шаардлагатай байна.

Иймд сэтгэл зүйн талаас дэмжиж зөвлөх сэтгэл зүйч, биеийн тамирын багшид тухайн хүүхдүүдийн биеийн нөхцөл байдал, хөдөлгөөн хийх чадамжийн төвшин зэргийг мэргэжлийн зүгээс зөвлөх эмч мэргэжилтэн хэрэгтэй байгаа учир энэхүү ажлыг гүйцэтгэх “Тусгай мэргэжлийн баг” бүрэлдэхүүнийг бүрдүүлэх шаардлагатай ба уг багийн тусламжтай тусгай хэрэгцээт оюутан бүр өөрсдийн бие, эрүүл мэндэд тохирсон “Бие бялдарын хичээлийн хөтөлбөр”-т хамрагдсанаар насан туршийн дасгал хөдөлгөөнтэй холбоотой мэдлэг боловсролыг авах боломжтой юм. “Тусгай мэргэжлийн баг”-ийг бүрдүүлэх боломжит хоёр шийдэлтэй буюу их, дээд сургууль бүрд орон тоо гаргах эсвэл явуулын багаар дамжуулан гүйцэтгэх боломжтой.

Дүгнэлт

Их, дээд сургуулиудад суралцаж буй тусгай хэрэгцээт оюутнуудын бие бялдрын хэрэгцээ болон биеийн тамирын хичээлийн агуулга хоёрын ялгааг гаргаж, тэдэнд тохирсон боломжит шийдлийг эрэлхийлсэн. Судалгаанд хамрагдсан тусгай хэрэгцээт оюутнууд дасгал хөдөлгөөн хийхгүй байснаар үүсэх эрсдэлийг мэдэж байсан ч юуг хэрхэн хийх талаар ойлголт тааруу байсан нь судалгааны үр дүнгээс харагдсан. Зарим их, дээд сургуульд эмчилгээний биеийн тамирын хичээл үзэх боломжтой ч тусгай хэрэгцээт оюутны нөхцөл байдалд нийцдэггүйгээс гадна тэднийг уг хичээлийн мэдээ мэдээллээр зохих төвшинд хангаж чаддаггүй байна. Мөн судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь өөрсдийг нь ойлгодог, эрүүл мэндийн нөхцөл байдлыг мэргэжлийн нүдээр хардаг, өөрсдийнх нь эрүүл мэндэд тохирсон хөдөлгөөн хийлгэдэг багш, мэргэжилтэн хэрэгтэй байгааг илэрхийлэхийн сацуу тэдгээр оюутнуудын бие бялдрын нөхцөл байдалд нийцээгүй энгийн биеийн тамирын хичээлийг эрүүл мэндийн хувьд бэрхшээлгүй оюутнуудтай хамтдаа судлах нь тэдэнд ихээхэн хүндрэл учруулдаг байна.

Энэ мэт тусгай хэрэгцээт оюутнуудын үзэл бодол, туршлагаас үндэслэн тэдэнд зориулсан биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийг оюутан бүрд тусгайлан бэлтгэх “Тусгай мэргэжлийн баг”-ийг их дээд сургууль бүрд зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай ба тус баг нь мэргэжлийн эмч, сэтгэл зүйч, хөдөлгөөн засалч гэсэн гурван ерөнхий бүрэлдэхүүнтэй байх нь тохиромжтой гэж үзэв.

Түлхүүр үг: Бие бялдрын хичээл, Эмчилгээний биеийн тамир, Тусгай мэргэжлийн баг

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар (2018). Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Монгол улсын стандарт. *Клиникийн бүтэц, үйл ажиллагаа* (2021). Монгол Улс, Улаанбаатар хот.
3. U.S. Department of Health and Human Services. *Physical Activity Guidelines for Americans*, 2nd edition (2018). Department of Health and Human Services Physical Activity Guidelines for Americans
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн ерөнхий газар. “Хөгжлийн бэрхшээл судлал ба инновац-2020” (2020). Монгол улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ

Э.Болдмандах¹

¹ Шуурхай удирдлагын албаны мэдээлэл шуурхай удирдлагын төвийн шуурхай удирдлагын хэлтэс /102/-ийн мэдээлэл хүлээн авагч цагдаагийн ахмад

Үндэслэл

Хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авах арга хэмжээг төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлаас баталж байгаа хууль, тогтоолд тусган өгч, хүний эрхийг хангах чиглэлээр мэдрэмжтэй хууль батлах талаар Улсын Их Хурлын дарга, Г.Занданшатар 2021 оны намрын ээлжит чуулганы хуралдааны нээлтийн үйл ажиллагаанд хэлсэн үгэндээ онцгойлсон билээ. Өнөө үеийн сургалтын зорилго нь иргэдэд бие дааж суралцах, ажил хөдөлмөр эрхэлж амьдрах арга чадварыг эзэмшүүлэх, өөрийнхөө мэдлэг чадвараа хөгжүүлэх, хурдацтай өөрчлөгдөж буй орчинд дасан зохицох, шинийг хүлээн авах, хийж бүтээх, өрсөлдөх чадвартай хүнийг төлөвшүүлэх явдал боллоо. Мөн коронавирусын цар тахлын үед хүн бүр технологийн дэвшлийг ашиглан зайнаас төрөл бүрийн сургалтад хамрагдах шаардлагатай тулгарч байна. Цар тахлын энэ үед Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо, Боловсрол, шинжлэх ухааны яамны зүгээс цахим сургалтын орчинг дэмжсэн арга хэмжээнүүдийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Цахим сургалтын орчинг нэвтрүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг орхигдуулалгүй анхаарч байна. Бид нэг үе мэдлэг, чадвар, төлөвшилт хэмээн дэс дараалалтай сургалтын процесс явагддаг байсан бол өнөөдөр аливаа зүйлийг сурах, бүтээх гэсэн чин эрмэлзэл, хандлагатай байх нь чухал болоод байна. Үүнтэй уялдан шинэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сургалтын агуулга, багш, иргэдийн хандлага, сурах, сургах арга, үнэлгээ зэрэг сургалтын технологийн бүх элемент өөрчлөгдөхөөс өөр аргагүй болно. Энэ цаг үед сургахын тухай биш, суралцахуйн тухай ярих нь илүү оновчтой асуудал боллоо.

Материал ба арга зүй

- Мэдээлэл цуглуулахад: Туршилтын арга, асуулгын арга, ярилцлагын арга
- Мэдээлэл боловсруулахад: Цуглуулсан мэдээлэлд анализ хийж дүгнэлт хийх аргыг ашигласан болно.

Үр дүн

2011-2018 оны хооронд гэхэд л дэлхийн 800 гаран их, дээд сургуулиуд 10,000 гаруй төлбөргүй цахим сургалтыг интернетэд байршуулсан байна. 2020 онд, зөвхөн АНУ-д гэхэд цахим сургалт заах арга зүйн худалдаа 37.6 тэрбум доллар байхаар тооцоолсон байна. Covid-19 вирусийн тархалтаас шалтгаалан энэ тоо өсөх ч магадлалтай. Олон улсын онлайн сургалтын

платформд богино хугацааны болон мастер докторын гэх мэт эрдмийн зэрэг олгох боломжтой 69 улсын 15,957 зайн сургалтын хөтөлбөр бүртгэлтэй байна. Зөвхөн АНУ-д, 2017 онд 6,651,536 оюутан дор хаяж нэг онлайн сургалтад хамрагдсан байна. Энэ мэтээр цахим сүлжээний асар өргөн боломжийг боловсролын салбарт ашиглаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцахын ач холбогдлыг бүрэн ойлгож, хүсэл тэмүүлэл нь дараах төсөөлөлтэй холбоотой байдаг. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн өөрсдийн хандлага нь бусдаас хамааралтайгаас үл хамааралтайруу чиглэсэн байдаг.
- Тэдний цагийн болон үйлийн зан төлөв нь аливаа зүйлийг хойш тавих бус, харин "тухай бүрд нь" гэсэн байдалд шилжих ба судлагдахуунд төвлөрөх бус олж буй амжилтандаа, сурч мэдэж буй зүйлдээ илүү тулгуурладаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сургалтад анхаарах зүйлс:

- Идэвхтэй оролцоо: Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийгөө аль болох дайчилж чадвал тэдний сургалт үр ашигтай, хурдан шуурхай болж чадна. Тэдэнд аль болох сурсан зүйлээ практикт хэрэглэх нь л чухал байдаг.
- Сургалтын орчин аюулгүй, тайван байх: Хөгжлийн бэрхшээлтэй хүн амар тайван, чөлөөтэй, тэдний үзэл бодол, сонголт, туршлагыг үнэлж, харгалзаж үзсэн, найрсаг, хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлбэл сургалт амжилттай болно.
- Хүртэхүйн олон тал: Бид нүдээрээ үзэж, гараараа барьж, сонсож, үнэрлэж, амталж, хийх явцдаа суралцдаг. Иймд аль болох олон төрлийн хүртэхүй оролцож байвал сургалт илүү амжилттай болно гэдгийг мартаж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд аль нэг хүртэхүйн мэдрэмжийн асуудалтай байдаг, харин бусад мэдрэхүйгээ өндөр төвшинд хөгжүүлэх нь ахиц гаргах магадлал өндөр байдаг.

Шинэ мэдлэг чадварыг практикт хэрэглэх боломж олговол сургалтын амжилтад сайнаар нөлөөлнө. Гэхдээ шинэ ойлголт, чадварыг ялгаатай нөхцөлд хэрэглэхдээ мөн л өмнө нь юу мэддэг, чаддаг байсантай нь холбож өгөх хэрэгтэй. Нөгөө талаар суралцагч уруу үнэлгээ хийсэн мэдээллээ эргэн явуулах нь тэднийг дэмжих, урам зориг өгөхөд ач холбогдолтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөр өөрийн туршлага арга барил аль хэдийн суусан учир энгийн загвартай байх аргагүй бөгөөд тэдэнтэй ажиллаж буй багш аль болох суралцагчдынхаа сурах хэв маягийг урьдчилан тогтоохыг оролдох нь чухал. Аливаа сургалтыг амжилттай болгох үндэс нь бэлтгэлээ сайн хангах явдал юм.

Дүгнэлт

Санал зөвлөмж сургалтын тайланг оролцогчдоос гадна бусад холбогдох газруудад тараана. *Өнөөдөр хүн бүр сурч боловсрох эрхээ эдэлж чадаж байна уу?, Боловсрол эзэмших нь яагаад чухал вэ?, Хүүхэд бүрд чанартай боловсролыг үнэ төлбөргүй олгож байна уу?, Боловсролын хүрээнд*

жендэрийн тэгш эрхийг хангаж чадаж байна уу?, Боловсролын чанар сайжирч байна уу?, Эдгээр зорилт биелэгдэх боломжтой юу?, Өнөөдөр боловсрол эзэмшихэд ямар асуудал тулгардаг вэ?, Монголд боловсролын асуудлаар ямар санаачлага, үйл ажиллагаа өрнөж байгаа вэ?, Боловсролын төлөө та юу хийж чадах вэ? гэсэн асуултууд гарч ирж байна. Боловсрол нь хүмүүний хөгжлийн арга тал төдийгүй түүний эрчим хүч буюу энерги бөгөөд тасралтгүй, насан туршийн шинжтэй. Иргэн бүр өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд эзлэх байр суурь, мэргэжлийн чадвараа дээшлүүлж, нийгэм эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцох, насан туршдаа суралцах нь мэдлэг хуримтлуулахаас илүүтэйгээр тухайн хүнд суралцахууд сурах чадварыг хөгжүүлэхэд чиглэж мэдээлэл, нийгэм, соёлын болон бусад харилцаанд ороход шаардлагатай олон талт чадварыг эзэмшихэд сургана. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр авьяас билэг, мэдлэг чадварыг эзэмшихэд хүрэх тэмүүлэл, оролдлогоор янз бүрийн орон зайд албан бус хэлбэрээр эзэмшиж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол гэдэг нь: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдлэг, чадварыг олгох замаар өөрсдийн тулгамдсан асуудлыг олж харан тодорхойлдог, түүнийг шийдэх арга замыг судлан олж, төрийн бодлогоор дамжуулан асуудлаа шийдвэрлэж чаддаг ардчилсан нийгмийн идэвхтэй, оролцоотой иргэн болоход нь нөлөөлөх. Хувь хүний давуу чанараараа өөрийгөө чиглүүлж, амьдралын туршдаа эзэмших оюун ухааны хөгжил юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сургалтад шинэ дэвшилтэт технологийг ашиглан дүрсээ харж сургалтад оролцох боломж, дуу ярианы технологийн дэвшлийг сургалт болон ажил амьдралд нь ашиглан дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн суралцах боломжоор хангах шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, сургалт, дэвшилтэд технологи*

Ашигласан материал:

1. Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр, АББЗСҮТ, 2006 он
2. Ё. Нямдаваа насанд хүрэгчдэд зориулсан сургалтын материал бэлтгэх, 2002 он
3. О. Мягмар “Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд, УБ, 2000он
4. “ Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол” онол арга зүй АББЗСҮТ, 2008 он
5. “ Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол” гарын авлага АББЗСҮТ, 2008 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ТЭГШ ХАМРАН СУРГАХ НЬ

Б.Болормаа¹

¹ Ховд аймгийн Булган сумын 2-р дунд сургуулийн дизайн технологийн багш

Үндэслэл

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ерөнхий боловсролын сургуульд элсэн орохыг хориглосон заалт байхгүй. Бага, дунд боловсролын тухай хуулийн “ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд суралцах нөхцөл бололцоог хангах ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээний хүрээ, төрөл, чанарыг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох, бие даан ажиллаж амьдрах чадвар эзэмшүүлэн нийгэмшүүлэх ба сургалтын таатай орчин бүрдүүлэх нь хамгаас чухал юм. Ерөнхий боловсролын ердийн сургалттай сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гарган тэгш хамруулан суралцах боломжийг бий болгох шаардлагатай байна.

Зайлшгүй хамрагдах ёстой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүрэн дүүрэн боловсролын үйлчилгээнд хамруулж сургахад мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ муу, сургалтад зориулсан ном, сурах бичиг, гарын авлагын хүртээмжгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд хүүхдүүдээ сургах, боловсролтой болгох нийгэмшүүлэх талаар хангалттай мэдлэг мэдээлэл байхгүй хүүхдийг сургалтад хамруулахад эцэг, эхэд тохиолддог нийтлэг бэрхшээл гэх мэт олон асуудал нийгэмд тулгараад байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн адил тэгш сурах, боловсрол эзэмших үйл явцад тулгараад байгаа асуудлыг тодруулах, санал, зөвлөмж гаргах үүднээс энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамран сургах, татан оролцуулах, зөв харилцаа хандлагатай болгон төлөвшүүлэх, нийгэмшүүлэх, хамран сургах хүүхдийн боловсролд анхаарах зарим асуудлыг судлан тодорхойлох

Материал ба арга зүй

Асуулга, ажиглалт, туршилт, харьцуулан дүгнэх, баримт бичгийн шинжилгээний аргуудыг хэрэглэсэн болно.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамран сурах боломжийг тодорхойлох, багш нараас судалгаа авах, ямар, ямар бэрхшээлүүд тулгардаг эсэх, цаашид анхааран өөрчлөх ямар боломжууд байж болохыг эрэлхийлэх

нь судалгаа хийх гол үндэслэл болж байгаа юм. Ердийн сургалттай сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш нараас судалгаа авсан болно.

Багш нараас түүврээр авсан судалгаа

График 1.





График 2.



Судалгааны үр дүнгээс үзэхэд багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад олон бэрхшээл тулгардаг, сургалтын орчин бүрдүүлэхэд анхаарах, туслах багштай байх, ном сурах бичиг дутагдалтай, тусгайлан тохижуулсан анги танхимтай болох, нэмэгдэл ажлын хөлс олгох гэх мэт олон асуудлыг тэмдэглэжээ. Эцэг эх, гэр бүлийн зүгээс тусалж дэмжих, хамтран ажиллахыг хүлээдэг нь харагдаж байгаа ч багш нар хөгжлийн бэрхшээлтэй шавь нартаа үргэлж санаа тавьж сэтгэлийн дэм өгч, үе тэнгийн найз нөхөдтэй болж өөрийгөө илэрхийлэх, бусадтай зөв боловсон харьцах, тодорхой ахиц амжилттай суралцахыг хичээн ажиллаж байгаа нь харагдаж байна. Статистикийн нэгдсэн сангийн мэдээллийг авч үзвэл Ховд аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 2866 иргэдээс:

- Харааны-282
- Сэтгэцийн- 459,
- Хэл яриа-184
- Сонсголын-222
- Хөдөлгөөний-568
- Хавсарсан-228
- Бусад төрлийн-923 иргэн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Манай Булган сумын хувьд Ховд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 13% хувь буюу 370-аад иргэн байдаг. Үүнээс 0-16 насны 26 хүүхэд байдаг гэсэн тоон судалгаанаас үзэхэд Булган сумын 1-р сургуульд 8-17 насны 6 хүүхэд, 2-р сургуульд 9-16 насны 5 суралцагч, Насан туршийн

боловсролын төвд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнээс 13-18 насны 3 суралцагч буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 54% хувь нь ердийн сургалттай сургуульд хамрагдан суралцаж байгааг харж болно. Үлдсэн 46% хувь нь огт сургуульд хамрагдаж чадаагүй нь маш харамсалтай.

Дүгнэлт

Ерөнхий боловсролын сургууль нь тэгш хамран сургах боловсролыг дэмжих зорилгоор "Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах хэрэгцээг тодорхойлж, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, тухайн хүүхэд ихийг сурч чадахгүй ч үе тэнгийн найз нөхөдтэй болж өөрийгөө илэрхийлж сурах, харилцааны соёлд суралцаж төлөвших, нийгэмших, хүсэл сонирхлоо хөгжүүлж амьдрах чадварт суралцах нь хамгаас чухал. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотроос хөдөлгөөний бэрхшээл, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүд нь сургуульд явах, бие даан очиж чадахгүй, хичээлээ ойлгодоггүй, хаана хэнд хандаж боловсролын ямар үйлчилгээ авахаа мэдэхгүй байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн энэ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, үе тэнгийнхэн болон сургуулийн удирдлага, багш нарын зүгээс тэдний нэр төрийг нь хүндэтгэн харьцах хандлага маш хэрэгтэй.

Түлхүүр үг: *Хүүхэд, хөгжил, хандлага, оролцоо, нийгэмшүүлэх*

Ашигласан материал:

- [1]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх гарын авлага (2019)
- [2]. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагаа (2019)
- [3]. Боловсролын хууль / бага, дунд /
- [4]. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль
- [5]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам

“САЙН САНАА- САЙХАН СЭТГЭЛ” ОЮУТНЫ НЭГДЛИЙН ОРОЛЦООТОЙГООР ХЭРЭГЖҮҮЛСЭН “ХҮН БҮРД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН” ТӨСЛИЙН ҮР ДҮН

П. Дуламжав, С. Цэеэрэгзэн, Э. Ариунцэцэг, Д. Оюунсүрэн, Б. Мэндхүү¹
¹АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн багш нар
mendkhuu@mnums.edu.mn.

Үндэслэл:

Монгол улсын хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй 30000 орчим нь насанд хүрээгүй хүүхдүүд үүнээс 22000 гаруй хүүхэд тусгай болон ЕБС-д суралцаж байгаа ба [8]. Дархан-Уул аймагт нийтдээ 500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг ба тус сургуулийн хэмжээнд 12 оюутнууд суралцаж байна. Сүүлийн үед баригдаж буй барилга, үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг шийдэж ажиллаж байгаа [9] хэдий ч стандартын бус шатны налуу, бариул зэрэгтэй байгаа нь дахин эрсдэл авах, гэмтэх нөхцөлийг бүрдүүлж байна. Төр засгаас сонсголын бэрхшээлтэй иргэд, сурагчдад зориулсан, тэдгээрийн хүсэн хүлээж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүйгээр яаралтай авахад чиглэсэн тодорхой төсөл, хөтөлбөрүүдийн нэг нь Анагаахын сургуульд суралцагчдад Сонсголгүйн боловсрол олгох, дохионы хэлний хэлмэрчийн асуудал туйлын чухал тавигдаж байна. АШУҮИС-ийн Оюутан суралцагч, багш, ажилтнууд, ажилчид ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй 12 суралцагчдад боловсролын стандартын шаардлагыг хангасан аюулгүй, эрүүл орчинд суралцах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, боловсролын чанартай үйлчилгээг тэгш хүртээх боломж олгох, сонсголгүйн боловсрол олгохын тулд “Хүн бүрт хүртээмжтэй орчин” төслийг хэрэгжүүлэх үндэслэл боллоо.

Зорилго

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС-ийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад суралцах боломжийг хангах, “Ээлтэй босго-1”, “Ээлтэй босго-2” сургуулийн Б болон В оюутны байранд бий болгох, ХБИ-ийн бие, сэтгэлзүйн онцлогийг тусгасан асаргаа, сувилгааны ном, гарын авлага, сурах бичгийн сургалтын булан байгуулах, төгсөх дамжааны оюутнуудад дохионы хэлний сургалт зохион явуулах

Зорилтууд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд болон хүмүүст тус сургуулийн хичээлийн Б байр болон В байранд Монгол улсын стандартын дагуу налуу гүйцэтгэх.
2. “Дохионы Хэлний Хэлмэрч Орчуулагчдын холбоо” Дархан дахь салбар ТББ, “Сонсголгүйн боловсрол” ТББ-ууд хамтран 20 удаагийн “Харилцааны анхан шатны дохионы хэлний сургалт”-ыг явуулах.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан асаргаа, сувилгааны сургалтын гарын авлага, сургалтын материалуудтай "Номын булан" байгуулах

Материал ба аргазүй

БСШУСЯ–наас зарлагдсан Азийн Хөгжлийн Банкны төгрөг 5.053 400 төг санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэлийн төсөл" (ДБШТ) -ийн хүрээнд Оюутны санаачилгын "Хүн бүрт хүртээмжтэй орчин" төсөл нь Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 178-р тогтоолоор баталсан "Орлоготой оюутан" үндэсний хөтөлбөр [5], Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2019 оны А/563 дугаар тушаалаар батлагдсан [3], "Оюутны санаачилгын тэтгэлэгт төсөл сонгон шалгаруулалтад тэнцэж, уг төсөл амжилттай хэрэгжсэн болно.

Үр дүн

1. "Ээлтэй босго-1", "Ээлтэй босго-2" нь Дархан-Уул аймгийн Их, Дээд Сургуулийн хэмжээнд төдийгүй Дархан-Уул аймгийн албан байгууллагуудад хэрэгжүүлэхээр үлгэр жишээ загвар стандарт "Ээлтэй босго" болсон.
2. Дохионы хэлний сургалтыг явуулснаараа сонсголын бэрхшээлтэй иргэд эмнэлэгт үйлчлүүлэхэд бэрхшээлгүй болж, яаралтай тусламжийг цаг алдалгүй авах ба дохионы хэлний сургалтад суусан төгсөх ангийн оюутнууд ажлын байрны шалгаруулалтад давуу тал болох ба Монгол Улсын хэмжээнд анх удаа АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Салбар Анагаах Ухааны сургуульд явуулснаараа шинэлэг тал нь оршино.

Дүгнэлт

1. Иргэний барилгын төлөвлөлтөд ХБХ-ний шаардлагыг тооцсон орон зай, орчныг бий болгоход Үндсэн шаардлага MNS 6055;2009 стандартад зааснаар налуу зам 1*12 харьцаа бүхий налууутай, налууны 2 хажуугаар 90 см өндөртэй хашлагатай, 50 см өндөрт бариултай, бариулын үзүүр хэсэг нь дугуйруулж заасан ба тэнгэрцэр эргэх эргэх боломжтой тэгш талбай зэрэг стандартын дагуу АШУҮИС-ийн Дархан АУС-ийн Б байранд "Ээлтэй босго-1", АШУҮИС-ийн Дархан АУС-ийн Оюутны байранд "Ээлтэй босго-2"-ыг тус тус бүтээн байгуулсан.
2. "Хүн бүрд хүртээмжтэй орчин" төслийн баг болон "Дохионы Хэлний Хэлмэрч Орчуулагчдын холбоо" Дархан дахь салбар ТББ, "Сонсголгүйн боловсрол" ТББ-ууд хамтран 20 удаагийн "Харилцааны анхан шатны дохионы хэлний сургалт"-ыг АШУҮИС-ийн Дархан АУС-ийн төгсөх курсын 43 оюутнуудад зааж сургаж дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгосон.

Түлхүүр үг: *Ээлтэй босго, Оюутны санаачилга, Дохио хэлний сургалт*

Ашигласан материал:

1. Балжинням А Сэргээн засах судлал, Улаанбаатар, 2015 он
2. Батцэнгэл Г. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган, сэтгэлзүйн зарим асуудал УБ.2007 он
3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны А/563 дугаар тушаалаар батлагдсан “Оюутны санаачилгын тэтгэлэгт төсөл
4. Даваасүрэн Л Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засалтын талаарх эмхтгэл, Улаанбаатар, 2007 он
5. Монгол Улсын Засгийн Газрын 2016.12 сарын 7-ны өдрийн 178-р тогтоолоор баталсан “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр

ОЮУТНУУДЫН ОРОЛЦООТОЙГООР ХЭРЭГЖҮҮЛСЭН “10 ОЮУТАН & 10 ХБХ” ТӨСЛИЙН ҮР ДҮН

н. Оюунчимэг, Э. Ариунцэцэг, Д. Оюунсүрэн, Б. Мэндхүү¹

*¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн багш
нар*

mendkhuu@mnums.edu.mn. 99700232

Үндэслэл

Дархан-Уул аймагт хөгжлийн бэрхшээлтэй нийт 118 хүүхэд байгаа боловч Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхчүүдийн холбоотой хамтран бага насны хүндэтэр оноштой 10 хүүхдүүдийг сонгон авсан нь “10 оюутан & 10 ХБХ” төсөл хэрэгжих зорилтот бүлэг болсон. Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдүүдэд чин сэтгэлээсээ ирээдүйд эзэмших мэргэжил ба хүмүүнлэг тэдний зовлон бэрхшээлийг хүндэтгэн ойлгох, ах эгчийн ёсоор тусалж хандах хэрэгцээ, нөхцөл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бага ч гэсэн хувь нэмрээ оруулах шаардлага нь “10 оюутан & 10 ХБХ” төслийг санаачилан, хэрэгжүүлэх үндэслэл боллоо.

Зорилго

“10 оюутан & 10 ХБХ” төсөл нь Дархан-Уул аймгийн хөгжлийн хүнд бэрхшээлтэй 10 хүүхдүүдэд хөдөлгөөн засал, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах дэвшүүлэн тавьсан зорилгынхоо хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. “10 оюутан & 10 ХБХ” төсөл нь Дархан-Уул аймгийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд 22 удаагийн хөдөлгөөн засал, нөхөн сэргээх хөдөлгөөн засал, бариа эмчилгээ, цэгэн эмчилгээ, ахуй засал, бариаг нийтдээ 10 хүүхдүүдэд 200 удаагийн засал, бариаг хичээлийн бус цагаар багш, эмчийн удирдлага дор хуваарийн дагуу гэрт нь очин хийж, гүйцэтгэх
2. Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхэддээ эдгэрэх итгэл найдвар төрүүлэх, хүмүүс ойлгож, мэргэжлийн зүгээс туслан, дэмжиж байна гэдгийг мэдрүүлэн эерэг хандлагыг бий болгож, чин сэтгэлээсээ туслах
3. Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхэддээ ерөнхий биеийн байдлыг хөдөлгөөн засал, нөхөн сэргээх хөдөлгөөн засал, бариа эмчилгээ, цэгэн эмчилгээ, ахуй засал, бариаг хийх бүртээ хянах, чийрэгжих боломж олгох, цаашдаа бие даан амьдрахад сургах
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд “Дагаад сураарай” 3 удаагийн аяныг зохион байгуулах

Материал ба арга зүй

БСШУСЯ–наас зарлагдсан Азийн Хөгжлийн Банкны 4.060.100 төгрөг санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэлийн төсөл” (ДБШТ) -ийн хүрээнд Оюутны санаачилгын “10 оюутан & 10 Хөгжлийн бэрхшээлтэй

хүүхэд” төсөл нь Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 178-р тогтоолоор баталсан “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны А/563 дугаар тушаалаар батлагдсан, “Оюутны санаачилгын тэтгэлэгт төсөл сонгон шалгаруулалтад тэнцэж, уг төсөл амжилттай хэрэгжсэн болно.

Үр дүн

“10 оюутан & 10 ХБХ” төсөл нь Дархан-Уул аймгийн хөгжлийн хүнд бэрхшээлтэй 10 хүүхдүүдийг сонгон авч, 1 хүүхдэд 22 удаа, нийт 10 хүүхдэд 200 удаагийн засал, хөдөлгөөн засал, бариа засал, цэгэн бариа, ахуй засал нөхөн сэргээх үйл ажиллагааг, сэргээн заслын хичээлийн багш, хүүхдийн саа саажлын нөхөн сэргээх бага-эмч Алтанчимэгийн хяналт, удирдлага дор хуваарийн дагуу хичээлийн бус цагаар 7 хоног бүрийн Даваа-Бямба гарагуудад хөдөлгөөн засал, бариа эмчилгээ, цэгэн эмчилгээ, ахуй эмчилгээний тусламж үйлчилгээг гэрт нь очин тусламж үйлчилгээг үзүүлсэн ба бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд “Дагаад сураарай” аяныг зохион байгуулах үйл ажиллагаа явуулсан.

Дүгнэлт

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн Уламжлалт заслын ангийн 10 оюутан “10 оюутан & 10 ХБХ” төслийг 6 сарын хугацаанд хэрэгжүүлснээр хөгжлийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй бага насны 10 хүүхдийн мөчдийн саа, саажилт, танин мэдэхүй тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх эмчилгээний үр дүн сайн гарах болно гэж төсөөлж байсан боловч хүнд хэлбэрийн саа саажилттай хүүхдүүд байсан учраас бид тэдэнд сэтгэлзүй талаас маш их дэмжлэг үзүүлсэн, тэдний зовиур шаналгаа бага зэрэг ч гэсэн хөнгөрсөн гэж дүгнэж байна.

Түлхүүр үг: *Оюутны санаачилга, хөгжлийн бэрхшээл, сэргээн засал*

Ашигласан материал:

1. Балжинням А Сэргээн засах судлал, Улаанбаатар, 2015 он хуу 13
2. Батцэнгэл Г.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган, сэтгэлзүйн зарим асуудал, Улаанбаатар, 2007 он
3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны А/563 дугаар тушаалаар батлагдсан “Оюутны санаачилгын тэтгэлэгт төсөл
4. Даваасүрэн Л Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засалтын талаархи эмхтгэл, Улаанбаатар, 2007 он
5. Монгол Улсын Засгийн Газрын 2016.12 сарын 7-ны өдрийн 178-р тогтоолоор баталсан “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр

МӨЛХӨЖ БАЙВЧ, МӨРӨӨДЛӨӨР ЖИГҮҮРЛЭСЭН АЛТАН ХАРААЦАЙ

У.Уранчимэг¹

¹ Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг

Үндэслэл

“Хараацай шувуу тэрээр эрхий мэргэн харваачид сүүлээ сэт харвуулсан боловч халин дүүлэх чадвараа алдаагүй” гэдэг гэсэн монгол ардын үлгэр домог байдаг. Үүнтэй утга ижил хөгжлийн бэрхшээлтэй болсон хэдий ч хүсэл мөрөөдлөөрөө жигүүрлэн өнөө цагийн залуусын нэгэн адил зүрх сэтгэлийн дуудлагаараа амьдарч буй Монгол орны хөдөө суурингийн “Алтан хараацай” охины амьдралын бодит түүх, хөгжлийн бэрхшээлтэй гэгдэх хүүхэд, иргэдийн боловсрол эзэмших үйл явц монгол орны хэмжээнд хэрхэн өрнөж буйг энэхүү өгүүлэлдээ дүрслэн үзүүлэхийг зорьсон нь энэ билээ. Асуудал байвал шийдэл заавал бий !!!

Зорилго

Хүн төрөлхтөн түүхэндээ хөгжлийн бэрхшээлийн тухай асуудал байсаар ирсэн ба байх болно гэж үздэг. Тэгвэл төрөлхийн буюу олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал өнөөгийн нөхцөлд ямар байгаа вэ? Хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгох ёстой вэ? гэсэн түмэн зүйлийн асуулт тулгардаг. Эдгээр асуултад хариу өгөхийн тулд энэхүү судалгааг хийв.

Материал ба арга зүй

“Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй”, “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй”, БСШУЯ-ны 2019 оны А/292 тушаал, Цахим нийтлэл, www.1212.mn /статистикийн мэдээллийн лавлах/ зэрэгт агуулгын шинжилгээ хийн ХБХ сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байсаар байгаа нь нийгэмд боловсролгүй “Үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцөлийг нь бүрдүүлж байгаагийн нэг жишээ болгон “Хөдөө суурингийн “Алтан хараацай” буюу монгол орны нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын төлөөлөл нэгэн охины амьдрал түүхийг судлан энэхүү өгүүллэгийн гол төлөөлөл болгон бичлээ.

Үр дүн

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар харааны бэрхшээл 11690-10,9 %, сонсголын бэрхшээл 8585 – 8,0%, хэл ярианы бэрхшээл 4086 -3,8%, хөдөлгөөний бэрхшээл 21545 -20,1%, сэтгэцийн бэрхшээл 20728 -19,4 %, хавсарсан 7334-6,8%, бусад 33107-30,9% эдгээр иргэд эдлэх ёстой эрхээ эдэлж чадахгүй байгааг бид анзаарсан ч анзаараагүй мэт хууль нь ч хүний эрх нь ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүрэн төгс үйлчилдэггүй. Монгол улс 2011 оны байдлаар 61095 эрэгтэй хүн буюу 57 %, 45980 эмэгтэй хүн буюу 43% -ийг эзэлж байна. Хөдөлмөр хийх насны 88240 хүн хөдөлмөрийн

чадвараа бүр буюу түр алдсан харамсалтай эмгэнэлтэй тоон мэдээлэл гарч байна. Ийнхүү 0-18 насны 12476 иргэний нэг буюу Алтан хараацай охин монгол орны баруун бүсийн, захын аймгийн нэгэн сумд өндөр настай өвөө ээжийн хамт амьдран суудаг. Алтан хараацай охины хувьд эрүүл саруул хөөрхөн охин төрсөн боловч 4 нас хүрээд түүний 4 мөч саажиж улмаар явах чадваргүй болсон төдийгүй гар хурууны мэдрэл алдагдан юм атгаж барьж чадахгүй болоод өдгөө 14 жилийн жилийн нүүр үзэж байна. Энэ хооронд түүний ээж охиноо эрүүл саруул сайн хүн болгохын төлөө эмнэлэг, рашаан, шавар, лам бөө гээд хүний хамаг л зөвлөсөн сайн гэх бүгдийг гүйцээн олон өдөр, шөнөгүй зүтгэж бас ч овоо хэдэн төгрөг зарлагдсан боловч охины биед дээрдсэн зүйлгүй байсаар улмаар тулгуур эрхтний саажилт гэсэн оноштойгоор суугаа байдалд орсон билээ. Энэ зовлонт амьдралын жилүүдэд түүний төрсөн эцэг хөлд орохгүй хүнийг үүрч, тэвэрч явсаар залхлаа гээд хөөрхий охин, түүний ээж хоёрыг орхин Улаанбаатар хотын зүг яваад сураг алдарсан гэдэг. Энэ хугацаанд Алтан хараацай өдрөөс өдөрт өсөн томрохын хэрээр түүний амьдралыг харах, таних чадвар өөрчлөгдөн тэлж, өөрийнхөө төрхийг хараад гуньж гутарч байсан өнөөх их гутрал, шаналал аажим аажмаар нимгэрэн өөрийнх нь өмнө буруутай мэт ширүүн харахаас харц далдирдаг өвөө, ээж хоёрыгоо зүрх сэтгэлийн угаас хайрлан өөрийн чадах хэмжээгээр туслахыг хичээн зүтгэнэ. Гэвч явъя гээд хөлгүй, хийе гээд гаргүй хүн яах ч билээ. Дэмий л сэтгэлд бодогдож нүдэнд харснаа хийхийг оролдон байвч чи хэрэггүй ээ, чи чадахгүй гэдэг үгийг сонсох бүрийд сэтгэл дотор ямар нэгэн юм шатаж байгаа юм шиг болж уур цухал оволзоно. Эцэст нь ажил хөдөлмөр хийж чадахгүйгээ мэдэрч өөрийн хүслээр бичиг үсэгт суралцан орчлон ертөнцийн сайн сайхныг олж харах, мэдэж, мэдрэх хүсэл давамгайлсан байвч түүний амьдарч буй энэ нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль байдаггүй нь даанч гаслантай. Гэсэн ч тэрээр бууж өгсөнгүй ээждээ хэлж 1 дүгээр ангийн Монгол хэл, Математикийн ном авчруулан эрдэм ном сурах аянд эцэс төгсгөлгүй хөл тавьсан билээ. Одоо Алтан хараацай бүрэн дүүрэн уншиж бичиж сурсан төдийгүй, япон, англи хэлний толь бичиг, ярианы дэвтэр ашиглан уншиж, бичиж, ярьж сурахыг оролдохын зэрэгцээ гэр интернет худалдан авч Facebook хаяг нээн үеийнхээ олон сайхан хүүхдүүдтэй найзлан тэдний ертөнцөд амьдарч байна. Хувь тавилан түүний хөл гарын хөдөлгөөнийг хязгаарласан ч оюун ухааны хөгжлийнхөө эрчмээр хөлтэй хүний хийж чадаагүй зүйлийг хийж чадаж байна гэж боддог. Нэг эрхтний саажилт нөгөө нэг эрхтний үүргийг орлон гүйцэтгэдэг гэдэг энэ билээ. Гагцхүү түүнд өөрийн эрдэм мэдлэг, сэтгэл зүрхээ зориулах сайн багш дутагдсан хэвээр, тэр зөвхөн бие даан суралцаж байгаа ч олон зүйлийн учрыг таньж эс чадна. Тэрээр үеийн олон хүүхдийн дунд орж найзлан нөхөрлөх, сурч мэдэхийн хүслэн туйлын их байвч өөрийн биеийн гадаад /суугаа байдал/ байдлаас болоод хүний дунд орох бүү хэл таньж мэдэхгүй хүнд өөрийн энэ байдлаа харуулах ч дургүй гэнэ. Учир нь түүнийг шоолон тохуурхах нөгөөх л хүмүүсийн ялгаварлан гадуурхалтаас энэ мэтээр манай орны олон зуун охид, хөвгүүд хөгжлийн бэрхшээлтэй

гэдэг тодотголтой айдас, хүйдэс тээн нуугдмал амьдарсаар. Тэгвэл бид хөгжлийн бэрхшээлтэй хүнд бэрхшээлгүй нийгмийг буй болгосноор хүн өөрийн хөгжлийн боломжит дээд нөхцлийг давуу талаа болгон хөгжүүлж, гэр бүл цаашлаад улс нийгмийнхээ төлөө амжилттай ажиллаж амьдарч чадахын эх үндсийг тавьж өгч болохгүй юм гэж үү. Энэхүү асуултыг монгол орны нийт иргэд та өөрөөсөө асууж үзээрэй. Магадгүй асуултын хариу олдох ч юм бил үү.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ХБИ нь бусдаас бие махбод, сэтгэцийн хувьд бага зэрэг л өөр боловч бидэнтэй нэгэн адил хүн гэсэн хүндлэл, хандлагыг төлөвшүүлэх, хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхах харилцааны хэв маягийг өөрчлөх гэх мэт бүх хэлбэрийн гадуурхлаас ангид байлгаж чадвал **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ –БЭРХШЭЭЛ БУС** болох талтай.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /цаашид ХБХ гэх/, Тэгш хамрагдалт, Хөгжих, сурч боловсрох, Сургах орчин, нөхцөл*

Ашигласан материал:

- 1.“Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй”, БСШУЯ.,УБ.2007.
2. “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй”, БСШУЯ., УБ. 2019.
3. БСШУЯ-ны 2019 оны А/292 тушаал,
- 4.Цахим нийтлэл
5. www.1212.mn /статистикийн мэдээллийн лавлах/

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОЛОВСРОЛ

Ц.Өлзийбат¹

¹ Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын Дадал сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч

Үндэслэл

Монгол улс НҮБ-аас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” конвенцод 2009 онд нэгдэж орсон. Энэ конвенцын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхүүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч, боловсрох эрхийг хангаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” өргөн хүрээтэй хуулийг 2016 онд баталсан. Хэдийгээр олон улсын болон Монгол Улсын хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж нэрлэж байгаа боловч манай боловсролын байгууллагуудад тэд “Боловсролын тусгай хэрэгцээтэй” хүүхэд юм. Тэгэхээр бид тэдний боловсролын тусгай хэрэгцээг хангах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна. Монгол оронд хөгжлийн бэрхшээлтэй (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар 2020 оны байдлаар) 108399 хүн байгаагаас эрэгтэй 61209, эмэгтэй 47190 хүн байна. Гэвч өнөөдрийн байдлаар бүх хэрэгцээг хараахан хангаж чадахгүй байна. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсрол эзэмшиж буй хөгжлийн бэрхшээлтэй 8000 орчим суралцагч байгаа нь 81 хувь нь боловсрол эзэмшиж буйг илтгэж байна. Боловсролын асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 100 хувь боловсрол эзэмшүүлэхэд чиглэж байгаа бөгөөд тусгай сургууль байгуулж, ердийн сургуульд сурах боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боломжит нөхцөлөөр нь хамруулж байгаа юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхээ бүрэн эдэлж, 100 хувь сургалтад хамрагдаж боловсрол эзэмшиж байгаа эсэхэд судалгаа хийж, нийгмийн нэг гишүүн байлгаж, бусдын ажил сурч боловсорч хөдөлмөр эрхлэх, эрхтэйг нийгэмд ойлгуулах

Зорилт:

- Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг судлах
- Олон улсын байгууллага, НҮБ-ын конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн тодорхойлсон байдлыг судлах
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хэрэглэдэг хөгжлийн

бэрхшээлийн ангиллыг судлах

- Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхойлсон байдал
- Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд хамрагдсан

байдлын судалгаа

Судалгааны ач холбогдол:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмшиж буй байдалд дүн шинжилгээ хийж, боловсролд хамрагдаагүй иргэдийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, боловсролын салбарт тусгай хэрэгцээт боловсролд чиглэсэн арга хэмжээнүүдийг судалж, тусгай хэрэгцээт боловсролын цаашдын хөгжилд хувь нэмэр оруулахуйц шинэлэг санааг дэвшүүлэн тавих.

Материал ба арга зүй

Судалгаанд статистик мэдээлэл цуглуулах аргыг өргөн хэрэглэсэн. Юмс үзэгдлийн байр байдал, хөгжил хөдөлгөөнийг илэрхийлэх үзүүлэлтийн систем, аргачлал боловсруулж, судалгаа, шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйн бэлтгэл хангах, зорилгоо тодорхойлох, мэдээ цуглуулах буюу ажиглалт явуулах, нэгтгэл, бүлэглэлт хийх, боловсруулалт судалгаа хийх зэрэг алхмуудыг үе шаттай зохион байгуулсан

Үр дүн

Судалгааны дүнд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын 75 хувь нь боловсрол эзэмшиж, 25 хувь нь боловсрол эзэмшиж чадахгүй байна. ЕБС-д 1751, сургуулийн өмнөх боловсролд 179 хүүхэд, тусгай хэрэгцээний сургуульд суралцаж байна. Үлдсэн 73 хувь нь энгийн сургуульд суралцаж байна. Олон улсын төвшинд үзвэл дундаж хөгжилтэй болон ядуу буурай оронд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших нөхцөл муу байдаг бөгөөд энэ асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй нь (Энэтхэгт 10%, Индонезид 60 хувь нь сургуульд бага сургуульд суралцаж, Камбодид 15%, Индонезид 58 хувь нь дунд сургуульд суралцаж байна) харагдаж байна. Бид тэгш хүртээмжтэй боловсролыг эзэмшүүлэх чиглэл баримтлан ажиллаж байгаагийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сурч боловсрох эрхийн хүрээнд зайлшгүй боловсрол эзэмшүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Улсын хэмжээнд 2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр. Ерөнхий боловсролын сургуульд 6301 хүүхэд суралцдагаас 1751 нь тусгай (25, 55, 63, 70 дугаар сургуулиуд оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй) 6 сургуульд суралцдаг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй нийт хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын 27 хувь нь тусгай сургуульд суралцаж байна. Сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт 1076 хүүхэд суралцдагаас 179 нь 10, 186 гэсэн хоёр тусгай цэцэрлэгт суралцдаг нь нийт сурагчдын 16,6 хувь нь тусгай цэцэрлэгт суралцаж байна. Нийтэд нь аваад үзвэл нийт хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын 26 хувь нь тусгай сургуульд суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт сурагчдын 25 хувь

нь огт боловсрол эзэмшиж чадахгүй байгаа нь тэдгээрт сурч боловсрох орчин нөхцөл дутмаг байгааг харуулж байна. Бид цааашдаа тэгш хамран сургах боловсролын хүртээмжийг нэмэгдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 100 хувь боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Бид тэгш хүртээмжтэй боловсролыг эзэмшүүлэх чиглэл баримтлан ажиллаж байгаагийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сурч боловсрох эрхийн хүрээнд боловсрол эзэмших эрхтэй болно.

Түлхүүр үг: *Тусгай хэрэгцээ, цэцэрлэг, сургууль, бэрхшээл, хөгжил*

Ашигласан материал:

1. ХНХЯ (2020). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа 2020, Монгол улс, Улаанбаатар хот
2. БСШУЯ, ЭМЯ (2018). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 2018 он.
3. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл (2016 он)., дугаар 1
4. Статистик мэдээллийн сан (2020 он)., Боловсрол https://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_1
5. Золзаяа.Б., (2013 он). Тэгш Хамруулан Сургах Боловсролыг Хэрэгжүүлэх Явцад Багшид Тулгарч Буй Асуудлыг Судалсан нь.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЗУРАХ ҮЙЛИЙГ ДЭМЖИХ НЬ

Д.Жавзансүрэн, Ч.Ням-Очир¹

¹Увс аймаг, Улаангом сум, Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв

Үндэслэл

Тухайн суралцагчид нь сонсголын бэрхшээлтэй болон аутизмын хам шинжтэй учир бусадтайгаа харилцахад тулгарч буй бэрхшээл нь дохионы хэл мэдэхгүй, хэл ярианы бэрхшээлтэй учир зургаар уншиж танин мэдэх шаардлагатай болсон. Монголын боловсролын салбар сүүлийн жилүүдэд амжилттай хөгжиж байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал болох 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр дугаар А/304, А/699, А/460 хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах, цэцэрлэг сургуульд хамрагдалтыг сайжруулах тухай батлан оруулсан “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд **“нийт хүүхэд”** гэсэн зорилгоо **“хүүхэд бүрийн хөгжил”** гэсэн зорилго дэвшүүлж хүүхэд бүрт хөгжих суралцах тэгш эрхийн баталгааг хангах хүртээмжтэй, чанартай ерөнхий боловсролын үйлчилгээ бий болгох суурь зарчимд тулгуурлан бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж байна. Ялгарах онцлог нь тэд бусдаас онцгой тэднийг бид хөгжлийн бэрхшээлтэй гэхээсээ илүү **ойлгох** тэдний дотор байгаа ертөнцийг ойлгох мэдрэх явдал юм.

Зорилго

“Миний дуртай мэргэжил” сэдэвт тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтаар дамжуулан сонирхолтой, хийж чаддаг зүйлээр дамжуулан мэргэжлээ зөв сонгох, өөртөө итгэлтэйгээр хөдөлмөр эрхлэх боломжийг нээн хөгжүүлэх, хүсэл сонирхлыг тодорхойлох. ирээдүйн ажил мэргэжлийн баримжаатай болгож, хөдөлмөр эрхлэх боломжийг нээж хөгжүүлэх нь

Материал ба арга зүй

Анкет асуулга, анализ, туршилт, ажиглалт, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглалаа. Улаангом сумын Насан туршийн боловсрол, Хүүхдийн хөгжлийн төвийн Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн тусгай хэрэгцээт боловсролын бага боловсролын сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид судалгаанд оролцсон.

Үр дүн

Онолын түвшинд судалж үзэхэд Вальдорфийн сурган хүмүүжүүлэх ухаан-“Хүүхэд бүхэлдээ мэдрэхүйн эрхтэн”, Рижжиогийн сурган хүмүүжүүлэх ухаан-“Хүүхэд бол судлаач, шинийг нээгч, Хүүхэд бол нийгмийн эд эс., Тэдний цаг хугацаа томчуудынхаас өөр”, Женев, ОУ-ын Боловсролын бага хурал (2008)-“Тэгш хамруулах боловсрол” гэж тус тус ойлгоно. Зураг уншлага, зураг дүрслэлийн арга зүйгээр хүүхдийг хөгжүүлж сургалтыг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

Онцлог шинж

- ✓ Зураг болон дүрс зурж чаддаггүй.

- ✓ Схем зураг уншиж ойлгодоггүй.
Боломжит шалтгаан
- ✓ Зураг , дүрс, биетийг хараад таньж, нэрлэн зурж, бүтээх чадвар сул.
- ✓ Нүдний болон гарын хөдөлгөөн нь зөрдөг
Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал , зөвлөмж
- ✓ Хялбар дүрсээс эхлэн бага багаар хүндрүүлсэн зураг зурахад нь туслах.
- ✓ Зургийг цэвэр нямбай зурж чадахгүй байсан ч ерөнхий дүрслэлийг гаргаж зурсан бол зөв гэж үнэлэх.
- ✓ Схем зураг дээр гол зүйлийг нь тодруулж өгөх.
Хүүхдэд өгөх зөвлөмж
- ✓ Хялбар дүрсийг харж дуурайлган зурах.
- ✓ 2 дүрсний ялгааг хэлэх
Хүүхэдтэй ажиллах арга зүй
- ✓ Нэг даалгавар гүйцэтгэсний дараа амраах.
- ✓ Тогтвортой сууж чадахгүй болсон үед чимээ багатай газар хэсэг амраах.
- ✓ Богино хугацаанд хийж дуусгах даалгавар өгч аажмаар хугацааг уртасгах.

Үйл ажиллагаа- I түвшин

Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн бага боловсролын 3 сурагч Б, В, Н нар нь зургийн хичээлд сонирхолтой. Зураас зурж гарын жижиг булчин хөгжүүлэх үйлдэл хийлгэдэг. Буддаг ном нь дээр ажиллах \ зураас зурах, хайчлах, товчлох\ гэх мэт.

Үйл ажиллагаа-II түвшин

Уран зураг – Урлангийн танхимд сурагчидаа оруулж танилцуулж, уран зургийн багш С. Басанхүү багшаас заавар зөвлөгөө авч сурагчидаа оношлов.

Анхан шатны зургийн хичээл \хэлбэр дүрс өнгөний уусгалт хэмжээ өнгө ялгаж будах, 1 болон 8 цифр ашиглан амьтан зурах\ зөгий, шоргоолж, хун, эрвээхэй\ гэх мэт өнгийг ялгаж таньдаг болсон. Хэлбэр дүрсээс эхлэн бага багаар хүндрүүлсэн зураг зурахад багшийн тусламжтайгаар үйл ажиллагаа явагдсан. Зургийг цэвэр нямбай зурж чадахгүй байсан ч ерөнхий дүрслэлийг гаргаж зурсан бол зөв гэж үнэлсэн.

Үйл ажиллагаа-III түвшин

Сурагчид зургийн дугуйланд хамрагдаж эхэллээ. Хялбар аргаас хүндрүүлсэн түвшний зургийг зурж байна. Урланд 7 хоногт 2 цагийн сургалтад хамруулж байна. цэцгийн дэлбээ, цоморлиг, шилбэ, навчны хэлбэр дүрсийг илүү нарийвчлалтайгаар зурж дүрсэлж сурах. Өнгөний уусгалт, орон зайн баримжаа, хэмжээ хэлбэр дүрсийг ялгах.

Сурагчид зургийн дугуйланд хамрагдсанаар зураг зурах арга барилд суралцаж, өнгө дүрс таних чадвар эзэмшсэн.

1.Нийгэмшихүйн чадамжийг үнэлсэн нь

- Зурсан, наасан, баримлаар хийсэн зохион бүтээсэн зүйлдээ баярладаг болсон.
- Дуурайх дохио зангаа ашиглан харилцах, дүрэм журмыг дагадаг болсон.
- Зураг зурахдаа өөрөө ямар будаг харандаагаар дүрслэхээ мэддэг болсон.
- Зурагны том жижиг хэмжээ, орон зайн баримжаатай болсон.
- Бусдыг мэдэрч, зохицон харилцдаг болсон. \Жишээ нь: Найздаа

- харандаа будаг аа өгч, түүнд туслах гэх мэт \
- Бусдын хичээлийн хэрэглэгдэхүүн, эд зүйлсийг хэрэглэхдээ зөвшөөрөл авдаг болсон.
 - Баримлын шавраар хийж чадах зүйлээ бие даан гүйцэтгэдэг болсон.
2. Дүрслэх урлагийн чадамжийг үнэлсэн нь
- Цифрээр төрөл бүрийн аргаар амьтан зурдаг болсон. /Жишээ нь: хун, зөгий, эрвээхий г.м /
 - Дүрс, зургийг төрөл бүрийн будгаар хүрээнээс илүү гаргалгүй буддаг болсон. /Жишээ нь: тосон, өнгийн харандаа, усан будаг/
 - Баримлын шавраар хэлбэр дүрс, амьтан, тоо илэрхийлж сурсан.
3. Хэл ярианы чадамжийг үнэлсэн нь
- Зурган карт ашиглан хэлж ярьж чаддаг болсон.
 - Үгийн утга санаа ойлгодог болсон.
 - Бусдын асуултыг анхааралтай сонсож, тохирох хариулт өгдөг болсон. \ Жишээ нь: Энэ ямар өнгөтэй дүрс вэ? \ Уншлагын зурган карт дээр ажилдаг болсон.
4. Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамжийг судалсан нь
- Хүүхэд үйл явдал, учир шалтгааны талаар лавлаж асуудаг болсон. \ Жишээ нь: Навч яагаад ногоон өнгөтэй байдаг вэ? гэх.м/
 - Хүүхэд зураг зурсныхаа дараа дэвтэр балаа буцаагаад цүнхэндээ хийдэг, цэвэрч нямбай гамтай хэрэглэдэг, хаяж гээгдүүлэхгүйг хичээдэг болсон.

Дүгнэлт

Багшийн арга зүйд шинэлэг өөрчлөлт гарч, багш хүүхдийн зурах сэтгэхүйд тохирсон уран зургийн бэлдэц, гуаш, харандаа, бийр өнгийн төрөл бүрийн будаг, ватум цаасыг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна. Хүүхэд зураг зурснаар хүүхэд олон дахин давтаж, чадвараа сайжруулж, тэвчээртэй, хатуужилтай, эхэлснээ дуусгадаг болж, хүүхдийн анхаарал, орон зайн баримжаалал хөгжиж, хүүхэд хөдөлгөөн, нийгэмшихүй, хэл яриа, орчин, математик, хөгжим, дүрслэн урлах зэрэг бүх талын хөгжлийг нэгэн зэрэг олж авах боломжтой юм байна гэж дүгнэн, хүүхдүүд анги нийтээрээ хамтын ажиллагаа, харилцаанд ач холбогдол өгдөг болж, хүүхэд аав, ээж, ах эгч, дүү болон бусадтай зурсан зургаа танилцуулж, тэдэнд зааж байхдаа өөртөө итгэлтэй байх, эцэг эх хүүхдийн бүтээлч үйлийг дэмждэг, хичээлийн хэрэгсэл авч өгч, туслахдаа дуртай болж, хүүхдээ сонсдог, ярилцдаг болох юм.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, мэргэжил, нийгэмшихүй, зураг дүрслэл*

Ашигласан материал:

1. Жайка төсөл, Туршилтийн сургуулийн жишээний эмхтгэл МУБИС, Боловсрол судлалын сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхмийн эрхлэгч дэд. проф. доктор Г. Батцэнгэл УБ хот. 2019 он
2. Тэгш хамруулан сургах боловсрол \ видео хичээл \ УБ хот. 2019 он
3. Дүрслэх урлаг, технологи I УБ хот 2018 он.
4. БСШУЯ. Хүүхэд нэг бүрийн хөгжлийн төлөө. УБ хот. 2013 он
5. АМЧБО- ДЖ. Холландын судалгааны сорил

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ МЭРГЭШСЭН БАГШ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХ, ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Д.Алтансүх¹

¹ Нийслэлийн ерөнхий боловсролын 29 сургууль
Sukhee_mgl89@yahoo.com

Үндэслэл

Тусгай хэрэгцээт боловсролын багш нь ТХБ шаардлагатай хүүхэдтэй ажиллах сургалтын арга зүй, ур чадвар, хандлага, боловсрол судлал, сэтгэл судлалын онолын мэдлэг ур чадварыг эзэмшсэн байдаг. Тусгай хэрэгцээт боловсролын салбар нь үүсэж хөгжөөд 60-аад жилийн түүхийг үдэж байгаа харьцангуй шинэ салбарын нэг юм. Одоогоор манай орны хувьд мэргэжлийн боловсон хүчин буюу согог зүйч багшийн дутагдалтай байна. Улсын хөгжил иргэний боловсролоос, иргэний боловсрол багшийн хөгжлөөс гэдэг тиймээс багшаа хөгжүүлж, чадавхжуулж, мэдлэгтэй, чадвартай, сэтгэлтэй боловсон хүчнийг бий болгож чадваас энэ салбарын хөгжил төдий чинээ өндөр байх юм.

Зорилго

Тэгш хамруулах сургалт эрчимтэй яригдаж, хэрэгжиж байгаа энэ цаг үед багш нараа чадавхжуулах боломж нөхцөлийг судлах, өнөөгийн тусгай сургуулиудын мэргэжлийн согог зүйч багш нар, тусгай сурганы багш боловсон хүчний хүрэлцээ, хангамж болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч, боловсрох, төлөвших нөхцөлийг бүрдүүлэхэд нарийн мэргэшсэн багшийг бэлтгэх, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Материал ба арга зүй

ТХБ шаардлагатай хүүхдийн сурч боловсрох эрхийг нь хангахад тусгай сурганы багшийн хүрэлцээ хангамж, багшийг бэлтгэх хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодруулах сэдвийн хүрээнд багшийн хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулах, боловсруулах, судалгааны асуулга боловсруулан нэгтгэн дүгнэв.

Үр дүн

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБ-ийн тусгай 6 сургуульд 2021- 2022 оны хичээлийн жилд мэргэжлийн согог зүйч багш 10 ажиллаж байгаагаас тэтгэвэрт гарсан ажиллаж байгаа 3 багш байна, МУБИС –ийн 1 жилийн хөрвөх сургалт болон бусад сургалтад сурч мэргэжил дээшлүүлсэн багш нар цөөнгүй ажиллаж байна. Тусгай хэрэгцээт боловсролыг эзэмшүүлдэг сургуулийн багш нарын хувьд тогтмол ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлсээр байдаг. Ахмад багш нар болон согог зүйч багш нараас зөвлөгөө тусламж авах, хувиараа цахим сүлжээ, ном товхимол уншиж судлах зэргээр мэдлэг, мэдээлэл авч өөрийгөө

хөгжүүлдэг. Сургууль болон бусад байгууллагаас сургалт семинар цөөн явагддаг ч үр дүн, чанар сул байдаг гэсэн хариулт өгч байгаа юм. Иймээс хойшид багш нараа хөгжүүлэх сургалт, семинар, ажлуудыг тогтмол, шат дараатай зохион байгуулж хэвших нь нэн чухал байна.

Дүгнэлт

Тусгай хэрэгцээт боловсролын багш нар болон боловсролд тэгш хамруулах үйлчилгээ үзүүлж байгаа нийт багш нарын хувьд хүүхэд бүрийн хөгжлийн бэрхшээлийн төвшинг тодорхойлж, оношилж, тэдний хэрэгцээнд тохирох дэмжлэг, арга барил, арга зүйгээр боловсрол эзэмшүүлэх, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх нь чухал юм. Иймээс багш нараа сургах, хөгжүүлэх асуудал нэн тэргүүнд тавигдах учиртай.

Дүгнэлт 1. Согог зүйч багш нь тусгай хэрэгцээт боловсролын тулгуур суурь, ТХБ шаардлагатай хүүхдийг чиглүүлэгч, ирээдүйд хөтлөгч хүмүүс юм. Сүүлийн жилүүдэд мэргэжлийн согог зүйч багшийн нөөц хомсдолд орсон учир дэлхийн тусгай хэрэгцээт боловсрол өндөр хөгжсөн улс орнуудад согог зүйч багш нарыг бэлтгэх, хөгжүүлэх шаардлага бий болж байна. Эдгээр багш нарын сурсан мэдлэг, чадварыг ашиглан тусгай сургуулийн багш нарт тогтмол, системтэй сургалтууд зохион байгуулж багш нарыг хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтууд зохион явуулж, тусгай сургуулийн багш нарынхаа мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, чадваржуулах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Дүгнэлт 2. Тусгай 6-н сургуулийн багш нарын хувьд богино хугацааны модуль сургалтууд болон МУБИС-ийн 1 жилийн хөрвөх сургалтаар тусгай сурганы болон тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүй, ур чадварыг эзэмшсэн байдаг. Иймээс тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлж байгаа сургуулийн багш нарыг мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэх, хөгжүүлэх нь маш чухал асуудлын нэг болоод байна.

Дүгнэлт 3. Улсын хэмжээнд тусгай хэрэгцээт хүүхдүүдийн ихэнх нь хөдөө орон нутагт алслагдмал оршин сууж байгаа бөгөөд хот суурин газрынхаа ерөнхий боловсролын сургуульд суралцдаг. ТХБ шаардлагатай хүүхдүүд нь хөгжлийн ялгаатай байдал, багш боловсон хүчний асуудал, сургалтын орчин нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс үүдэн хичээлээс завсардах асуудал үүсдэг. Тэгш хамруулах боловсрол эрчимтэй яригдаж, хэрэгжиж байгаа энэ цаг үед нийслэлийн болоод орон нутгийн багш нарыг хөгжүүлэх, мэргэшүүлэх ажлыг тусгай сургуулийн мэргэжлийн багш нарыг түшиглэн системтэй сургалтуудыг шат дараалан зохион байгуулж нийслэлийн болоод орон нутгийн багш нарт ТХБ, тэр дундаа ТХБ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар илүү өргөн мэдлэгийг олгох боломжтой болно. Ингэснээр багш нар ТХБ шаардлагатай хүүхдийг оношлох, хөгжлийн төвшинг тодорхойлох, тухайн төвшинд тохируулан хүүхэдтэй ажиллах арга барил, арга зүйг тодорхойлох цаашлаад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан сургалтын үйл ажиллагаандаа ашиглах боломж бүрдэх юм.

Түлхүүр үг: *Багш, Багшийн хөгжил, ТХБ*

Ашигласан материал:

1. Пүрэвдорж.ч, Багшлахуйн менежмент, УБ.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх нь, эмхтгэл, УБ. 2013
3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт, шинжилгээ, УБ. 2007
4. [www. Legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
5. www.cnki.net

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Г.Алтанцэцэг¹

¹НХЖХОНАБХА-ны Захиргааны удирдлагын газрын бичээч, цагдаагийн дэд ахлагч

Үндэслэл

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод 2009 оны 5 сарын 13-ны өдөр нэгдэн орсон. НҮБ-ын гишүүн орны хувьд тус конвенцын үзэл баримтлалд тулгуурлан үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм зэргийг хүндэтгэсэн, эрхийг дээдэлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд Улсын Их Хурлаас батлан гаргасан. Монгол Улсад Үндэсний статистикийн хорооны 2019 оны байдлаар нийт хүн амын 3,3 хувийг ХБИ-д эзэлж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “сурч, боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” гэж хуульчилсан. Энэхүү эрхийг хүн бүр тэгш хүртээмжтэй эдлэх эрхтэй боловч хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд сурч, боловсрох эрх зөрчигдсөөр байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 5.1.3 дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний “сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх” зарчмыг баримтална хэмээн хуульчилжээ.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй зарим асуудлыг зохицуулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Материал ба арга зүй

Баримт бичгийн шинжилгээ хийх

Үр дүн

Сурч боловсрох эрх ба хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй зарим асуудал: Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой хүн бүр хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой ба энэхүү эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ч нэгэн адил байна. **“Хөгжлийн бэрхшээлтэй хүн”** гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй

оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ хэмээн хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” гэж хуульчилжээ. Монгол Улсын иргэн та сурч боловсрох эрхтэй ба энэхүү эрх, эрх чөлөөг эдлэх бүрэн эрхтэй юм. Үндэсний статистикийн хорооноос гаргасан тайлангаар 2016 оны Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 100,993 хүн байна. Тэдний 40.8 хувь нь төрөлхийн, 59.1 хувь нь ахуйн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 10,407 хүүхэд байгаагаас 12.1 хувь нь харааны, 8.3 хувь нь хэл ярианы, 7.6 хувь нь сонсголын, 17,6 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 21.2 хувь нь хөдөлгөөний, 9.8 хувь нь хавсарсан бэрхшээлтэй байна. 2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 26 насан туршийн боловсролын төв, 326 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 9291 хүүхэд суралцаж байгаагийн 18,5 хувь буюу 1716 нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Тэдний 30,9 хувь нь оюун ухааны бэрхшээлтэй, 4,5 хувь нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй суралцагчид байна. Тэдний 39,8 хувь буюу 683 нь бага боловсрол, 41,6 хувь буюу 714 суурь боловсрол, 18,6 хувь буюу 319 нь бүрэн дунд боловсрол эзэмших төвшний ангид суралцаж байна. Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1.076 хүүхэд цэцэрлэгт, 6.301 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна. Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.0 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 69.3 мянга буюу 66.9 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна. Дэлхийн ихэнх улс орнууд хөгжлийн бэрхшээлийн статистик, уламжлалт чиг хандлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол өнөө үед бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, сайн сайхан амьдрах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулсаар байна.

Дүгнэлт

Монгол улсын иргэн бүр сурч, боловсрох эрх Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон ба энэхүү эрхийг хэрэгжүүлэх субъект нь төр юм. Төрөөс ХБИ-ийг нийгмийн харилцаанд тэгш оролцоотой оролцуулах, эрх, эрх чөлөөг нь хангах олон хууль тогтоомж, эрх зүйн акт, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллан, үр дүнг тооцоор байна. Сурч, боловсрох эрхийн хэрэгжилт нь орон нутаг, нийслэлийн хэмжээнд харилцан адилгүй ба хүртээмжийн хувьд ялгамжид байдал үүсч байгаа тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялгамжид байдлыг багасгах арилгах зорилгоор дараах саналыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.4-т хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах гэсэн заалтад нэмэлт,

өөрчлөлт оруулах. “...сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах, тэгш хүртээмжтэй хамруулах, хэрэгжилтийг хангах” гэж өөрчлөх. Нэмэлт, өөрчлөлт оруулснаар ХБИ-ийн сурч, боловсрох эрхийг хэрэгжилтийг хангах үүргийг төр бүрэн хариуцаж, үйл ажиллагаа нь эрчимжих боломж бүрдэнэ.

2. ХБИ-ийн хөгжих, сурах онцлог, хэрэгцээнд нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад бүрдүүлэх, шинээр байгуулах.

3. Нийгмийн харах өнцгийг өөрчлөх, ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх насны хүмүүст зориулсан ХБИ-ийн тухай контентыг нэмэгдүүлж, нөлөөллийн аргыг эрчимжүүлэх.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сурч боловсрох эрх*

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он
3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенц” 2009 он.
4. Бага, дунд боловсролын тухай хууль. 2002 он. ТМ №19.
5. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” 2016 он. ТМ №9

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ, ХӨГЖИХ ТЭГШ БОЛОМЖ

Ч.Одонтуяа¹

¹Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг

Odontuyachinzorig@gmail.com

Үндэслэл

Монгол Улсын хувьд сургуулийн өмнөх, бага, дунд болон дээд боловсролын хүртээмж сайжирч байгаа боловч тэгш байдал, чанарын асуудал чухал хэвээр байна. Ердийн цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо цөөнгүй байдаг. Цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгамдаж буй асуудал их, хөгжих боломж хомс байгаагаас хүүхэд бүр хөгжих, сурч боловсрох эрхээ эдэлж чаддаггүй. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн адил боловсрол эзэмших үйл явцад тулгардаг асуудлыг тодорхойлж, цаашид санал зөвлөмж гаргах үүднээс энэхүү сэдвийг сонгон авсан.

Зорилго

Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн анги бүлэгт адил тэгш сурах, нийгэмших, тэдний хөгжих боломжийг нэмэгдүүлэх

Материал ба арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай онолын ерөнхий ойлголт, цэцэрлэгт хамрагдаж буй байдлыг судлах, олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрхэн тэгш хамран сургадаг талаар судлах.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээл нь эмзэг хүн амыг пропорциональ бусаар үүсгэдэг. Дэлхийн эрүүл мэндийн судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тархалт нь өндөр орлоготой орноос доогуур орлоготой оронд илүү их байдаг. Нэн ядуу хүмүүсийн тавны нэг, эмэгтэйчүүд, өндөр настнуудад хөгжлийн бэрхшээлийн тархалт бас илүү байдаг (4). Доогуур орлоготой, ажилгүй, боловсрол доогуур хүмүүс мөн хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байдаг. Сонгогдсон орнуудад хийгдсэн олон үзүүлэлттэй багц судалгаагаар ядуу айлын, угсаатны цөөнхийн хүүхдүүд бусад хүүхдүүдээс илүү хөгжлийн бэрхшээлд өртөх илүү эрсдэлтэй байдаг (5).

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн тухай конвенц болон Үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хязгаарлаж байгаа орчны үүргийг онцолсон байдаг. Тайланд дараах саад бэрхшээлүүдийг дурдаж байна. Үүнд:

Бодлогыг төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг анхаардаггүй эсвэл байгаа бодлого стандарт нь мөрдөгддөггүй. Тухайлбал: хамран сургалтын бодлогын хувьд Бүх нийтээрээ боловсрол олох тунхаглалын хэрэгжилтийг хянах түншлэлд оролцсон нийт 28 орноос 18

нь л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулсан, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургуульд зуучилдаггүй, эсвэл ерөөсөө хамран сургалт явагдаггүй гэдэг талаараа маш бага тайлбар өгсөн байдаг (6). Боловсролын бодлогод гарч байгаа нийтлэг дутмаг зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хамруулахад зориулсан ямар нэгэн санхүүгийн болон бусад урамшуулал дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлд зориулсан нийгмийн хамгаалал, дэмжлэг үйлчилгээ дутмаг байдаг.

Итгэл үнэмшил, мухар сүжиг, таамаглал боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж болон нийгмийн оролцоонд саад бэрхшээлийг бий болгож байдаг. Тухайлбал: багш, сургуулийн захиргаа, бусад хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдийн хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг энгийн сургуульд хамруулахад нөлөө үзүүлдэг.

График 1.



Дүгнэлт

Монгол улсад нийт 786 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдгаас тэдгээрийн 576 нь СӨБ-д хамрагдан суралцдаг буюу 73 орчим хувь нь цэцэрлэгт явдаг. Харин цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 90-100 хүртэлх хувиар цэцэрлэгт хамруулах шаардлагатай байна. Мөн тоонд анхаараад зогсохгүй чанар буюу цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжүүлэх тал дээр эрх зүйн зохицуулалт, санхүүжилт шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг олон улсад хөгжүүлж сургаж буй аргуудаас харахад тусгаарлаж биш энгийн хүүхдүүдтэй хамт сургах нь нийгэмшихэд илүү ач холбогдолтой байдаг нь харагдаж байна.

Ирээдүйд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд эзлэх байр суурьтай, нийгэмшсэн хүн болж төлөвшихөд багш бидний оролцоо хамгийн чухал бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай ангид явуулахаас илүү энгийн хүүхдүүд дунд хүмүүжүүлж, хөгжүүлэх нь сургалтын үйл ажиллагаа үр дүнд ач холбогдолтой. Сургуулийн өмнөх боловсролын багш нарын дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхолгүй байдаг бөгөөд багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах шаардлагатай.

Бага насны хүүхдийг эерэг зөв хандлагаар хөгжүүлэн төлөвшүүлж тэдэнд ирээдүйдээ итгэлтэй зөв хандлага, төлөвшилтэй иргэн болоход багш нарын оролцоо чухал юм.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эрсдэл, бодлого*

Ашигласан материал:

1. НҮБ, ХБХ-ий эрхийн тухай конвенци, 2006 он.
2. Сингх Силва Паркер, эрх зүйч
3. Монгол Улсын Үндсэн Хууль 14 дүгээр бүлгийн 2 дахь хэсэг
4. Женев, Олон Улсын Боловсролын бага хурал, 2008 он
5. Үндэсний статистикийн хороо, 2020 он

ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН БИЕЙН БҮРДЛИЙН СУДАЛГАА (ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Ш.Энхбүрэн¹, Ц.Ариунбаяр, Х.Дүүрэнжаргал²

¹ МУБИС-Биеийн тамирын сургууль

²ХУД 63-р тусгай сургууль

enkhburen@msue.edu.mn

Үндэслэл

Хүүхдэд хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг хийх, тэдэнд үүсэж буй ямар нэгэн өөрчлөлт, гэмтэл, согогийг засах зэрэг асуудал нь нийгмийн салбарын нэлээд хязгаарлагдмал хүрээнд яригддаг байсан үе хэдийнээ өнгөрч нийт ард иргэд, үндэстний хэмжээнд авч үзэх болжээ. ЕБС-ийн бага ангийн хөгжлийн бэрхшээлгүй сурагчдын хөгжлийн талаарх судалгаа цөөнгүй байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй тэр тусмаа оюун ухааны бэрхшээлтэй (ОУБ)-тэй сурагчдын биеийн эрүүл мэнд болон хөдөлгөөний чадварт нөлөөлөх үндсэн үзүүлэлт болох биеийн бүрдлийн зохистой харьцаа, түүнд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн хоорондын холбоо хамаарлын судалгаа хомс байна.

Зорилго

Биеийн бүрдлийг судалснаар сурагчдын биеийн тэгш харьцаа, эрүүл мэнд, биеийн өсөлт, хөгжилтийн онцлог ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж биеийн тамирын сургалтын арга зүйг оновчтой сонгох, сургалтандаа хэрэглэх, ялгаатай байдлын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, орчин нөхцөл, хөдөлгөөн, хооллолттой нь уялдуулан төлөвлөх боломжтой.

Материал ба арга зүй

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хүрээнд нөхцөл байдлын судалгаануудын тайлан, сайтууд ("InBody-720 Biospace" (DSM-BIA), IBM SPSS statistic 20), илтгэлүүд, нийгмийн социал медиа орчны мэдээллүүдэд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.


Үр дүн

Судалгаанд хамрагдсан сурагчдын булчингийн өөхний хэмжээ, биеийн жин, араг яс булчингийн масс, биеийн өөхний хэмжээ, биеийн жингийн харьцаа, өөхний эзлэх хувь, дээд, доод мөчийн харьцаа нормоос бага зэрэг ихэссэн, өөрчлөлт орж байгаа нь ажиглагдаж байна. Мөн эцсийн фитнес онооны нийлбэрээр 80 оноотой 3 сурагч, дийлэнх нь "С" -ээс доош үнэлгээтэй байгаа анхаарал татаж байна.

Хүснэгт 1. Биеийн бүрдлийн шинжилгээний дундаж үзүүлэлт

		25	55	63	70	Тусгай сургууль дундаж
Биеийн бүрдлийн шинжилгээ	Дотор ус /ICW/	9,7 %	11,1 %	13.2 %	13.9 %	11.9 %
	Гадар ус /ECW/	6,3 %	6,94 %	8.1 %	7.9 %	7,31 %
	Уураг	4,2 %	4,8 %	5.7 %	5.4 %	5,02 %
	Эрдэс бодис	1,4 %	1,7 %	1.9 %	1.7 %	1,6 %
	Биеийн өөхний масс /BFM/	79,7 %	82,8 %	82.7 %	82 %	81,8%
Булчин өөхний харьцаа	Жин	29,8	33,1	35.8	38.3	34,2%
	Араг яс, булчингийн масс /SMM/	10,6	12,5	15.3	14.2	13,1 %
	Биеийн өөхний масс /BFM/	8,1	8,5	11.7	10.8	10 %
Таргалалтын оношилгоо	Биеийн жингийн индекс /BMI/	16,4	17.9	20	19.6	18,4 %
	Өөхний эзлэх хувь /PBF/	25,5	24.4	24	25	24,7 %
	Бэлхүүс, таазны харьцаа /WHR/	0,75	0,78	0.81	0.80	0,78 %
Дээд, доод мөчдийн харьцаа	Баруун гар	0,39	0,38	0.37	0.36	0,37 %
	Зүүн гар	0,36	0,36	0.38	0.38	0,37 %
	Нуруу	0,38	0,36	0.38	0.38	0,37 %
	Баруун хөл	0,38	0,36	0.36	0.36	0,36 %
	Зүүн хөл	0,38	0,36	0.38	0.38	0,38 %
Нийт фитнес оноо	A	-	-	-	-	-
	B		81 оноо 1 сурагч	80 оноо 1 сурагч	80 оноо 1 сурагч	80 оноо 3 сурагч
	C	70-78 3 сурагч	72-78 4 сурагч	73-79 6 сурагч	75-79 7 сурагч	72-79 21 сурагч
	D	-	68 оноо 1 сурагч	61-63 2 сурагч	63-68 2 сурагч	61-68 5 сурагч
	F	Edema 1 сурагч	-	50 оноо 1 сурагч	57-58 2 сурагч	50-58 3 сур Хаван 1сур

График 1. Биеийн бүрдлийн шинжилгээ



Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан Тусгай (25, 55, 63, 70-р) сургуулийн оюун ухааны бэрхшээлтэй хөнгөн хэлбэрийн сурагчдын биеийн бүрдлийн шинжилгээг дүгнэж үзвэл усны зөв хэрэглээг хэвшүүлэх, дийлэнх сурагчдын булчингийн масс сул, биеийн жин болон өөхний хэмжээ нэмэгдэж, биеийн тэгш харьцаа алдагдаж улмаар хөдөлгөөний хомсдолд орох, уян хатан чадавх, биеийн тэнцвэр хөдөлгөөний эвсэл муудах, биед зайлшгүй хэрэгцээтэй ус уураг, эрдэс бодисын хэмжээ багассанаар хэт их ачаалал өгөхөд бэртэж гэмтэх, биеийн бусад үзүүлэлтүүд дагаж өөрчлөгдөх магадлал өндөр байгаа нь анзаарагдаж байгаа тул сурагч, эцэг, эх, багш нарын гурван талт харилцааг сайжруулах тэдэнд тохирсон өдрийн дэглэм зохиох, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх, амарч зугаалах, тохирсон биеийн хүчний ажил хийлгэх шаардлагатай байна. Мөн тэдний онцлог, ялгаатай байдалд тохирсон хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн агуулга тодорхойлох, тоон баримт мэдээг ашиглан бэлтгэл, сургуулилтаа төлөвлөх, биеийн тамирын хичээлийн үр дүнг нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм гэж үзэж байна.

Түлхүүр үг: Оюун ухааны бэрхшээл, биеийн бүрдэл, биеийн тэгш харьцаа

Ашигласан материал:

1. Батцэнгэл, Г. (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс* Улаанбаатар хот. Соёмбо Принтинг ХХК.
2. Одгэрэл, Д., Намираа, Б., Шинкава, М., Ариунтунгалаг, М. (2016). *Тэгш хамруулах боловсрол* Улаанбаатар хот. Мөнхийн Үсэг ХХК.
3. Хаяаши, Кензо., Торигое, Такаши., Исава, Шинзо., Ишикура, Кенжи., Такано, Миюки. (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол*. Улаанбаатар хот.
4. Одгэрэл, Д., Намираа, Б. (2018). *Тусгай боловсрол*. Улаанбаатар. Сод пресс ХХК.
5. JICA. Цүчимото Такаюки. (2008). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг удирдан чиглүүлэх гарын авлага*. I, II. Улаанбаатар хот.
6. БСШУСЯ. (2018). *Суралцагчдын 2017-2018 оны хичээлийн жилийн тайлан*. УБ хот.
7. Батдэлгэр, Ж., Баяржаргал, Б., Батжаргал, Г., Мандах, Д. (2020) "Бага насны хүүхдийн сэтгэл судлал" 3 дахь хэвлэл . УБ. Би Си Ай ХХК.
8. Оюунбилэг, А. (2020). *Бага насны хүүхдийн анатоми, физиологи эрүүд мэндийн үндэс* УБ. Эм Жи Эл ХХК.
9. Жу юун мён., Ким ёо вон., & KOICA (2018). *Биеийн тамирын тусгай боловсролын онол практик* И бурам.

СЗСҮТ-ИЙН МБУЧОС-ИЙН ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН АСУУДАЛ БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ХАНДЛАГЫГ СУДАЛСАН НЬ

Н.Уянга¹, Л.Ариунаа²

¹СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн багш

²МУБИС-ийн ТХБТ-ийн 4 дүгээр курсийн оюутан

Үндэслэл

Монгол улсын хувьд ХНХЯ-наас Монгол Улсын Их хуралд өргөн барьсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд зааснаар 15- 34 насныхныг залуучууд хэмээн тодорхойлсон байдаг. Залуучуудын насны ангилал нь тухайн улс орны нийгэм эдийн засгийн, улс төрийн болон бүтцийн асуудлаас болж ялгаатай байна. Улс орны нийгэм эдийн засаг хөгжил буурай, залуучуудаа сайн хөгжүүлж, боловсруулж чадахгүй бол төрөөс дэмжлэг туслалцаа үзүүлэх хугацаа урт байх магадлалтай. Залуу нас хүний амьдралын хамгийн эрч хүч, бүтээмжтэй үеэс гадна олон сорил, бэрхшээлийг даван туулах нас юм. Мөн тэдэнд маш олон төрлийн асуудал бэрхшээлүүд тулгарч байдаг байна. Тиймээс СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн оюутан, залуучуудын бэрхшээлийг даван туулах хандлагын төвшин болон ямар аргаар өөрт тулгамдаж буй асуудал бэрхшээлээ даван туулах талаарх судалгааг хийх хэрэгцээтэй байна.

Зорилго

СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн оюутнуудын асуудал бэрхшээлийн даван туулах хандлагыг судлаж дүгнэлт гаргахад оршино.

Материал ба арга зүй

Судалгааны мэдээлэл цуглуулахад дараах арга зүйг ашигласан болно. Үүнд: “Бэрхшээлийг даван туулах хандлагыг үнэлэх” стандарт сорил (A-COPE) болон баримт бичиг судлах арга

Үр дүн

График 1. Оюутны хүйсийн байдал






График 2. Оюутны насны харьцаа



Тус судалгаанд СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн 65 оюутан, залуучууд хамрагдсан болно. Энэхүү судалгаанд нийт 14- 41 насны оюутнууд


хамрагдсан бөгөөд тэдгээрийн 69.4 хувь нь 20-40 насны оюутнууд байгаа бол хамгийн бага хувийг 41 болон түүнээс дээш насныхан эзэлж байна. Мөн судлуулагчдын 53.2 хувь нь эрэгтэй харин 46.8 хувь нь эмэгтэй оюутнууд хамрагдлаа.

График 3. Бэрхшээлийн даван туулах хандлага



даван туулах хандлага нь өөр хоорондоо харилцан адилгүй байгааг харж болох юм.

График 4. Оюутан залуучуудын асуудал бэрхшээлийг даван туулах хандлагын төвшинг суралцаж буй ангиар харьцуулсан нь



Тус судалгаанд хамрагдсан оюутан залуучуудын асуудал бэрхшээлийг даван туулах хандлагын төвшинг тухайн оюутнуудын суралцаж буй ангиар харьцуулж харвал гар утас, телефон аппаратын засварчны ангийн оюутнуудын 33.3 хувь нь маш сайн хөгжилтэй байгаа бол нарийн бичгийн дарга, бичиг хэргийн ажилтны ангийн оюутнуудын бэрхшээлийг даван туулах чадвар нь бүгд сайн хөгжилтэй байгаа нь дээрх графикаас харагдаж байна. Харин бусад мэргэжлийн ангийнхныг харвал бэрхшээлийг даван туулах чадвар дундаж болон сайн хөгжилтэй хүүхдүүд ойролцоо үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

Тус судалгаанд хамрагдсан оюутнуудын бэрхшээлийг даван туулах хандлага нь маш өндөр төвшинд хөгжсөн оюутнуудын үзүүлэлт 1.7 хувьтай байгаа бол нийт судлуулагчдын дийлэнх хувь болох 54.2 хувь нь аливаа асуудал бэрхшээлийг даван туулах хандлага нь сайн хөгжилтэй байна. Харин оюутнуудын асуудал бэрхшээлийг даван туулах хандлага нь сул болон маш сул хөгжилтэй оюутнууд байхгүй байгаа бол дундаж төвшний хөгжилтэй оюутнууд нь 44.1 хувийг эзэлж байна. Дээрх графикаас хархад тус сургуульд суралцаж буй оюутан залуусын асуудал бэрхшээлийг даван туулах хандлага нь өөр хоорондоо харилцан адилгүй байгааг харж болох юм. Нийт судлуулагчдын 42 хувь нь өөрийгөө хөгжүүлэх замаар ямар нэгэн сургалт семинарт хамрагдаж спортоор ихэнхдээ болон олонтаа хичээллэдэг мөн тэдний 48.4 хувь нь найз нөхөдтэйгөө спорт тоглоом болон бильярд, теннис зэргийг тоглож цагийг зөв боловсон өнгөрүүлэхээс гална өөрт тулгамдаж буй асуудал бэрхшээлийг эерэг аргаар шийдвэрлэж чаддаг байна. Харин 11.3 хувь нь өөрийгөө хөгжүүлэх ямар нэгэн оролдлого огт хийдэггүйгээс гадна 11.5 хувь нь эргэн тойрныхоо бусад хүмүүсийг буруутгадаг бол 3.2 хувь нь ихэнхдээ зүй бус үг хэллэг болох хараалын үг хэлдэг байна. Мөн 44.3 хувь нь хааяа даа болон зарим тохиолдолд бусдыг буруутгадаг бөгөөд 17.7 хувь нь бүдүүлэг зохисгүй үг хэллэгийг зарим тохиолдолд хэрэглэдэг болохыг харж болох юм. Тиймээс оюутан залуучуудын аливаа бэрхшээлд хандах хандлагыг эерэгээр төлөвшүүлэх түүнийг даван туулахдаа зөв зохистой арга техник хэрэглэх ашиглах зөвлөмж мэдээллийг амьдрах ухааны чадвар хичээлээр тогтмол хүргэх энэ төрлийн чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй гэж дүгнэж байна.

Түлхүүр үг: Асуудал бэрхшээл, бэрхшээлийн даван туулах чадвар, хөгжлийн бэрхшээлтэй оюутан залуучууд, мэргэжлийн боловсрол

Ашигласан материал:

1. Мягмар О. (2016) Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд /Дөрөв дэх удаагийн хэвлэл/ Улаанбаатар
2. Туяа.Б. (2017) “Клиник практикт хэрэглэх аргачлалууд” УБ.
3. Батсайхан Б. Дэлгэржав М. (2013) Ерөнхий сэтгэл судлал, Улаанбаатар
4. Мягмар О. (2010) Сэтгэл судлал II дэвтэр, Улаанбаатар
5. Санжжав Д. Жамц Д. (2007) Ерөнхий сэтгэл судлал. Улаанбаатар

ХӨДӨЛМӨРИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ

Э.Нандин-Эрдэнэ¹

¹ Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургууль
Nandianan0113@gmail.com

Үндэслэл

Хүүхэд бүр 16 нас хүртлээ заавал суралцах ёстой бөгөөд төрийн өмчийн сургууль ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгодог. Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомж нь нэлээн олон хуулийг хамран зохицуулагддаг. Гэвч эрх зүйн баримт бичгүүдэд заагдсан олон эрх амьдрал дээр хэрэгжихгүй зөрчигдөж байна. ХБ хүүхдүүдийн сурах эрх зөрчигдөж буй үндсэн шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчинг бүрдүүлж өгөөгүй тэдэнтэй ажиллах багш нарыг бэлтгээгүй, асаргаа сувилгааны асуудлыг шийдээгүй, ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дутуу чадвартай, тусгай хэрэгцээ шаардлагатай хүмүүс гэсэн буруу ойлголт хандлагаас үүдэлтэй юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх, боловсрол эзэмшихэд учирч байгаа саадыг арилгах, асуудал дэвшүүлэн гаргалгаа олох болон боловсролыг тэгш хүртээхэд зорилго нь оршино.

Материал ба арга зүй

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүрээнд судлаачын үүднээс ажиглах замаар (Японы БСШУЯ Тусгай хэрэгцээт боловсролын талаарх албан ёсны сайт, <https://www.dinf.ne.jp/doc/english/asia/resource/z00ap/003/z00ap00309.html>, <https://www.nda.ie/> "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал" Ц.Цэвэлмаа 2017., УБ материалуудыг ашиглан судалгааны ажлаа явуулсан.

Үр дүн

Боловсролын асуудал нь хүний ирээдүйн насан туршийн амьдралын баталгаа болохынхоо хувьд ямар ч нөхцөлд хүний ажил олох боломжыг нэмэгдүүлдэг. 21-р зуун нь биеийн хүч хөдөлмөр гэхээсээ илүү оюун ухаанд суурилан ажилладаг болсон нь ажил олгогчид ажилтныг ХБИ эсвэл зүгээр эсэхэд анхаарахгүй ижил байдлыг хүсэхэд хүргэсэн юм. Тиймээс ч энэ нь ХБИ нь ч гэсэн ижил төвшний мэдлэг боловсрол эзэмших шаардлагатай гэдгийг энэхүү илтгэлийн хүрээнд агуулсан юм.

Хүснэгт 1. Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын байгууллагын судалгаа

Сургуулийн төрөл	Сургуулийн тоо	Жагсаалт					Багш тоо	Ажилчид тоо
		цэцэрлэг	Заавал эзэмших		Бүрэн дунд	Нийт		
			Бага	дунд				
Хараагүй хүүхдүүдийн сургууль	71	268	678	448	2294	3688	3323	1758
Сонсголгүй хүүхдүүдийн сургууль	104	1263	2210	1279	1792	6544	4908	1836
Оюуны хомсдолтой хүүхдүүдийн сургууль	543	57	20585	16060	34751	71453	38288	7801
Хөдөлгөөний хомсдолтой хүүхдүүдийн сургууль	197	59	7811	4455	6392	18717	14090	3381
Эрүүл мэндийн хомсдолтой хүүхдүүдийн сургууль	91	1	1410	1379	1400	4190	3598	722
Нийт	1006	1648	32694	23621	46629	104592	65057	15498

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхэд сөргөөр нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл нь эрх зүйн орчноос илүүтэй хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна. Хууль тогтоомжид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах ерөнхий үзэл баримтлал байгаа боловч Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулахад биет болон биет бус хүчин зүйлүүд байсаар байна. Шийдвэрлэх асуудал нь, нийтийн эзэмшлийн гудамж, талбай нь хүүхдүүдийн зорчих боломжийг төдийлөн хангаж чадаагүй, ариун цэврийн өрөө, сургалтын хэрэгсэл, ширээ, сандал, самбар, ном сурах бичиг, багшлах боловсон хүчин хангалтгүй зэрэг нь эргээд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд сурах боломжоор хангагдахгүй байх, сургууль завсардах, улмаар бусдаас хоцрох үндэс сууриуд хамаарагдана. Иймээс эдгээр асуудлуудыг шийдвэрлэсэн тохиолдолд боловсрол эзэмших нөхцөл нэмэгдэнэ.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тусгай хэрэгцээт боловсрол, ялгаварлан, тусгай хэрэгцээт хүүхдийн сургууль, Засгийн газрын бодлого*

Ашигласан материал:

1. БСШУЯ Тусгай хэрэгцээт боловсролын талаарх албан ёсны мэдээлэл
2. Disability information resources official information site <https://www.dinf.ne.jp/doc/english/asia/resource/z00ap/003/z00ap00309.html>
3. National disability authority <https://www.nda.ie/>
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа 2020 Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
5. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал” Ц.Цэвэлмаа 2017., УБ

МУБИС-Д СУРАЛЦАЖ БУЙ СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Ж.Хулан, Б.Мөнхзаяа¹

¹МУБИС-ийн ТХБТ-ийн 4 дүгээр курсийн оюутан

Үндэслэл

1989 онд НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаар Хүүхдийн эрх, эрх чөлөөний тухай “Хүүхдийн эрхийн конвенц”-ийг баталсан ба түүнээс хойш гарсан олон улсын баримт бичиг, тунхаглалуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад боловсрол олгох, тэдний эрхийг хамгаалах, нийгэм хамт олон дунд нь нийгэмшүүлэх талаар онцлон заасан. Энэ конвенцийн 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн дүүрэн аз жаргалтай амьдрахын тулд дэмжлэг тусламж, халамж хэрэгтэйгээс гадна сурч боловсрох эрх эдлэх, дээд зэргээр өөртөө итгэх, улмаар нийгмийн интегралчлалд тэгш эрхтэйгээр бүрэн оролцох эрхтэй хэмээн заасан. Үүний улмаас Монгол Улсын Боловсролын их сургуульд суралцаж буй сонсголын бэрхшээлтэй тулгамдаж буй асуудлыг судалж илрүүлэх шаардлагатай байна.

Зорилго

Монгол улсын Боловсролын их сургуульд суралцаж буй сонсголын бэрхшээлтэй оюутнуудад тулгамдаж буй асуудлыг илрүүлж, тэдэнд шаардлагатай тусламж дэмжлэгийн чиглэлийг тодорхойлох

Материал ба арга зүй

Сонсголын бэрхшээлтэй оюутнуудаас урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ SPSS 22 программыг ашигласан.

Үр дүн

График 1. Таны нас





График 2. Хүйс



Тус судалгаанд нийт 21 оюутан хамрагдсанаас дийлэнх хувь нь 23-24 насныхан байгаа бол 17-20 насны оюутнууд цөөн хувийг эзэлж байна. Энэ нь магадгүй их сургуульд элсэж буй оюутнуудын тоо цөөрч байгааг илтгэж байгаа юм. Харин хүйсийн харьцааг харвал эмэгтэй оюутнууд дийлэнх хувийг эзлээд байна.

Хүснэгт 1. Оюутнуудын суралцаж буй мэргэжил

1	Бага ангийн багш	4.5	Тус судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх хувь нь 3 болон 4 курсын оюутнууд эзэлж байна. Сонсголын бэрхшээлтэй оюутнууд нь дийлэнх хувь нь өөрийн сонирхсон мэргэжлээрээ суралцдаг боловч ТХББ-ийн мэргэжил тэднийг их, дээд сургуульд суралцахад нь илүү ойр байдаг байна.
2	Биеийн тамирийн багш	4.5	
3	Дүрслэх урлаг дизайнерайн багш	4.5	
4	Мэдээлэл зүйн багш	4.5	
5	Нийгмийн ажил	4.5	
6	Солонгос хэлний багш, орчуулагч	4.5	
7	Сургуулийн өмнөх боловсролын багш	4.5	
8	Сэтгэл судлал	4.5	
9	Тусгай хэрэгцээт боловсролын багш	9.1	

Хүснэгт 2. Тулгамдаж буй бэрхшээл

1	Үг, утгын зөрүү	9.5
2	Багш, оюутан, ажилчдын харилцаа хандлага	4.8
3	Дохионы хэлний орчуулагч байхгүй	81.0
4	Сургалтын тохиромжгүй орчин	4.8

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд нь шууд ярианаас үгийн утгыг бүрэн ойлгодоггүй бөгөөд энэ нь тухайн оюутнуудад их, дээд сургуульд суралцахад хүндрэлтэй байгаа бөгөөд үүнээс гадна нэн тулгамдаж буй асуудал нь ямар ч сургууль дохионы хэлний орчуулагч байдаггүйтэй холбоотой юм. Оюутнуудтай ярилцахад багш нар болон оюутнуудын хандлага, анхан шатны дохионы хэлний мэдлэг байдаггүйгээс олон асуудлууд тулгамддаг байна. Дээр үзүүлсэн хүснэгтэд нэн тулгамдаж буй асуудлуудыг гаргасан болно. Дээрх бэрхшээлүүдээс үүдэн оюутнуудын харилцаа хоорондын ойлгомжгүй байдал төдийгүй бие даалт болон хичээл зэргээ ойлгоход хүндрэл учирдаг байна.

Дүгнэлт

Монгол улсын Боловсролын их сургуульд суралцаж буй сонсголын бэрхшээлтэй оюутнуудын сонсголын алдагдал болон сонсох чадварыг нэмэгдүүлэх хэрэгсэл ашиглалтын тоон харьцуулалт нь тэдний дийлэнх хувь нь бүрэн сонсголгүй хүүхдүүд байгааг илтгэж байна.

Сонсголын бэрхшээлтэй оюутнууд нь бичгийн хэл сайн мэддэггүй, үгийн утгыг ойлгоход хүндрэлтэй байдгаас үүдэлтэй багш бусад оюутнууд болон гэр бүлийнхэнтэйгээ ч харилцахдаа ихэвчлэн дохио зангаагаар харилцдаг нь тэдний бусадтай ойлголцох байдалд тийм ч сайн нөлөө үзүүлдэггүй байдаг байна. Энэхүү судалгаагаар сонсголын бэрхшээлтэй оюутнуудын бусадтай харилцах, ойлголцох байдал нь дундаж төвшинд байгааг харж болох юм. Тиймээс сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд, тус сургуулийн бүх багш нар, оюутны зөвлөлийн гишүүд болон бусад оюутнуудад зориулсан дохионы хэлний анхан шатны сургалтыг системтэйгээр зохион байгуулах

шаардлагатай гэж үзэж байна.

Тухайн хүүхдүүдийн бусадтай харилцах, ойлголцох байдлаас хамааран тэдний бие даалт болон хичээлийн даалгавраа хийж гүйцэтгэхэд нь үг, утгын зөрүү, дохионы хэлний хэлмэрч орчуулагч, багш оюутнуудын харилцаа хандлага, сургалтын тохиромжгүй орчин зэрэг олон төрлийн бэрхшээлүүд тулгарч эхэлдэг байна. Сургуулийн захиргаа тус сургуулийн багш нар сонсголын бэрхшээлтэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг онцгойлон анхаарч тохируулгат сургалтын орчинд ялгаатай байдлыг хүндэтгэсэн сургалтын арга зүйг ашиглан тухайн хүүхдийн чадварыг дэмжин ажиллаж, сургууль бүр дээр дохионы хэлний хэлмэрч орчуулагч ажиллуулах зэрэг мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Тус сургуульд ажиллаж буй багш ажилчид, суралцаж буй оюутнууд зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын онцлог чадвар тэдэнтэй хэрхэн зөв зохистой харилцах, ямар дэмжлэг тусламж үзүүлэх талаарх мэдээ мэдээлэл, зөвлөгөө зөвлөмжийг тогтмол үзүүлэх хэрэгцээтэй байна.

Түлхүүр үг: Сонсголын бэрхшээлтэй суралцагч, дэмжлэг туслалцаа

Ашигласан материал:

1. Тусгай боловсролын дэмжих төв, (2017). Тусгай боловсролыг дэмжих төвийн үүрэг оролцоо болон үйл ажиллагаа сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийн гарын авлага. Улаанбаатар.
2. Батцэнгэл,Г. (2014). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэл зүйн зарим асуудал. Улаанбаатар.
3. Ишикура.К, Исава.Ш, Батцэнгэл (2010) “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах онол арга зүйн зарим асуудал” УБ.
4. Ишикура.К бусад “(2018). Тусгай хэрэгцээт боловсрол” УБ.
5. Д.Одгэрэл (2018) “Тусгай боловсрол” УБ.,

RELATIONSHIP BETWEEN EARLY CHILDHOOD EDUCATION AND EQUITY (FOCUS ON MONGOLIAN CHILDREN WITH DISABILITIES)

Х.Сансармаа¹, С.Сэлэнгэ², Г.Болормаа³

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ²Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ³Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын холбоо

xsansarmaa@yahoo.com

Introduction

The socio-economic reforms of the 1990s created discrimination in the education sector, particularly among children of gender and minority groups include the poor, rural populations, ethnic, racial, and linguistic minorities, and disabled children with a focus on providing basic education and equal rights for all students, especially in less developed countries. In the early 2000s World Education Forum in Dakar's Action Plan (2000), Senegal which takes 164 countries, clearly state that the education system must be made more flexible in order to ensure the education of out-of-school and disadvantaged students and equal access to quality primary education for all children (UNESCO, 2000). In short, ensuring equity in education is not only the beginning of human development but also of social freedom (Shermen & Poirier, 2007). In order to create inclusive education and equal opportunities, The Ministry of Education and Science of Mongolia has taken measures to ensure equal access to education for children with disabilities. By the joint order of the three Ministers of Health, Labor, and Social Welfare, the "Action Plan for the Implementation of the National Program to Support the Rights, Participation and Development of Persons with Disabilities for 2018-2022" has been approved and is being implemented (MLSW & JICA, 2019). Unfortunately, there is a lack of kindergartens with infrastructure and a favorable learning environment for children with disabilities in the country, and there is still discrimination. School facilities should allow all students, with or without handicaps, to fulfill their education without hindrance. Inclusive education has not yet been fully implemented, kindergartens close to children's homes are not ready to educate them, and there are still barriers without special equipment, access, and this indicates that the kindergarten enrollment rate is very low.

Aim of study

This study aims to identify policy measures and recommendations for further educational equity by analyzing international and local research reports based on the current situation of access to early childhood education level for children with disabilities in Mongolia.

Methodology

The search for studies that include an analysis of the association between early childhood education (focus on children with disabilities) and equity was conducted using the main bibliographic databases of the scientific literature in

these platforms and resources. The keywords (taken from the corresponding thesauri) used in the initial exploration were «*early childhood education*», «*equity*», «*children with disabilities*», «*enrollment*», «*barrier-free*». After the initial search, in which more than 50 studies of different types were filtered (books, doctoral theses, articles, research reports, etc.), approximately main 25 studies were selected for their apparent association with the research object of this study.

Results

How is the work of early childhood education which focuses on children with disabilities in Mongolia? Enrollment ratio: According to the National Statistics Office's official report for 2020, 108,399 (3.3%) of Mongolia's population has some kind of disability, and approximately 1765 (0.4%) of them are children aged 2-5 (NSO, 2021). In the 2020-2021 academic year, a total of 247,040 children are enrolled in pre-primary school, of which 1,156 are children with disabilities. This represents 65.4 percent of all children aged 2-5 who need to attend preschool. However, there are only 1-2 children in the country's regular kindergartens, 187 in the 10th kindergarten for children with special paralysis, 78 in the 186th kindergarten, and 30-70 in other private kindergartens. In terms of types of disabilities, for example, visually impaired children are enrolled in approximately two groups nationwide, for a total of 23 children in kindergartens. This means that the concept of inclusive education has not yet been fully implemented, kindergartens close to children's homes are not ready to educate them, and there are still barriers without special equipment, access, and this indicates that the kindergarten enrollment rate is very low. ***Barrier-free:*** The Availability, Quality, and Child Development Outcomes of Preschool Education Services in Mongolia (2016) show that the facilities, infrastructure, and learning environment needed to improve the material base and activities of kindergartens are not in place (WB, 2016). The ability of children to assess their level of development and readiness for school and the specifics of their development, as well as the lack of special training and adjustment for different needs of children with disabilities, make a significant difference in their readiness for school. ***How the changes were made? Analyzing the policies: is there a rule/law/anything to solve the problem? Who is the person with a disability?*** The Law on the Rights of Persons with Disabilities (2016) states that "a person with a permanent physical, mental, emotional or sensory impairment is limited in his or her ability to participate fully and effectively in social life as others due to the combination of other environmental barriers". In addition, the Law on Preschool Education was amended in 2016 to provide for the education of up to two children with disabilities in one class of a regular kindergarten and for the hiring of additional teachers as needed.

Conclusion

What are the big issues now? Lack of proper investment in education has negatively affected the quality, access and services of pre-school education. As

a result, children with disabilities are not fully enrolled in regular kindergartens due to the lack of facilities, kindergarten infrastructure, favorable learning environment infrastructure, special needs training equipment, and teachers' communication and teaching methods with children with disabilities. The modern way is lack of the understanding and development of special needs education (Battsengel, 2020). Inadequate access to education for children with disabilities and children with severe disabilities remain out of school (Khurelbaatar, 2018; MECSS, ADB, JPDF, 2019). Children with disabilities do not have access to regular kindergarten or additional support (WB, 2016). School and kindergarten administrators and teachers are reluctant to enroll children with disabilities due to a lack of methods for working with children with disabilities and don't accept these students because of lack of learning environment. It is common for parents to take their children out of kindergarten due to the lack of access to the road transportation for children with disabilities to schools and kindergartens and infrastructure problems especially difficulties to take and pick up to school and kindergartens in the cold winter. Training of teachers for special needs education is not enough (Battuya, 2013; Battsengel & Baigalmaa, 2018), and all students who are studying in teacher training university to become teachers should be required to take elective courses in the content of “Inclusive Education” in the future (Battsengel, 2020). ***How we can do improving the relationship between early childhood education and equity in international context?*** Considering that human capital development policy is a priority, one of the measures to develop early childhood education is to increase the enrollment rate in kindergartens in the basic documents of the education sector (OECD, 2020). The decision to legislate compulsory or free education for young children, followed by changes in the distribution of funding was an important step in ensuring equal rights for all, especially for disadvantaged children (OECD, 2020; UNISEF, 2019).

Keywords: *Early childhood education, Equity in Education, Children with disabilities, Enrollment, Barriers-Free*

References:

1. Battsengel, G. (2020). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс. “Psychological basis of education for children with disabilities”*. Mongolia, Ulaanbaatar.
2. MLSW & JICA (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, мэдээллийн лавлах. “Disability Issues: Policy, Operations, and Information Directory”*. Mongolia, Ulaanbaatar.
3. NSO (2021). *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. “Unified statistical database”*.
4. Khurelbaatar (2018). Dropout of disadvantaged students in school system (Case of Mongolia). In МУБИС (Eds), *“Тусгай хэрэгцээт боловсролын багш, онол практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл* (p.104-111). Mongolia, Ulaanbaatar.
5. Shermen, J.D. & Poirier (2007). *Educational equity and public policy: comparing results from 16 countries*. Montrie: UNESCO.



V БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНД

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭ /ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ЖИШЭЭН ДЭЭР/

Н. Түмэндэмбэрэл¹, Ч. Мандалсайхан, Ж.Жаргал, О.Мөнхөө, Б.Даваасүрэн²

¹АШУУИС, ²Говь-Алтай Анагаах Ухааны сургууль

Tumendemberel@mnumns.edu.mn

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна[2]. Монгол улсын нийт хүн амын 2.8 хувь буюу 120 мянга орчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ / байгаагаас 55.2 хувь нь эрэгтэйчүүд, 44.8 хувь нь эмэгтэйчүүд, 35.5 хувь нь төрөлхийн, 64.5 хувь нь олдмол шалтгаан буюу ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд байдаг байна[3]. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй 940 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт иргэдийн 4.9%- ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзлэж байна. Иймээс улсын дундажтай харьцуулахад манай аймаг 2.1%-иар илүү байгаа нь ХБИ-ийн тулгамдаж буй асуудлыг судлахыг зорьсон бөгөөд цаашид Есөнбулаг сумын хэмжээнд ХБИ-дэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор уг судалгааг хийж байна.

Зорилго

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоо бүхий асуудлыг судлах

Зорилт

1.Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох

2.Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг судлах

Практик ач холбогдол

Сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлагыг судалж арга хэмжээний үндэслэл сургуулийн багш, оюутан өрхийн эрүүл мэндийн эмч, сувилагч нарын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулан, хамтран ажиллах таатай орчинг бий болгох төсөл боловсруулахад судалгааны баримт болгох

Материал ба арга зүй

Судалгаанд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Марал- Алтай, Энх- Алтай, Жаргалант- Алтай өрхийн эрүүл мэнд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 260 иргэдээс асуумж судалгааг судалгааны зорилготой холбоотойгоор зорилтот бүлгээс ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг удирдамж гарган материал цуглуулж аналитик судалгааны агшингийн болон чанарын судалгааны аргыг ашиглав. Судалгаанд ХБИ-ийн холбооны тэргүүн, тэргүүлэгч болон багийн иргэд хамрагдлаа. Асуумж судалгааг хаалттай 10, нээлттэй 5 асуумжаар авсан ба амьдарч буй орчинд болон өрхийн эрүүл мэндийн төвд ажиглалт хийж баримтжуулан дүгнэлт өгсөн.

Үр дүн

Сувилагчийн орон тоо бага 25%-50% дутуу хангагдсан учир ажлын ачаалал их, сувилагч мэргэжилтэн давхар ажил хариуцдаг, хүн амын тоо их, гэрийн тусламж үйлчилгээ хийхээр явахад эмнэлэг дээр хүлээлт их үүсдэг иймээс гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 34.8%-44.9% байнгын асаргаа сувилгаа үзүүлэх шаардлагатай гэрийн тусламж үйлчилгээ хэрэгтэй одоо ажиллаж байгаа сувилагчийн орон тоо хүртээмжийн байдал дутагдалтай байна. ХБИ-д тусламж үйлчилгээ үзүүлэхэд цаг хугацаа их шаарддаг заавал хамтарч очих нөхцөл гардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 74.4%-83% гэрт амьдарч байгаа хаалга үүдээ нээхгүй, нохойтой, ууртай, зарим хүмүүс согтуу, олон талын асуудлыг асууж шаарддаг, хэлж байгаа зүйл нь ойлгомжгүй эрсдэлтэй зүйлүүд их байдаг гэж эмч сувилагч нарын 83% хариулж байсан. Эрүүл мэндийн даатгалаас олгож буй мөнгө санхүү хүрэлцээ муу, тусламж үйлчилгээний хэрэглэгдэхүүний дутагдалтай үйлчлүүлэгчийн сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөлүүд хангалтгүй. Бусад сум болон түр оршин суугчид олон 3.6% сувилагч нар голдуу амралтын өдрөөр гэрийн сувилахуйн тусламж хүргэдэг. 100%

Дүгнэлт

1.Сувилагчид ноогдох хүн амын тоо олон, сувилагчийн орон тоо дутагдалтай, нэг хүн 2-3 ажил хавсарч хийдэг ажлын ачаалал ихтэй, ХБИ-д зориулсан зам талбай, өрөөний тоноглол стандартын шаардлага хангахгүй, гэрийн сувилахуйн тусламж үзүүлэхэд үйлчлүүлэгчтэй холбоотой эрсдэл ихтэй зэрэг тулгамдсан асуудлууд байгааг бидний судалгаа тодорхойлж байна.

2.Судалгаанд хамрагдсан ХБИргэдийн 74% нь сувилахуйн тусламж үйлчилгээ хангалтгүй гэрийн асаргаа сувилгаа үзүүлдэггүй 42% сувилахуйн тусламж үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээлтэй дуудахад ирдэггүй, өрхийн эрүүл мэндийн төв хол, үүд хаалга ороход хэцүү суух газаргүй бэрхшээлтэй асуудлууд их байгаа нь Есөнбулаг сумын хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээ, ялангуяа гэрийн асаргаа сувилгааг сайжруулах шаардлагатай

байгааг харуулж байна.

Түлхүүр үг: *Сувилахуйн тусламж, хөгжлийн бэрхшээл*

Ашигласан материал:

1. ЭШБХЭмхтгэл (2018) Өрхийн анагаах ухааны тулгамдсан асуудлууд
2. Мэдээллийн лавлах (2017) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал Монгол улс Улаанбаатар хот
3. Мэдээллийн лавлах (2018) Говь- Алтай аймгийн статистик мэдээ Говь-Алтай аймаг
4. Эрүүл мэндийн яам (2017) Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал Монгол улс Улаанбаатар хот
5. Эрүүл мэндийн яам (2018) Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал Монгол улс Улаанбаатар хот

АТФ ЛЮМИНОЭФФЕКТИВ АППАРАТААР ЭМНЭЛГИЙН КЛИНИКИЙН БОЛОН АХУЙН ГАДАРГУУН ХАЛДВАРГҮЙЖҮҮТЭЛ, ЦЭВЭРЛЭГЭЭГ ШАЛГАСАН ДҮН

Б.Өнөрбилэг, О.Гантулга Д.Өлзийбүрэн Н.Урангоо А.Од¹
*¹Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэргээн Засалт, Сургалт, Үйлдвэрлэлийн
Төвийн Сэргээн Засах Төв эмнэлэг*

Үндэслэл

АТФ (Adenosine Triphosphate Tests) аппарат, сорилын тестээр эмнэлгийн, хүнсний үйлдвэрлэлийн, нийтийн хоолны, гэр ахуйн бүх төрлийн гадаргуунууд болон ариутгасан багажны ариутгалын чанарыг богино хугацаанд, чанарын өндөр төвшинд алдаа багатайгаар илрүүлэхээс гадна эмнэлгийн ажилтнуудын гарын ариун цэвэр, дахин хэрэглэгдэх олон тунт эмнэлгийн эм материал, багаж хэрэгслүүдийн халдваргүйжүүлэлтийн чанарыг шалгах, эмнэлэгт хэрэглэгдэх усны цэвэр болон ариун чанарыг шалгахад нэн тохиромжтой хяналтын систем юм.

Зорилго

Сэргээн Засах Төв эмнэлгийн клиникийн болон ахуйн гадаргуун халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний чанарыг АТФ (Adenosine Triphosphate Tests) тестер аппаратаар шалгах

Зорилт

1. Клиникийн А, В, С бүсийн зарим гадаргуун халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний чанарыг түргэвчилсэн АТФ тестерээр (тоон утга/RLU) шалгах
2. Клиникийн А, В, С бүсийн гадаргуун халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний чанарын үр дүнг харьцуулан дүгнэх

Судалгааг 2021.04.09-2021.04.12 хүртэл 72 цагийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Материал ба арга зүй

Судалгааны хүрээ: Сэргээн Засах Төв эмнэлгийн клиникийн болон ахуйн нийт 47 гадаргуу:

- Эмнэлгийн клиникийн А бүсийн гадаргуунууд
- Эмнэлгийн клиникийн В бүсийн гадаргуунууд
- Эмнэлгийн клиникийн С бүсийн гадаргуунууд

Судалгааны шинэлэг тал: Монгол улсад уг аппаратаар хийгдэж байсан аливаа судалгааны ажил байхгүй бөгөөд эмнэлгийн клиникийн гадаргуунуудын хяналтыг АТФ тестерээр, тэр дундаа алдаа хамгийн бага гаргадаг Hygiene брендийн (АНУ) SystemSure аппаратаар шалгаж, үр дүнг тооцож байгаа нь судалгааны ажлын шинэлэг тал юм.

Судалгааны арга, хэрэглэгдэхүүн:

- **Тохиолдлын ажиглалтын судалгаа, ATP Monitoring (5)**
- Статистик боловсруулалтыг **SPSS-15** программ
- **Hygiene** брендийн (АНУ) **SystemSure** аппарат 1 ширхэг
- **Hygiene** брендийн (АНУ) **UltraSnap** тестер/урвалж 50 ширхэг

Судалгааны тоон утгын тайлбар:

- 0-30 (RLU) бол Ариун гэсэн төлөвт
- 31-180 (RLU) бол Цэвэр гэсэн төлөвт
- 180-450 (RLU) бол Бохир гэсэн төлөвт
- 450-с (RLU) дээш бол Хэт бохир гэсэн төлөвт

Үр дүн

Клиникийн А, В, С бүсийн нийт 47 гадаргууг хамруулсанаас А бүсийн гадаргуунууд 17%, В бүсийн гадаргуунууд 63.8%, С бүсийн гадаргуунууд 19.2%-г тус тус эзэлж байв.

Дүгнэлт

1. Клиникийн А, В, С бүсийн нийт 47 гадаргуун халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний чанарыг түргэвчилсэн АТP-н/тоон утгаар/ шалгахад:
 - Эмнэлгийн клиникийн А бүсийн нийт 8 гадаргууд үзэхэд 37.5% нь ариун, 37.5% нь цэвэр, 25% нь хэт бохир гэсэн үзүүлэлттэй байна. Дундаж утга 222.5 буюу бага бохирдолтой байна.
 - Эмнэлгийн клиникийн В бүсийн нийт 30 гадаргууд үзэхэд 20% нь ариун, 40% нь цэвэр, 23.4% нь бохир, 16.7% нь хэт бохир гэсэн үзүүлэлттэй байна. Дундаж утга 313.9 буюу бохирдолтой байна.
 - Эмнэлгийн клиникийн С бүсийн нийт 9 гадаргууд үзэхэд 11.1% нь цэвэр, 22.2% нь бохир, 66.7% нь хэт бохир гэсэн үзүүлэлттэй байна. Дундаж утга 832.5 буюу хэт бохирдолтой байна.
2. Клиникийн А, В, С бүсийн нийт 47 гадаргуун халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний чанарыг харьцуулан дүгнэхэд:
 - Эмнэлгийн клиникийн А бүс (өндөр эрсдэлтэй бүс) дундаж утга 222.5 буюу харьцангуй бага бохирдолтой байхад клиникийн В бүс (дунд зэргийн эрсдэлтэй бүс) дундаж утга 313.9 буюу бохирдолтой, клиникийн С бүс (бага эрсдэлтэй бүс) дундаж утга 832.5 буюу хэт бохирдолтой байгаа нь статистик ялгаа бүхий байна. Уг үр дүнгээр эмнэлгийн ажилчид А бүсэд өндөр ач холбогдол өгч, халдваргүйжүүлэлт цэвэрлэгээг хуваарийн дагуу хийдэг, харин бага эрсдэлтэй В болон С бүсэд ач холбогдол өгөлгүй халдваргүйжүүлэлт цэвэрлэгээнд сул ханддаг байж болно.

Түлхүүр үгс

АТФ – Аденозинтрифосфат

RLU - Relative Light Units

Ашигласан материал:

1. Эрүүл Мэндийн яам. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээлэл. 2021.11.10
2. Эрүүл Мэндийн яам. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээлэл. 2021.11.05
3. Эрүүл Мэндийн Сайдын А/537 тоот тушаал, 62х, 2019.11.29
4. ATP Testing: A Proven Method to Measure Cleanliness. Page 3. Available from <https://www.hygiene.com/healthcare-cleaning-verification-system/>
5. Philip Carling MD. Methods for assessing the adequacy of practice and improving room disinfection. American Journal of Infection Control 41 (2013) S20-S25
6. Centers for Disease Control and Prevention/Healthcare Infection Control Advisory Committee (HICPAC). Guidelines for environmental infection control in healthcare facilities. Environmental Surfaces, E.VI. B.2. and E.I.E.3. Atlanta [GA]: Centers for Disease Control and Prevention; 2003. Available from: http://www.cdc.gov/hicpac/pdf/guidelines/eic_in_HCF_03.pdf. Accessed February 14, 2013.
7. Sato T. [Infection control in hospitals]. Masui. 2010 Jan;59(1):56-63. Japanese. PMID: 20077771.
8. <https://www.worldometers.info/coronavirus/>
9. <https://www.who.int/news/item/20-10-2021-health-and-care-worker-deaths-during-covid-19>

ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

*Э.Баасанхүү¹ Д.Батлхам² Б.Мөнх-Эрдэнэ² Д.Сарангэрэл³
АШУУИС-ийн Төв эмнэлэг¹, АШУУИС Сувилахуйн сургууль², АШУУИС Био
анагаахын сургууль³*

Үндэслэл

Тархины саажилт нь олон эмгэгүүдийн хам шинж бөгөөд хүүхдийн хөдөлгөөний үйл ажиллагаа, тэнцвэр болон төрх байдалд нөлөөлдөг мэдрэлийн тогтолцооны эмгэг юм [1]. Тархины саажилт нь улс орны хувьд харилцан адилгүй байгаа боловч дунджаар 1000 төрөлтөнд 1.5-3.8 тохиолддог[2,3, 4]. Монгол улсын статистик үзүүлэлтэд тархины саажилт 1000 амьд төрөлтөнд 3 тохиолддог мөн тархины саажилттай 1600 гаруй хүүхэд байдаг. Манай улсад Бобат эмчилгээний үр дүнг тархины саажилттай хүүхдэд судалсан судалгаа хийгдээгүй тул энэхүү судалгааны ажлыг хийсэн. Судалгааны ажлын шинэлэг тал:

1. Бобат эмчилгээний аргаар тархины саажилттай хүүхдүүдэд хөдөлгөөн засал эмчилгээ хийсний дараах үр дүнг хөдөлгөөн засал эмчилгээ хийхээс өмнөх үр дүнтэй харьцуулан тооцож байгаа нь Монголд анх удаа учраас судалгааны ажлын шинэлэг тал.
2. Тархины саажилттай хүүхдүүдийг GMFCS үнэлгээгээр бүлэг болгон хувааж эмчилгээ хийх нь шинэлэг тал болно.

Зорилго

Тархины саажилттай хүүхдүүдэд Бобат аргаар хийсэн хөдөлгөөн засал эмчилгээнд дүн шинжилгээ хийх.

Зорилт

1. Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнг WeeFIM болон хөдөлгөөн хөгжлийн шалгуур (GMFM-88) үнэлгээгээр үнэлэх.
2. Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнг оролцогчдын хөдөлгөөний түвшингөөр ангилан үнэлэх.
3. Тархины саажилттай хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хөдөлгөөн засал эмчилгээний үр нөлөөг WeeFIM шалгуураар үнэлэх.

Материал ба арга зүй

Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээний дараах үр дүнг үнэлэхийн тулд эргэмж байдлаар (retrospective study) судлах загварыг ашиглан тоон судалгааны арга ашигласан. Бид судалгааг Улаанбаатар хотын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төвийг түшиглэн явуулсан. Судалгаанд хүүхдийн төвөөр хэвтэн эмчлүүлж байсан 2-17 насны тархины саажилттай 94 хүүхдүүдийг зорилтод түүврийн аргаар

хамруулсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд 14 хоног хөдөлгөөн засал эмчилгээнд явсан бөгөөд 1 цагийн хугацаатай хөдөлгөөн засал эмчилгээ хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв дээрх хөдөлгөөн заслын үнэлгээний хуудаснаас хоёрдогч дата нь дээр ажилласан. Хүүхэд тус бүрийн мэдээллийг кодож, нууцалсан. Хэвлэн нийтлэхдээ хувь хүний нэрийг дурдахгүй, зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашигласан.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн:

Хөдөлгөөн засал эмчилгээний өмнө ба дараа хөдөлгөөний хөгжлийн шалгуур мөн уг үнэлгээнд тулгуурлан их биеийн хөдөлгөөний үйлдлийг тодорхойлох системээр үнэлж бүлэг болгож өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд доорх процедур болон хэрэглэгдэхүүнүүдийг ашигласан.

1. Хөдөлгөөн засал эмчилгээ (Bobath) аргаар хийсэн. Эмчилгээний өмнө болон дараа нь хөдөлгөөний хөгжлийн шалгуур (GMFM-88), өдөр тутмын үйл ажиллагаа (WeeFIM) үнэлгээгээр үнэлсэн.
2. Оролцогчдыг их биеийн хөдөлгөөний үйлдлийг тодорхойлох систем (GMFCS)-ээр насаар нь болон хөдөлгөөний чадвараар нь хүнд, дунд, сайн гэж бүлэг болгон хуваасан.

Үр дүн

Тархины саажилттай хүүхдэд Бобат эмчилгээг ашиглан хөдөлгөөн заслын эмчилгээ хийхэд (GMFM-88 $p < 0,0001$, WeeFIM $p < 0,0001$) статистик ач холбогдол бүхий сайжрал ажиглагдсан. Мөн тархины саажилттай хүүхдүүдийг хөдөлгөөний хөгжлөөр нь GMFCS-ээр 4 бүлэг болгон хуваасан. III, IV бүлгийн (III бүлгийн хүүхдүүд өөрөө юм түшээд өндийх, хэд алхах, богино зайд ганцаараа юм түшээд алхах чадвартай, IV бүлгийн хүүхдүүд ганцаараа суухдаа толгой сайн даана зарим үед их биед түшлэг хэрэгтэй, зогсох суухдаа тохирох дэмжлэгтэй, элэгдэж мөлхөх хөдөлгөөний чадвартай) хүүхдүүд бусад бүлгийн хүүхдүүдээс илүү сайжирсан байна. IV бүлгийн хүүхдүүд хөдөлгөөн засал эмчилгээ хийлгэсний дараа GMFM-88 үнэлгээний мөлхөх ба өвдөглөх, зогсох бүлгүүдэд бусад түвшингөөс илүү сайжирсан байсан.

Хүснэгт 1. GMFCS II, III, IV, V бүлгүүдийн WeeFIM шалгуурын үр дүнгийн харьцуулсан үр дүн

Regression coefficient β , (95%CI)				
Үнэлгээ	Төвшин	Зөрүү оноо	P утга	
WeeFIM	D	0.04(0.12 to -0.04)	2.29(0.71 to 3.68)	1 0.01*
	B	0.60(0.08 to 1.11)	2.29(0.71 to 3.68)	0.1 0.05*

Тэмдэглэл: Дундаж утга \pm стандарт хазайлт, * статистик ач холбогдолтой бүхий зөрүү $p < 0.05$ төвшин, D – GMFCS V төвшин C – IV төвшинтэй өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээний үр дүнг харьцуулав. B – GMFCS III

түвшинг C - IV төвшинтэй өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээний үр дүнг харьцуулав.

Дүгнэлт

1. Тархины саажилттай хүүхдэд хөдөлгөөн засал эмчилгээний дараа GMFM-88, WeeFIM үнэлгээнүүдийн чадварууд статистикийн ач холбогдол бүхий сайжрал ажиглагдсан. Иймд тархины саажилттай хүүхдэд хөдөлгөөн засал эмчилгээ үр дүнтэй болох нь харагдаж байна.
2. Тархины саажилттай дунд (GMFCS level-3,4) зэргийн хүүхдүүдэд хөдөлгөөн засал эмчилгээг Бобатын аргаар хийхэд тархины саажилттай хүүхдүүдийн хөдөлгөөний (мөлхөх ба өвдөглөх, зогсох, алхах ба гүйх) чадваруудыг сайжруулах ач холбогдолтой байна.
3. Тархины саажилттай дунд (GMFCS level-4) зэргийн хүүхдүүдэд хөдөлгөөн засал эмчилгээг Бобатын аргаар хийх нь өдөр тутмын үйл ажиллагааны шилжих хөдөлгөөний (сууж байгаад мөлхөх, зогсож байгаад суух, хэвтэж байгаад босож зогсох) чадварыг сайжруулах ач холбогдолтой байна.

Түлхүүр үг: *WeeFIM, GMFM-88, GMFCS, Хөдөлгөөний чадвар*

Ашигласан материал:

1. Krigger KW. Cerebral palsy: an overview. American family physician. 2006 Jan 1;73(1):91-100. PubMed PMID: 16417071. Epub 2006/01/19. eng.
2. Ryan JM, Cassidy EE, Noorduyn SG, O'Connell NE. Exercise interventions for cerebral palsy. The Cochrane database of systematic reviews. 2017 Jun 11;6(6):CD011660. PubMed PMID: 28602046. Pubmed Central PMCID: PMC6481791 physiotherapists and lecturers in physiotherapy. Epub 2017/06/12. eng.
3. Отгонбаяр П. Хүүхдийн тархины саа өвчний тархалт, түүнийг бага насны хүүхдэд илрүүлэх. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 1998, х.45-46
4. Цагаанхүү Г. Мэдрэл судлал. 2 дахь хэвлэл. Улаанбаатар, адмон: 2011.х.547-553
5. Oskoui M, Coutinho F, Dykeman J, Jetté N, Pringsheim T. An update on the prevalence of cerebral palsy: a systematic review and meta-analysis. Developmental medicine and child neurology. 2013 Jun;55(6):509-19. PubMed PMID: 23346889. Epub 2013/01/26. eng. 8

ТАРХИНЫ ХАРВАЛТЫН ДАРААХ ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ, ХӨДӨЛМӨР ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Д.Өлзийбүрэн, Д.Энхзаяа, Д.Сарантуяа¹
¹Сэргээн засах төв эмнэлэг

Үндэслэл

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын статистикийн мэдээлэл жил бүр дэлхийн хэмжээнд 15 сая хүн тархины харвалтаар өвчилж байгаагаас 5 сая нь нас барж, үлдсэн 10 сая нь тахир дутуу үлдэж байна. Монгол улсын хувьд тархины харвалт жил тутам дунджаар 100 000 хүн амд 290 тохиолдож, үүнээс нас баралт 100 000-д 49.0 хүрч байгаа нь харвалтын давтамжаар дэлхийд өндөр өвчлөлтэй орны тоонд хамаарч байна. Сэргээн засах төв эмнэлгээр үйлчлүүлж байгаа хэвтэн эмчлүүлэгчдийн 60% нь харвалтын дараах саа саажилт, үлдэц өвчнөөр эмчлүүлсэн учир тархины харвалттай үйлчлүүлэгчийг сонгон авч судаллаа.

Зорилго

Сэргээн засах төв эмнэлгээр хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн бие даах чадварыг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Материал ба арга зүй

Даралтын аппарат, пульс оксиметр, гонометр, цахилгаан давтамжит гүйдлийн эмчилгээ, motor cross, бөмбөг, доод мөчний хүчний аппарат, туслах хэрэгсэл, шат, parallel par, сунгалтын тавцан, тэнцвэрийн тавцан

Үр дүн

Тархины харвалтын дараах сэргээн засах эмчилгээ нь эрт хугацаанд өндийж суулгах, босож зогсох, туслах хэрэгсэл ашиглах, эрт алхах дасгал хийлгэх, хооллох, хувцаслах, өөртөө үйлчлэх чадвар, хөдөлгөөний чадвар хурдан сэргээх ач холбогдолтой юм.

Зураг 1.



Зураг 2.



Дүгнэлт

Идэвхтэй дасгал хөдөлгөөн, эмийн болон эмийн бус эмчилгээнд 11 хоног хамрагдсаны дараах байдлаар дүгнэхэд.

1. Үйлчлүүлэгч Б-ийн бие даан амьдрах чадвар, өөртөө үйлчлэх чадварууд эмчилгээний дараа давтан үнэлгээгээр 4% нэмэгдсэн.
2. Үений далайцыг ойртуулах, холдуулах хөдөлгөөн 10 градусаар тус тус нэмэгдсэн.
3. Үйлчлүүлэгч Б нь эмнэлгээс гарахдаа бусдын тусламжгүйгээр бие даан алхах, хувцсаа өмсөх, бие даан бие засаж сурсан.

Дээрх дүгнэлтээс харахад хөдөлгөөн заслын хөдөлмөр засал эмчилгээ нь тархины харвалтын дараа үр дүнтэй байгаа нь харагдаж байна. Иймээс сэргээн засах эмчилгээг цаг алдалгүй хийснээр үлдэц багатай сэргэлт хурдан явагдана.

Түлхүүр үг: Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэлт, дасгал хөдөлгөөн, идэвх оролцоо

Ашигласан материал:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага https://www.who.int/violence_injury_prevention/key_facts/VIP_key_facts.pdf
2. Тархины шигдээсийн сэргээн засахын удирдамж <https://moh.gov.mn/uploads/files/9fe478e716394dde23de3dfa53855c7d.pdf>
3. M.H. Thaut “Rhythmic facilitation of gait training in hemiparetic stroke rehabilitation”

БУРУУ СУУХ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДВАРЫГ БУУРУУЛЖ БУЙГ СУДЛАХ НЬ

М.Эрдэнэтуяа¹
¹ХБХСЗХТ-ийн Хөдөлгөөн засалч
Tuyaka1211@gmail.com

Үндэслэл

Дэлхий дахинд нурууны өвдөлт нь эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг үүсгэж буй шалтгаануудын нэг бөгөөд 10 хүний 8 нь амьдралын туршид ямар нэгэн байдлаар их бага хэмжээгээр нурууны өвдөлтөд өртсөн байдаг¹. Нурууны өвдөлтийн тохиолдлын 24-30% нь хөдөлгөөн хязгаарлагдсанаар үүсдэг ба удаан хугацаанд буруу суух нь цусны даралт болон цусан дахь холестерин нэмэгдүүлж, чихрийн шижин болон бусад өвчнөөр өвчлөх магадлал өндөр болгодог байна². Орчин үед сургуулийн насны хүүхдүүд нуруу хамгаалах техник мэдэхгүй олон цагаар буруу сууж хичээл хийх нь нуруу өвдөхөд ихээхэн нөлөөлсөөр байна. Манай улсад нурууны өвдөлтийн талаар хийсэн судалгаа ховор байдаг ба ялангуяа өсвөр насны хүүхдийн нурууны өвдөлтийг судалсан судалгаа байдаггүй нь уг судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго

Буруу суултаас үүссэн үйл ажиллагааны чадвар алдагдлыг судлах

Материал ба арга зүй

Судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй хүүхдүүдээс тархины саажилттай/атетойд, диплеги/ ,бусдын тусламж болон туслах хэрэгсэл ашигладаггүй /GMFM88-260-264 оноотой/ 12-17 настай, 30 хүүхдийг судалгаанд хамруулсан. Уг судалгааг нэг агшны судалгааны аргыг ашигласан ба үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS-25 программ ашиглан бодсон.

Үр дүн

Судалгаанд оролцогчдын 50% нь тасралтгүй 6-аас дээш цаг суудаг гэсэн нь үйл ажиллагааны чадвар алдагдалд орох өндөр эрсдэлтэй байгааг харуулсан ба булчингийн хүч, үений далайц, булчингийн тэсвэржилт хэвийн хэмжээнээс буурсан нь үйл ажиллагааны чадвар алдагдал үүсэхийг баталж байна.

Хүснэгт 1. Чадвар алдалтын харьцуулсан үр дүн

Чадвар алдалтын асуумж	Өвдөлттэй үйлчлүүлэгч	Өвдөлтгүй үйлчлүүлэгч
BDI score	9.6±3.2	0.26±0.70*

Тэмдэглэл: Дундаж утга±стандарт хазайлт; *p<0.05 ач холбогдолтой

Хүснэгт 2. Булчингийн хүчний харьцуулсан үр дүн

Булчингийн хүч	Өвдөлттэй үйлчлүүлэгч	Өвдөлтгүй үйлчлүүлэгч
Нугалах	3.0±0.1	4.5±0.51*
Тэнийлгэх	3.0±0.1	4.5±0.51*

Тэмдэглэл: Дундаж утга±стандарт хазайлт; *p<0.001 ач холбогдолтой

Хүснэгт 3. Үений далайцын харьцуулсан үр дүн

Үений далайц	Өвдөлттэй үйлчлүүлэгч	Өвдөлтгүй үйлчлүүлэгч
Нугалах	74.3±5.3	88.8±1.8*
Тэнийлгэх	22.1±2.7	30.0±0.1*
Баруун хажуу нугалах	22.0±2.0	30.0±0.1*
Зүүн хажуу нугалах	21.2±1.4	30.0±0.1*
Баруун тийш нугалах	21.3±1.8	30.0±0.1*
Зүүн тийш нугалах	21.4±1.6	30.0±0.1*

Тэмдэглэл: Дундаж утга±стандарт хазайлт; *p<0.001 ач холбогдолтой

Хүснэгт 4. Булчингийн тэсвэржилтийн харьцуулсан үр дүн

Булчингийн тэсвэржилт	Өвдөлттэй үйлчлүүлэгч	Өвдөлтгүй үйлчлүүлэгч
Нугалах	18.8±2.5	32.2±2.7*
Тэнийлгэх	19.7±1.7	31.2±1.8*

Тэмдэглэл: Дундаж утга±стандарт хазайлт; *p<0.01 ач холбогдолтой

Дүгнэлт

Дээрх харьцуулсан үр дүнгээс харахад удаан хугацаанд буруу суудаг үйлчлүүлэгчдийн үйл ажиллагааны чадвар нь бага цагаар суудаг хүүхдүүдээс буурсан нь харагдаж байна.

Түлхүүр үг: Буруу суулт, үйл ажиллагааны чадвар алдагдал, үений далайц, булчингийн хүч

Ашигласан материал:

[1] [Ewelina Matusiak-Wieczorek](#), [Elzbieta Dzionkowska-Zaborszczyk](#), [Marek Synder](#), [Andrzej Borowski](#) "The Influence of Hippotherapy on the Body Posture in a Sitting Position among Children with Cerebral Palsy" Int J Environ Res Public Health 2020 Sep 19;17(18):6846.

[2] Duthey B. *Priority Medicines for Europe and the World "A Public Health Approach to Innovation"* Background Low back pain, Geneva, Switzerland: WHO; 2017.

[3] [Isidora Vujcic](#), [Nemanja Stojilovic](#) - "Low Back Pain among Medical Students in Belgrade (Serbia): A Cross-Sectional Study" Pain Res Manag 2018 Feb 6;2018:8317906.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭ ХООРОНДЫН ЧАДВАР БУУРАЛТАД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Б. Элбэгдорж, М. Ариунболд¹

¹*Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
elbegdorjbayragnai@gmail.com, boldoo.mn1214@yahoo.com*

Үндэслэл

ХБХ-ийн чадвар алдалтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг хүн ам зүй, нийгэм эдийн засаг, улс төр, эрүүл мэндийн системээс хамаарч буй хүчин зүйлүүдийг тодорхойлохыг энэхүү ажлаараа зорьсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд үйлчлүүлж буй 60 хүүхдийн эцэг эхийн мэдээлэлд үндэслэн тоон өгөгдлийг дүн шинжилгээндээ ашиглан олон хүчин зүйлсийн шинжилгээ хийж, үр дүнг тоон статистик утгаар нотолсон.

Зорилго

Энэхүү ажлын үндсэн зорилго нь ХБХ-ийн чадвар алдалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход оршино.

Материал ба арга зүй

Чадвар алдагдал ба хүн ам зүй, нийгэм-эдийн засаг, эцэг эхийн зан үйл, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарын сонгосон үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг хамгийн бага квадратын аргаар үнэлсэн болно. ХБХ-ийн чадвар алдалтад нөлөөлөх хүчин зүйлсийн ложистик регрессийн шинжилгээний үр дүн болох статистик ач холбогдлын (итгэх утгын 95%) төвшин, Логарифмын харьцаа “Odds ratios”-г тооц он.

Үр дүн

Судалгааны ажлын энэ хэсэгт сэргээн засах эмчилгээний дараах чадвар алдалтанд хэрхэн нөлөөлж буй олон хүчин зүйлсийг статистик ач холбогдлын түвшинд тодорхойлж, үр дүнг танилцуулж байна.

Хүснэгт 1. ХБ хүүхдийн чадвар алдалтад нөлөөлж буй олон хүчин зүйлсийн ложистик регрессийн шинжилгээний үр дүн

Үл хамаарах хувьсагчид	ХБ хүүхдийн чадвар алдах магадлалын харьцаа (Odds ratio, Exp(B))				
	Загвар А	Загвар В	Загвар С	Загвар D	(95% ИХ)
Ах дүүсийн насны зөрүү					
1					
2	0.660**	0.681	*0.487	-0.485	(0.234-0.670)
3	0.430	-0.481	0.594	-0.295	
4	0.384*	0,347	0.608	-.547	

<i>Зурагт, утас, үздэг байдал</i> 1-1 цаг 1-3цаг 1-5 цаг					
		0.739	*0.782 *0.685	0.825 *0.712	(0.559-0.944)
		0.724			
<i>Өрхийн амьжиргааны төвшин</i> 500,000-800,000 800,000-1000,000 1,000,000- дээш					
		*0.481 *0.648	0.682 0.621	0.715 *0.751	(0.524-0.842)
<i>Нэмэлт тэжээл</i> Тийм Хааяа Үгүй					
		*0.848 0.812	0.941 *0.786	0.817 0.768	(0.754-1.282)
<i>Миний хүүхдийг эмнэлэг л эмчилнэ</i> тийм үгүй					
			*1.121	1.384	(1.124-1.415)
<i>Хүүхдийн бие сайжрах байдал</i> Эмнэлгээс Хүрээлэн буй орчноос Эмнэлэг болон ХБО					
			0.758 *0.812	0.812 0.931	(0.114-0.157)
<i>Мэдээ авдаг эсэх</i> Өдөр бүр Хааяа үздэг Огт үздэггүй					
				0.862 0.412*	(0.350-0,925)
<i>Хүүхэд дээрээ зорилт тавьсан уу</i> Тийм Үгүй					
				*0.420	(.405-0.589)
<i>Итгэл найдвар Эмнэлгээс Хэвлэл мэдээллээс Амжилттай явж байгаа ХБИ</i>					
				0.457 *0.685	(0.385-0.725)
2LL chi-square	7.482*	8.483*	6.025*	9.125	
R ² үнэлэгдсэн утгын тайлбарлах чадвар	7.91%	9.8%	6.2%	14.58%	

Тэмдэглэл: Үл хамаарах хувьсагчид нь регрессийн тэгшитгэлийн үнэлэгдсэн утгыг тайлбарлана. *p≤0.05 ач холбогдлын төвшинд хамаарлын коэффициентийг тооцов.

Дүгнэлт

Сэргээн засах эмчилгээний дараах чадвар алдалт нь дан ганц эрүүл мэндийн байгууллага биш асран хамгаалагч болон хүрээлэн буй орчны нөлөө их байгааг энэ судалгааны ажил нотолж байна. Ах дүүсийн 1-2 насны зөрүүтэй байдал нь сэргээн засах эмчилгээний дараах чадвар алдалтад нөлөөлж байна. Хүүхдэдээ зурагт, утас хэт их үзүүлдэг нь эмчилгээний байдалд сөргөөр нөлөөлж байна. Үр дүнгээс харахад эцэг эх нь итгэл найдвар олж аваад хүүхэд дээрээ зорилт тавиад тавьсан зорилгынхоо дагуу хичээж байна. Өрхийн мөнгөн орлого нь ХБ хүүхдийн чадвар алдалтад нөлөөлж байна. Сар бүр олгох мөнгөн тэтгэмж нь ашиг тустай. Иймээс аав юмуу ээжийн ажлын байраар хангахад төр засаг анхаарах шаардлагатай. Өрхийн мөнгөн орлого нэмэгдэхийн хэрээр ХБ хүүхэд нэмэлт тэжээл хэрэглэх нөхцөл бололцоо үүсдэг. Эцэг эхийн хандлага нь маш буруу ойлголттой байна. Дан ганц эмнэлгийн газарт найдаж байна. Гэртээ очоод юу ч хийхгүй буцаад ирэх нь сувилалд хэвтэхдээ анх ирсэн биеийн байдалтайгаа адилхан байна. Гэртээ туслах хэрэгсэл ашиглаж байгаа ХБ хүүхдийг туслах хэрэгсэл ашиглахгүй байгаа хүүхэдтэй харьцуулахад чадавх алдалт нь доогуур байна. Энэ нь хийгдсэн эмчилгээг бууруулах сул талтай. Учир нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд сувилалд эмчлүүлээд явдаг болоод гэртээ гарч, аав ээж нь шууд тэргэн дээр суулгах нь сэргэсэн хөдөлгөөнийг буцаад зогсонги байдалд оруулж өгч байдаг. Эцэст нь, олон хүчин зүйлийн шинжилгээгээр сэргээн засах эмчилгээний дараах чадвар алдалтад нөлөөлж буй хүчин зүйлсэд хүн ам зүй, нийгэм эдийн засаг, эрүүл мэндийн үйлчилгээ, эцэг эхийн шинж чанарын үзүүлэлтүүд статистик ач холбогдолын төвшинд тайлбарлах чадвар хамгийн өндөр байна. Тодруулбал, төрөлтийн дараалал, өрхийн амьжиргааны төвшин, зурагт үздэг, оршин суугаа газар зэрэг үзүүлэлтүүд нь ХБ хүүхдийн чадвар алдалтад нөлөөлж буй гол хүчин зүйлс болж байна.

Түлхүүр үг: *ХБХ-ийн чадвар алдалт, хүрээлэн буй орчин*

Ашигласан материал:

1. Зарим аймгуудад нялхсын эндэгдэл өндөр байгаа шалтгаан, бодлого, хөтөлбөрийн үр нөлөө, Хүний хөгжлийн илтгэл 2010-т зориулсан эх материал, А.Солонго 2011
2. Trends in Infant Mortality in United States: A Brief Study of the Southeastern States from 2005–2009, academic editor, HDI, USA Jane Scott. 2015.

ГУЯЫН АРЫН БҮЛЭГ БУЛЧИНГИЙН ЧАНГАРАЛТАЙ ХҮҮХДҮҮДЭД АШИГЛАХ СУНГАЛТЫН АВТОМАТ АППАРАТЫН ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭЖ ЭМЧИЛГЭЭНД АШИГЛАСАН ҮР ДҮН

Н.Цэсэнжав, А.Нямсүрэн, Д.Батлхам1

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
tsesenjavnaranbaatar@gmail.com

Үндэслэл

Хүнд амд суурилсан судалгаагаар нийт тархины саагийн 70-80% нь чангарсан саа байдаг. Ихэвчлэн гуяын арын бүлэг булчин чангарах тохиолдол элбэг байдаг. Бага насны хүүхдэд үүссэн гуяын арын бүлэг булчингийн чангарал нь биеийн төрх байдал болон хөдөлгөөний хяналтанд сөргөөр нөлөөлснөөр шинээр чадвар эзэмших явц алдагдаж, суух, мөлхөх, зогсох, алхах зэрэг үйл ажиллагааны алдагдал үүсдэг. Гадаадын эрдэмтэд гуяын арын бүлэг булчингийн хамгийн сайн сунгагдах эрсдэлгүй байрлал бол түнхний үеэр 90° градусаар нугалсан байрлалд өвдгийг дээш тэнийлгэх байрлал гэж тодорхойлсон байна.

Зорилго

Гуяын арын бүлэг булчинг(m.hamstring) сунгах автомат аппаратын загвар зохион бүтээж эмчилгээнд нэвтрүүлэх үр дүнг тооцох.

Материал ба арга зүй

ХБХСЗХТ-өөр 2021 оны 08-9 сарын хооронд үйлчлүүлсэн тархины саа оноштой үйлчлүүлэгчдээс гуяны арын бүлэг булчингийн чангаралтай 5-6 насны 20 оролцогчдыг сонгон хамруулсан. 20 оролцогчдыг 2 бүлэгт хуваан 1-р бүлгийн 10 оролцогчдод эмчилгээний явцад өөрсдийн зохион бүтээсэн сунгалтын аппаратыг ашиглаж 10 хоногийн турш 5-10 минутын давтамжтай эмчилгээ хийж үр дүнг эмчилгээний өмнө болон дараа харьцуулж тооцсон. 2-р бүлгийн 10 оролцогчдод эмчилгээний явцад гар аргаар сунгалтын дасгал хийж эмчилгээний дараах үр дүнг 1-р бүлгийн 10 оролцогчдын эмчилгээний дараах үр дүнтэй харьцуулж тооцсон.

Үр дүн

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Оролцогчид	Нас (M±SD)
10	5.9±0.87

Хүснэгт 2. Эмчилгээний өмнөх дараах хэмжилтүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа
Тахимны өнцөг	10.12±3.20	9.43±2.98*
Өвдөг тэнийлгэх далайц	7.38±2.33	5.72±1.81*

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, статистик ач холбогдол бүхий зөрүү $p < 0.001^*$ төвшин

Хүснэгт 3. Аппаратаар болон гараар сунгалт хийсэн эмчилгээний дараах тахимны хэмжилт

Үзүүлэлтүүд	Гараар	Аппаратаар
Тахимны өнцөг	9.8±3.3	4.6±2.0*

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, статистик ач холбогдол бүхий зөрүү $p < 0.001^*$ түвшин

Дүгнэлт

1. Гуяын арын бүлэг булчингийн чангаралтай хүүхдүүдэд сунгалтын автомат аппарат ашигласнаар эмчилгээний өмнө өвдөг тахийж тахимны өнцөг ихэссэн байсан бол эмчилгээний дараа булчин уртассаг тахимны өнцөг багассан байна.
2. Гуяын арын бүлэг булчингийн чангаралтай хүүхдүүдэд сунгалтын автомат аппарат ашигласнаар эмчилгээний өмнө өвдөг нугарах өнцөг ихэсч тэнийх өнцөг хязгаарлагдсан байсан бол эмчилгээний дараа булчингийн чангарал суларч өвдөг нугарах өнцөг багасч өвдөг тэнийсэн байна.
3. Гуяын арын бүлэг булчингийн чангаралтай хүүхдүүдэд аппарат ашиглаж болон гар аргаар сунгалтын дасгал хийж эмчилгээний дараа үр дүнг харьцуулахад аппарат ашигласан хүүхдүүдэд $p < 0.001$ зөрүүтэй илүү булчин суларч үр дүн гарсан байна.

Дээрх дүгнэлтүүдээс үзэхэд манай судалгааны багийн зохион бүтээсэн сунгалтын аппаратын загвар үр дүн сайн гарч байгаа нь бидэнд урам өгч байна. Цаашид манай судалгааны баг сунгалтын аппаратын загвараа улам чангаруулан гуяын арын булчингийн чангаралтай бүх насны хүүхдүүдэд ашиглахад тохиромжтой болгож улам чанаржуулж ажиллах болно.

Түлхүүр үг: Гуяын арын бүлэг булчин, сунгах автомат аппарат, давтамжтай эмчилгээ

Ашигласан материал:

- [1] Ц.Наранцэцэг, Yi Youg Koong, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл, Тархины саатай хүүхдийн хөлний булчингийн чангаралд ботулин токсин-а тарьсан эмчилгээний үр дүн (2017) 7-р дугаар (хуудас 113).
- [2] Д.Болормаа, Б.Рэнцэнханд, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл, Тархины саатай хүүхдэд хийсэн хөдөлгөөн заслын үр дүн (2018) 8-р дугаар (хуудас 55).
- [3] Lynn Lippert, S. Clinical kinesiology and Anatomy (2011) part 4 (260-326)



VI БҮЛЭГ
ДЭД БҮТЭЦ

КАМЕР АШИГЛАН МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛИЙГ ХӨРВҮҮЛЭХ НЬ

Ч.Намуун-Эрдэнэ¹, Ч.Отгонхүү²

¹МУИС, ²ХШУИС

namuunerdene@seas.num.edu.mn

Үндэслэл

Монгол улсад хэрэглэгддэг дохионы хэл нь хэд хэдэн төлөвүүдээр илэрдэг бөгөөд тухайлбал албан ёсны болон утгачилсан байдлаар өөрсдийн санаа бодлоо илэрхийлэн нийгмийн харилцаанд ордог байна. Энэхүү хэлээр нийгмийн харилцаанд орсныг төдийлөн эрүүл хүмүүс ойлгодоггүй учраас хоорондын харилцаа бий болж чадахгүй хязгаарлагдмал байдлаар харилцах болсон. Хүн амьтантай адилгүйгээр байгалиас заяасан хоорондоо харилцан үйлчлэх боломжтой дууны чадвартай байдаг. Үүн дээр ярианы хэл байх бөгөөд хүний гол шинж чанарын нэг болдог боловч харамсалтай нь бүх хүмүүс хэл ярианы чадвартай байдаггүй нийгмийн цөөнх гэж нэрлэгддэг сонсголын бэрхшээлтэй иргэд байна. Мөн дохионы хэл хөрвүүлэлтээр хийгдсэн ажил системүүд байгаа ч гэсэн дохионы хэл нь судалгааны идэвхтэй талбар байсаар байгаа нь цаашид хийгдэх ажлууд судалгаа байгаагийн нотолгоо юм. Маш олон судлаачид энэ асуудлыг шийдэх шинэ зам олохыг хичээсээр байгаа ба ихэнх нь статистик тодорхойлогч дээр суурилсан цогц хэрэгжүүлэлтийг хийж гаргаж байна [1]. Дохионы хэлэнд синтакс болон морфологи нь чухал үүрэг гүйцэтгэдэг ба үгээр тушаах эсвэл автомат бүрэлдэхүүнүүд нь дохионы утгыг үндсээр нь өөрчилж чаддаг [2]. Эдгээр сонсголын бэрхшээлтэй иргэд нийгэм болон хоорондын харилцаанд орохдоо өөрсдийн суурь хэл болох дохионы хэлийг хэрэглэдэг. Хэдийгээр эдгээр хүмүүсийн хувьд суурь хэл нь боловч эрүүл хүмүүсийн хувьд сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй харилцаа үүсгэхэд маш хүндрэлтэй байдаг нь харагдаж байна [4]. Системийг олон нийтийн газар суурилуулан ашиглах боломжтойгоороо давуу талтай болж байгаа юм. Үйлчилгээний газруудад сонсголын бэрхшээлтэй хүмүүст энэхүү системийг зориулан хэрэглэснээр эдгээр хүмүүс болон үйлчилгээний ажилтны хооронд харилцааны хүндрэл багасна гэж найдаж байна.

Зорилго


Дохионы хэл нь сонсголын бэрхшээлтэй хүмүүс хоорондын харилцааг бий болгодог суурь хэл юм. Иймд энэхүү асуудлыг шийдэхийн тулд Microsoft Kinect камерыг ашиглан сонсголын бэрхшээлтэй болон эрүүл хүмүүсийн хооронд харилцааг үүсгэх системийг хөгжүүлэхийг зорилго.

Материал ба арга зүй

Ангилалтын функц бол сонсголын бэрхшээлтэй хэрэглэгчид хөдөлгөөн хийхэд хөдөлгөөн нь дүрстэй нийцэж гаралтыг үүсгэнэ. Фрейм дарааллаар нь оруулахад ангилалт нь тогтсон толь бичгээс фреймийн дарааллаар харьцуулалт хийдэг. Сонсголын бэрхшээлтэй хэрэглэгч камер луу харж

өөрийнхөө хэлэх гэсэн үгээ дохиогоор илэрхийлэхэд камер нь хүлээн авч сонирхож буй цэг дээр анализ хийж өгөгдлийг нормчлон тодорхойлогч фреймүүдийг цуглуулан харьцуулалт хийснээр тухайн дохио текст болгон дэлгэцлэнэ. Энэхүү дэлгэцлэгдсэн текст нь эрүүл хүнд харагдах болно.


Схем 1.



Зураг 1. Арга зүй

A. Microsoft Kinect XBOX 360TM

Үг	Танилт
Сайн уу	Баруун гарын хөдөлгөөн
Чи	Баруун гар тохойн хөдөлгөөн
Нэр	Баруун зүүн гарын хөдөлгөөн
Нас	Баруун зүүн гарын хөдөлгөөн
Хот	Баруун зүүн гар, мөрийн хөдөлгөөн



Зураг 2. Үг дэлгэцлэл

хамтаар хэрэглэгддэг [6].

Туршилт үр дүн

Энэхүү бүлэгт монгол дохионы хэлний хөрвүүлэлт түүний туршсан үр дүнг харуулах юм. Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Microsoft Kinect XBOX 360 камераар дэмжигдсэн өгөгдөл хэрэглэсэн.

Суурь дохионы жагсаалтыг үүсгэх туршсан. Систем нь бодит хугацаанд ажиллах шаардлагатай, хэрэглэгч нэг удаа дохиог хийхэд хариуг нь шууд гаргаж байгаа. Интерфейс нь энгийн ойлгомжтойгоор харагдаж байгаа энэ

Микрософт компаниас гаргасан шинээр гаргахдаа тоглоомын консол дээр RGB-D камерыг ойлгон ажиллуулсан. RGB, аудио нь 3 мэдрэгчтэй байдаг. Тэд хоёулаа хөдөлгөөнийг илрүүлэхийн тулд хэрэглэгчид өөрийн биеийн хөдөлгөөнийг тодорхойлох дууг таних боломжийг олгодог. Микрософт Kinect хөгжүүлэлт нь робот, үйлдлийн системийг таних зэрэг компьютерын харааны салбарт бусад хэрэгцээтэй программ

нь хэрэглэхэд илүү болж байна. Мөн дохионы хэлний бүрэлдэхүүн нь эдгээр хөдөлгөөнийг авч танилт хийдэг. Үгнүүдийн х,у,z координатын хувьд ийм координтаар үг бүрийг илрүүлж байна.

Дүгнэлт

Энэ судалгааны ажлаар, Kinect камерыг ашиглан монгол дохионы хэлний хөрвүүлэлтийг хийдэг систем хөгжүүлсэн. Kinect камерыг хугацааны арга алгоритмтай хамт ашиглаж танилтын хувь болон хугацааг хувьд бодит хугацаанд ажиллах боломжоор хангаж өгнө. Цаашид үгийн холбоосыг ашиглаж өгүүлбэрээр орчуулах болон харилцааны бүх талын дохионы хэлийг монгол хүмүүс хэрэглэх боломжтой байхаар системийн суурь нь тавигдаж байна. Сайжруулалт хийсэн үгийг хэрэглэхээс гадна утга зүйг сайжруулан хэл шинжлэлийн салбартай холбон яриа давхар үүсгэж утга зүй талаас нь зөв өгүүлбэр гаргах боломжтой юм.

Түлхүүр үг: Дохио; танилт; дүрс боловсруулалт

Ашигласан материал:

1. D.Martinez, "MSc Thesis - Sign Language Translator using Microsoft Kinect XBOX 360TM" ,VIBOT 5. , *Department of Electrical Engineering and Computer Science, Computer Vision Lab, University of Tennessee.*
2. Pavlovic, V.I. and Sharma, R. and Huang, T.S., "Vision-Based Gesture Recognition: A Review", *Pattern Analysis and Machine Intelligence, IEEE Transactions on, 1997*
3. D. M. Gavrila, "The Visual Analysis of Human Movement: A Survey", *Computer Vision and Image Understanding, 1999.*
4. Li, X., Parizeau, M., Plamondon, R.: Training Hidden Markov Models with Multiple Observations A combinatorial Method. In: *IEEE Transactions on PAMI, Vol. PAMI-22, No. 4, pp. 371-377 (2000)*
5. Official Microsoft Xbox website, introduction of Kinect, <http://www.xbox.com/en-US/kinect-14416-14441>. pyCat and Kinect, overview of the CopyCat Kinect demo on the website of the *Center for Accessible Technology in Sign (CATS)*,
6. Starner, T., Pentland, A.: Real-Time American Sign Language Recognition from Video Using Hidden Markov Models. In: ISCV '95 Proceedings of the *International Symposium on Computer Vision,*

ДОХИО ХЭЛНИЙ ЦАГААН ТОЛГОЙН ҮСЭГ ТАНИХ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЗАГВАР

Б.Луубаатар, Г.Мөнхжаргал, Г.Мөнх-Эрдэнэ, А.Отгонбаяр, Д.Нандин-Эрдэнэ¹
¹Монгол улс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль,
 Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль

Үндэслэл

Монгол улсын хэмжээнд хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй нийт 12768 иргэд байна. Харин албан ёсны хэлмэрч монгол улсын хэмжээнд нийт 15 байдаг ба энэ тоо баримтыг харахад сонсголын бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн хэлмэрчээр дамжуулж бусадтай харилцах боломж тун хомс байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, цаашлаад тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг багасгах нэг том хүчин зүйл болж байна.

Зорилго

Энэхүү судалгааны ажил нь дохионы хэлний бичлэг буюу өгөгдлийг бичвэр лүү хөрвүүлэх зорилготой юм. Ингэснээр бид хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн эрх тэгш оролцоог хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлж чадна.


Материал ба арга зүй

Хиймэл оюун ухааны нэг төрөл болох машин сургалтын аргуудыг (Transformer, Convolution neural network, You only look once, Hand tracking) ашиглан туршилтууд хийн үр дүн гаргав.

Үр дүн


YOLOv5 нь урьдчилан бэлдсэн олон төрлийн загвартай. Тэдний хоорондох ялгаа нь моделийн хэмжээ болон тооцоолол хийх хугацааны хоорондын зөрүү юм. Хөнгөн загварын YOLOv5s хувилбар нь ердөө 14MB боловч тийм ч нарийвчлалтай биш юм. Нөгөө талд бидэнд YOLOv5x байгаа бөгөөд хэмжээ нь 168 MB, хамгийн үнэн зөв хувилбар юм.

График 1.




YOLOv5s

График 2.



YOLOv5m

График 3.



YOLOv5l

Хүснэгт 1.

Model	metrics/precision	metrics/recall	F1 score
YOLOv5s	0.92692	0.93003	0.928472396
YOLOv5m	0.95634	0.94767	0.95198526
YOLOv5l	0.96469	0.95472	0.959679106

Hand Tracking(Гар илрүүлэх): Гар илрүүлэх модель нь бидэнд хоёр гарын 42 цэгийг дүрслэх X, Y ,Z тэнхлэгийн мэдээллийг өгснөөр эдгээр өгөгдлөөр transformer модель цагаан толгойн 34 үсэг болон 1-10 хүртэлх тоог сургасан үр дүнг харуулав. (Хүснэгт 1)

Схем 1. Архитентор





График 4. Confusion matrix



Хүснэгт 1. (Үр дүн)

<i>Precision</i>	<i>Recall</i>	<i>F1-Score</i>
0.864514	0.85438	85.42286

Дүгнэлт

Дохионы хэлний цагаан толгойн үсгийг таних хоёр үе шат бүхий туршилтууд хийгдсэн. Эхний туршилт цагаан толгойн хөдөлгөөнгүй тэмдэгтүүдийг YOLOv5 объект илрүүлэгч ашиглан хийсэн. Туршилтууд **F1-score=95.96%** гарч хангалттай сайн үр дүн харуулсан.

Хоёр дахь туршилтад хөдөлгөөнт үсэг сургах тул дараалсан утгын(sequential) модель ашиглана. YOLOv5-аас өгсөн bounding box-г дараалсан утгын модельд өгөх нь их хэмжээний тооцоолол шаардана. Иймд бидний зүгээс тооцооллыг бага байлгах нэгэн боломж нь моделийн оролтын хэмжээг цөөлөх юм. Hand tracking модель нь бидэнд хоёр гарын 21 буюу нийт 42 цэгийн x, y, z координатыг өгөх ухаалаг шийдэлтэй, оновчлол сайтай pre-trained модель тул бүтэн зурган өгөгдөлд боловсруулалт хийснээс олон дахин тооцоолол хэмнэж чадна. Тиймээс цагаан толгойн үсэг болон 1-10 хүртэл тоог онцлог цэгийн өгөгдөл болгон авч Transformer модельд сургаснаар **F1-score = 85.42%** оновчлолтойгоор дохионы хэлний

цагаан толгойн үсгийг бичвэрт хөрвүүлж зорилгодоо хүрэхэд нэг шат ахисан, мөн цаашдын бидэнд тулгарах хамгийн том асуудал нь өгөгдөл(dataset) цуглуулах болон монгол хэлний өгүүлбэрзүйн(NLP) модель сургах гэж үзэж байна.

Түлхүүр үг: *Дохионы хэл, машин сургалт, дүрс боловсруулалт*

Ашигласан материал:

1. ХБХХЕГ ТБ <http://www.gadpwd.gov.mn/index.php>
2. YOLOv5 by AyushExel <https://github.com/ultralytics/yolov5>
3. Mediapipe python сан <https://google.github.io/mediapipe/solutions/hands.html>
4. Continuous Sign Language Recognition: Towards Large Vocabulary Statistical Recognition Systems Handling Multiple Signers by Oscar Koller 2015 <https://www-i6.informatik.rwth-aachen.de/publications/download/996/Koller-CVIU-2015.pdf>
5. Indian sign language interpreter using image processing and machine learning by Shubhendu Apoorv 2020 <https://iopscience.iop.org/article/10.1088/1757-899X/872/1/012026/pdf>

МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ

Г.Чулуун-Эрдэнэ, Д.Насанханд¹
¹МУБИС, НХУС, АХТ
Chuluun-erdene@msue,edu.mn

Үндэслэл

НҮБ (1994) нь дохионы хэлийг харилцааны хэл, ЕХ (2016) бодлогод дохионы хэл, дохионы хэлний хэлмэрчийн талаар тушаал, шийдвэр хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй цөөнхийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, мэдээллийг хүртээмжтэй олж авах, хэлний хэрэглээг баталгаажуулснаар дохионы хэлний олон хэлбэр болох хэлмэрчлэх, хадмал бичвэр, аман хэлмэрчийг олон нийтийн үйл ажиллагаа, олон улсын хурал, чуулганд хэрэглэж эхэлснээр дэлхий нийтээр дохионы хэлэнд хандах хандлага өөрчлөгдөх нөхцөл болж байна. Монгол Улс “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)-д дохионы хэлний байр суурийг баталгаажуулж өгснөөр хүний үндсэн эрх, боловсрол олж авах эрхийг хангахад бодлого, зохицуулалтаар дэмжиж байгаагийн илрэл юм.

Зорилго

Сонсголын бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд ороход эх хэл болох дохионы хэлийг хэрхэн хэрэглэж буй хэлний хэрэглээг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Материал ба арга зүй

Баримт бичгийн судалгаанд хууль, эрх зүйн баримт бичигт дохионы хэлний хэрэглээг тусгасан заалтуудын агуулга, дохионы хэлтэн цөөнх бүлгийн хэлний хэрэглээг асуулгын аргаар авч үр дүнг боловсруулав.

Үр дүн

Монгол Улсын зургаан хууль, гурван бодлогын баримт бичиг, хоёр хөтөлбөрийн 40 гаруй заалтад дохионы хэлний талаар тусгаснаас 85 орчим хувь нь хэлний бодлогын хувьд хэл эзэмшихүй, хэлний хэрэглээтэй холбоотой заалтууд оржээ. Эрх зүйн механизмын хувьд хэлний эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хөтөлбөрт тусгасан нь бодлогын хувьд цогц болж гэж үзэхээр байна.

Судалгаанд оролцогчдоос дохионы хэлийг анх хэрхэн сурсныг тодруулахад 8% нь цэцэрлэг, 10% нь гэр бүл, 23% нь найз нөхөд, 48.7% сургуулийн орчинд сурсан хэмээн хариулсан нь тэдний эх хэл болох дохионы хэлийг хүүхдийн хөгжлийн эхэн үед заах сургалтын байгууллага хангалтгүй, дохионы хэлийг оройтож сурч байна гэж дүгнэлээ.

Хүснэгт1 Дохионы хэл ба бичгийн хэлний нийт хүрээ

Хэрэглэний хүрээ	бичгээр байнга	голдуу бичгээр	бичиг болон дохио хослуулан	голдуу дохио	дохионы хэлээр байнга	дохионы хэлмэрчийн тусламжтай	бичиг, дохионы хэлмэрч хослон	дохионы хэл болон хадмал бичиг
Албан харилцаа	13%	29%	6%	6%	16.5%	3.4%	1.7%	10.1%
ОНМХ	18%	18%	5,5%	6,4%	12,8%	9%	6%	-
Албан бус харилцаа	14.3%	12.8%	23.7%	12%	4,5%	12.8%	3.2%	13%
Дундаж	15%	20%	11.7%	8.1%	11.3%	8.4%	3.7%	7.7%

Дээрх гурван харилцааны хүрээнээс харахад сонсголын бэрхшээлтэй иргэд бичиг, дохио хавсран болон бичгийн хэлээр түлхүү нийгмийн харилцаанд орж байна. Тэдэнд эх хэл болох дохионы хэлээ хэрэглэх орчин нөхцөл бүрдээгүй, дохионы хэлтэй хэлмэрчийн хүрэлцээ хангамж байхгүй байгаагаас үүдэлтэй нийгмийн харилцаанд ороход хэл, соёлын бэрхшээл үүсэх, мэдээллийг хүртээмжтэй авч чадахгүй байх зэрэг олон асуудалтай тулгарч байна.

Дүгнэлт

1. Монгол дохионы хэлний хэрэглээг бодлогын баримт бичигт тодорхой тусгасан ч хүртээмжтэй хэрэгжихгүй байна. Ялангуяа мэдээлэл олж авах эрх хязгаарлагдмал байна. Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрч болон хадмал бичигтэйгээр дамжуулах шаардлагатай юм.
2. Дохионы хэлтэн цөөнхийн хувьд дохионы хэлээ хэрэглэх боломж, орчин бүрдээгүйгээс нийгмийн харилцаанд орохдоо харилцааны хэлбэрийн бүхий боломж (дохио-19.4%, бичгээр харилцах-35%, хэлмэрчээр туслуулах-19.4%, хуулийн дагуу итгэмжлэгдсэн хүнээр төлөөлүүлэх-10.1%, энэ бүгд-11%)-ийг ашигладаг нь судалгаагаар нотлогдов. Иймээс тэдний эрхийг хангах үүднээс төр захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах дохионы хэлний хэлмэрч болон дэвшилтэд аргыг хэрэглэх нь чухал байна.

Түлхүүр үг: дохионы хэл, хэлний хэрэглээ, нийгмийн харилцаа, сонсголын бэрхшээл

Ашигласан материал:

1. Улаанбаатар: Монгол Улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2016.02.05
2. БСШУЯ. (2018). *Боловсролын статистик: 2017-2018*. Улаанбаатар: Эд маркет.

3. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (2019) Хүний эрх: онол арга зүйн
4. ХННЯ. (2020). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. Улаанбаатар.сэтгүүл №2,
5. Чулуун-Эрдэнэ, Г (2020). Монгол дохионы хэлний нөхцөл байдал, макро түвшний хэрэглээ. Хэрэглээний хэл шинжлэл, Боть V/20/, 143-154х Улаанбаатар: Соёмбо принтинг

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ СТАНДАРТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ

П. Чулуунчимэг¹

¹ МУИС-Хууль зүйн сургуулийн V курсын оюутан
chuluunchimeg@gmail.com

Хураангуй

Монгол улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасны дагуу төрөөс иргэн бүр нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжоор хангах үүрэгтэй. Мөн уг салбарын гол хууль болох Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.1-т “Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна” гэж заасныг хэрэгжүүлэх боломжит бүхий л нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Гэвч **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 10.2-т заасны дагуу баталсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 стандартын 5.8.1, 7.2.1 дэх** заалтууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг ноцтой зөрчиж байгаа юм.

Зорилго

Уг судалгааны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас тогтоож буй хууль, дүрэм, журам, стандарт, хариуцлагын хэмжээ, эрх зүйн үндэслэл, тэдний хэрэгжилтийн механизм, хэрэгжих бодит нөхцөл боломжийг судлах замаар эрх зүйн орчныг сайжруулах арга замыг боловсруулахад түлхэц өгөх

Материал ба арга зүй

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр гарсан хууль, стандартуудад агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.3-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсроход ... иргэн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ” гээд: 6.3.1-т **“нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх”** гэж нийтийн тээврийн үйлчилгээнд тэгш хамрагдахгүй байх нөхцөлийг ялгаварлан гадуурхалт болохыг тогтоож хуульчилсан байна. Мөн Хуулийн дээрх заалтын дагуу баталсан **“Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 Стандартын 5.8.1-т** “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ... нийтийн тээврийн

хэрэгсэлд орох ба буух, суух, зорчих үед нь жолооч, кондуктор, бусад зорчин явагчид анхаарал тавьж тусална” гэж заасан.

Уг заалтын хувьд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйлд тус харилцаанд баримтлах нийтлэг зарчмуудын нэг болох “сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, эрхэм чанар, **хувийн хараат бус байдлыг хүндэтгэх**” зарчим ба Монгол улсын Үндсэн хуулиар олгогдсон тэгш байдлын зарчим агуулгаараа зөрчигдөж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрийн аливаа үйл ажиллагаа, өдөр тутмын амьдралаа бие даан, хэнээс ч хараат бусаар удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн хамгаалалтын гол зорилго оршиж байгаа юм. Гэвч ийнхүү стандартчилсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн дангаар өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, хувийн төлөвлөгөө гаргах, хэнээс ч хараат бусаар амьдрахад хязгаарлалт болж байгаагаас гадна хэний оролцоо, тусламжгүйгээр хувийн амьдралаа үргэлжлүүлэх боломжийг төрөөс бүрэн дүүрэн бүрдүүлэх үүргээсээ татгалзаж, бусад иргэдэд нялзааж байгаа хэлбэр юм. Мөн түүнчлэн бусад иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслахыг үүрэгжүүлж чадахгүй бөгөөд ийм эрх зүйн боломж/жишээ нь, туслаагүй гээд шийтгэх нь зохисгүй учир/ ч байхгүй юм. Иймд тус стандартын энэ заалт нь хууль зөрчиж байгаа юм.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэвэл “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 стандартын 5.8.1, 7.2.1-т заасан заалтууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг ноцтой зөрчиж байгаа юм. Мөн Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд “нийтийн тээврийн үйлчилгээ, тавигдах шаардлага”-ыг зөрчсөнөөс үүдэн хариуцлага хүлээлгэх асуудал хуульчлагдаагүйгээс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 10.2-т заасан стандартуудыг зөрчсөнтэй холбоотой асуудал хариуцлагын гадуур үлдэх, хариуцлагын механизм хэрэгжихгүй байх бодит боломж бүрдэж байгаа ба энэхүү хариуцлагын асуудал ердөө 3 заалтаар зохицуулагдаж буй нь хариуцлагын асуудлыг маш хайнга бөгөөд өргөн хүрээнд авч үзэж байгаагийн илрэл бөгөөд энэ нь нарийвчилсан, тусгай харилцаанд хуулийн хариуцлага ногдуулах, гэм буруугийн хэмжээнд тохирсон хариуцлага ногдуулах асуудлыг сулруулж байгаа юм.

Түлхүүр үг: *Нийтийн тээврийн автобус, Монгол улсын стандарт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн автобусаар үйлчлүүлэх эрх*

Ашигласан материал:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” НҮБ-ийн конвенц
2. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
4. Авто тээврийн тухай хууль
5. “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 стандарт

МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Шинэцэцэг, Т.Бямбацэрэн¹

²Хараат бус судалгааны хүрээлэнгийн судлаач нар

Үндэслэл

Хэвлэл мэдээлэл бол хүмүүсийн итгэл үнэмшил, санал бодол, хандлагыг төлөвшүүлэхэд болон төр, засгийн шийдвэрт нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгэм дэх аливаа асуудлын талаар хэвлэл мэдээлэлд нийтэлж мэдээлэх нь уг асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулж, нийгэм улс төрийн хүрээнд шийдвэрлэвэл зохистой чухал сэдвүүд болгон тавьдаг. Ингэхдээ хэвлэл мэдээлэл нь нийгэм, соёлын цөөнхийн бүлгүүдэд өөрсдийгөө илэрхийлэх **тэгш боломж олгох**, янз бүрийн сонирхол, янз бүрийн **үзэл бодлын индэр болох**, хэрэглэгчдийнхээ эрэлт, сонирхолд нийцүүлэн тухайлсан асуудлаар агуулгын **сонголт хийж болох** боломжийг бүрдүүлэх гэжээ.

Зорилго

Монголын үндэсний олон нийтийн телевизийн мэдээний хөтөлбөр, өдөр тутмын сонинд мониторинг хийж үнэлгээ өгөх зорилготой.

Материал ба арга зүй


Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд шинжилгээ хийхдээ социологийн тоон болон чанарын судалгааны арга болох контент анализын аргаар хийсэн бөгөөд шалгуур үзүүлэлтүүдээ Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим, Америкийн сэтгүүл зүйн зарчим, Олон улсын сэтгүүлчдийн холбооны тунхаглал, Радио телевизийн мэдээллийн агентлагуудын захирлуудын холбооноос гаргасан сэтгүүлчдийн ёс зүйн дүрэм зэргээс үндэслэж боловсрууллаа. Арга зүй ойлголтын зөрүүтэй байдлаас сэргийлж хувьсагч буюу шалгуур үзүүлэлтүүдээ тоон хэлбэрээр илэрхийлэхийг зорьсон.

Үр дүн

МҮОНРТ мэдээний хөтөлбөрт хийсэн мониторингийн үр дүн: МҮОНРТ-ийн оройн 20:00 цагийн 351 нь мэдээний хөтөлбөрт (нэг жилээр) мониторингийг хийж гүйцэтгэлээ. 2020 оны 11-сарын 1-с 2021 оны 11 сарын 1-ны хооронд оройн мэдээний хөтөлбөрт 346 цагийн эфир цацагджээ. Мониторингийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах 22 сэдвийн мэдээ цацагдсан бөгөөд энэ нь нэг жилийн хугацаанд 1413 секунд буюу 23.5 минутад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг талаар мэдээлжээ. Нэгж мэдээний үргэлжлэх дундаж хугацаа 64.2 секунд байна. “ОНРТ”-ийн хуулийн 8.2.7-д үндэстний цөөнх, эмэгтэйчүүд хүүхэд, **хөгжлийн бэрхшээлтэй** иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх хэмээн заасан байдаг.

Гэвч МҮОНРТ-ийн нэг жилийн хугацаанд 346 цагийн мэдээний хөтөлбөрт 1 цаг хүрэхгүй хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар дурдаж байна. 2020 оны 1;2;9 сар, 2021 оны 1;2;3;4;5;7 саруудад хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар мэдээлэл огт дурдагдаагүй бөгөөд энэ нь хэвлэл мэдээлэл ба нийгмийн олон тал онолын үүднээс тухайлсан нийгмийн асуудал бүр дээр агуулгын сонголт хийж мэдээлэл авах боломжийг хязгаарлаж буй хэрэг юм. Мэдээний эрэмбэ, дараалал, хөтөлбөрийн бүтэц дэх мэдээний байршилд төдийлөн ялгаа ажиглагдаагүй. Сэтгүүл зүйд аливаа мэдээллийг 2 ба түүнээс дээш эх сурвалжаар баталгаажуулах стандарт тавьдаг. Дээр дурдсан 22 сэдвийн мэдээллийг эх сурвалжаар харвал 50 % буюу 11 нь мэдээ 1 эх сурвалжтай байна. Эх сурвалжийн төлөөллийн хувьд тухайлсан сэдвийн хүрээний асуудал учир холбогдох эх сурвалжуудыг зураг 2 харуулснаар дурджээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл хүргэхдээ дор хаяж 1 эх сурвалжтай, эх сурвалжийн төлөөлөлтэй, төлөөллийг нэрлэсэн байгаа нь сайшаалтай хэдий ч мэдээний төрлийн хувьд 77.2 % д буюу 17 мэдээнд мэдээллийг зөвхөн мэдээ хэлбэрээр хүргэж байна. Мэдээллийн хөтөлбөрт тухайн сэдвийн талаар фото болон шууд сурвалжлаг, тухайн мэдээнд өртөж буй гол дүрийн ярилцлага, үзэл бодол, шүүмж гэх мэт олон төрлөөр мэдээлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголт хандлагыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй юм. Мэдээний сэдвийн хувьд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээлэл дийлэнх хэсгийг эзэлж байгаа бөгөөд сэдэв агуулгаас хамаарч нэгж мэдээний үргэлжлэх хугацаанд ялгаа байхгүй байна.

Өдөр тутмын сонинд хийсэн мониторингийн үр дүн: 2020 оны 11 сарын 1-с 2021 оны 11 сарын 1-ны хооронд өдрийн сонины 216 дугаарт, өнөөдөр сонины 223 дугаарт мониторингийг хийж гүйцэтгэлээ. Өнөөдөр сонины хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нэг жилийн турш 10 нийтлэл, өдрийн сонины хувьд 26 нийтлэлд дурдагджээ. Үүнийг сонины нийт дугаарт эзлэх хувиар схем 1-д харуулав.



Схем 1. Өдөр тутмын сонинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нийтлэж буй байдал, хувиар

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл сонинд эзлэж буй хэмжээ, см2

Нийт сонин см2/цаасны Хэмжээ		Дундаж хуудасны тоо	Сонины нийт см2	ХБ-г дурдсан см2/ цаасны хэмжээ		Сонинд эзлэх ХБ-н хувь
2494.8	A2	20	49896	239.4	A5	0.48
2494.8	A2	12	29937.6	1247.4	A3	4.17

Дүгнэлт

Олон нийтийн санал бодлыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээлэл онцгой үүрэгтэй. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл хараат бус, өөрөө тодорхой хариуцлага хүлээдэг, олон ургалч байж ардчиллыг дэмждэг. Сонгон авсан хоёр сонин аль аль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл маш бага түгээдэг. Мөн түүнчлэн олон эх сурвалжаас мэдээллээ хүргэдэггүй байна. Өнөөдөр сонин нь төсөл хөтөлбөрийн хүрээнд л мэдээлэл дамжуулдаг бол бусад үед нийгмийн дэмждэг шаардлагатай бүлгийн талаарх мэдээллийг огт түгээдэггүй байна. Төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа шигээ тогтмол мэдээлэл хүргэж чадах юм бол мэдээллийн тэнцвэртэй найдвартай байдал нэмэгдэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дүрслэн харуулахдаа голдуу тэргэнцэр дээр суусан болон тэмдэгт зургийг ашигласан. Нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхийг илүү тусгасан байгаа нь бидний гол анхаарах ёстой зүйл юм. Мөн түүнчлэн нийтлэл бүрд тухайн уншигч хүнд тогтсон нэр томъёо хэвшмэл ойлголтыг үлдээдэг байна. Цаашид МҮОНРТ жилийн нийт мэдээний хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээгээ нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг зөвхөн мэдээ хэлбэрээр биш мэдээний төрөл зүйл бүрийг ашиглах, өдөр тутмын сонинууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл хүргэж буй дугаарынхаа тоог нэмэгдүүлэх, тухайн мэдээний агуулаг, цаг хүрээтэй нийтлэлийнхээ эзэлж буй талбайг уялдуулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, МҮОНРТ, өдөр тутмын сонин, хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Ашигласан материал:

1. Д.Оюунцэцэг. (2010). *Олон нийтийн санаа бодлын социологи.*
2. Хэвлэлийн хүрээлэн. (2018) *Монголын үндэсний олон нийтийн телевизийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг.* Улаанбаатар хот.

ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМД ОРОЛЦОХ ОРОЛЦОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Н.Алтжин¹ /b18fa1326@ufe.edu.mn/

А.Гарамням¹ /b18fv1109@ufe.edu.mn/

Э.Номуундарь¹ /b18ft1117@ufe.edu.mn/

Э.Энэрэл¹ /b18fa1224@ufe.edu.mn/

¹Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

Үндэслэл

Дэд бүтцийн нэг хэсэг болох Монгол улсад баригдаж буй олон нийтээр ашиглах барилга, байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг тодруулах зорилго тавилаа. "LEAD MONGOLIA" хөтөлбөрийн зүгээс хэрэгжүүлж буй "Хүртээмжтэй хот - City for all" төслийн судалгааны үр дүнд үндэслэн УБ хотын 6 дүүргийн хүний хөдөлгөөн ихтэй газруудад байрлах 2000 орчим барилга байгууламжийн мэдээллийг цуглуулан стандарт хангасан байдлаар нь бүрэн хангасан, дутуу хангасан, хангаагүй гэсэн 3 үнэлгээгээр үнэлж, ангилав. Ийнхүү үнэлгээг хийх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ирээдүйн хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэд бүтцийн зохион байгуулалтыг хийхэд нэн чухал нөлөөтэй.

Зорилго

Жил ирэх бүр олноор баригдаж буй олон нийтийн зориулалттай барилга, байгууламж, явган хүний зам, талбай буюу дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, стандартын дагуу баригдсан эсэхийг тодруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Материал ба арга зүй

МИНУ газрын зураг, ХБХХЕГ, ХНХЯ болон ҮСХ-ны зүгээс хийсэн судалгааны тайлан, илтгэл, нийгмийн сүлжээн дэх мэдээллүүдэд шинжилгээ хийж, үр дүнг боловсруулав.

Үр дүн

Нийт барилга байгууламжуудыг үнэлэхдээ тэргэнцэртэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан байдлыг голчлон авч үзсэн ба стандарт хангасан эсэхийг үнэлэхийн тулд налуу зам, хаалга, босго, цахилгаан шат, ариун цэврийн өрөө гэсэн 5 шалгуур үзүүлэлтүүдийг тооцож авсан болно.

Судалгааны дүнгээс харахад газрын зураг дээр тэмдэглэгдсэн, үнэлгээ хийгдсэн барилга байгууламжийн ердөө 6.3 хувь нь тэргэнцэртэй иргэдэд зорчих боломжтой, стандартыг бүрэн хангасан барилга байгууламж гэж гарсан бол 39 хувь нь стандартыг дутуу мөрдсөн, харин үлдсэн 54.6 хувь нь зорчих боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй стандартын бус байгаа барилга байсан нь харагдаж байна.

Стандартыг дутуу мөрдсөн болон огт стандарт хангагдаагүй барилга байгууламжийн дийлэнх хувь нь худалдаа үйлчилгээ болон боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламж байсан нь эргээд

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оролцож чадахгүй байх, бие даасан бус бусдаас хараат байх зэрэг сөрөг үр дагавруудыг авчрах гол хүчин зүйлийн нэг болж байна. Хөгжихөд эрүүл мэнд, бие махбодийн хувьд бэрхшээл байгаа хэдий ч хүрээлэн буй орчны хүртээмжгүй байдал нь хөгжих хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх итгэлээ алдахад хүргэж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнг нэгтгэн харахад Монгол улсын барилга байгууламж, олон нийтийн талбай, зам нь нийт иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал муу, хууль тогтоомжид заасан стандарт, шаардлагыг хангаж чаддаггүй. Төр засгийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслүүдийг санаачилж, хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хотын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч чадахгүй байна.

Нийт барилга байгууламжийг орон сууц болон орон сууцны бус гэж 2 ангилсан. Орон сууцны бус зориулалттай барилга байгууламжид явуулдаг үйл ажиллагаагаар нь эмнэлэг, сургууль цэцэрлэг, үйлчилгээ, соёлын, төрийн байгууллага гэж ялган судалгааны үр дүнг авч үзсэн. Судалгааны үр дүнгээс харахад дийлэнх барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчиход хүндрэлтэй стандартад нийцээгүй байгаа нь иргэд эрхээ эдэлж чадахгүй байгааг харуулж байна. Иргэдэд хамгийн ойр байж, хөгжихөд нь туслах, дэмжлэг үзүүлэх ёстой эмнэлэг, сургууль, төрийн байгууллагын стандартыг хангасан байдал маш бага үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт 2014 барилгын ердөө 127 барилга нь стандартыг хангасан гэж гарчээ.

Иймд өмнө нь баригдсан барилгуудыг стандарт нийцүүлэн дахин тохижилт засварын ажлыг хийх, ирээдүйд баригдах барилгын зураг төслийг шаардлагад нийцүүлж, шаардлагад нийцээгүй барилгын зураг төслийг түдгэлзүүлэх, улсын комиссоос хүлээж авахгүй байх арга хэмжээг авч хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг эдлүүлэх, хамгаалах тал дээр анхааран ажиллах хэрэгтэй. Хүртээмжтэй байдал нэмэгдэж иргэд бусдаас хараат бус, бие даасан байх нь цаашлаад

ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны төвшнийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

График 1. Улаанбаатар хотын барилга байгууламжийн стандарт хангасан байдал



Түлхүүр үг: Хот байгууламж, стандартын хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлт

Ашигласан материал:

[1]. Аиди, М. (2017). *Газрын зураг*. <https://map.minu.mn/?c=47.92919:106.93679:16&fbclid=IwAR0ZUQcly5VlBMoUAxUqIMfGSoq6xXlOrGY3lwWk4jrAmnMA7hzZPwLqXoo-ээс> Гаргасан

[2]. яам, Б. х. (2020). *Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл*. Барилга хот байгуулалтын яам: https://mcis.gov.mn/storage/uploads/process/file_1622742897446443_162126263699813.pdf-ээс Гаргасан

[3]. Г.Өлзийхутаг. (2020 оны 1 24). *Хүртээжгүй хот төлөвлөлт ба "Хөгжлийн бэрхшээлтэй" барилгууд*. Ikon.mn: <https://ikon.mn/opinion/1rzo-ээс> Гаргасан

[4]. М.Алтансүх. (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт*. Улаанбаатар: Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам.

(2020). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа*. Улаанбаатар хот: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

[5]. Хөдөлмөр, н. х. (2019). *Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн хууль зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал*. <https://www.unescap.org/sites/default/files/3.3%20Social%20Inclusion%20in%20Infrastructure%20Development.pdf>-ээс Гаргасан

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ НЬ АМЖИЛТАД ХҮРЭХЭД СААД БОЛОХ ЁСГҮЙ

Б.Энхболд¹

¹ Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн зохицуулагч,
цагдаагийн ахлах дэслэгч

Үндэслэл

Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа бөгөөд бараг 200 сая хүн үйлдлийн бэрхшээлтэй амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлийн тархалт жил ирэх тусам ихэс ч байгаа учир энэ асуудал бүх нийтийн анхаарлын төвд байх болно. Энэ нь хүн ам өндөр настай болж хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өс ч, мөн чихрийн шижин, зүрх судасны өвчин, хавдар, сэтгэцийн эрүүл мэндийн өвчин гэх мэтийн эрүүл мэндийн архаг нөхцөл байдал дэлхий дээр өс ч байгаатай холбоотой. Дэлхий дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, боловсролд хамрагдалт хангалтгүй, эдийн засгийн оролцоо бага байгаа зэрэг нь хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс илүү ядууралд өртөх шалтгаан нь болж байна. Бидний байнга авч байдаг эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, тээвэр, мэдээлэл зэрэг үйлчилгээг авахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад бэрхшээл учирдаг. Энэ бэрхшээл нь анхаарлаас гадуур байгаа хүмүүст илүү хүнд тусдаг байна. Хөгжлийн бэрхшээл нь хүн төрөлхтний нэгэн нөхцөл байдал юм. Бараг хүн бүр амьдралынхаа тодорхой нэг хэсэгт түр хугацаагаар эсвэл байнга хөгжлийн бэрхшээлтэй болдог. Өндөр настай хүмүүсийн үйлдэлд /функц/ бэрхшээл тулгарах нь элбэг байдаг. Хөгжлийн бэрхшээл нь иж бүрэн цогц асуудал юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтэц, хүртээмжид үнэлгээ хийж, нөхцөл байдлыг тодруулах

Материал ба арга зүй

Баримт бичиг болон бодит тоон мэдээлэл анализ хийв.

Үр дүн

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх зориулалт бүхий нийтийн тээврийн хэрэгсэл бараг байхгүйтэй адил зөвхөн суусан үед байрлах хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэд зориулсан хэсэг эсвэл сандал л байгаа болохоос тэргэнцэртэй хүн хэрхэн нийтийн тээврийн хэрэгсэлд нэвтрэх нь ойлгомжгүй байна. Одоогоор манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулагдсан нийтийн тээврийн такси 1 ширхэг, нийтийн тээврийн автобус 2 ширхэг байгаа нь бид тэдэнд ямар ч ээлгүй хандаж байгаа нь үүнээс харагдана. Мөн үүнтэй холбоотой бас нэгэн чухал асуудал нь зорчих орчныг бүрдүүлж өгөх нь нэн тэргүүн чухал асуудал юм.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тандалт судалгааны багаас

жил бүр гаргадаг судалгаанаас харахад 2020 оны осол гэмтлийн шинэ тохиолдлын тэргүүлэх 5 шалтгааны нэг нь зам тээврийн ослоос үүдэлтэй осол гэмтэл эзэлж байна. 2020 оны судалгаанд зам тээврийн ослын улмаас нийт 18306 хүн гэмтэж бэртсэн гэсэн тоо мэдээ гарсан, түүнчлэн насны бүлгээс хамааран осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан өөр өөр байдаг. Жишээ нь: Бүх насанд уналт 1-р шалтгаан болж байна. Мөн 5 хүртэлх насанд түлэгдэлт, 5-9, 15-24, 30-49 болон 70+ насанд амьгүй механик хүчинд өртөх 2-р шалтгаан болж байгаа бол 25-39 насанд хүчирхийлэл, 10-14, 50-69 насанд зам тээврийн осол дэд байрт орж байна.

Эндээс харахад зам тээврийн ослын улмаас гэмтэж бэртэж байгаа тохиолдол ихсэх хандлагатай байгаа нь энэхүү статистик тоо мэдээллээс харагдаж байна.

Өдөрт дунджаар зам тээврийн ослын дуудлага мэдээлэл 300-400 ирж үүнээс зам тээврийн ослын холбогдолтой дуудлага мэдээлэл 200-300 бүртгэгдэж ослын улмаас 5-8 хүн улсын хэмжээнд гэмтэж бэртэж байгаа нь өөрөө маш их эрсдэлийг дагуулж байна. Энэ оны эхний 10 сарын байдлаар гэхэд зам тээврийн ослын холбогдолтой дуудлага мэдээлэл улсын хэмжээнд 57745 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4.7 хувь өссөн, бүртгэгдсэн зам тээврийн осол 16721 гарч өмнөх оны мөн үеийнхээс -9.5 хувь буурсан, ослын улмаас гэмтсэн хүн 1933 бүртгэгдэж өмнөх оноос

Хүснэгт 1. Осол гэмтлийн тэргүүлэх 8 шалтгаан

Насны бүлэг	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4 нас n=20189	Уналт 44.9%	Түлэгдэлт 17.9%	Амьгүй механик хүчинд өртөх 14.4%	Амьд механик хүчинд өртөх 10.5%	Тодорхойгүй 6.7%
5-9 нас n=12947	Уналт 53.1%	Амьгүй механик хүчинд өртөх 16.3%	Зам тээврийн осол 10.5%	Амьд механик хүчинд өртөх 10.5%	Түлэгдэлт 4.4%
10-14 нас n=10833	Уналт 49.3%	Зам тээврийн осол 16.4%	Амьгүй механик хүчинд өртөх 15.2%	Амьд механик хүчинд өртөх 10.6%	Хүчирхийлэл 2.8%
15-19 нас n=9830	Уналт 39.8%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	Зам тээврийн осол 16.2%	Хүчирхийлэл 9.1%	Амьд механик хүчинд өртөх 8.1%
20-24 нас n=11611	Уналт 32.4%	Амьгүй механик хүчинд өртөх 23.2%	Зам тээврийн осол 15.9%	Хүчирхийлэл 14.5%	Амьд механик хүчинд өртөх 6.3%
25-29 нас n=13387	Уналт 31.9%	Хүчирхийлэл 21.7%	Амьгүй механик хүчинд өртөх 18.2%	Зам тээврийн осол 14.2%	Амьд механик хүчинд өртөх 5.5%
30-34 нас n=14807	Уналт 33.8%	Амьгүй механик хүчинд өртөх 20.6%	Хүчирхийлэл 17.8%	Зам тээврийн осол 13.6%	Амьд механик хүчинд өртөх 4.9%
35-39 нас n=11358	Уналт 33.2%	Амьгүй механик хүчинд өртөх 21%	Хүчирхийлэл 17.2%	Зам тээврийн осол 14.5%	Амьд механик хүчинд өртөх 4.8%
40-44 нас n=9530	Уналт 34.6%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	Хүчирхийлэл 15.2%	Зам тээврийн осол 14.5%	Амьд механик хүчинд өртөх 5.1%
45-49 нас n=8130	Уналт 38.6%	Амьгүй механик хүчинд өртөх 17.1%	Зам тээврийн осол 14.8%	Хүчирхийлэл 13.3%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
50-54 нас n=7231	Уналт 43.3%	Зам тээврийн осол 14.9%	Амьгүй механик хүчинд өртөх 14.9%	Хүчирхийлэл 10.5%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
55-59 нас n=5974	Уналт 49.1%	Зам тээврийн осол 13.5%	Амьгүй механик хүчинд өртөх 13.4%	Хүчирхийлэл 8.2%	Амьд механик хүчинд өртөх 5.7%
60-64 нас n=4115	Уналт 55.5%	Зам тээврийн осол 12.4%	Амьгүй механик хүчинд өртөх 11.8%	Амьд механик хүчинд өртөх 5.9%	Хүчирхийлэл 4.9%
65-69 нас n=2113	Уналт 60.9%	Зам тээврийн осол 11.2%	Амьгүй механик хүчинд өртөх 9.4%	Амьд механик хүчинд өртөх 5.8%	Хүчирхийлэл 3.6%
70+ нас n=3442	Уналт 70.6%	Амьгүй механик хүчинд өртөх 7.9%	Зам тээврийн осол 6.8%	Амьд механик хүчинд өртөх 4.1%	Тодорхойгүй осол 3.5%

-19.6 хувь буурч, хэргийн улмаас 625 хүн гэмтсэн гэсэн судалгаа гарсан байна. Энэхүү тоо мэдээллээс харахад манай улсад хэчнээн хүн зам тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа вэ гэдэг судалгааг гаргах нь зайлшгүй нөхцөл шаардлага тулгарч байна.

Хүснэгт 1.

гэх мэт.

Дүгнэлт

Энэхүү илтгэлийн дүгнэлтэд 2 асуудлыг тавьж шийдэх гарц хууль эрх зүйн орчинд хийх шаардлагатай

байгаа мөн дэд бүтцийн асуудал ямар байгаа нь яаж шийдвэл оновчтой үр ашигтай болох талаар судалгааны ажлаа гол болгон чиглүүлсэн.

1. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд бүтцийн асуудал маш хангалтгүй байгаа бөгөөд хууль эрх зүйн орчинд тусгаж өгсөн хэдий ч хэрэгжилт гүйцэтгэл яг газар дээрээ байхгүй байна. Хамгийн наад захын асуудал тээврийн хэрэгслийн асуудал тэр дундаа нийтийн тээврийн асуудал маш хангалтгүй байна. Хэдийгээр хууль эрх зүйн орчиндоо тусгаж өгсөн хэдий ч хэрэгжихгүй байгаа нь харамсалтай байна.

2. Төрийн байгууллага хоорондын уялдаагүй байдлаас болж зам тээврийн осол хэргээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болж хохирч үлдэж байгаа иргэдийн судалгааг хийдэггүй байгаа нь учир дутагдалтай байна.

Шийдэж болох саналууд

- Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэл хийгдэж улсын хөрөнгөөр худалдан авалт тендерийн асуудал шийдэгддэг энэ тал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих, бууж, суух бүх нөхцөлийг хангасан худалдан авалт хийх шаардлагатай байгааг дээрх судалгаан дээр үндэслэх.

- Такси үйлчилгээ хувийн компаниуд эрхлэн явуулдаг ч тэдний зөвшөөрөл үйлчилгээг төрийн байгууллага хариуцдаг учир мөн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай тоноглол бүхий таксийг үйлчилгээнд нэвтрүүлэх шаардлагатай байна.

- Тээврийн цагдаагийн албаны мэдээлэл судалгааны тасаг нь зам тээврийн улмаас гэмтэж бэртэж байгаа хүмүүсийн тоо судалгааг хөтөлдөг. Ослын улмаас гэмтэж бэртэж байгаа иргэн гэмтлийн эмнэлэг дээр очиж тэнд зам тээврийн ослын улмаас гэмтсэн гэсэн тоо судалгааг гаргадаг. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл судалгааг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам хариуцаж хийдэг ч зам тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон гэсэн судалгаа байхгүй байна. Иймд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах үүднээс энэ төрлийн нарийвчилсан шалтгаан нөхцөлийн судалгааг хийх шаардлагатай байгаа болно.

Түлхүүр үг: Саад бэрхшээл, хүртээмж, дэд бүтэц

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
2. Гэмтэл согог үндэсний судлалын төвийн статистик тоон мэдээлэл, 2020 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоон мэдээлэл, 2020 он

ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДЭХ АРГА ЗАМ

Б.Хулан¹

¹ Дотоод хэргийн их сургуулийн багш, цагдаагийн ахлах дэслэгч
khulan0806@gmail.com

Б.Отгонбат²

²Цагдаагийн ажил эрх зүй 2 жил 3222-р дамжааны сонсогч
botgonbat882@gmail.com

Үндэслэл

Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх түүний дотор чөлөөтэй зорчих эрх нь гадны орнуудад техник технологи хурдацтай хөгжиж байгаа өнөө үед маш сайн хангагдаж байгаа тухайн улс орнуудад өөрийн орны тухайн иргэдэд үзүүлэх үйлчилгээ нь манай орныхоос хангалттай илүү байна. Монгол Улсад хөгжлийн бэрхшээл нь хүн дээрээ дээрх тодорхойлолтоор тодорхойлогдож байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох оролцоо нь харьцангуй бага, муу байна. Үүнийг сайжруулахын тулд тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахилгаан автомашин бүтээж, нийгмийн хэрэгцээнд гаргах шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү автомашиныг хэрэгцээнд гаргаснаар тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд алслагдмал дүүргээс өөрөө өөрийгөө зөөвөрлөж нийгмийн амьдралд оролцох боломжтой болох юм.

Зорилго

Энэхүү автомашин нь монгол оронд оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд дундаа тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн нийгэм болон өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагт Монгол оронд амьдарч ажиллаж байгаа, мөн тулгуур эрхтнээ алдсанаас болон нийгэмд оролцож чадахгүй байгаа өнөө үед тэрхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, мөн гадаадад үнэ өртөг ихтэй тэргэнцэртэй хүн унах боломжтой автомашиныг Монгол орны хувьд үйлдвэрлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дотооддоо гадаадын үнэ бүхий тэдгээр автомашиныг үйлдвэрлэх боломж, тэргэнцэртэй иргэд замын хөдөлгөөнд оролцон амьдрах хүсэл тэмүүлэл нь улам нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлт ч мөн дагаад өсөх боломжтой бөгөөд ажилгүйдэл багасаж, бусдад хүндрэл чирэгдэл учруулахгүй, бусдын хараа хяналтгүй хөдөлгөөнд оролцох боломжтой болно гэж үзсэн.

Энэхүү илтгэлийн зорилго нь хөдөлгөөний хязгаарлалттай болон тэргэнцэртэй иргэдийн ажиллаж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлж, тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэр дундаа чөлөөтэй зорчих эрхийг хангаж тэдгээрийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх, хүний туслалцаагүйгээр өөрөө ажилруугаа автомашин жолоодон явах боломжтой болгох явдал юм.

Үр дүн

Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чөлөөтэй зорчих эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал,

шийдэх арга зам сэдвийн хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, түүний дотор чөлөөтэй зорчих эрхийг хангахын тулд эхний ээлжид уг эрхийн хэрэгжилтийн тухай нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоомж, дүрэм журамд хуульчлан зааж өгөх.
2. Уг эрхийг хангахын тулд тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан цахилгаан машиныг бүтээх, турших, нийгмийн хэрэгцээнд гаргах. /Энэхүү цахилгаан машиныг ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсогч Б.Отгонбат зохион бүтээсэн бөгөөд холбогдох мэдээллийг хавсралтаас харах боломжтой.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулан үздэг тухай дурдсан ба үүний нэг төрөл болох тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй орчин буюу эргэн тойрны нийгэм, ахуй байдлын нөхцөл, төлөв хийгээд эдгээр нөхцөлийн нийтлэг зүйлээр холбоо бүхий хүмүүсийн цогц нь эрүүл, аюулгүй байх үндэс нь байгаль орчноос гадна засаг төрийн дэглэм, нийгмийн хэв журам зэрэг нийгмийн орчноос хамаарах тухай үзсэн ба энэ эрх нь тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрхэн хэрэгжиж байгаа тухай, мөн энэхүү эрх хэрэгжихэд ямар асуудлууд тулгамдаж байгаа тухай авч үзлээ.

Техник, технологи хурдацтай хөгжиж байгаа өнөө үед энэхүү автомашин нь манай улсад оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дундаа тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн нийгэм болон өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагийн хэлхээнд амьдарч ажиллаж, тулгуур эрхтнээ алдсанаас болоод нийгмийн харилцаанд заавал бусдын тусламжтайгаар оролцож байгаа хүмүүсийн хувьд тэрхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

Мөн гадаадын улс, орнуудад өндөр үнэ, өртөгтэй байдаг тэрхүү тэргэнцэртэй хүн унах боломжтой автомашиныг өөрийн орны хувьд үйлдвэрлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дотооддоо гадаадын үнэ, өртөг бүхий тэдгээр автомашиныг хямд зардлаар өөрсдөө үйлдвэрлэх боломж ийнхүү байгаа нь тэргэнцэртэй иргэд замын хөдөлгөөнд оролцож улмаар тэдний амьдрах хүсэл тэмүүлэл нь улам нэмэгдэж түүнтэй холбоотойгоор тухайн иргэдийн хөдөлмөр эрхлэлт өсөх боломжтой бөгөөд ажилгүйдэл буурч улмаар бусдад хүндрэл чирэгдэл учруулахгүй, бусдын хараа хяналтгүй бие даан нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцох боломжийг бий болгож өгснөөрөө чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: *Тэргэнцэр, техник, технологи, автомашин, хөдөлмөр эрхлэлт*

Ашигласан материал:

1. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮР ДҮН (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

Э.Мөнхжин, Г.Цовоодаваа¹

¹ ШУТИС

munkhjinet@must.edu.mn

Үндэслэл

Улаанбаатар хотод социализм задран унасны дараа нийгэм эдийн засаг, хот байгуулалтын бодлогод өөрчлөлт гарсан. Монголд социализмын өөрчлөлтөөс хойших 90-ээд оноос хойш хөдөөгөөс Улаанбаатар хот руу шилжих шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж, гэр хороололд асар их өсөлт гарч нийгэм, байгаль орчны асуудал үүсгэсэн. Албан бус суурьшил буюу гэр хороолол нь 90-ээд оноос хойш хот суурин газрын тэлэлт болон тархай бутархай болсон ч Улаанбаатар хотод 18-р зуунаас орон зайн хэлбэр нь эхэлсэн. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд “Гэр хорооллын дахин хөгжүүлэх төсөл” нэртэй хөтөлбөрүүд сүүлийн 20-иод жил нэр нь өөрчлөгдөн агуулга нь сайжран үргэлжилсэн ч яг хэрэгжилт дээр төрийн оролцооноос илүү хувийн аж ахуй нэгжүүд болон хувь хүмүүс хоорондоо тохиролцон барилга байгууламж барин одоогийн орон зайн нөхцөл байдлыг үүсгээд байгаа билээ. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын гэр хороолол нэртэй суурьшлын бүсийн өөрчлөлт буюу дахин хөгжүүлэх төслийн хэрэгжилт дээр голлон анхаарсан болно.

Зорилго

Гэр хорооллын дахин хөгжүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, орон зайн тулгамдаж буй асуудлуудыг (хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлага) цаг хугацааны үе үеэр нь тодорхойлж, оролцогч талуудын үүрэг, оролцоо, хамтын ажиллагааг судлан төр, хуулийн байгууллагын шийдвэрүүд хэрхэн нөлөөлж байгааг одоогийн нөхцөлд үүсэж буй суурьшлуудын орон зайг дүгнэн цаашдын авах арга хэмжээг хот байгуулалтын онолын дагуу бий болгох.

Материал ба арга зүй

Энэхүү судалгааны ажил нь Улаанбаатар хотын газрын зураглалд гэр хорооллын дахин хөгжүүлэх төсөл ашигласан морфологийн томоохон харьцуулсан судалгааны эхлэл юм [7]. Гол мэдээллийн эх сурвалж нь Google газрын зурагт агуулагдсан зургийн архив, веб архив зэрэг холбогдох мэдээллийн сан бүхий Google Earth юм. Судалгааны ажилд гурван суурин сонгон авсан бөгөөд тус бүр нь хотын орон зайн дахин хөгжүүлэлт явагдсан чухал суурины морфологи хэрхэн үүссэнийг нарийвчлан харуулсан зураглалыг гаргасан.



Үр дүн

Улаанбаатар хотын гэр хорооллын дахин хөгжүүлэх төслийг хэрэгжилтээр нь авч үзвэл төлөвлөлтийн байршилд орсон 24 байршил байгаа бөгөөд анх санаачилсан төслийн агуулгад бүрэн нийцсэн хэрэгжсэн байршил байхгүй бөгөөд түүнтэй төстэй агуулгатай 14 байршил байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт хамгийн их барилга баригдсан байршил тогтооход хотын төвийн бүсийн гэр хорооллууд буюу СБД-ийн 9, 10, 11-р хороо 7-р хороолол, БГД-ийн 16-р хороо Гандантэгчэнлин хүрээ хороолол, БЗД-ийн 25, 18-р хороо буюу Зүүн сэлбэ Натурын орчим.



Зураг 1 Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 -р хороо буюу Улаанбаатар хотын “7-р нэгж хороолол”

Зураг 2 Баянгол дүүргийн 16-р хороо буюу “Гандантэгчэнлин хүрээ хороолол”



Зураг 3 Баянзүрх дүүргийн 25, 18-р хороо буюу Зүүн сэлбэ “Натур”

Хүснэгт 1. 7-р хороолол, Зүүн сэлбэ, Ганданд баригдсан барилга бүрийн орон зайн үзүүлэлтүүд

Архитектур орон зайн шаардлага хангасан орон сууцны тоо	Гэр хорооллын дахин хөгжсөн газар нутгийн нэмэгдсэн барилга байгууламжийн архитектур орон зайн шаардлага хангасан, хангаагүй үзүүлэлт		
	7-р хороолол	Зүүн сэлбэ	Гандан
Нийт шинээр баригдсан орон сууцны тоо	75	92	46
Бүх үзүүлэлтийг хангасан	5	3	2
Авто зогсоолын тоо	7	13	11

Архитектур орон зайн шаардлага хангасан орон сууцны тоо	Гэр хорооллын дахин хөгжсөн газар нутгийн нэмэгдсэн барилга байгууламжийн архитектур орон зайн шаардлага хангасан, хангаагүй үзүүлэлт		
	7-р хороолол	Зүүн сэлбэ	Гандан
Гадна тоглоомын талбайн хэмжээ	4	8	2
Ногоон байгууламжийн талбайн хэмжээ	18	3	4
Пандусын хэмжээ	4	6	4
Үг үзүүлэлт	12	5	9

Тухайн байршлууд дээр баригдсан орон сууцны барилгууд ямар архитектур орон зай үүсгэж байгааг шалгаж үзэхийн тулд байршил бүрд очин судалгаа хийн мэдээллийн сан үүсгэн дүгнэлт хийсэн. Үүнд айлын тоо авто машины зогсоолын хоорондын харьцааг харах зорилготой, оршин суугчдын тоо ногоон байгууламжийн талбайн хэмжээн харьцаа гэх зэргийг харахын тулд судалгааг нарийвчлан хийсэн. Үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан орц гарц буюу Пандусын хэмжээ шаардлага хангасан орон сууц 6% байгаа нь үнэхээр харамсалтай байна.

Дүгнэлт

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн одоогийн нөхцөл байдлыг нийтэд нь дүгнэн үзэхэд хэрэгжсэн төслүүд нь дахин төлөвлөлтийн зорилгод нийцэхгүй оршин суугчдын тав тухтай байдлыг хангахгүй орон сууц баригдсан байгаа тул дахин төлөвлөлт буюу хөгжүүлэлт гэж үзэж болохгүй. Харин төрөөс авч хэрэгжүүлж байгаа дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч талууд харилцан ашигтай хамтран ажиллаж, үйл явцыг илүү сайжруулахын тулд 3 төрлийн зарчмыг ханган, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Доорх гурван зарчмыг оролцогч талуудын хамтын ажиллагаанд хангаж ажиллаж чадаагүйгээс үүдэн дахин төлөвлөлтийн үйл явцад алдаа дутагдлууд гарч ирсэн байна.

Түлхүүр үг: Гэр хороолол, дахин хөгжүүлэх төсөл, ерөнхий төлөвлөгөө, архитектур орон зай,

Ашигласан материал:

1. Jay Forrester – Urban dynamics, 1969
2. Lewis D. Hopkins – Urban development, 2001
3. Fredrick Steiner, Kent Butler (American Planning Association) – Planning and Urban design standards, 2006
4. Stuart Meck, American Planning Association - Growing Smart Legislative Guidebook, 2002
5. Kevin Lynch – A Theory of Good city form, 1981

